



Иргэдийн оролцооны эрх зүйн орчин ба үнэлгээ

Судалгааны тайлан

Улс төрийн боловсролын академийн 20 жилийн ойд зориулав.

*Энэхүү тайлан нь Ардчиллыг Хамгаалах Иргэний
Нийгмийн төлөөх Дэлхийн Хөдөлгөөний дэмжлэгтэйгээр
Улс төрийн Боловсролын Академиас бэлтгэгдсэн болно.*

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

DDC
153.15
И-788

Судлаачид

Л.Анар-Эрдэнэ (Улс төрийн боловсролын академийн багш)
Б.Батхүү (Бодлогын судлаач)
Б.Баярмаа (“Хөвсгөл далайн эзэд” ТББ захирал)
П.Мөнхцэцэг (Судлаач, Төслийн ажилтан)
Н.Мягмарцоож (МУБИС, Улс төр судлал, социологийн тэнхимийн
эрхлэгч, доктор (Ph.D))
Л.Отгонтуяа (Удирдлагын академийн багш)
Ц.Цэцэнбилэг (Төслийн удирдагч, доктор (Ph.D))
М.Энхбат (Улс төрийн боловсролын академийн гүйцэтгэх захирал)

Техник редактор

П.Мөнхцэцэг (Судлаач, Төслийн ажилтан)

ISBN 978-99962-928-9-7

“АРВИН СУДАР” ХХК Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Э.Мөнгөнчимэг
Эхийг **“АРВИН СУДАР” ХХК**-д бэлтгэж хэвлэв.
Утас: 7010-0855, 99070855, 9601-0855
Хэвлэлийн хуудас: 25 х.х
Цаасны хэмжээ: 297x210 мм А4
Хэвлэсэн тоо: 100 ширхэг
Хэвлэсэн он: 2013 оны 4 сар

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	4
ОРШИЛ.....	5
Нэгдүгээр хэсэг: МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ЕРӨНХИЙ ОРЧИН	
ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ЕРӨНХИЙ ШИНЖИЛГЭЭ.....	8
<i>Н.Мягмарцоож</i>	
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН УЛСЫН ИХ ХУРАЛ, СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИУДАД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН БАЙДАЛ	20
<i>М.Энхбат, П.Мөнхцэцэг</i>	
ОРОН НУТГИЙН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮДЭД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН БАЙДАЛ.....	30
<i>Л. Анар-Эрдэнэ</i>	
Хоёрдугаар хэсэг: МОНГОЛ УЛСЫН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ БАЙДАЛ	
ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИ ЛГЭЭ.....	40
<i>Л.Отгонтуяа</i>	
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ.....	51
<i>Б.Баярмаа</i>	
НИЙГМИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮДЭД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН БАЙДАЛ.....	72
<i>Б.Батхүү</i>	
ХАВСРАЛТУУД.....	73

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АИХ	Ардын Их Хурал
БОА	Байгаль орчны алба
БОАЖЯ	Байгаль орчин, Аялал жуулчлалын яам
БОНБҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОНБНҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нэгдсэн үнэлгээ
БОНХЯ	Байгаль орчин, Ногоон хөгжлийн яам
БОХХААБХ	Байгаль орчин, Хүнс, Хөдөө аж ахуйн байнгын хороо
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МБОИЗ	Монголын байгаль орчны иргэний зөвлөл
МҮНХ	Монголын үндэсний ногоонтны хөгжил
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ННФ	Нээлттэй нийгэм форум
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
ОНХХ	Олон нийттэй харилцах хэлтэс
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УИХ	Улсын Их Хурал
УМХЕГ	Улсын мэргэжлийн хяналтын Ерөнхий газар
УТБА	Улс төрийн боловсролын академи
ХАА	Хөдөө аж ахуй
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс
ХМБ	Хэвлэл мэдээллийн байгууллага
ХХҮХ	Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний коммис
ШУА	Шинжлэх ухааны академи
ФСЭХ	Философи, социологи, эрх зүйн хүрээлэн

Өмнөх үг

Монгол улс ардчиллын замналыг сонгож 20 гаруй жил тууштай явжсны үр дүнд ардчиллын суурийг баттай тогтоож чадсан билээ. Монгол улсын гаргасан идэвхи, чармайлт, ололт олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, үүний нэг илрэл нь Монгол улс Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг (АОХН) 2011 оноос даргалах хариуцлагатай үүргийг хүлээн авсан явдал юм. Монгол улс АОХН-ийг даргалахдаа ардчиллын боловсрол, иргэний нийгмийн байгууллагуудын төлөвшилд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, АОХН-ийн бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, ардчиллыг бэхжүүлэхэд бусад улс оронтой туршлага солилцох, авлигатай тэмцэх зэрэг асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч ажиллаж байна. Эдгээрийг амжилттай хэрэгжүүлж чадах нь ардчилсан үйл явцыг гүнзгийрүүлэн бэхжүүлж, эргэлт буцалтгүй болгоход чухал ач холбогдолтой юм.

Манай улсын ардчилсан өөрчлөлтийн он жилүүдийн нэгэн чухал ололт нь иргэний нийгмийн байгууллагуудын хөгжил, төлөвшил юм. Иргэний нийгмийн оролцоогүйгээр ардчилсан нийгмийг төсөөлөх аргагүй. Төрийн зүгээс иргэнийхээ үгийг сонсдог, тэдэнд шуурхай үйлчилдэг, ажлаа ил тод, нээлттэй явуулдаг байлгахын төлөө ажиллаж байна. Иргэдийнхээ санаа бодол, санал санаачилгыг үйл ажиллагаа, шийдвэртээ тусгахыг илүүд үзэж, иргэний нийгмийг төлөвшүүлэхийн төлөө анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд төвлөрлийг сааруулах, орон нутгийн төсвийн эрхийг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад өгөх, төсвийг төлөвлөх, зарцуулах, хяналт тавихад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх асуудлыг юуны өмнө чухалчилж байна. Ингэхдээ иргэдийн оролцоог бид ямар байдлаар харж байна вэ? Иргэдийн оролцоог хангахад эрх зүйн орчин хэр зэрэг бүрдсэн байна вэ? гэсэн асуулт нэн тэргүүнд тавихдаг учиртай.

Аливаа явцад дунд хугацааны үнэлгээ хийж, түүнд тулгуурлан стратеги тодорхойлох нь амжилтаа бататгах, алдаагаа засах, залруулах, цаг, хөрөнгө, хүч хэмнэх ихээхэн ач холбогдолтой. Иймээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар, Улс төрийн Боловсролын Академиас санаачлан “Иргэдийн оролцооны эрх зүйн орчин, хэрэгжилтийн байдалд шинжилгээ хийх” төслийн хүрээнд АНУ-ын Ардчиллыг дэмжих сангийн дэмжлэгээр судалгаа хийж, судалгааны завсрын үр дүнг энэ номондоо толилуульж байна.

“Иргэдийн оролцооны эрх зүйн орчин, хэрэгжилтийн байдалд шинжилгээ хийх” төслийн хүрээнд Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа тулгуур хууль болон салбар хоорондын хуулинд иргэдийн оролцоо хэрхэн тусгалаа олсоныг шинжлэн үзэх, тулгуур хуулинд тусгасан үзэл санаа салбарын хуультай хэрхэн уялдаж байгаа болон УИХ, Засгийн газрын тогтоол, яамдын сайд нарын тушаалаар баталсан журмууд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын бодлого шийдвэрт хэрхэн нөлөөлж байгаа, хэрэгжилт ямар байгаа зэргийг тодорхойлох нь энэ судалгааны гол зорилго юм. Судалгаанд иргэдийн оролцооны үндсэн хэлбэр буюу мэдээллэх, зөвлөлдөх, идэвхитэй оролцоо, иргэдийн хяналт гэсэн ангиллаар хууль эрх зүйн актыг шинжилж, эерэг сөрөг тал, боломжтой тохиолдолд хэрэгжилтийн байдлыг судаллаа.

Иргэдийн оролцоо нь өөрийн өвөрмөц соёл, үнэлэмж, сэтгэлгээний цогц үйл явц

байдаг. Монголчууд өнөөдөр энэ үйл явцад том эргэлт гаргаж, эрчимтэй өөрчлөлт хийж байна. Энэ өөрчлөлтийн гол хөтөч нь эрх зүйн харилцаа. Эрх зүйн харилцаа нь иргэдийн оролцоог зохицуулдаг, урамшуулдаг байх ёстой. Манайд ийм чадамж байна уу? үгүй юу? Гэдгийг оношлохын тулд өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудад шинжилгээ хийх анхны алхмыг энэ судалгаагаар эхлүүлж байна.

Төсөл хэрэгжүүлэх, судалгаа хийхэд дэмжлэг үзүүлсэн Улс төрийн Боловсролын Академи, Стратегийн судалгааны хүрээлэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн хүний эрх, иргэдийн оролцооны зөвлөх Ч.Сосормаа, референт Д.Дорждэрэм, судлаачид, удаа дараагийн хэлэлцүүлэгт оролцож үнэтэй санал зөвлөмж өгсөн иргэний нийгмийн төлөөлөгчид, яам, агентлагийн түшмэл, эрдэмтэн мэргэд, төслийн удирдагч доктор Ц.Цэцэнбилэг, төслийн ажилтан П.Мөнхцэцэг нарт талархал илэрхийлье.

Улс төрийн Боловсролын
Академийн УЗийн дарга, доктор (Ph.D)
Д.Ганбат

Оршил

Сүүлийн жилүүдэд манайд улс иргэний оролцоотой нийгмийн загварын тухай ихээхэн ярих боллоо. Төрийн захиргааны байгууллагууд иргэнд илүү нээлттэй, ил тод үйл ажиллагаа явуулах, аливаа бодлого, шийдвэрийг гаргах, хэрэгжүүлэхдээ иргэний оролцоог хангахыг хичээх болов. Гэхдээ иргэний оролцоог хангаж байгаа хэлбэр, үйл ажиллагаа нь харилцан адилгүй, чанар, үр дүн нь хүссэн хэмжээнд хүрэхгүй байх нь нийтлэг байна. Толилуулж буй судалгаанд үүний суурь болох иргэдийн оролцооны эрх зүйн орчинг шинжлэн дүр зургийг гаргах оролдлого хийгдсэн болно.

Ардчилал туйлын зорилго биш харин тогтмол үйл ажиллагаа, хамтын ажиллагааны үйл явц гэж хэлж болно. Ардчиллыг иргэдийн оролцоогүй төсөөлшгүй¹ бөгөөд иргэдийн оролцоогоор ардчиллын төлөвшил, чанарыг хэмжиж болох юм. Оролцооны ардчилал нийгмийн өөрчлөлтийг бий болгодог². Иргэдийн оролцоо болон хяналт нь ардчиллын тулгуур зарчим бөгөөд 2007 оноос иргэдийн оролцоог идэвхжүүлэх, хөхиүлэн дэмжих, хангах гэсэн судалгаа, санаачилгууд нэлээд гарч эхэлсэн билээ. Үүнд иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ, Түншлэл, Монголын Нээлтэй нийгэм, олон улсын байгууллагууд их үүрэг гүйцэтгэсэн болно.

Ер нь 1990 оноос хойшх Монгол дахь иргэдийн оролцооны талаарх чиг хандлагыг гурван үед хувааж болох бөгөөд ардчиллыг ухаарч ойлгох эхний шатанд иргэдийн оролцоог сонгуулиар төлөөлүүлж, иргэдийн идэвх тохиолдлын, зохион байгуулалтгүй, төрийн зүгээс ч Үндсэн хуулийн тунхгийн шинж чанартай бусад хуулиар баталгаажуулах хэдэн заалт бүхий дээрээс доошоо чиглэсэн нэг урсгалтай иргэдийн оролцоо зөвхөн сонгууль, санал, гомдол, ард иргэдийн санал асуулгаар хязгаарлагдсан байсан. Энэ нь 2000-ад оны эхэн хүртэл үргэлжилсэн бөгөөд 2003 оны Монголд зохион байгуулагдсан Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын хурлын бэлтгэл болон дараах үед Монгол дахь ардчиллын төлөв байдал, чанар, иргэний байгууллагуудын төлөвшил, байдлын үнэлгээ хийгдэж үр дүнд нь төр иргэний харилцаа ба төрөөс иргэдийнхээ өмнө үйл ажиллагаагаа хариуцах чадвар сул, иргэдийн оролцоонд төрийн болон төрийн бус байгууллагууд, албан тушаалтнууд үр нөлөөтэй дэмжлэг үзүүлж чадахгүй байгаа асуудал тавигдсан билээ. Хоёр дахь шатанд иргэдийн идэвх, оролцооны асуудал өргөнөөр хэлэлцэгдэж иргэний нийгмийн байгууллагууд төлөвшиж албан зохион байгуулалтын хэлбэрт орсон. Иргэдийн оролцооны талаарх судалгаа хийгдэж иргэдийг идэвхжүүлэх, оролцоог хангах санаачилгууд орон нутагт хэрэгжиж эхэлсэн. Төрийн зүгээс ч иргэдийн оролцоог дэмжиж 2008-2012 оны Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт төр иргэний харилцаа ба иргэдийн оролцоонд төрийн болон төрийн бус байгууллагууд, албан тушаалтнууд үр нөлөөтэй дэмжлэг үзүүлэхээр дэлгэрэнгүй заажээ³. 2008 онд төр иргэний нийгмийн харилцаа, хамтын ажиллагаа

¹ Pimbert, M. and Wakeford, T. (eds) (2001) 'Deliberative democracy and citizen empowerment', Special issue of PLANotes 40 pp. 23-28. International Institute for Environment and Development, London.

² Fung Archon (2006) Empowered Participation: Reinventing Urban Democracy. Princeton University Press.

³ Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсвийн гүйцэтгэлд мониторинг хийх үйл ажиллагаанд төрийн бус байгууллагуудыг оролцуулах, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах

идэвхжиж 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр болсон ТББ-уудын анхны зөвлөлдөх уулзалтаас Засгийн газартай хамтран ажиллах Иргэний нийгмийн зөвлөл байгуулагдан Засгийн газар, Иргэний нийгмийн зөвлөлтэй хамтран ажиллах гэрээ 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдөр баталгаажсан юм.⁴ Иргэдийн оролцооны чиг хандлагын өрнөлийн 3 дахь шатыг 2009 оны 12 сарын 15-ны өдөр Ерөнхийлэгчийн дэргэдэх Иргэний танхим нээгдэж үйл ажиллагаагаа эхлүүлсэнтэй холбож болно. Үүгээр төр иргэдийн өмнө хүлээх үүрэг, мөн иргэд хууль боловсруулах, төр, орон нутгийн шийдвэрт нөлөөлөн оролцох үүрэгтэйг тунхаглан иргэдийн оролцооны суваг, боломжийг олгож хоёр талт урсгалт хамтын ажиллагааны суурийг бэхжүүлсэн билээ.

Иргэдийн оролцооны өрнөлийн эл шатын нэг томоохон алхам бол Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж энэ оны эхээр 2013 оныг “Шууд ардчилал-иргэдийн оролцоо”-г дэмжих жил болгож зарласан явдал юм. Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай шинэ хуульд тусгагдсан үзэл санааг бодит ажил хэрэг болгохын тулд “Шууд ардчилал-иргэдийн оролцоо”-гоор дамжуулан төвлөрлийг сааруулах үндэсний дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг батлан гаргаж “Шууд ардчилал-иргэдийн оролцоог дэмжих” бодлогын зөвлөл байгуулж, бодлогын зөвлөлийн дүрмийг баталж гаргасан. Энэ ажлын хүрээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, шууд ардчиллыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэх, “Шууд ардчилал-иргэдийн оролцоо”-ны бодлогын баримт бичгийн төсөл, цахим санал асуулга, зайны сургалтын талаар иргэдийн оролцоог Иргэний танхимаар дамжуулан хангах, орон нутгийн төсвийн ил тод байдлын жишиг стандарт болон зар мэдээ түгээх журам, аймаг, сумын болон орон нутгийн хурлын дүрэм, орон нутгийн хөгжлийн сан, иргэдийн оролцоотой худалдан авалт, шууд ардчилал-иргэдийн оролцоог дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулсан байна⁵.

Ийнхүү иргэдийн оролцооны ач холбогдол чухалчлагдах болжээ. Гэвч иргэдийн оролцоог хангах эрх зүйн орчин хэр зэрэг байна вэ гэсэн асуудал гарч ирж байна. Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, үр нөлөөг сайжруулах суурь нь эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, түүнийг хэрэгжүүлэх тодорхой арга замыг бий болгох явдал юм. Иймээс Ерөнхийлөгчийн Тамгын газраас санаачлан Ардчиллыг дэмжих сангийн дэмжлэгтэй Улс төрийн Боловсролын Академиас иргэдийн оролцооны эрх зүйн шинжилгээг хийж судалгааны үр дүнг энэхүү тайланд толилуулж байгаа юм.

Уг тайланг бэлдэх, судалгаа шинжилгээнд, **хэрэглэсэн нэр томьёо, судалгааны арга зүйн** талаар товч дурдъя.

Оролцоог иргэд санал бодлоо илэрхийлж шийдвэр гаргахад нөлөөлөх үйл явц гэж тодорхойлдог⁶. Шерри Арнстейн оролцоог улс төр, эдийн засгийн үйл явцаас гадуурхагдсан иргэдийг ирээдүйд эдгээр үйл явцад оролцуулах боломжийг бүрдүүлдэг эрх мэдлийн дахин хуваарилал юм гэж үзсэн⁷. Иргэдээс төрийн

ажиллагааг эрчимжүүлэх тухай Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 93 дугаар тогтоол гарсан ололт байсан.

⁴ <http://www.demo.org.mn/newsdetail.php?NewsID=101>

⁵ <http://www.legalinfo.mn/details/125>

⁶ James L. Creighton (2005) The Public Participation Handbook: Making Better Decisions Through Citizen Involvement. John Wiley & Sons Inc.

⁷ Sherry Arnstein (1969) A Ladder of Citizen Participation.

байгууллага, ажилтны бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих болон тэдгээрт нөлөөлөхийн төлөө хийж байгаа аливаа үйл ажиллагаа, үйл явцыг оролцоо гэж нэрлэж болно. Энэ утгаараа оролцоо бол хүн бүрийн өдөр тутмын амьдралын нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Ардчилсан улс оронд иргэдийн оролцоо нь сонгуульд саналаа өгч төр засгаа байгуулах улмаар төрийн бодлого боловсруулах, төсөв батлах ба хэрэгжүүлэхэд оролцох, үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих, хариуцлага тооцох механизмаар дамжин хэрэгждэг. Иймээс иргэдийн оролцоог төрийн байгууламж иж бүрэн, тал бүрээс нь хангаж байж үр өгөөжөө өгдгийг олон улсын туршлага харуулж байна. Иргэдийн оролцоо дараах үйл ажиллагаанд нэн чухал⁸:

- Сонгуульд оролцож саналаа өгөх, сонгуулийн үйл ажиллагааг хянах, үнэлэх
- Бодлого /төсөв/ боловсруулахад оролцох
- Бодлого хэрэгжүүлэхэд оролцох
- Үйл ажиллагааны /төсөв/ хэрэгжилтэнд хяналт тавих
- Үнэлгээ өгөх/ хариуцлага тооцох

Судалгааг хийхдээ иргэдийн оролцооны дараах хэлбэр хууль тогтоомжид хэрхэн тусгасан эсэхийг шинжилсэн болно.

Мэдээллээр хангах, мэдээллийн хүртээмж, ил тод байдал

Оролцогчид тодорхой төлөвлөгөө болон шийдвэрийн талаар мэдээлэлтэй байх, төрийн зүгээс мэдээллийг олон нийтэд өгөх, нээлттэй байлгах, нөгөө талаас иргэд өөрсдийн хүссэн мэдээллийг хайх, олж авах боломж нөхцлийг бүрдүүлсэн байх учиртай. Мэдээлэл иргэдийг идэвхжүүлж, анхаарлыг нь тухайн асуудалд хандуулж, үйл ажиллагаанд татан оролцуулдаг учраас оролцооны анхны хэлбэр болдог.

Зөвлөлдөөн

Үүнд оролцогчид өөрсдийн санал бодлоо илэрхийлж оролцогч нарын санал бодлыг асуух, саналыг сонсох, уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах бүхий л хэлбэрүүд хамаарна. Зөвлөлдөөн нь бодлого боловсруулагчид (шийдвэр гаргагчид) болон олон нийтийн хооронд хос урсгалтай харилцаа бий болгож улмаар тэдгээрийн хоорондын түншлэлийн суурь болдог оролцооны хоёр дахь хэлбэр юм.

Хамтын ажиллагаа, идэвхитэй оролцоо

Хамтран ажиллах бол оролцооны хамгийн идэвхитэй хэлбэр юм. Шийдвэр гаргагчид оролцогчдыг ажлын хэсэгт оруулах зэргээр хамтын шийдвэр гаргахад шууд оролцуулахыг хэлнэ. Иргэдээр өөрсдөөр нь асуудлыг шийдвэрлүүлж байгаа шууд оролцооны хэлбэрүүд бол төр ба иргэдийн хамтын ажиллагааны хамгийн дээд шат болдог.

Иргэдийн хяналт

Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагаанд иргэд болон ИНБ-ууд шууд болон шууд бус хяналт тогтоох боломжийг бий болгох, тэдгээрийн хяналтыг хэрэгжүүлэх нь оролцооны дөрөв дахь хэлбэр болдог.

Иргэдийн оролцооны эдгээр 4 хэлбэр Монгол улсын суурь болон салбарын хуулиуд хийгээд хууль, бодлого боловсруулах болон орон нутгийн түвшинд хэрхэн тусгагдсанг энэхүү тайланд авч үзлээ. Түүнчлэн шинжилгээндээ Шерри Арнстейны иргэдийн оролцооны шатлалыг ашигласан болно⁹.

⁸ Иргэдээ сонсож, иргэдтэйгээ зөвлөлдөж, хөгжлийг хамтдаа бүтээхүй. УБ., Китон принт, 2012.

⁹ Мөн тэнд. х.21.

Төслийн судалгааг IDEA-гийн арга зүйд үндэслэсэн дор дурьдсан зарчим, шалгуур үзүүлэлт, судалгааны аргыг ашигласан.

Судалгааны зарчим:

- Олон улсын энэ төрлийн судалгааны нийтлэг арга зүйтэй нийцсэн байх
- IDEA-ийн арга зүйн үндсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг жишиг болгон баримтлах
- Монгол Улсын хууль, журам, тогтоол, төрийн бодлого, түүний хэрэгжилтэд анализ хийх
- Бодит амьдралын үндэслэл нотолгоонд тулгуурлах, олны оролцоог хангасан
- Өмнө хийгдсэн судалгааны мэдээллийг ашиглах.

Судлаачдын багт 6 судлаач, 2 зөвлөх ажилласан. 4 дугуй ширээний ярилцлагад төрөл бүрийн төлөөллийн нийт 140 хүн оролцож тэдний ажлын туршлага, саналыг тайланд санал, зөвлөмжид тусгасан билээ.

Төслийн судалгааанд нийгмийн судалгааны дараах чанарын аргыг голлон хэрэглэсэн.

- Төрийн бодлого, хууль, бодлогын шинжтэй баримт бичигт контент-анализ хийж дүн шинжилгээнд логфреймын аргыг ашигласан
- Экспертийн үнэлгээ
- Кейсийн дүн шинжилгээ
- Өмнө хийгдсэн судалгааны тайлан мэдээллийн харьцуулсан анализ хийсэн. Үүний тулд 2005-2012 онуудад хийгдсэн иргэдийн оролцооны сэдэвт хамаарах 150-иад тайлан, хэрэгжсэн төслийн тайлан, илтгэлийн мэдээллийн сан бүрдүүлсэн.

Мэдээллийн анхдагч эх сурвалж

- Үндсэн хууль, суурь 20 хууль, салбарын хуулиуд, хөтөлбөр, журам, тогтоол, аймаг, дүүргүүдийн бодлогын шинжтэй баримт бичиг
- 4 дугуй ширээний ярилцлагын явцад цугларсан баримт материал
- Ярилцлагын транскриптууд

Тайлангийн бүтэц

Иргэдийн оролцоог төсөв, нийгэм (боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж), байгаль орчны чиглэлийн хууль, үндэсний болон дэд хөтөлбөрүүд, хуульд нийцүүлэн гаргасан журмууд, Эдийн засаг болон хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага болон зарим эрдэмтэн судлаачдын арга зүйд үндэслэн дээр дурьдсан иргэдийн оролцооны 4 хэлбэрээр авч үзэн үнэлгээ хийсэн. Ингэхдээ судлаач бүр өөрийн тайланг дараах бүтэцтэй бичсэн. Үүнд:

- *Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал*
- *Хэрэгжилт*
- *Эерэг тал*
- *Сөрөг тал*
- *Дүгнэлт, санал, зөвлөмж*

Энэхүү тайлан судалгааны дунд шатны үр дүн бөгөөд анхдагч мэдээллийн эх сурвалж, тэдгээрийн шинжилгээг толилуулахыг хичээсэн болно. Тайлан хоёр хэсгээс бүрдсэн бөгөөд нэгдүгээр хэсэгт Монгол улсын иргэдийн оролцоо Үндсэн хууль, суурь хуулиудад хэрхэн тусгагдсан хийгээд хууль боловсруулах түвшин болох УИХ, Монгол улсын Ерөнхийлөгч, сонгуулийн тухай хуулиудыг шинжилж, Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөр, ИТХ-ын дэг, Иргэний танхимын журмуудад иргэдийн

оролцоо хэрхэн хангагдсаныг орон нутгийн түвшинд авч үзсэн болно. Хоёрдугаар хэсэгт иргэдийн оролцоо салбарын эрх зүйн баримт бичигт хэрхэн тусгагдсанг судалсан болно. Ингэхдээ иргэдэд хамгийн хүртээлтэй тулгам салбаруудыг сонгож тухайн салбарын судлаачид шинжилгээ хийсэн.

Номын хавсралтад судлаачдын мэдээллээ нэгтгэсэн тайлан бичих суурь болгож боловсруулсан хүснэгтийг оруулсан болно. Үүгээр энэхүү тайлан олон нийтэд илүү хүртээлтэй болно гэж найдаж байна.

Уг тайланг богино хугацаанд бичиж их хүч, хөдөлмөр, идэвх чармайлалт гаргасан судлаач нартаа талархал илэрхийлье
Төслийн удирдагч: Ц.Цэцэнбилэг, доктор (Ph.D)

Нэгдүгээр хэсэг

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ЕРӨНХИЙ ШИНЖИЛГЭЭ

Н.Мягмарцоож

1992 онд Монгол улс шинэ ардчилсан Үндсэн хууль баталж засгийн бүх эрх ард түмний мэдэлд байж, хүний эрх эрх чөлөөг хуульчлан баталгаажуулсан нь оролцооны үндсэн эрхүүд хэрэгжих эхлэл болсон юм. Монгол улсын иргэд шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан төрийг удирдах эрхтэй болж, үзэл бодлоо янз бүрийн түвшинд илэрхийлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаанд оролцох, гэр бүл нийгмийн харилцаанд эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш оролцох зэрэг эрхүүд хууль тогтоомжуудад тусгагдсан байна.

Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудад иргэдийн оролцоог хэрхэн хангаж байгаа талаар шинжилгээ хийж, түүнд учирч буй бэрхшээл, хэрэгжилтийн байдал, сайжруулах арга замуудыг санал болгох зорилгоор энэхүү шинжилгээг хийв. (Хавсралт 2)

МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ БА ИЛ ТОД БАЙДАЛ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Мэдээллийн эрх зүйн орчинд шинжилгээ хийхдээ мэдээлэл түүний ил тод байдал болон иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг хэрхэн зохицуулсан байгаа эсэхийг тодруулах зорилгоор авч үзлээ.

Монгол улсын Үндсэн хууль (1992) –д төрийн болон байгууллагын нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх болон хүлээн авах эрхийг баталгаажуулсан чухал заалт орсон. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011) – д улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төрийн байгууллагуудын мэдээллийн, үйл ажиллагааны, хүний нөөцийн, төсөв санхүүгийн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын талаар 42 заалт, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахад чиглэгдсэн 46 заалтууд байгаа бөгөөд мэдээллийн цаг хугацаа, төрийн байгууллагын болон мэдээлэл өгч буй этгээдийн үүрэг хариуцлага зэргийг нэлээд тодорхой заажээ.

Ерөнхийлөгчийн тухай (1993), УИХ-ын тухай /шинэчилсэн найруулга/ (2006), Засгийн газрын тухай (1993), Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/ (2006) зэрэг хуулиуд, бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрх, төрийн байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангах зорилго бүхий заалтууд харьцангуй сул байгаа бөгөөд ихэвчлэн төрийн байгууллагын шийдвэрийг мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэд мэдээлж байхаар заасан байна. Цөөн тохиолдолд мэдээллийн алба, үйл ажиллагааны ил тод байдал, мэдээллийн төвүүдийг байгуулж ажиллуулах, тайлангийн мэдээ, нээлттэй хуралдааны талаар, иргэдийн өргөдөл гомдол, хүсэлт зэрэг мэдээллийг бичгээр болон амаар гаргаж болохоос гадна цахим хэлбэрээр авах талаар заасан УИХ-ын болон Засгийн газрын 10 гаруй тогтоол гарсан байна. Мэдээллийг хэрхэн хайх хүлээн авах, түгээх үйл явц болон тэдгээрийн цаг хугацааны талаар тухайлсан заалтууд нэн ховор байгаа нь оролцоонд сөргөөр

нөлөөлж байгаа ч Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар олон асуудлуудыг зохицуулах боломж харагдаж байна.

ТББ-ын тухай хууль (1997)-д ТББ-ын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахаас гадна тэдгээрт төрийн байгууллагуудын мэдээлэл нээлттэй байх, төрийн байгууллагаас гаргасан шийдвэрт мэдээлэл хийх эрх нээгдсэн зэрэг сайн талууд байгаа ч тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх арга механизм нь тодорхой бус байгаа юм.

Төсвийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2011) – д төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх, төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх тухай заасан нь мэдээллийн ил тод байдлыг хангаж иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдол бүхий заалт болсон байна.

Мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалт нь төр, байгууллага, хувь хүний нууцын тухай (1995) хууль юм. Төрийн нууцын тухай хуулиар 59 төрлийн мэдээллийг нууцад хамруулж нэг бүрчлэн нэрлэн заасан. Байгууллагын нууцын тухай (1995) хуулиар тухайн байгууллага нууцаа өөрөө тогтоож, нууц мэдээллийг хамгаалах журам батлах үүрэг хүлээлгэсэн нь мэдээллийн эрх чөлөөг зүй бусаар хязгаарлаж байна. Цаашид төрийн нууцад хамруулах мэдээллийг нууцлах шаардлагатай эсэхийг үнэлж, нууцлах мэдээллийг аль болох цөөрүүлэх, байгууллагын нууцад хамаарах мэдээллийг хуулиар нэрлэн тогтоох шаардлагатай байна.

Үнэлгээ

Мэдээллийн нээлттэй байдлын талаар 2003 оноос хойш “Глоб интернэшнл” ТББ, Олон улсын “ARTICLE 19” байгууллага, “Нээлттэй нийгэм форум” ТББ зэрэг олон судалгааны байгууллага тодорхой чиглэлээр судлан мэдээллийн нээлттэй, ил тод байдал хангалтгүй байгаа талаар нэлээд бичжээ. Тухайлбал: судалгаанд оролцогчдын төр засгийн байгууллагын шийдвэр үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүссэн цагтаа авч чаддаг байдал⁶-ыг авч үзвэл мэдээллийг төвөггүй олж авч чаддаг байдал 2005 онд 25,9% байсан бол 2010 онд 22,7% болж ялимгүй буурсан бол, мэдээллийг эрж сурж байж олж авдаг байдал 2005 онд 23,5% байсан бол 2010 онд 26,7% болж өсчээ. Мэдээлэл авах шаардлагагүй гэсэн хүмүүс 2005 онд 22,5% байсан бол 2010 онд 12,6% болсон байна.

Судалгаанд оролцогчдын төр засгийн байгууллагын шийдвэр үйл ажиллагааны талаарх мэдээллийг олж авдаг эх сурвалж⁷-ийг авч үзэхэд албан ёсны мэдээллээс 2005 онд 29,6% авч байсан бол 2010 онд 28,6% болж, мэдээллийн хэрэгслээс авдаг байдал 2005 онд 2,9% байсан бол 2010 онд 41,7% болж огцом өссөн байна. Албан тушаалтнаас мэдээлэл авдаг байдал 2005 онд 4,3% байсан бол 2010 онд 10,2% болсон байна.

⁶ Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт (2009-2010). 2010. УБ, ШУА ФСЭХ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр. х.64.

⁷ Мөн тэнд. х.65.

Мэдээллийг бусдад түгээдэг хэвлэл мэдээллийн ажилтнууд болон сонирхогч иргэнд мэдээлэл хайх олж авахад нь төрийн албан хаагч саад учруулах, мэдээлэл өгөхөөс татгалзах, хуульд заагаагүй мэдээллийг нууцлах, удирдах албан тушаалтны зөвшөөрөл бичиг шаардах тохиолдол цөөнгүй гарч байна⁸.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн цахим хуудсанд⁹ Ерөнхийлөгч, түүний ажлын алба тэдгээрээс гарсан шийдвэр, Иргэний танхимын талаарх мэдээлэл, иргэний танхимаар хэлэлцүүлэх асуудалд саналаа өгөх, иргэдийн шууд оролцоотой төсвийн менежментийн тухай, иргэдийн оролцоо, шууд ардчиллын талаарх гарын авлага хэрэглэгдэхүүн зэргийг байрлуулсан байна. Монгол Улсын хувьд бодлого шийдвэр боловсруулах үйл явцын талаар зарим мэдээллийн хэрэгслүүдийг ашиглаж байна. Тухайлбал: УИХ-ын цахим хуудсанд¹⁰ хуулийн төслийн ерөнхий мэдээлэл болон 17 нэмэлт мэдээллийг оруулсан. “Төрийн мэдээлэл” сэтгүүл тогтмол хэлбэрээр албан ёсоор гарч байна. Хууль тогтоол зэрэг эрх зүйн актуудыг дээрх сэтгүүлд хэвлэгдсэн хувилбарыг эх сурвалж болгон ашиглаж байна.

Монгол Улсын Засгийн газрын цахим хуудсанд¹¹ Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудал болон хуулийн төслийн талаарх мэдээлэл нээлттэй байна. Засгийн газар, яамдууд, аймаг нийслэлийн ЗДТГ-ууд, бусад агентлаг төрийн байгууллагууд өөрсдийн мэдээллийн бие даасан бүтэц болох тогтмол хэвлэн гаргадаг сонин сэтгүүл, цахим хуудас зэрэгтэй болсон байна. Мөн орон нутгийн ИТХ-ууд, ЗДТГ-ууд бие даасан цахим хуудас болон сонин сэтгүүл зэргийг гаргаж бодлого шийдвэрийн талаар мэдээлдэг болж эхлээд байна¹².

Төрийн үйл ажиллагаатай холбогдуулан ТББ дангаар буюу хамтран мэдэгдэл хийдэг болсон бөгөөд зарим нь бодит үр дүнгээ өгсөн байна. Тухайлбал: “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хууль 10 шахам ТББ-уудын нэгдсэн “Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн”-ий идэвхтэй чармайлтын үр дүнд 2009 онд батлагдсан.

Төрийн байгууллагын цахим хуудсанд хийсэн мониторингийн¹³ үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан байгууллагын хувьд эрхэм зорилгоо тавьсан байдал 2010 онд 70.8% байсан бол 2011 онд 53.1% болж 17.7%-иар, үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг цахим хуудас мэдээлсэн байдал нь 12.1%-иар, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг мэдээлсэн байдал 35.4%-иас 20.8% болж, хүний нөөцийн хувьд зарласан сул орон тооны зар 80%-иас 18.8% болж тус тус буурсан байна.

⁸ Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. 2008. УБ, Монгол улсын хүний эрхийн үндэсний Комисс. х.34.

⁹ <http://www.president.mn/>

¹⁰ <http://www.parliament.mn/>

¹¹ <http://open-government.mn/>

¹² Нийслэлийн хөдөлмөрийн газар <http://www.ubbirj.mn/>, Авто замын газар <http://www.road.ub.gov.mn/>, Нийслэлийн цагдаагийн газар <http://www.ubpolice.mn/> гэх мэт

¹³ Төрийн байгууллагын вэб сайтын ил тод байдал \мониторингийн тайлан\ 2012. УБ. НҮБ, Авлигатай тэмцэх газар, ЗГХЭГ, IRIM,

Харин 2010 оны байдлыг 2011 онтой харьцуулахад дараах үзүүлэлтүүд өсчээ. Үүнд: албан хаагчийн ёс зүйн дүрмийг нийтлэх нь 16.9% байсан бол 45.8% болж, тухайн байгууллагын олон нийттэй харьцах мэргэжилтний овог нэрийг мэдээлэх байдал 26.2%-иас 57.3% болж, тухайн байгууллагын шуудангийн хаяг нь тавигдсан байдал нь 6.2%-иас 26% болж, байгууллагын хаяг, байгууллагатай холбоо барих утас, факсын дугаар зэрэг нарийвчилсан мэдээлэл бага зэрэг, байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төслийн гүйцэтгэл ба дараа жилийн төсвийн төслийг тавих нь бага хувиар, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мөрдөж буй хууль тогтоомжийг вэбсайтанд байрлуулсан байдал 66.2%-иас 78.1% хүртэл өссөн, дүрэм журам, заавар 70%-иас 75% болтлоо ихэсчээ.

Энэ бүгдийг дүгнэн үзэхэд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн хэрэгжилт бага зэрэг сайжирсан боловч нарийн мэдээллийг албан тушаалтнаас л авч байна. Харин мэдээллийг иргэд хайх, хүлээн авах талаар Монгол улсын Үндсэн хуульд тодорхой заасан бөгөөд энэ нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд тусгалаа олж хэрэгжих боломж нээгдсэн. Гэхдээ бодит байдал дээр мэдээлэл нь тогтмол биш, ихэвчлэн цахим хуудас, сонин, сэтгүүлээр хязгаарлагдаж байна.

ЗӨВЛӨЛДӨХ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Зөвлөлдөөний эрх зүйн орчны шинжилгээг хийхдээ нэг талаас тодорхой шийдвэр, үйл ажиллагааны өмнө иргэдийн санал санаачилгыг хэрхэн хүлээн авч буй асуудал, нөгөө талаас тэрхүү санал санаачилгыг хэрхэн хэрэгжүүлсэн талаарх мэдээллийг иргэдэд хүргэх асуудлуудыг авч үзлээ.

Монгол улсын Үндсэн хууль (1992)-д иргэд төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй байхаар заасан бөгөөд үүнтэй холбогдон бие даасан хууль 1995 онд гарч бүхий л түвшинд иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхээр үйлчилж байна. Энэ хууль нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, мэдэгдэл тэдгээрийг гаргагчийн эрх, төрийн байгууллага албан тушаалтны үүрэг, өргөдөл гомдол гаргах, хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх зэрэг үйл ажиллагааг тусгасан байна. УИХ-ын тухай /шинэчилсэн найруулга/ (2006), Засгийн газрын тухай (1993), Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/ (2006) зэрэг хуулиуд, бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд иргэдийн өргөдөл гомдлыг төрийн захиргааны төв байгууллага, холбогдох албан тушаалтан хүлээн авч шийдвэрлэх асуудлыг үүрэг болгосон заалтууд байна. Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх талаар бие даасан хууль болон хуулийн холбогдох зүйл заалтууд байгаа ч өргөдөл гомдол шийдвэрлэлтийн ил тод байдал, шийдвэрлэх хугацаа, буцах холбоо, хариуцлага зэргийг тодорхой болгох шаардлагатай байна. Тухайлбал: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995)-д өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацааг 30 хоног хэмээн заасан эрх

бүхий албан тушаалтнууд түүнийг 90 хоног болгох сунгах эрхтэйгээр заасан байгаа юм.

Улс орнуудын туршлагаас харахад иргэдтэй зөвлөлддөг хамгийн түгээмэл, тархсан арга бол ард нийтийн санал асуулга байдаг. Монгол улсын Үндсэн хуульд УИХ-ын эрх хэмжээний хүрээнд ард нийтийн санал асуулгыг эрхлэн явуулах эрхийг хуульчилж, улмаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын их хурлын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь хамтарч, мөн Үндсэн хуулийн хорин зургаадугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан хууль санаачлагчид тус тус санал асуулга явуулахыг санаачлах эрхтэй болсон. 1995 онд Ард нийтийн санал асуулгын тухай бие даасан хууль 28 зүйлтэй батлагдан гарч 2006 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн хэдий ч өнөөдрийг хүртэл нэг ч удаа хэрэгжсэнгүй. Ард нийтийн санал асуулгын тухай хуульд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар болон улс орны гадаад дотоод бодлогыг тодорхойлоход иргэдээр сонголт хийх шаардлага гарсан үед санал хураалт явуулахаар заасан ч ямар тохиолдлыг шаардлагатай гэж үзэх нь тодорхойгүй байгаа юм. Мөн иргэд санал асуулгыг эрх бүхий субъектүүдээр дамжуулан санаачлах эрхтэй болсон хэдий ч хэрхэн ямар тохиолдолд хүлээн авах, хэрэгжүүлэхгүй бол ямар хариуцлага хүлээх талаар зохицуулалтгүй байна. Ард нийтийн санал асуулга зайлшгүй явуулах чиглэлүүд, иргэдийн тодорхой хувийн санаачилгаар үндэсний болон орон нутгийн түвшинд санал асуулгыг явуулдаг болох нь нэн чухал болоод байгаа юм.

Бодлого шийдвэрийн төслийг иргэд санаачлах эрхтэй байх, эсвэл тэдний санал бодлыг хүлээн авч тусгадаг байх нь иргэдтэй зөвлөлдөж буй чухал алхам юм. Монгол улсын Үндсэн хуульд иргэд хуулийн төслийн саналаа холбогдох хууль санаачлагчид гаргах эрхтэй байхаар заасан. Хууль, Улсын их хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль 2001 онд батлагдаж иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид бичгээр уламжлах бөгөөд тэрээр уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно хэмээн зааж, хууль санаачлагчийн эрхийн хүрээнд хуулийг боловсруулахдаа иргэдийг шууд оролцуулах, тэдний санал зөвлөмжийг авах, хуулийн үйл явцын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зэрэг асуудлуудыг 3, 6, 9, 18, 19-р зүйлүүдэд оруулжээ. Гэвч энэхүү иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн заалтууд нь *...санаачилж болно, ...уламжлах, ...боловсруулж болно, ...харгалзан үзэж болно, ...үндэслэлтэй гэж үзвэл, ...зохион байгуулж болно, ...оруулж болно, ...хэлэлцүүлж болно* хэмээн зөвшөөрсөн хэм хэмжээ давамгайлж байгаа нь түүний хэрэгжилтэнд томоохон бэрхшээл болохоор харагдаж байна.

УИХ-ын түвшинд иргэд хууль санаачлах төслөө гишүүдэд тавьж болох талаар, харин Засгийн газрын гишүүдэд хуралдаанаар хэлэлцэх асуудалд саналаа оруулах талаар, орон нутгийн түвшинд хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах эрхүүд хуульчлагдсан байгаа нь сайшаалтай ч иргэдийн хууль, шийдвэрийн төсөл санаачлах эрх нь шууд хэрэгжихэд төвөгтэй, ямар тохиолдолд буцаах, ямар тохиолдолд заавал хүлээн авах, хугацаа зэрэг нь тодорхойгүй зэрэг бэрхшээлүүд байна.

Хууль болон дүрэм журам, шийдвэрүүдийн төсөлд иргэд, байгууллагаас санал, шүүмжлэл, нэмэлт өөрчлөлтийн санаа, мэдээлэл хүлээн авах замаар төр, засгийн түвшинд гарах шийдвэрийг сайжруулах, шийдвэр гаргахад олон нийтийг оролцуулах зорилгоор 2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд Иргэний танхим байгууллагдаж өөрийн дагаж мөрдөх журмыг гарган хэрэгжүүлж эхэлсэн. Мөн Улсын Их Хурлын тухай хуулийн 21.4 дэх заалтад үндэслэн нээлттэй сонголыг¹⁴ 4 удаа зохион байгуулж, УИХ-ын Хүний эрхийн дэд хороо нь Хууль зүйн байнгын хорооны 2009 оны 16-р тогтоолоор 7 хэсэг 35 зүйл бүхий “Нээлттэй сонголт зохион байгуулах журам”-ыг баталжээ.

ТББ-ын тухай хууль (1997)-д хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саналыг нь үндэслэн төрийн бус байгууллагыг оролцуулж болохоор зааж холбогдох зарим тогтоолд тусгалаа олсон ч ТББ –ын саналаа илэрхийлэх үйл явц тодорхойгүй байна.

Үнэлгээ

Монгол улсад Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар бүх шатны төрийн байгууллагууд иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэж тайлан гаргадаг. УИХ-д 1992 оноос хойш 40 мянга гаруй өргөдөл, гомдол, санал иржээ. Эдгээрийн 60% нь нийслэлээс, 40% нь хөдөө орон нутгаас ирсэн байна. 1992 онд 1213 өргөдөл, гомдол, санал ирж байсан бол 2011 онд 2832 иржээ. Хамгийн их өргөдөл гомдол санал ирсэн он бол 2005 он бөгөөд нийт 6112 байна¹⁵.

Монгол улсын Засгийн газарт 1992 онд 1041 өргөдөл, гомдол, санал ирснээс 82,9% нь хяналтанд орж, түүний 92% нь шийдвэрлэгдэж байсан бол, 2011 онд 1728 өргөдөл, гомдол, санал ирснээс 97,8% нь хяналтанд орж түүний 86,2% нь шийдвэрлэгдсэн байна. Эдгээр он жилүүдээс 2008 онд хамгийн олон буюу 2383 өргөдөл, гомдол, санал ирснээс 89,8% нь хяналтанд орж 91,5% нь шийдвэрлэгджээ.

2010 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн хэмжээнд иргэдээс амаар 73726, бичгээр 391479, утсаар 15628, цахим хэлбэрээр 190 нийт 481023 өргөдөл, гомдлыг хүлээн авсан. 132305 буюу 27,5%-ийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлж, 342158 буюу 71,1%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг өгсөн ба хугацаа болоогүй 6541, хугацаа хэтэрсэн 19, нийт 3560 өргөдөл хүлээгдэж үлдсэн байна¹⁶.

Ард нийтийн санал асуулгын тухай хууль батлагдсанаас хойш 18 жил өнгөрчээ. Энэ хугацаанд төрийн гадаад, дотоод бодлогыг тодорхойлоход нэг ч удаа иргэдээрээ сонголт хийлгээгүй байна.

¹⁴ Дэлхийн олон улс орнуудад бодлого, шийдвэрийн төсөлд иргэдийн саналыг сонсох, тэднийг шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулах зорилгоор олон нийтийн нээлттэй сонголыг зохион явуулдаг.

¹⁵ <http://www.parliament.mn/>

¹⁶ <http://open-government.mn/>

УИХ, Засгийн газрын цахим хуудсанд хуулийн төслийн ерөнхий мэдээлэл болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудалд иргэд цахим хэлбэрээр саналаа өгөх боломж бүрдсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Иргэний танхимаас иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлгүүдийг явуулж байгаа бөгөөд анх 2009 оны 12 дугаар сарын 15-нд Иргэний танхим анхны хэлэлцүүлгээ “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль”-ийн төслөөр эхэлсэн. Үүнээс хойш олон арван хуулийн төслөөр хэлэлцүүлэг хийж нэг хэлэлцүүлэгт дунджаар 150 орчим иргэн бүртгүүлж тэднээс 90 орчим нь хэлэлцүүлэгт оролцож тэдний дунджаар 30 орчим иргэн санал бодлоо илэрхийлдэг байна.

Энэ бүгдийг дүгнэн үзвэл, *Иргэдийн санал санаачилгыг хүлээн авах, шийдвэрлэх талаар*: Иргэдээс гарсан санал санаачилгыг хүлээн авч шийдвэрлэх талаар холбогдох хуулиудад нэлээд заалтууд байна. Тухайлбал хуулийн төслийн санал, хурлаар хэлэлцэх асуудал, өргөдөл, гомдол, санал хүлээн авах зэрэг болно. Харин хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалтын механизм нь тодорхой бус байгаа юм. *Иргэдийн санал санаачилгыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдэх*: Иргэд өөрсдийнх нь санаачилгыг дэмжсэн эсэх, дэмжээгүй бол учир шалтгааныг нь сонсох эрхтэй байх нь ардчиллын нэгэн чухал үзүүлэлт байдаг ч Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжуудад энэ талаар ямар нэгэн зохицуулалт бараг байхгүй байгаа юм. Байгаа зарим нэг зохицуулалт нь үндэслэлтэй гэж үзвэл, шаардлагатай бол гэх зэрэг тодорхой бус байдлаар хуульчлагджээ.

ИДЭВХТЭЙ ОРОЛЦООНЫ ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Иргэдийн идэвхтэй оролцооны эрх зүйн орчны шинжилгээг хийхдээ нэг талаас иргэдийн шууд оролцоог хэрхэн зохицуулсан, нөгөө талаас төлөөллийн байгууллага болон төлөөлөгчдөөр дамжуулан иргэдийн оролцох боломжийг хэрхэн тусгасан талаар авч үзлээ.

Монгол улсын Үндсэн хууль (1992)-д засгийн бүх эрх ард түмний мэдэлд байж, ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэхээр заасан. Энэ нь Монголын иргэд шууд оролцох эрхээ баг хорооны иргэдийн нийтийн хурал, Ерөнхийлөгчийн, УИХ-ын, Орон нутгийн сонгууль, ард нийтийн санал асуулгад оролцож эдлэхийг, мөн сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулан төрийг удирдахад оролцохыг заасан юм. Дээрх эрхийг хэрэгжүүлэхээр бие даасан хууль болон холбогдох хуулиудад зарим нэг зүйл заалтууд орсон байна.

Бүх шатны сонгуулийн тухай хууль болон ард нийтийн санал асуулгын тухай хуульд иргэдийн оролцох эрхийг сайн баталгаажуулсан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хаяг болон бичиг баримтын зөрчилтэй иргэдийн сонгуульд оролцох эрхийн хязгаарлагдмал байдал, гадаадад ажиллаж амьдарч буй иргэдийг сонгуульд оролцуулах талаарх эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Баг хорооны иргэдийн нийтийн хурлын эрх хэмжээг хэтэрхий хязгаарласан нь иргэдийн оролцох идэвх сонирхлыг бууруулахад хүргэж, иргэд өөрсдийн сонгосон төлөөлөгчидтэй

хариуцлага тооцох механизм орон нутгаас бусад түвшинд хуульчлагдаагүй зэрэг дутагдал байсаар байна.

Ард нийтийн санал асуулгын тухай хууль 1995 онд батлагдсан нь иргэдийн шууд оролцоог хангахад ихээхэн түлхэц болсон хэдий ч хэрэгжиж байсангүй. Нөгөөтээгүүр ард нийтийн санал асуулгын тухай хуулийн ерөнхий агуулгыг харахад сонгуулийн хуультай зарчмын хувьд нэлээд төстэй, зайлшгүй санал асуулга явуулах асуудлыг хуульчлаагүй, санал асуулгыг санаачлах, шийдвэрлэх үйл ажиллагаа нь хязгаарлагдмал зэрэг асуудлууд байсаар байна.

Төсвийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль (2011)-д төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулж тэдний оролцоог хангахар заасан нь Монгол улсад иргэдийн шууд оролцоог хангахад чухал алхам болсон заалт болоод байна.

Үнэлгээ

Монгол улсын иргэний Үндсэн хуулиар олгогдсон сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт нэлээд амжилтыг олсон хэдий ч хүндрэл бэрхшээлүүд гарсаар байгаа юм. Тухайлбал: Иргэдээс өөрсдөөс хамаарахгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр энэхүү эрхээ эдлэхэд хүндрэл учирч байгаа юм. Үүнд: иргэний бүртгэлийн системийн алдаатай байдал, улс төрийн намуудын дотоод ардчилал муу, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хязгаарлагдмал, иргэдийн төрд итгэх итгэл суларсан, улс төрийг сонирхох байдал буурсаар байна. Мөн улс төр, нийгэм, эдийн засаг, байгаль газар зүйн зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөгөөр сонгогчдын оролцоо жил ирэх тусам буурсаар байна.

УИХ-ын сонгуульд оролцогчид: 1990 онд АИХ-ыг сонгох ардчилсан сонгууль явагдаж нийт сонгогчдын 98% нь оролцож байсан бол 2012 онд нийт сонгогчдын 65,24% оролцож, энэ нь 1990 онтой харьцуулахад 33,75%-иар буурсан буюу жилд дунджаар 1,53% буурсан үзүүлэлт гарч байна. *Ерөнхийлөгчийн сонгуульд оролцогчид:* 1993 онд нийт сонгогчдын 92,71% оролцож байсан бол 2009 онд 73,59% болж нийтдээ 19,12%-иар буурсан нь жилд дунджаар 1,195% -ийн бууралттай байгааг харуулж байна. *Орон нутгийн сонгуульд оролцогчид:* 1996 онд нийт сонгогчдын 72,1% оролцож байсан бол 2008 онд 49% болж олон газруудад ирц хүрээгүйн улмаас дахин сонгууль явагдаж байсан бол 2012 онд энэ байдал дахин давтагдсан бөгөөд нийслэлийн 149 хэсгийн хороонд ирц хүрээгүйн улмаас дахин сонгууль явагдсан билээ.

2008 оноос төр, иргэний нийгмийн харилцаа, хамтын ажиллагаа өргөжин 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн ТББ-уудын анхны зөвлөлдөх уулзалтаар Засгийн газартай хамтран ажиллах иргэний нийгмийн зөвлөл байгуулагдсан. 2011 оны 2 сарын 11-ний өдөр Монгол улсын Засгийн газар Иргэний нийгмийн Зөвлөлтэй хамтран ажиллах гэрээний дагуу “Иргэний нийгмийн тогтвортой хөгжлийг хангах төрийн бодлого”-ын үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Өнөөдөр Монгол улсад ТББ-д холбогдох 130 гаруй хууль тогтоомж, шийдвэрүүд байна. Үүнээс

20 хууль, 10 гаруй УИХ, Засгийн газрын тогтоолд ТББ-ын оролцооны тухай асуудлыг авч үзсэн байна.

Идэвхитэй оролцоог дүгнэхэд, *Иргэд төрийн үйл ажиллагаанд шууд оролцох боломж*: Иргэдийн төрийн үйл ажиллагаанд шууд оролцох эрх нь өнөөдрийн байдлаар ИТХ-ийн, УИХ-ын, Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох, баг хорооны ИНХ-д оролцох, ард нийтийн санал асуулгад оролцох, мөн дээрх байгууллагуудад сонгогдох эрхээр хуульчилагдсан байна. Гэтэл бодит байдал дээр ард нийтийн санал асуулгын хууль батлагдсанаас хойш нэг ч хэрэгжээгүй, иргэдийн сонгох болон сонгогдох эрх зөрчигдөх байдал гарсаар л байна. *Иргэд төлөөллийн байгууллага болон төлөөлөгчдөөр дамжуулан оролцох боломж*: Эдгээр хуулиудад иргэдийн төлөөллийн байгууллага болон төлөөлөгчдийн эрх хэмжээг хуульчилсан заалтууд голдуу байгаагаас тэдгээрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж ажиллах талаарх зохицуулалт маш бага байна. Гэхдээ ИНБ-уудын түншлэл ЗГ-тай хамтран ажиллаж байгаа нь сайшаалтай юм.

ИРГЭДИЙН ХЯНАЛТ ТАВИХ БОЛОМЖ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Иргэдийн хяналт үнэлгээний эрх зүйн орчин нь иргэд шууд болон шууд бус хяналтын тухай асуудал байдаг бөгөөд Монгол улсын Үндсэн хуулинд иргэдийн хяналт, үнэлгээ хийх эрхийн талаар тусгайлсан заалт байхгүй байна. Харин хяналт, үнэлгээ хийх эрхийг ихэнх тохиолдолд төрийн байгууллага, албан тушаалтанд олгож Төрийн Аудитын тухай (2003), Төрийн хяналт шалгалтын тухай (2003) хуулиуд батлагдсан байна. Эдгээр хуулиудад иргэдийн хяналт, үнэлгээ хийх эрхтэй холбоотой гурван төрлийн заалтууд байна. Нэгд: Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн аудитын байгууллага гүйцэтгэлийн аудитын болон бусад тайланг хэвлэн нийтлэх буюу бусад арга замаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтэд түгээх, аудитын байгууллага өөрийн хийсэн аудитын тайлангийн жагсаалтыг улирал тутам гаргаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим сүлжээгээр мэдээлэх, иргэдэд нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг хэвлэмэл эхээр нь буюу хувилж өгнө хэмээн заажээ. *Хоёрт*: Иргэдийн төлөөллийн байгууллага /ИТХ/ хяналт шалгалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын тайланг хэлэлцэхээр заасан ч яаж тайлагнах, ИТХ-ын санал дүгнэлтийн талаар тодорхой тусгаагүй байна. *Гуравт*: Хяналт шалгалтын байгууллага хяналт шалгалт хийхдээ ТББ, иргэдийн дэмжлэгийг авч болох ба өөрийн эрхлэх хүрээний асуудлаар иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу хяналт шалгалт явуулж болно хэмээн заажээ. Гэвч энэ нь иргэд, ТББ-ын дэмжлэгийг хэрхэн авах талаар тусгаагүй, мөн хяналт шалгалт явуулах эсэх нь тухайн Хяналт шалгалтын байгууллагын асуудал болж байна.

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006)-д баг хорооны засаг дарга иргэдэд жил бүр тайлангаа тавихаар заасан нь иргэд баг хорооны засаг даргын ажлын тайланг хянан хэлэлцэх боломж бүрдсэн ч тайланг хэлэлцүүлсний дараах алхмуудыг тодорхой тусгаж өгөөгүй байгаа юм.

Үнэлгээ

Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд иргэд хяналт тавих талаарх эрх зүйн орчинд төдийлөн ахиц дэвшил гарахгүй өнөөдрийг хүрсэн байна. Мөн төрийн хяналтын чиг үүргийг гүйцэтгэдэг байгууллагуудын үйл ажиллагаа дахь иргэдийн оролцооны эрх зүйн орчин хангалтгүй байна.

Энэ бүхнийг дүгнэвэл, *Иргэдийн шууд хяналт тавих боломж*: Дээрх хуулиудад иргэдийн шууд хяналт тогтоох болон хариуцлага тооцох механизмын талаар зохицуулсан заалт байхгүй байна. *Иргэд шууд бус хөндлөнгийн байгууллагаар дамжуулан хянах боломж*: Суурь болон тулгуур хууль, салбар хуулиудад иргэдийн хяналтын талаарх зохицуулалт байхгүй хэдий ч хяналт шалгалтын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын үйл ажиллагаа дахь иргэдийн шууд бус хяналтын талаар зарим нэг заалтууд байна. Гэвч эдгээрийн утга нь тодорхойгүй, зохицуулах механизм нь тодорхой бус байна.

Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн 1-р бүлгийн 3-р зүйл, 2-р бүлгийн 16.9,10,12,16,17-д иргэдийн оролцооны үндсийг бүрдүүлж холбогдох зарим хуулиудаар зохицуулж байна. Гэтэл эндээс дараах бэрхшээлүүд гарч ирж байгаа юм. Үүнд:

А. Одоогийн мөрдөгдөж байгаа зарим хуулиудын зүйл заалтууд нь оролцуулж болно, шаардлагатай гэж үзвэл, үндэслэлтэй гэж үзвэл гэх зэргээр хэрэгжихэд төвөгтэй олон янз байгаа,

Б. Иргэдийн оролцооны үндсийг гаргаж ирсэн ч хэрэгжүүлэх арга механизмуудын талаар тусгаж өгөөгүй, эсвэл холбогдох дүрэм журмууд гараагүй байдаг,

В. Хууль тогтоомжуудын хэрэгжилт муу байна. Тухайлбал: 2011 онд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” батлагдсан нь иргэдийн оролцоог хангахад, тэр дундаа иргэдийн мэдэх эрхийг хангахад чухал нөлөөтэй хууль болсон. Гэвч энэхүү хуулийн хэрэгжилтийн байдал муу байна. “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын судалгаагаар: Төсвийн мэдээллийг “өөрийн цахим хуудсанд” байрлуулах тухай дээрх хуулийн 9.1.1.а заалтыг 2012 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 12 цагийн байдлаар 82 төсвийн байгууллага, орон нутгийн нэгж хэрэгжүүлсэн эсэхийг лавлахад Хэнтий, Дархан-Уул аймгууд 2012 оны төсвийг баталсан тухай ИТХ-ын тогтоолоо цахим байршуулжээ.

Зөвлөмж

Иргэдийн оролцооны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлийг дараах байдлаар гаргаж байна. Үүнд:

Мэдээллийн эрх зүйн орчинг сайжруулахын тулд дараах зүйлүүдийг анхаарах хэрэгтэй байна.

- Хууль тогтоомжид мэдээллийг дээд зэргээр нээлттэй болгох заалт оруулах;
- Төрийн болон байгууллагын нууцын зэрэглэлийг сайтар тогтоох, нарийвчлан гаргах;

- Мэдээллийг хаалттай байлгахад нөлөөлж буй хууль болон хуулийн заалтуудыг өөрчлөх;
- Мэдээлэл олж авах үйл явцад дэмжлэг үзүүлэх: мэдээлэл авах хүсэлт шаардлагыг аль болох шуурхай, шударга биелүүлэх, мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд энэ шийдвэрийн эсрэг хараат бус байгууллагад хандан давж заалдах эрхээр хангах;
- Мэдээллийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйлдлийн талаарх эргэж мэдэгддэг тогтолцоог хуульчилж өгөх шаардлагатай байна.

Зөвлөлдөөний эрх зүйн орчинг сайжруулахад дараах зүйлүүдийг анхаарах хэрэгтэй байна.

- Аливаа бодлого шийдвэр гаргахын өмнө олон нийттэй зөвшилцдөг жишиг тогтоох;
- Зөвлөлдөөнд сонирхогч талуудын оролцох боломжийг нээлттэй болгох;
- Иргэдийн санал, хүсэлт гомдлыг шийдвэрлэх хугацаа болон хэрхэн яаж шийдвэрлэсэн үйл явц, хариу үйлдлийг тодорхой ил тод байлгах зэрэг ордог.

Иргэдийн шууд оролцоог дэмжих эрх зүйн орчинг сайжруулахын тулд: Монгол Улсын Засгийн газраас санаачилж буй хууль, тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон бусад актын төслийг боловсруулахад иргэдийг оролцуулах дүрэм журмыг баталж, мөрдүүлэх, орон нутгийн ИТХ-ын бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийг оролцуулах, удирдлагын ил тод байдлыг дээшлүүлэх, орон нутгийн зарим чухал асуудлыг хэлэлцэхэд (төсөв г м) олон нийтийг оролцуулдаг жишгийг тогтоож, хуралдааны дэгд шинээр оруулах нь зүйтэй байна. Хууль болон УИХ-ын бусад шийдвэрийг боловсруулахад хэрэгжүүлж эхлээд байгаа Нээлттэй сонсголын механизмыг (Хүний эрхийн дэд хорооны “Нээлттэй сонсгол”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Иргэний танхим”) цаашид өргөжүүлэн бусад Байнгын хороод мөн Засгийн газар, орон нутгийн ИТХ-уудын үйл ажиллагаанд нэвтрүүлж, дээрх нээлттэй сонсголын тухай УИХ-ын Чуулганы дэгийн тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль зэрэгт нэмж оруулах нь зүйтэй юм. Иргэд өөрсдийг нь төлөөлөн төрийг удирдах эрхийг хэрэгжүүлж буй субъектүүдийг нийтийн эрх ашиг, сонирхлыг илэрхийлэн хамгаалж чадахгүй байна хэмээн тодорхой хувийн санал гарсан тохиолдолд эргүүлэн татдаг эрхийг олгох хэрэгтэй байна. Орон нутгийн болон үндэсний түвшинд иргэдийн санал асуулгуудыг явуулдаг болж, зайлшгүй санал асуулга явуулах шаардлагатай асуудлуудыг хуульчлах хэрэгтэй байна.

Эдгээр санал зөвлөмжийг дараах хэдэн түвшинд хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүнд:

1. Ерөнхийлөгчийн түвшинд:

- Иргэний танхимын статус, үйл ажиллагааг хуульчлах
- Нийтийн эрх ашиг сонирхолын асуудлаар иргэдийн гаргасан санал санаачилгыг дэмжих, хэрэгжүүлэх, уламжлах үүргийг хуульчлах

2. Улсын Их Хурлын түвшинд:

- Нээлттэй сонсгол, нээлттэй хэлэлцүүлгийг бодлого шийдвэр батлан гаргахын өмнө зохион байгуулахаар хуульчлах. Ингэхдээ байгалийн баялаг, үндэсний

аюулгүй байдал, хүний эрхийн талаар шийдвэр гаргахын өмнө заавал нээлттэй сонголт хэлэлцүүлэг хийдэг байх.

- Хууль, бодлого шийдвэрийн төсөл санаачлах эрхийг иргэдэд олгох. Иргэд хуулийн төсөл санаачлан хэлэлцүүлэхэд нийт сонгогчдын 1% -аас доошгүй төлөөллийн гарын үсэг цуглуулан УИХ-ын гишүүдийн санаачилсан төслийн адилаар хэлэлцүүлдэг болох.
- Иргэдийн санаачилга буюу хориг тавих эрхийг баталгаажуулах. УИХ-аас батлан гаргасан хууль, бодлого шийдвэрийг сонгогчдын тодорхой хувийн гарын үсэг зурснаар буцааж дахин хэлэлцдэг болох.
- УИХ-аар иргэдийн санал бодлыг заавал асууж байж шийдвэр гаргадаг шийдвэрийн жагсаалтыг гаргах.
- Иргэдийн эрх ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй, тэдний төлөөлөл болж чадахгүй байна гэж иргэдийн тодорхой хувь үзсэн тохиолдолд УИХ-ын гишүүнийг эргүүлэн татах санал гаргах эрхийг иргэдэд олгох.

3. Засгийн газрын түвшинд:

- Нээлттэй сонголт, нээлттэй хэлэлцүүлгийг бодлого шийдвэр батлан гаргахын өмнө зохион байгуулахаар хуульчлах. Ингэхдээ байгалийн баялаг, үндэсний аюулгүй байдал, хүний эрх зэрэг тодорхой чиглэлээр шийдвэр гаргахын өмнө заавал нээлттэй сонголт хэлэлцүүлэг хийдэг байх.
- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудалд иргэд санал өгөх, шинээр хэлэлцэх асуудал оруулах эрхийг баталгаажуулах хэрэгтэй бөгөөд энэ нь Засгийн газрын гишүүдийн санаачилсан төслийн адилаар хэлэлцүүлдэг болох.
- Иргэдийн чуулган зохион байгуулах. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, байгаль орчин уул уурхайн асуудлаар иргэдийн чуулганыг зохион байгуулдаг болох.
- Иргэдэд үйлчилгээ үзүүлж буй төрийн байгууллагууд үйлчилгээний стандартыг батлан мөрдүүлэх.
- Иргэдээр үнэлүүлдэг тогтолцоог хуульчлах.
- ИНБ-уудаар төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг сайжруулах.

4. Орон нутгийн түвшинд:

- Хурал болон Засаг даргын дангаар шийдвэрлэх эрхгүй асуудлуудыг хуульчлах. Үүнд тухайн орон нутагт мөрдөгдөх дүрэм журам, байгалийн баялаг ашиглах, эзэмших зөвшөөрөл олгох, орон нутгийн санал асуулга, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө зэргийг оруулах.
- Иргэдийн эрх ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй, тэдний төлөөлөл болж чадахгүй байна гэж иргэдийн тодорхой хувь үзсэн тохиолдолд хурлын төлөөлөгч, засаг даргыг эргүүлэн татах санал гаргах эрхийг иргэдэд олгох.
- Хурлын зар түгээх тогтолцоог хуульчлах.
- Хурлын хуралдааны нээлттэй ил тод байдал, иргэд хуралдаанд ажиглагчаар орж суух эрхийг хуульчлах.
- Иргэний танхим, нээлттэй сонголт, нээлттэй хэлэлцүүлгийг хуульчлах.

- Хөршийн холбоо, иргэдийн өөртөө туслах бүлгүүд, өөрийн удирдлагыг дэмжсэн эрх зүйн зохицуулалтууд бий болгох,
5. *Ард нийтийн санал асуулгын тухай хуульд:*
- Санал асуулгыг үндэсний болон орон нутгийн түвшинд явуулахаар тодорхой хуульчлах.
 - Санал асуулгыг дараах тохиолдолд зайлшгүй явуулахаар хуульчлах.
 - Санал асуулгыг төрийн дотоод, гадаад бодлогыг тодорхойлохтой холбогдсон тодорхой асуудлаар ард нийтийн сонголт хийлгэх шаардлага гарсан тохиолдолд;
 - Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар;
 - Стратегийн орд газрын байгалийн баялагыг ашиглах, эзэмших, экологийн тэнцвэрт байдал алдагдуулахаар болон алдагдуулж буй аливаа асуудлыг шийдвэрлэхэд;
 - Нийтийн эрх ашиг, сонирхлын асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн хоорондын байр суурийн зөрөө гарсан үед;
 - Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд сөргөөр нөлөөлж болохуйц олон улсын гэрээ, конвенцид нэгдэн ороход;
 - Гадаадын аль нэгэн улс орноос үндэсний нийт бүтээгдэхүүнээс илүү гарсан зээл тусламжийг авах үед;
 - Санал асуулгыг санаачлах эрх бүхий субъектүүдээс гадна иргэд, *иргэний нийгмийн байгууллага, эвсэл холбоод сонгуулийн насны иргэдийн 20 000 гарын үсэг цуглуулж* санал асуулга явуулах тухай саналаа уламжилдаг болох.
 - Иргэд санал асуулгад саналын хуудас ашиглан мөн цахим хэлбэрээр оролцдог болох.
6. *Иргэд болон иргэний нийгмийн хяналтыг хүч нөлөөтэй, зохистой болгох чиглэлээр эрх зүйн цоо шинэ өөрчлөлт хийх хэрэгтэй байна.* (холбогдох хууль тогтоомжуудад шинээр зүйл заалт нэмэх, өөрчлөх)
7. *Иргэдийн оролцоог дэмжсэн хууль журмуудыг батлан гаргах шаардлагатай байна.* Нээлттэй хурлын тухай, Нээлттэй сонголын тухай, Нээлттэй хэлэлцүүлгийн тухай, Орон нутгийн санал асуулгын тухай, Төр, ИНБ-уудын хамтын ажиллагааны тухай,
8. *Иргэдийн оролцооны бүтцийг бий болгох* – Мэдээлэл, зөвлөлдөөн, идэвхтэй оролцоо, иргэдийн хяналтын асуудал эрхэлсэн албан тушаалтан, салбар, хэлтэс зэргийг бий болгон оролцоог хангах чиг үүрэгтэй болгох.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОЛОН УЛСЫН ИХ ХУРАЛ,
СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН
БАЙДАЛ**

М.Энхбат, П.Мөнхцэцэг

Монгол улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлд: “Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан бөгөөд хууль боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог зохицуулсан гол эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийж цаашид анхаарах асуудлыг үнэлэхийг зорилоо. Энэ хэсгийн судалгаагаар зөвхөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай эрх зүйн баримт бичгийг судлах замаар мэдээллийн хүртээмж ба ил тод байдал, зөвлөлдөх орчин нөхцөл, идэвхтэй оролцоо болон иргэдийн хяналт тавих боломж хангагдсан эсэхийг тодорхойллоо. (Хавсралт 3)

МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ БА ИЛ ТОД БАЙДАЛ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Мэдээллийн хүртээмж ба ил тод байдлыг хангасан заалт Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон УИХ-ын тухай хуульд нэг, Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх журмын тухай хуульд хоёр л заалт байгаа бөгөөд харин процессын хуулиуд болох сонгуулийн тухай хуулиудад мэдээллийг дэмжсэн заалтууд харьцангуй сайн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулинд “Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зөвшөөрснөөр төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэхээс гадна хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ” гэж ямар мэдээллийг, хэнд, ямар механизмаар хүргэхийг тодорхой заасан байна.

УИХ-ын тухай хуулинд “УИХ-ын үйл ажиллагаа нь хараат бус, нээлттэй, ил тод, хариуцлагатай, иргэдэд хүртээмжтэй байх бөгөөд асуудлыг тал бүрээс нь хэлэлцэж цөөнхийн саналыг хүндэтгэн үзэж олонхын саналаар шийдвэрлэх зарчимд тулгуурлана” гэж нээлттэй, ил тод байдлыг хангаж, иргэдэд мэдээллийг хүртээмжтэй хүргэхээр тусгасан байна.

Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулинд “хуулийн төсөл, түүний үзэл баримтлал болон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх, цахим хуудсанд байршуулах зэрэг бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлнэ” гэж заасан бөгөөд мөн хуулийн төсөлд санал авахдаа төслийг бүрэн эхээр нь байгууллагынхаа цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулна гэж мэдээлэх хэлбэр, хугацааг тодорхой болгож хуульчилсан байна

Сонгуулийн тухай хуулиудад сонгууль бэлтгэн явуулах ажил ил тод байх ба хэвлэл мэдээллийн байгууллага сонгууль бэлтгэн явуулах ажлын явц, сонгуулийн дүнг олон нийтэд шуурхай мэдээлэх үүрэгтэйг заасан байна. УИХ-ын сонгуулийн тухай хууль (2011 оны 12 дугаар сарын 15 өдөр), Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2012 оны 12 дугаар сарын 21-ны өдөр) шинэчлэн батлагдаж мэдээллийн хүртээмж ба ил тод байдлыг хангасан заалтуудыг харьцангуй сайжруулж оруулсан байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулинд Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө Аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэй аймагт долоо, нийслэлд таван гишүүнтэй байгуулж, улсын хэмжээнд нийтэд мэдээлэх бөгөөд аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүрэгтээ санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлэхээр, сонгуулийн хэсгийн хороог санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлэхээр хуульчилсан байна. УИХ-ын сонгуулийн тухай хуулинд энэ хугацаа нь 5 хоногоор илүү байгаа бөгөөд ажиллах бүрэлдэхүүн нь 2-5 гишүүнээр илүү байгааг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 1 Сонгуулийн хуулиудын харьцуулалт

№	Сонгуулийн хороод байгуулах, ажиллах бүрэлдэхүүн томилох	Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль	УИХ-ын сонгуулийн хууль
1	Сонгуулийн ерөнхий хороо	Байгуулах өдөр	50
		Ажиллах бүрэлдэхүүн	5-7
2	Тойргийн хороо	Байгуулах өдөр	45
		Ажиллах бүрэлдэхүүн	5
3	Хэсгийн хороо	Байгуулах өдөр	40
		Ажиллах бүрэлдэхүүн	Дарга, нарийн бичгийн дарга, гишүүд

Энэ нь мэдээллийн ил тод байдлыг хангаж, мэдээлэх хугацааг тодорхой болгож, мэдээллийг иргэн бүрт хүртээмжтэй хүргэх зорилгыг хангасан заалт болж байна.

Мөн Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулинд байгуулагдсан сонгуулийн хэсгийн хороод нь ажиллах цагийн хуваарь, сонгуулийн санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлж, сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн ажиллах байранд, өөрийн ажиллах байргүй бол сум, хорооны Засаг даргын Тамгын газрын байранд, санал авах байр бэлэн болсны дараа санал авах байранд ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгохоор тусгасан нь мэдээлэл цаг хугацаандаа иргэдэд хүрэх нөхцлийг бүрдүүлж өгсөн заалт болсон.

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу тухайн нутаг дэвсгэрийн Иргэний бүртгэлийн мэдээллийн улсын санг үндэслэн улсын бүртгэлийн байгууллагын сонгогчдын бүртгэлийн мэдээллийн сангаас сонгуулийн эрх бүхий иргэний эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, регистрийн дугаар, оршин суугаа газрын бүртгэлийн мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, хэсэг нэг бүрээр нь нэгтгэн гаргаж уг жагсаалтыг сонгуулийн жилийн гуравдугаар сарын 1-ны өдрөөс өмнө сонгууль дуустал өөрийн цахим хуудаст байрлуулахаар заасан байгаа бол УИХ-ын сонгуулийн тухай хуулинд хэсгийн хороод сонгогчдын нэрсийн жагсаалтыг 20-с доошгүй хоногийн өмнө өөрийн байранд ил тавьж сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгож, сонгогчдын нэрсийн жагсаалтыг сонгуулийн жилийн гуравдугаар сарын 15-ны өдрөөс өмнө сонгууль дуустал өөрийн цахим хуудаст байрлуулахаар заасан байгаа нь иргэдэд хүргэх мэдээллийг тодорхой болгосон ч эдгээр заалтын хугацааны хувьд хоорондоо 15 хоногийн зөрүүтэй байна.

Үнэлгээ

Мэдээлэл нь цаг хугацаандаа, тогтмол, хүртээмжтэй, хэрэгцээтэй, энгийн ойлгомжтой байж мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангадаг бол эдгээрийг бүрэн дүүрэн хангасан заалт дээрх хуулиудад байхгүй бөгөөд холбогдож гарсан хуулиуд нь ч хоорондоо зөрчилдсөн тохиолдлууд байна. Тухайлбал: УИХ-ын тухай хуулинд “УИХ-ын үйл ажиллагаа хараат бус, нээлтэй, ил тод байх” заалтыг тухайн хуулийн 29 дүгээр зүйл. Чуулганы хуралдааны нийтлэг журмын 29.1. Хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. 29.2. Хэлэлцэх асуудлын шинж байдал, гишүүдийн саналыг харгалзан энэ хуулийн 29.1-д зааснаас бусад асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно гэсэн заалтаар, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Хуралдааны нийтлэг журмаар мөн хязгаарлагдаж хаалттай хуралдаан явуулж болох заалтыг оруулсан байгаа нь хоорондоо зөрчилдсөн заалтууд болж байна.

Мөн Ерөнхийлөгчийн тухай хуулинд Ерөнхийлөгчийн зарлиг захирамжийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зөвшөөрснөөр төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэхээс гадна хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ гэсэн заалт байгаа бөгөөд монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч төрийн тэргүүн нь бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргаж, гаргасан зарлигт Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох нөхцлийг Үндсэн хуульд тусгасаар байхад Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга зөвшөөрөхгүй бол ард түмэнд мэдээлэхгүй байхаар хуульчилсан нь хоорондоо зөрчилдсөн заалтууд болж байна. Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрэмд Тамгын газрын дарга нь Ерөнхийлөгчийн зарлиг, захирамж, хэлэх үг боловсруулах ажлыг нэгтгэн зохион байгуулж, хяналт тавьж, эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, шийдвэрт нийцүүлэн захирамж гаргаж, биелэлтийг хангуулж ажиллах үүрэгтэйг л заасан болохоос нийтэд мэдээлэх эсэхийг зөвшөөрөх тухай заалт

байхгүй учир хувь хүний нөлөөллөөс болж ерөнхийлөгчийн зарлиг захирамжийг нийтэд мэдээлэхгүй байх нөхцөл бүрдэж байна.

Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг нийтэд мэдээлэх үйл ажиллагаа нь ерөнхийдөө Ерөнхийлөгчийн Тамгын газрын вэб сайтаар¹⁷ мэдээлэгдэж байгаа бөгөөд энэ вэб сайтад Ерөнхийлөгчийн хэлсэн үг, ярилцлага, мэндчилгээ, санаачилж байгаа хуулийн төсөл зэрэг нь байнга шинэчлэгдэж байхад зарлиг захирамжуудыг шинэчлэн оруулаагүй байна. 2013 оны 2 дугаар сарын 28-ны байдлаар энэ вэб сайтын мэдээлэлтэй танилцахад 2012 онд Чингис хаан Тэмүжиний мэндэлсэн огноог албан ёсны болгож ёсчлох тухай, Үндсэн хуулийн хичээл заах тухай, Монгол судлалыг дэмжих сан байгуулах тухай, Засгийн газарт чиглэл өгөх тухай, Номын баярын өдөр тэмдэглэх тухай 5 зарлиг оруулж 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөс хойш шинээр зарлиг оруулаагүй байна. Захирамжийн хувьд “Шилдэг залуу эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдад Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгох журмыг батлах тухай” 2011 онд баталсан 146 дугаартай захирамжийг 2012 оны 8 дугаар сарын 31-нд оруулсан байна.

УИХ-ын гишүүдийн намтар, чуулганы болон байнгын хороодын мэдээлэл, үйл ажиллагааны чиглэл, хэлэлцүүлгийн шатанд байгаа хуулийн төсөл, УИХ-ын шийдвэрийн төслүүд болон бусад мэдээлэл Монгол УИХ-ын вэб сайтад¹⁸ тавигдаж мэдээллүүд нь харьцангуй шинэчлэгдэж байна.

Мэдээлэл хир хүртээмжтэй байх тал дээр вэб сайтад байршуулна, төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтэлнэ, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр мэдээлнэ гэсэн заалтууд нь хэн, хэзээ, мэдээлэх нь тодорхойгүй байгаагаас мэдээлэл цаг хугацаандаа иргэдэд хүрэлгүй хуучирсан байх, иргэд төрийн төв хэвлэлийг тухай бүр үзэх боломжгүй байх, вэб сайтыг ашиглаж чадахгүй байх, хэдийгээр бүх аймгийн төвүүд интернэтэд холбогдсон байгаа ч зарим сум суурин интернэтэд холбогдоогүй байгаа зэргээс шалтгаалж төрийн мэдээллийг түгээж буй хэлбэр нь олон нийтээс хүсч хүлээсэн тэр хэмжээнд хүрэхгүй байна.

Харин Сонгуулийн тухай хуулинд нийтэд мэдээлэх үйл ажиллагааг хэн, хэзээ, хэрхэн мэдээлэх тухай тодорхой нарийн заалттай тусгасан байгаа ч зарим зүйл заалтын хэрэгжилт сул байгаа нь өнгөрсөн УИХ сонгуульд мониторинг хийсэн ТББ-уудын судалгаанаас харагдаж байна. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.11 дэх заалт “Хэсгийн хороо энэ хуулийн 20.9-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ хуулийн 20.10-г заасан сонгуулийн насны иргэдийн мэдээлэлтэй тулган хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө өөрийн байранд ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно” гэсэн заалтын дагуу хэсгийн хороо 2012 оны 6-р сарын 8-ны өдөр гэхэд сонгогчдын нэрсийн жагсаалтыг ил тавьсан байх хуулийн заалтыг мониторинг хийж байгаа 20 хэсгийн хорооноос 8 нь л биелүүлж ажилласан¹⁹ хангалтгүй үзүүлэлттэй байна.

¹⁷ <http://www.president.mn/>

¹⁸ <http://www.parliament.mn/>

¹⁹ Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторинг. 2012. Филантропи Хөгжлийн төлөө Төв.

ЗӨВЛӨЛДӨХ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

УИХ болон Ерөнхийлөгч, Засгийн газрын түвшинд иргэд, ИНБ-уудын саналыг авах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, эргэх холбоо тогтоох, иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх зэргээр зөвлөлдөх орчинг хангаж буй байдалд дүн шинжилгээ хийлээ.

УИХ-ын тухай хуульд “Иргэд, байгууллагаас ирүүлсэн хуулийн төсөл, УИХ-ын бусад шийдвэрийн талаарх саналыг судлан үзэж, шаардлагатай гэж үзвэл хуулийн төсөл санаачлах, шаардлагагүй бол энэ тухай хариуг бичгээр өгнө” гэж иргэдийн хууль санаачлах эрхийг дэмжсэн заалтыг оруулсан байна.

Мөн Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд “Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн саналаа хууль санаачлагчид бичгээр уламжлах бөгөөд тэрээр уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно” гэж заасан бөгөөд шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч нь нийгмийн нэн чухал харилцааг зохицуулахаар санаачилсан хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай саналаа УИХ-д оруулж ард нийтээр хэлэлцүүлэхдээ нийт ард түмнээр, нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүрээнд, тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд хэлэлцүүлж болох ба хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай УИХ-ын шийдвэрийг үндэслэн Засгийн газар энэ ажлыг зохион байгуулж, дүнг нэгтгэн УИХ-ын чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэхэд танилцуулж аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчид Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу “хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулна” гэж хэлэлцүүлэг явуулах нөхцлийг хангаж өгсөн байна.

Мөн УИХ-ын дэгийн тухай хуульд “Төр, нийгмийн анхаарал, ашиг сонирхлыг хөндсөн төслийг нэгдсэн хуралдаан хэлэлцэх нь зүйтэй гэж шийдвэрлэсний дараа анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө уг төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлүүлж олон нийтээс санал авах ажлыг байнгын хороо зохион байгуулж болно” гэж заасан нь олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулалтай явуулах нөхцлийг бүрдүүлсэн бөгөөд “Байнгын дэд хороо тодорхой асуудлын талаар эрдэмтэд, шинжээчид, сонирхлын бүлэг, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын санал сонсох мэдээлэл авах зорилгоор нээлттэй сонсгол зохион байгуулж болно” гэж тухайн санаачилж байгаа хуулийн талаар мэдлэг, туршлагатай ИНБ болон иргэдийг оролцуулах тэдгээрийн санал бодлыг сонсох боломжийг нээсэн байна.

Үндсэн хуульд Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй бөгөөд төрийн байгууллага албан тушаалтан нь иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэйг заасан байдаг. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэж хариуг нь шууд өгөх, эсвэл хариуцан шийдвэрлэх эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлж энэ тухай хариу мэдэгдэх ажлыг Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар зохицуулсан байна.

УИХ-ын тухай хуульд “УИХ-ын гишүүн нь иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэж хариуг нь шууд өгөх, эсхүл хариуцан шийдвэрлэх эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлж энэ тухай хариу мэдэгдэх эрхтэй”-г тусгайлан заасан бөгөөд иргэд, байгууллагаас УИХ, түүний байнгын болон дэд, түр хороо, тэдгээрийн удирдлага, гишүүдэд ирүүлсэн өргөдлийг судлах, шийдвэрлэх, өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг сонсох, холбогдох албан тушаалтнаас тайлбар авах асуудлыг УИХ-ын Өргөдлийн байнгын хороо хариуцан ажиллахаар хуульд тусгасан байна. УИХ-ын Тамгын газар нь гишүүд иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг нэгтгэн дүгнэж УИХ-ын дарга, Өргөдлийн байнгын хороо, гишүүдэд мэдээлэх үүргийг хуулиар хүлээсэн.

Сонгуулийн тухай хуулинд сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон асуудлыг шийдвэрлэх талаар сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн байвал өөрийн болон өөрийн гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс арваас доошгүй хоногийн өмнө бичгээр гаргаж болохоор зааж, Улсын бүртгэлийн холбогдох байгууллага иргэний бүртгэлийн мэдээллийн улсын санг үндэслэн дээрх гомдол гаргасан иргэний мэдээллийн талаар лавлагаа гаргах ба уг лавлагааг үндэслэн хэсгийн хорооны дэргэд ажиллах иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан тухайн сонгогчийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг гурав хоногийн дотор сонгогчдын нэрийн жагсаалтад оруулахаар тусгаж, шийдвэрлэх хугацааг тодорхой зааж өгсөн байна. Мөн сонгууль зохион байгуулах болон санал авах, санал тоолохтой холбогдсон асуудлаар гарсан өргөдөл, гомдлыг сонгуулийн хэсгийн хороод эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй бол эрх бүхий дээд шатны байгууллагад уламжилж зохих шатны сонгуулийн хороо гомдлыг хүлээж авснаас хойш гурван хоногийн дотор хянан шийдвэрлэж гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэхээр хуульчилсан байгаа нь сонгууль будлиангүй явагдах бас нэг нөхцлийг хангаж байна.

Үнэлгээ

Ерөнхийдөө зөвлөлдөх орчинг хангасан заалт дээрх хуулиудад харьцангуй олон байгаа боловч шаардлагатай бол, үндэслэлтэй бол гэсэн заалтууд нь асуудлыг хоёр талтай болгож байна. Тухайлбал: УИХ бүрэн эрхийнхээ хүрээнд хууль болон УИХ-ын бусад шийдвэрийн талаар иргэд байгууллагаас ирүүлсэн саналыг судлан шаардлагатай гэж үзвэл төсөл санаачлах гэсэн заалтын шаардлагатай гэж үзэх шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгаж өгөөгүй болохоор ямар нөхцөлд шаардлага хангасан төсөл болохыг иргэд болон ИНБ-ууд мэдэх боломжгүй байна. Иймээс иргэд байгууллагаас ирсэн хуулийн төсөл шаардлага хангаагүй гэх шалтгаанаар буцах магадлалтай байна.

Мөн хууль санаачлагч нь нийгмийн нэн чухал харилцааг зохицуулахаар санаачилсан хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай саналаа УИХ-д оруулж болно гэсэн заалт нь иргэдэд илүү өргөн боломж олгож байгаа мэт боловч уг хуулийн

19.2.-т нь хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай оруулсан саналыг УИХ-ын чуулганаар хэлэлцэж, гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэх заалт нь бас л хуулийн хязгаарлалт болж байна.

Харин Үндсэн хуулийн 16.1.12-д заасны дагуу иргэд “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үүрэгтэй” гэсэн үндсэн хуулийн эрх нь УИХ-ын Өргөдлийн байнгын хороогоор дамжин баталгаажих боломжтой байна.

УИХ-ын Өргөдлийн байнгын хорооноос 2012 оны 1 дүгээр сарын 4-ны өдрөөс 8 дугаар сарын 7-ний өдөр хүртэлх хугацаанд УИХ-ын дарга, УИХ-ын гишүүдэд хаяглан ирүүлсэн 392 ширхэг өргөдөлд нэг бүрчлэн, нарийвчилсан шинжилгээ хийлгэхэд түүний 96 хувь нь хувийн хүсэлт бүхий өргөдөл байсан байна. Хувийн хүсэлт бүхий өргөдөл гэдэгт тухайн иргэний өөрийн болон гэр бүлийн асуудал, санхүүгийн хэрэгцээ шаардлага гэх мэт иргэний хувийн амьдралд хамаарах асуудлаар дэмжлэг хүссэн бүх хүсэлтүүдийг хамруулсан бөгөөд энд мөнгө, эд бараа, ажилд орохыг хүссэн, орон гэр, шагнал урамшуулал гэх мэт асуудлууд зонхилж байна. Судалгааны дүнгээс харахад УИХ-д хандан ирүүлж байгаа хувийн хүсэлт бүхий өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх эрх бүхий байгууллага нь орон нутгийн төрийн захиргааны байгууллага болон яамдын эрхлэх асуудалд хамаарч байгаа бөгөөд иргэд эдгээр байгууллагад хандалгүй шууд УИХ-д хандаж байгаа нь иргэдийн эрх зүйн боловсрол дутмаг, энэ талаар мэдээлэлгүй байгааг²⁰ харж болохоор байна.

Харин зөвлөлдөх орчныг бүрдүүлж өгсөн томоохон ажил бол Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн санаачилагаар 2009 оны 12 дугаар сарын 15-нд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа Ерөнхийлөгчийн дэргэдэх “Иргэний танхим” юм. Энэ танхимын ажлын алба нь төрийн шийдвэр гаргах түвшинд иргэний оролцоог нэмэгдүүлэх, ард иргэдийн санал бодол, байр суурийг хууль тогтоогч, шийдвэр гаргах байгууллагад хүргэх зорилгын хүрээнд нээлттэй хэлэлцүүлэг, сонсгол, санал солилцох уулзалт, ажлын хэсгийн хуралдаануудыг зохион байгуулан ажиллаж байна. Иргэний танхим нь 2010 онд 75 хэлэлцүүлэг уулзалтаар 3965 иргэнд, 2011 онд 98 хэлэлцүүлэг уулзалтаар 4781 иргэнд, 2012 онд 78 хэлэлцүүлэг уулзалтаар 3418 иргэнд үйлчилсэн байна.²¹

Харин Засгийн газар иргэдийн санал бодлыг сонсох, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх талаар “11-11 төв”-ийг байгуулсан нь дээрх асуудлыг шийдвэрлэх гарц болж байгаа бөгөөд иргэддээ нээлттэй, тунгалаг төрийг цогцлоох, хүнд суртлыг халах, хурдан шуурхай үйлчилгээг эрхэмлэх үүднээс иргэдийн саналыг утас, цахим хуудас, фэйсбүүк, твиттер, мобайл, мессеж, имэйл, скайп, киоск (санал бичих машин)-оор болон өөрийн биеэр ирэх зэрэг 10 сувгаар хүлээн авч тухайн хариуцан ажилладаг салбарт нь хувиарлаж байгаа нь иргэдийн цаг, мөнгийг хэмнэсэн, иргэдээ сонсох сайн ажил болсон байна. Мөн энэ төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шат

²⁰ С.Оюунтуяа, А.Мөнхнаран : Иргэдийн хувийн хүсэлт бүхий өргөдөл: агуулга, түүнийг УИХ-аас шийдвэрлэсэн байдал баримт бичгийн судалгаа. 2012.

²¹ <http://www.irgen.org/>

болон ариун цэврийн өрөөг шийдэж өгсөн нь бүх иргэдийн зөвлөлдөх оролцоог хангаж, иргэдээс ирсэн санал, гомдол, өргөдлийг ерөнхийдөө ажлын 3 хоногт багтаан тухайн салбар чиглэлийг хариуцдаг газарт нь илгээж байна. Харин иргэдийн санал гомдлын хариултын хувьд Засгийн газар болон яамдуудад хандсан асуудлаар иргэдийн санал хүсэлтийн хариуг харьцангуй хурдан хугацаанд дэлгэрэнгүй байдлаар өгч байгаа бол Ерөнхийлөгчийн Тамгын газар болон УИХ-д ирж байгаа өргөдөл гомдолд хариулах явц удаан, санал гомдлыг хүлээж авлаа, холбогдох гишүүний туслахаар дамжуулан танилцуулсан гэх мэт хариултууд зонхилж байна.²² Эдгээр санал хүсэлтүүд нь <http://www.11-11.mn/> цахим хуудсандаа байрлаж иргэд хариултаа унших боломжтойгоос гадна ямар сувгаар ирсэн, ирсэн мэдээллийн ямар байгууллагад хувиарласан, мөн тухайн байгууллага ямар хариулт өгсөн зэргийг шүүлт хийж үзэх боломжтой байна. Мөн УИХ, Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын цахим хуудсаар²³ иргэдийн саналыг хүлээн авч байгаа ч иргэдийн илгээсэн санал, хүсэлт харагддаггүй байгаа нь иргэдэд санал, гомдлын хариултыг бүрэн дүүрэн өгч байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй болгож байна.

ИДЭВХТЭЙ ОРОЛЦООНЫ ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Шийдвэр гаргагчид иргэдийн төлөөллийг ажлын хэсэгт оруулах, эрх мэдэл шилжүүлэх зэргээр хамтын шийдвэр гаргахад шууд оролцуулж иргэдээр өөрсдөөр нь асуудлыг шийдвэрлүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаад голлон анхаарч шинжиллээ.

Хамтын шийдвэр гаргахад иргэдийн идэвхтэй оролцоог хангасан заалт Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон УИХ-ын тухай хуулинд байхгүй байгаа бөгөөд харин Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 9.2-д “Хуулийн төслийн үзэл баримтлалыг хууль санаачлагчаас өгсөн чиглэлийн дагуу тухайн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг, хуулийн этгээд, иргэн боловсруулж болно”. Мөн хуулийн 9.9-д “Хуулийн төсөл боловсруулах явцад холбогдох мэргэжлийн байгууллага, шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага болон бусад байгууллага, иргэдээс санал авч төсөл боловсруулахад харгалзан үзэж болно” гэсэн заалтууд л байна.

Үндсэн хуульд иргэдийн сонгох, сонгогдох эрхийг тусгайлан зааж өгсөн болохоор сонгуулийн тухай хуулийн иргэдийн оролцооны заалтууд нь иргэдийн шууд бус оролцоог хангасан заавал байх үйл явц юм.

Үнэлгээ

Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд “Хуулийн төслийн үзэл баримтлалыг хууль санаачлагчаас өгсөн чиглэлийн дагуу тухайн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг, хуулийн этгээд, иргэн боловсруулж болно” гэсэн боловч иргэд хуулийн үзэл баримтлалыг боловсруулах, хууль санаачлагч субъекттэй хэрхэн харилцах асуудал тодорхойгүй,

²² <http://www.11-11.mn/>

²³ <http://www.parliament.mn/>, <http://www.president.mn>, <http://www.irgen.org/>,

хууль санаачлагч тухайн асуудлаар иргэдийн дэвшүүлсэн саналыг хэрхэн тусгах, жишиг, зохицуулалт байхгүй байна. Мөн хуулийн 9.9-д хуулийн төсөл боловсруулах явцад холбогдох мэргэжлийн байгууллага, шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага болон бусад байгууллага, иргэдээс санал авч төсөл боловсруулахад харгалзан үзэж болно гэсэн заалт нь харгалзан үзэхгүй ч байж болно гэсэн сөрөг утгыг агуулсаар л байна.

Иргэдийн оролцооны үр нөлөөтэй тогтолцоо бүрдүүлэхэд Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний Танхимын болон аймаг, хот, дүүргүүдийн ИТХ-ын дэргэд байгуулагдаж байгаа Иргэний танхимын үйл ажиллагаа нь ихээхэн тус дэмжлэг үзүүлж байна. Иргэний танхимд болсон хуулийн төслийн хэлэлцүүлэг 2010 онд 20 удаа болж 670 хүн, 2011 онд 8 болж 492 хүн, 2012 онд 2 удаа болж 123 хүн хамрагдаж давхардсан тоогоор нийт 1285 иргэн оролцсон байна²⁴. Эндээс харахад эхний 2 жилд хуулийн төслийн хэлэлцүүлэг харьцангуй сайн хийгдэж хэлэлцүүлэгт оролцсон иргэдийн 84% нь хамрагдсан бол сүүлийн 1 жилд хоёрхон удаа л хуулийн төслийн хэлэлцүүлэг хийсэн байгаа нь хангалтгүй үзүүлэлттэй байна.

ИРГЭДИЙН ХЯНАЛТ ТАВИХ БОЛОМЖ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын тухай хуулинд иргэдийн хяналт тавих боломжийг хангах эрх зүйн заалт байхгүй байна. Харин Сонгуулийн тухай хуулинд төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах болон ИНБ-ын үүрэг хариуцлагыг хуульчилж өгсөн байна. Энэ хуулийн 9.5-д “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага нь Сонгуулийн Ерөнхий хорооноос тогтоосон журмын дагуу сонгуулийн хороод, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ / мониторинг/ хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, түүнд эрхээ хэрэгжүүлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад туслалцаа үзүүлэх эрхтэй” гэж заажээ.

Сонгуулийн санал авах ажиллагаанд нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн томилсон сонгуулийн ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болох бөгөөд ажиглагч нь сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, санал авах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн тухай хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглан хянахаар хуульчилсан байна. Сонгуульд ажиглалт хийх иргэн нь сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах, саналын хуудасны битүүмжлэгдсэн байдалтай танилцах, санал авах, тоолох ажлыг ажиглах, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагар санал авах сонгогчдын нэрийн жагсаалт, тэднээс санал авах чиглэл, хуваарь, явцтай танилцах, санал бэлтгэх бүхээг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмж болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах, санал авах байранд санал авах үйл явцыг бүхэлд нь ажиглаж болохуйц суудалтай байх, санал авах үйл явцад

²⁴ Иргэний танхимын ажлын тайлан. 2010. 2011. 2012 он

зөрчил гарвал хэсгийн хорооны даргад мэдэгдэж, залруулахыг хүсэх, илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, баримтжуулах, гэрчээр гарын үсэг зуруулах, дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах, хэсгийн хорооны гишүүдээс холбогдох мэдээлэл авах, сонгуулийн хорооны хуралдааныг ажиглах, ажиглалтын тайлангаа нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх, саналын хуудасны зурган болон тоон үзүүлэлтийг цахим хэлбэрээр хуулбарлан авах эрхтэй байна.

Мөн сонгуулийн үйл явцыг ил тод, шударга байлгаж сонгогчийн эрхийг баталгаажуулах, сонгуулийн үр дүн үнэн зөв, бодитой байх зарчмыг хангах үүднээс сонгуулийн хэсэгт санал тоолох ажиллагааг УИХ-ын сонгуульд санал авах өдрийн 20.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулах бол Ерөнхийлөгчийн сонгуульд санал авах өдрийн 22.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулахаар хоёр цагийн зөрүүтэй хуулинд тусгасан байна.

Үнэлгээ

Сонгуулийн үйл явцад иргэд хяналт тавих боломжтой байх нь сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх гэсэн болзошгүй зөрчил будлианаас сэргийлж сонгуульд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд онцгой чухал нөлөөтэй. Ийм ч учраас. Сонгуульд анх удаа дотоодын төрийн бус байгууллагууд хөндлөнгийн хяналт шинжилгээ / мониторинг/ бие даасан ажиглалт хийж сонгуулийн үйл явцын ил тод байдлыг жинхэнэ утгаар нь бодитой хангах боломжийг нээсэн. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 44.9-р заалтыг үндэслэн Сонгогчдын боловсрол төв болон 8 төрийн бус байгууллага нэгдэн “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-г байгуулан уг сүлжээний 200 ажиглагч 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагааг ажиглаж, сонгуулийн үйл явцад мониторинг хийсэн. Тус сүлжээний гишүүд энэхүү мониторинг, ажиглалтыг аливаа улс төрийн нам, эвсэл холбоод, нэр дэвшигчийн нөлөөнөөс ангид, хараат бус байж зөвхөн сонгогчдын эрх ашгийг төлөөлөн, хуулийн хүрээнд, ил тод ажиллах ёс зүйн дүрмийн дагуу ажилласан бөгөөд хяналтын явцын үр дүнг сонгуулийн кампанит ажлын үеэр 2 удаа олон нийтэд тайлагнаж эцсийн тайланг 2012 оны 7 дугаар сарын 5-ны өдөр хэвлэлийн бага хурлаар нийтэд хүргэсэн. Сүлжээний гишүүн байгууллагууд 2012 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үйл явцад дараах таван чиглэлээр мониторинг хийсэн.

- Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторинг, “Филантропи хөгжлийн төлөө төв”
- Саналын хуудасны мониторинг, “Сонгогчдын боловсрол төв”
- Сонгуулийн өдрийн санал хураах, тоолох үйл явцын ажиглалт, “Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд” ТББ
- Сонгуулийн автоматжуулсан системийн мониторинг, “МИДАС”
- Хэвлэл мэдээллийн мониторинг, “Глоб Интернэшнл”

Ажиглат хийх иргэнийн эрхийг тодорхой хуульчилсан байхад энэ эрх зөрчигдөж намын ажиглагч нарт суудал засч өгсөн ч дотоодын байгууллагын ажиглагчдад

зориулсан ширээ сандал хангалтгүй байсан бөгөөд ажиглагчид зориулсан суудлыг хэт хол зассаны улмаас сонгогч хурууны хээ таниулахаас эхлээд саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжинд уншуулах хүртэл үйл явцыг бүхэлд нь ажиглах боломжгүй байх хүндрэл нийтлэг гарч байсан бол ажиглагчдад мэдээлэх шаардлагатай зарим мэдээллийг дутуу хэлэх, орхих, санал тоолох төхөөрөмжийн гэрчилгээ, серийн дугаарыг тэмдэглэж, мэдээлэл авах боломжоор хангаагүй, намын ажиглагч нарт илүү нааштай хандах зэргээр ялгаварлах байдал нэлээд түгээмэл ажиглагдсан байна.²⁵

Ерөнхийдөө ажиглалт хийсэн хэсгийн хороод дээр зохион байгуулалтын болон тохиолдлын чанартай жижиг зөрчлүүд гарсан ч энэ нь санал тооллогын дүнд сөрөг нөлөө үзүүлээгүй байна. Сонгуулийн санал хураах, тоолох, сонгуулийн дүнг гаргах үйл явцад зарим хэсгийн хороо санал бэлтгэх бүхээгүүдийг хооронд нь хэт ойр зайтай байрлуулснаас үүдэлтэй сонгогч саналаа нууцаар бэлтгэх боломж бага, саналын нууцлал алдагдах магадлалтай мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд (ХБИ) зориулсан налуу зам байхгүй байснаас ХБИ санал өгөхөд хүндрэл учирсан, санал хураах үйл явцад зарим хэсгийн хороод 07:00 цагаас өмнө санал авах ажиллагааны нээлтийг хийсэн, сонгуульд санал өгөхтэй холбоотой сонгогч саналын хуудсанд саналаа хэрхэн тэмдэглэх талаарх мэдээлэл дутмагаас болж бусад сонгогчид болон хэсгийн хорооны ажилтнуудаас заавар, зөвлөгөө авах, санал бэлтгэх бүхээгт бусад этгээдтэй хамт байх, бусдын бүхээг рүү шагайх болон саналын хуудсаа солилцож үзэх, сонгогч саналын хуудсыг төхөөрөмжид хэрхэн уншуулахаа мэдэхгүй мэдээллийн технологийн даамал, хэсгийн хорооны гишүүний туслалцаа авах тохиолдол мөн нэлээд гарсан бөгөөд үүнээс улбаатай саналын нууцлал алдагдах нөхцөл үүсч байсан зэрэг зөрчил дутагдал илэрсэн²⁶ нь дараа дараачийн сонгуульд эдгээр зөрчил алдааг гаргахгүй байх талаар хууль шинэчлэн найруулах шаардлагатайг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Хуулиудыг дээр дурьдсан оролцооны хэлбэрүүдээр шинжилж үзэхэд мэдээллийн хүртээмж ба ил тод, нээлттэй байдал болоод иргэдийн зөвлөлдөх орчинг бүрдүүлсэн заалтууд харьцангуй олон тусгасан боловч зүйл заалтын утга сул бөгөөд зарим хэлбэр нь тодорхойгүй байна. Харин иргэдийн идэвхтэй оролцоог хангасан, иргэдийн хяналт тавих боломжийг бүрдүүлсэн заалтууд цөөн байна.

Мэдээллийн хүртээмж ба ил тод нээлттэй байх нөхцлийг бүрэн дүүрэн хангасан заалт эдгээр хуулиудад байхгүй бөгөөд харин шинэчлэгдэн батлагдсан Сонгуулийн тухай хуулинд харьцангуй олон заалтаар тусгаж өгсөн байна.

Зөвлөлдөх орчинг хангасан заалт дээрхи хуулиудад харьцангуй олон байгаа боловч шаардлагатай бол, үндэслэлтэй бол гэсэн заалтууд нь уг хуулийн зүйл заалтын утгыг сулруулж байна. Харин иргэдээ сонсох тэдний санал, гомдол талархлыг хүлээн авах чиглэлээр харьцангуй сайн ажиллаж байгаа бөгөөд Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэнийн танхим болон Засгийн газрын 11-11 төвийн дурьдах хэрэгтэй.

²⁵ Сонгуулийн өдрийн ажиглалт: санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явцад хийсэн мониторинг. 2012. Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд ТББ.

²⁶ Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторинг. 2012. Филантропи Хөгжлийн төлөө Төв.

Иргэд шийдвэр гаргах түвшинд оролцох боломж эдгээр хуулиудад бараг байхгүй гэж хэлж болох бөгөөд энэ оролцоог хангаж орсон цөөн заалтууд нь хуулийн төсөл боловсруулж шийдвэр гаргах түвшинд ороцох боломжийг нээж өгсөн ч иргэд хуулийн үзэл баримтлалыг боловсруулах, хууль санаачлагч субъекттэй хэрхэн харилцах асуудал тодорхой тусгаагүй, хууль санаачлагч тухайн асуудлаар иргэдийн дэвшүүлсэн саналыг хэрхэн тусгах, жишиг, зохицуулалт байхгүй байна.

Төрийн хэргийг удирдахад иргэдийн хяналтыг бий болгож ИНБ-ын үүрэг хариуцлагыг хуульчилж өгсөн заалт сонгуулийн тухай хуулиудад л байна. Сонгуулийн үйл явцад иргэд хяналт тавих боломжтой байх нь сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх гэсэн болзошгүй зөрчил будлианаас сэргийлж сонгуульд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй байна.

Мэдээллийн хүртээмж ба ил тод байдлын талаар санал, зөвлөмж

- Хөдөө орон нутгийн иргэдэд төр засгаас явуулж байгаа бодлого шийдвэр тэдний ажил амьдралтай холбоотой асуудлуудыг шуурхай хүргэдэг мэдээллийн нэгдсэн бодлоготой болох;
- ОНХХ-ны ажилтан чуулган бүрээр иргэдээс ирүүлсэн хуулийн төслийн талаарх санал, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж ирүүлсэн байдлыг тогтмол мэдээлдэг сувагтай байх;

Зөвлөлдөх орчны талаар санал, зөвлөмж

- Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулинд иргэдийн оролцоог зохицуулсан дэлгэрэнгүй заалтыг оруулах, бүрхэг заалтуудыг тодорхой болгох, хязгаарлалт бий болгож буй “шаардлагатай бол”, “үндэслэлтэй гэж үзвэл” гэх мэт заалтыг тодорхой болгох;
- Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах хуулинд өөрчлөлт оруулан, иргэдийн саналд шуурхай хариу ирүүлдэг, эргэх холбоо бий болгох зохицуулалт оруулах;

Идэвхтэй оролцооны талаар санал, зөвлөмж

- Иргэдийн оролцоог зохицуулсан голлох хоёр хууль болох Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах хууль, Хууль бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг шинэчилэх;
- Иргэд хуулийн төсөл санаачлах асуудлаар хууль санаачлагчид хандах өөрийн саналыг уламжлах боломжийг нэмэгдүүлэх;
- Иргэдээс ирүүлсэн хуулийн төслийн саналыг хүлээн авах стандарт, хуулийн төсөл боловсруулах загварыг батлах;

Иргэдийн хяналт тавих боломжийн талаар санал, зөвлөмж

- Иргэд УИХ-ын чуулганы үйл ажиллагааг ажиглах нөхцлийг бүрдүүлэх;
- Иргэд чуулганы үйл ажиллагаанд суух хүсэлтээ илэрхийлсэн захидлын загварыг гаргах;

ОРОН НУТГИЙН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮДЭД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Л.Анар-Эрдэнэ

Орон нутгийн түвшинд шийдвэр гаргах эрх мэдэл бүхий байгууллага нь Иргэдийн төлөөлөгчдийн хурал (цаашид ИТХ гэх) юм. Орон нутгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг ИТХ-аар хэлэлцүүлж батлуулснаар ирэх дөрвөн жилийн хугацаанд тухайн орон нутагт хийж хэрэгжүүлэх ажлын үндсэн баримт бичиг болдог. ИТХ-ын хуралдаан нь өөрийн баталсан дэгээр зохицуулагддаг бөгөөд энэхүү дэг нь орон нутгийн хурлын байгууллагаас шийдвэр гаргах явцдаа иргэдийн оролцоог хэрхэн хангасан эсэхийг шинжлэх баримт бичиг юм. Орон нутгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, ИТХ-ын хуралдааны нийтлэг дэг, зарим нэгжүүдэд байгуулагдсан Иргэний танхимын журам зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд иргэдийн оролцоог хангасан байдлыг судлахыг зорилоо.

Энэ судалгаанд орон нутгийн албан ёсны вэб сайтуудад байрласан Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, ИТХ-ын хурлын нийтлэг дэг, Иргэний танхимын үйл ажиллагааны журмыг судлан, заалтуудыг (*хавсралт 3*) хүснэгтэнд бөглөн мэдээлэх, зөвлөлдөх, идэвхтэй оролцоо, хяналт, гэсэн хэсгүүдэд ангиллаа.

Судалгааны ажлын цаг хугацааны боломжоос шалтгаалаад орон нутгийн эрх зүйн баримт бичгүүдийг аймгуудын албан ёсны вэб сайтаас түүвэрлэлээ. Судалгаанд 10 аймаг, Улаанбаатар хотын 3 дүүрэг, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 14 аймаг, нийслэлийн ИТХ-ын Хуралдааны нийтлэг дэг, 4 аймгийн Иргэний танхимын үйл ажиллагааны журамд иргэний оролцоог хэрхэн хангасан талаар судалгаа хийлээ. (Хавсралт 4)

АЙМАГ НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР ДЭХ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН БАЙДАЛ

Орон нутгийн албан ёсны вэб сайтад Засаг даргын(цаашид ЗД гэх) үйл ажиллагааны хөтөлбөрөө байрлуулсан 12 засаг захиргааны нэгж байгаагаас таван засаг захиргааны нэгжийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь 2013-2016 оны /шинэ/, долоон нэгжийнх 2008-2012 оны бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр /хуучин/ байгаа нь нэг талаас орон нутгийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдээлэл олж авах эрх хангалтгүй хэрэгжиж байгааг харуулж байна. Судалгаа нь цаг хугацааны хувьд 2013 оны 1 дугаар сараар хязгаарлагдаж орон нутгийн сонгуулийн дараа хийсэнтэй холбоотойгоор зарим аймаг дүүргийн ИТХ хуралдаагүй, засаг даргаа сонгоогүй, үүрэг гүйцэтгэгчтэй зэрэг шалтгаанаар засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөө ИТХ-аас батлаагүй байх талтай.

Аймаг, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн онцлог нь бүрэн эрхийн хугацаанд /4 жил/ хийх ажлын жагсаалт байдлаар боловсруулагддаг тул Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх иргэний оролцооны хэрэгжилтэд үнэлгээ өгөх боломжгүй байсан. Аймаг дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг харьцуулахад 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2013-2016 оны үйл

ажиллагааны хөтөлбөрүүдийн хооронд шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах тал дээр багагүй ахиц байгааг тэмдэглэх ёстой.

Тухайлбал: 2008-2012 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд иргэний оролцоог хангах тухай дунджаар хоёр заалт орсон бол 2013-2016 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт дунджаар есөн (ес) заалт орсон нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд тодорхой ахиц байгааг харуулж байна.

Хүснэгт 2 ЗД-ын мөрийн хөтөлбөрийн харьцуулалт

№	Аймагууд	Хэлбэр	Мэдээлэх	Зөвлөлдөх	Идэвхтэй оролцоо	Хяналт	Нийт
1.	Увс аймаг	шинэ	1	2	4	5	12
2.	Баян-Өлгий аймаг	шинэ	1	1	2	1	5
3.	Сүхбаатар дүүрэг	шинэ	1	1	7	2	11
4.	Улаанбаатар хот	шинэ	3	4	9	2	18
5.	Сэлэнгэ аймаг	хуучин	1	1	0	0	2
6.	Говь-Алтай аймаг	хуучин	1	1	0	1	2
7.	Хэнтий аймаг	хуучин	1	0	0	2	3
8.	Архангай аймаг	хуучин	0	0	2	0	2
9.	Баянхонгор аймаг	хуучин	0	0	2	0	2
10.	Чингэлтэй дүүрэг	хуучин	0	0	0	0	0
11.	Багануур дүүрэг	хуучин	0	1	0	0	1

Увс аймгийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн оролцоог хангах чиглэлийн 12 заалт орсон нь одоогоор хамгийн олон заалттай аймагт тооцогдож байна. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт:

Иргэдийг мэдээлэлжүүлэх чиглэлээр

- Аймгийн ЗДТГ-т “Иргэдэд үйлчлэх нийтийн үйлчилгээний төв” байгуулах, зар мэдээллийн цахим самбар ажиллуулан иргэдийг мэдээллээр хангана. /5.16./

Орон нутгийн шийдвэр гаргахдаа иргэдийн байр суурийг тусгах, зөвлөлдөх чиглэлээр

- Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй болгон, иргэд ТББ-ын саналд тулгуурласан шийдвэр гаргах тогтолцоог бүрдүүлнэ. /5.1./
- Аймаг болон сумдад иргэний танхим байгуулан, хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг гаргаж ажиллана. /5.8./

Оролцоог дэмжих чиглэлээр

- Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэн, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ажлыг бодитойгоор хэрэгжүүлнэ. /5.5./

- Орон нутгийн иргэдийн бүлэг нөхөрлөлийг дэмжиж, хувиараа болон бичил уурхайгаар нүүрс, алт, давс зэрэг ашигт малтмал олборлогчдын ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлж ажиллана. /1.IX.11/
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулж, зорилтот бүлгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан, хөнгөн шуурхай хүргэх, халамжийн гэр, өргөөний үйлчилгээ, оёдлын цехэд ажиллуулахыг дэмжинэ. /1.LXIX.68/
- Хүүхэд бүр авьяасаа нээх, хөгжих боломжийг бүрдүүлэх, амжилт гаргах, мэргэжлийн чиг баримжаа олгоход үнэтэй хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн ба төрийн бус байгууллага, хамтлаг, клубын үйл ажиллагааг урамшуулах замаар тэдний оролцоонд тулгуурласан сургалтыг явуулахыг дэмжинэ. /3.4./
- . . . байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөлүүдийг дэмжиж ажиллана. /4.19./

Төсөв болон орон нутгийн шийдвэрт иргэдийн хяналт бий болгох чиглэлээр таван заалт туссан байна.

- Төсвийн нээлттэй, ил тод байдлыг хангаж, “Шилэн халаас” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /1. I. 1. /
- Төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалт, тендэрийн үйл ажиллагааг цахимжуулж, олон нийтэд нээлттэй, ил тод, шударга, хүнд сурталгүй, шуурхай болгоно. /1. I. 4./
- Аймгийн хэмжээнд олгодог тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчинг шинэчлэх, лицензийн ашиглалтанд хяналт тавих иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. /5.19./
- “Нийтийн албанд хувийн болон нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг зохион байгуулан, авлига хүнд сурталтай холбоотой мэдээллийг хүлээн авах итгэлтэй утас, электрон шуудангийн хаяг нээж ажиллуулна. /5.20. /
- Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэний зөвлөл, танхим, иргэдийн сэтгэл ханамжинд үндэслэн үнэлж дүгнэх зарчмыг мөрдөнө. /5.4./

Улаанбаатар хот

Мэдээлэх чиглэлээр;

- Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, олон нийтэд ил тод мэдээлэн, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлдэг болно. /5.9./
- Газрын харилцаатай холбоотой асуудлыг Нийслэлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд нээлттэй болгох талаар хууль эрх зүйн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч, газартай холбоотой бүх мэдээллийг нээлттэй, ил тод болгоно. /5.12./
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлдэг ажил, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, цахим засаглалыг хөгжүүлнэ. /5.5./

Орон нутгийн шийдвэр гаргахдаа иргэдийн байр суурийг тусгах, зөвлөлдөх чиглэлээр;

- Иргэдийн оролцоотойгоор газар зохион байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, барилга, объект барихдаа тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын саналыг заавал авдаг журамд шилжинэ. /2.1.2./
- . . . хотын тулгамдаж буй асуудлаар иргэдийн дунд олон нийтийн санал асуулга явуулж, тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг болно /5.4./
- Нийслэлийн “Иргэний танхим”-ыг шинээр байгуулж ажиллуулна /5.2./
- Авлигын эсрэг олон нийтийн зөвлөл байгуулна. /5.3./

Оролцооны чиглэлээр;

- Ашиглалтын шаардлага хангахгүй болсон хуучин орон сууцны барилгуудын газрын эрхийг бүртгэлжүүлж, иргэдийнх нь оролцоотойгоор дахин төлөвлөлт хийж барилгажуулах ажлыг концессын гэрээгээр хийж гүйцэтгэнэ. /2.3.2./
- Нийслэлийн иргэдийн ажиллаж, амьдрах, эрүүл, тохилог, аюулгүй орчинг бүрдүүлэх зорилгоор “Орон нутгийн хөгжлийг дэмжих” санг байгуулж, иргэд олон нийтийн оролцоотойгоор төлөвлөж зарцуулна. /3.10.2./
- Улаанбаатар хотын дүрмийг иргэдийн оролцоотой боловсруулж, батлан мөрдөнө. /5.1./
- Нийслэлийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын тогтолцоог нийслэлийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын идэвх санаачилгад тулгуурлан бий болгож хөгжүүлнэ. /1.3.2./
- Төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, хотын ногоон бүсийг 20 хувь хүртэл нэмэгдүүлэн “Хотын эко цагдаа” ажиллуулна. /1.3.4./
- Гэр хорооллын иргэдийн инженерийн нэгдсэн болон хэсэгчилсэн хангамжтай болох чиглэлээр хэрэгжүүлсэн санал, санаачилга, үйл ажиллагааг дэмжин, хөрөнгө оруулалтын тодорхой хувийг нөхөн олгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ. /2.2.2./
- Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвх санаачилгад суурилсан “хөршийн хамгаалалт” амгалан тайван байдлын тогтолцоо бүрдүүлнэ. /4.1.3./
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлж, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. /5.7./
- Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, олон нийтэд ил тод мэдээлэн, иргэдийн оролцоотой хэрэгжүүлдэг болно. /5.9./

Хяналтын чиглэлээр;

- Хотын үйл ажиллагааг ил тод байлган, гүйцэтгэлд хяналт тавих эрхийг иргэдэд олгоно . . /5.4./
- Тендэрийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 100 хувь

онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулна.
/5.13./

Сүхбаатар дүүрэг

Мэдээлэх чиглэлээр;

- Дүүргийн иргэдийг газраа өмчлөх ажлыг эрчимжүүлж, ил тод нээлттэй болгоно /2.1.3./

Зөвлөлдөх чиглэлээр;

- Хороо бүрт “хороо хөгжүүлэх сан” байгуулж энэхүү сангийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтыг хорооны иргэний танхимаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ /5.10./

Оролцооны чиглэлээр;

- Иргэдийн оролцоотойгоор газар зохион байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, барилга, объект барихдаа тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын саналыг авдаг журамд шилжинэ./2.1.1./
- Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, олон нийтэд ил тод мэдээлэн, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлдэг болно /5.4./
- Улаанбаатар хотын дүрэмд дүүргийн онцлог заалтуудыг иргэдийн оролцоотой боловсруулж, оруулна. /5.7./
- Иргэдийг эдийн засгийн аргаар дэмжих замаар дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж “Дүүргийн экологийн ажилтан” ажиллуулна. /1.1.3./
- Нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтад иргэд байгууллагын оролцоог нэмэгдүүлж, тэдний идэвх санаачилгыг дэмжиж урамшуулна. /1.3.2./
- Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвх санаачилгад суурилсан “хөршийн хамгаалалт” амгалан тайван байдлын тогтолцоог бүрдүүлнэ. /4.1.2./
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөтгөж, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвслээр гүйцэтгүүлнэ. /5.3./

Хяналтын чиглэлээр;

- Дүүргийн удирдлагаас гарч байгаа шийдвэрийг ил тод байлган, гүйцэтгэлд нь хяналт тавих эрхийг иргэдэд олгохын зэрэгцээ дүүрэгт тулгамдаж буй асуудлаар иргэдийн дунд олон нийтийн санал асуулга явуулж, тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг болно. /5.1./
- Тендэрийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулна. /5.5./

Баян-өлгий аймаг

Мэдээлэх чиглэлээр;

- Төрийн үйлчилгээг иргэдэд нээлттэй, ил тод болгож, шуурхай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж ажиллана. /5.1.1./

Зөвлөлдөх чиглэлээр;

- Төр засгийн үйл ажиллагаанд иргэний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймаг, сумын ИТХ-ын дэргэд “Иргэний танхим” байгуулна. /5.1.4./
- Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг нэг цонхны зарчмаар хэрэгжүүлж иргэдийн санал хүсэлтийг сонсдог төв болгон өргөжүүлнэ. /5.1.12./

Оролцооны чиглэлээр;

- Малын хулгайтай тэмцэх асуудлын хүрээнд байнгын үйл ажиллагаатай лавлах утас ажиллуулан үнэн зөв мэдээлэл өгсөн иргэдийг урамшуулдаг тогтолцоог бүрдүүлнэ. /5.2.4./

Хяналтын чиглэлээр;

- Аймгийн хэмжээнд уул уурхайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гадаад, дотоодын аж ахуйн нэгжийн лиценз болон үйл ажиллагааг ард иргэдийн оролцоотойгоор шалгаж, хатуу хяналт тавьж ажиллана. /1.2.7./
- Уул уурхайн салбар дахь төрийн зохицуулалт, хяналтыг чангатгаж, төрийн өмчийн оролцоог хязгаарлаж, үндэсний аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог дэмжинэ. /1.2.1./

2013-2016 оны бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх дөрвөн нэгжийн Засаг даргын мөрийн хөтөлбөр дэх иргэдийн оролцоог хангах заалтуудад шинжилгээ хийхэд нэг аймаг дунджаар 11,5 заалт оруулсан байгаа нь 2008-2012 оны Засаг даргын мөрийн хөтөлбөрүүдийн дунджаас даруй 9-өөр илүү байна.

Багануур дүүрэг:

- Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг төлөвлөх, шийдвэр гаргах үйл явцад иргэд, нийгмийн ба сонирхолын бүлгүүдийн оролцоог хангах зарчмаар иргэдийн санал бодлыг үйл ажиллагаандаа тусгана. /3.1.2./

Баянхонгор аймаг:

- Аймгийн Засаг даргын дэргэд хүүхдийн зөвлөл байгуулан хүүхдийн эрхийг хамгаалах, нийгэмшүүлэх, хөгжүүлэх, төлөвшүүлэх талаар бодлого шийдвэр гаргахад тэдний санаа бодлыг тусган хүүхдийн оролцоог хөгжүүлнэ. /1.5.2./

Архангай аймаг:

- Төрийн байгууллагаас иргэний нийгмийн байгууллагатай нягт хамтран ажиллаж гурван талт түншлэлийн харилцааг хөгжүүлнэ. /4.1./
- Аймгийн хөгжлийн хэтийн төлөвлөгөөг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэхийн зэрэгцээ бүх сумдын хөгжлийн хэтийн төлөвлөгөөг иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоотой боловсруулна. /4.5./

Хэнтий аймаг:

- Иргэний нийгмийн байгууллагын зүгээс тавих хяналтыг хүчтэй болгож аймгийн ЗДТГ-г нээлттэй утас ажиллуулна. /4.2./

- Аймагт хэрэгжиж байгаа болон хэрэгжих төсөл хөтөлбөр, тендэр шалгаруулалтыг ил тод нээлттэй байлгаж, хяналт тавих үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагаас оролцуулж ажиллуулна. /4.4./
- Аймгийн Засаг даргын дэргэдэх нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг иргэд хөдөлмөрчдөд ил тод, нээлттэй байлгаж, хийсэн ажлын тайлан, үр дүнг хэлэлцүүлж хэвшинэ. /4.5./

Говь-алтай аймаг:

- Хүүхдийн талаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад тэдний санаа бодлыг тусгаж, оролцоог нэмэгдүүлнэ. /1.5.8./
- Хариуцлагатай уул уурхайн зарчмыг баримтлан, хяналт үнэлгээг сайжруулан байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлын төвлөрүүлэлт, нөөц ашигласны төлбөрийн төлөлт зэргээр цахим мэдээллийн сан бүрдүүлж, олон нийтэд ил тод нээлттэй болгоно. /3.9./
- Нутгийн удирдлагад иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч, төрийн байгууллагад хяналт тавих, нөлөө үзүүлэх, дэмжлэг авах, ажил гүйцэтгэх зэрэг төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлж, хөгжүүлнэ. /4.2.1./

Сэлэнгэ аймаг:

- Аймгийн Боловсрол, соёлын газрын дэргэд “Боловсрол” ТВ-ын суваг, FM радиог шинээр байгуулж, иргэдэд мэдээллээр үйлчлэх хүрээг өргөжүүлнэ. /1.2.7./
- Иргэд олон нийт, төрийн бус байгууллагуудын болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай түншлэлийн харилцааг өргөжүүлж, тэдгээрийн ажил хэрэгч санал, санаачилгыг дэмжиж, хамтын ажиллагааны гэрээ байгуулан үр дүнг тооцож ажиллана. /3.1.8./

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан иргэний оролцоог хангах заалт нь Засаг захиргааны нэгжийн онцлогоос шалтгаалан өөр өөрийн онцлогтой байна. Тухайлбал: Нийслэл болон дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт: хот дахин төлөвлөлт, хотын дүрэм боловсруулах, газар олголт зэрэгт иргэдийн оролцоо хяналтыг бий болгохоор төлөвлөсөн байгаа бол хөдөө орон нутгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Тендэр болон уул уурхайн лиценз олголтонд иргэдийн хяналтыг бий болгох заалтууд түлхүү байна. Ерөнхийд нь дүгнэвэл Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Орон нутгийн шийдвэр гаргах түвшинд иргэний оролцоог хангахад чиглэгдсэн зорилтуудад нааштай өөрчлөлт байгаа нь харагдаж байна.

**ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НИЙТЛЭГ ДЭГ
ДЭХ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН БАЙДАЛ**

ИТХ-ын хуралдааны нийтлэг дэг нь хурлын байгууллага орон нутгийн түвшний шийдвэр гаргахдаа баримтлах зарчмыг тодорхойлдог бөгөөд орон нутгийн хурлын байгууллагаас шийдвэр гаргах үйл явцад иргэдийг оролцуулах хэлбэр нь одоогоор энэхүү дэгээр зохицуулагдаж байна. ИТХ-ын хуралдааны дэгээр орон нутгийн шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах бололцоотой эсэхийг

судлахын тулд Мэдээллээр хангах, идэвхтэй оролцоог хангах, зөвлөлдөх болон хяналт гэсэн үндсэн дөрвөн дэд бүлгийн хүрээнд:

- Хурлын шийдвэрийг иргэдэд мэдээлэх эсэх;
- Хурлын хэлэлцэх асуудалтай иргэд танилцах боломжтой эсэх;
- Иргэд болон бусад хамаарагч бүлгүүдийг оролцуулан хэлэлцүүлэг зохиох эсэх;
- Иргэд хуралдаанд хэлэлцүүлэхээр асуудал оруулах боломжтой эсэх;
- Хурлаар хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан асуулт асуух, тодруулга хийх, санал хэлэх боломжтой эсэх;
- Хэлэлцэх гэж буй асуудлаар иргэдээс урьдчилан санал авах эсэх;
- Хурлын хуралдаанд иргэд ажиглагчаар оролцох боломжтой эсэх;
- Төсөв хэлэлцэх явцад иргэдийн саналыг тусгах эсэх;
- Хурлын шийдвэрийг иргэдэд мэдээлэх эсэх;
- Иргэдийн гаргасан санал шийдвэрт хэрхэн туссаныг эргэн мэдээлэх эсэх;

зэрэг асуудлаар шалгуур тавьж иргэдийн оролцоо хангагдсан эсэхийг судаллаа.

Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал

Иргэний оролцооны анхдагч элемент нь мэдээллээр хангах явдал юм. Иргэд аливаа асуудлаар мэдээлэлтэй болсон тохиолдолд оролцох боломж нээгдэж оролцоог бий болгох үндэс суурь тавигдана. Орон нутгийн ИТХ-ын хуралдааны нийтлэг дэг дэх иргэдийг мэдээллээр хангах зохицуулалтуудад дүн шинжилгээ хийвэл дараах байдалтай байна. Хурал хуралдах, тодорхой асуудлаар хэлэлцэж шийдвэр гаргах тухай урьдчилан мэдэх боломжийг олгосон зохицуулалт орон нутгийн ИТХ-ын хурлын дэгүүдэд тун хангалтгүй байна. Бидний судалсан 13 засаг захиргааны нэгжийн хурлын дэгүүдээс хоёр аймгийн хурлын дэгт урьдчилан мэдээлэх заалт бага зэргээр тусчээ. Тодруулбал: Нийслэлийн ИТХ-ын 2012 оны 2/05 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг”-ын 12.10. дахь заалт, Ховд аймгийн ИТХ-ын хуралдааны дэгийн 4.1. дэх заалтуудад туссан хэдий ч иргэдийг мэдээллээр хангах үндсэн шаардлагыг хангаж чадахааргүй, хүртээмжтэй, энгийн ойлгомжтой байх, цаг хугацааны хувьд боломжтой байж чадах эсэх нь тодорхойгүй байна.

Нийслэлийн ИТХ-ын Хуралдааны дэгийн 12.10.-т “Хурлын тов, хэлэлцэх асуудлыг хурлын вебсайтад байрлуулж, урьдчилан таниулах боломжийг бүрдүүлнэ”, Ховд аймгийн ИТХ-ын хуралдааны дэгийн 4.1.-т “МУ-ын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар хуралдааныг хурлын тэргүүлэгчид хуралдаан эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө зарлаж, бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулж, хурлын тов, хэлэлцэх асуудлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлаж, төлөөлөгч нэг бүрт албан ёсоор мэдэгдэнэ” гэж заасан нь хэт ерөнхий заалт болсон байна. Аливаа мэдээлэл цаг хугацаа алдаж очвол үнэ цэнэгүй болдог. Зүй нь хурлын тов, хэлэлцэх асуудлыг иргэдэд мэдээлэхдээ тухайн асуудлаар нэмэлт лавлагаа, мэдээлэл цуглуулах, өөрийн байр суурийг тодорхойлох цаг хугацааны боломжийг олгосон зохицуулалт шаардагдаж байна. Мөн хурлын тов, хэлэлцэх асуудлыг иргэдэд мэдээлэхдээ Нийслэлийн ИТХ дан ганц хурлын вэб сайтад

байршуулахаар томъёолсон нь мэдээлэл хүртээмжтэй байх шаардлагыг хангахгүй байна. Хурлын хэлэлцэх гэж буй асуудлын төсөлтэй иргэдийг танилцах боломжийг олгосон зохицуулалт Дархан-Уул болон Нийслэлийн ИТХ-ын хуралдааны дэгт туссан боловч бусад 11 аймгийн ИТХ-ын хуралдааны дэгт уг зохицуулалт алга. Нийслэлийн ИТХ-ын хуралдааны дэгийн 11.9.-т “Энэ зүйлийн 11.6. дахь хэсэгт заасан хурлын төлөөлөгчдөд тараасан хэлэлцэх асуудлын баримт бичгүүдтэй танилцах боломжийг иргэдэд олгох зорилгоор сандал, ширээ бүхий тусгай өрөө, танхимыг ажлын цагаар гаргаж өгөх ба иргэд хүсвэл хуулбарлаж өгнө. Мөн олон нийтэд нээлттэй цахим хуудсанд байршуулна” гэж зохицуулсан нь хурлын хэлэлцэх асуудалтай иргэд танилцах боломжийг олгосон сайн зохицуулалт болжээ. Харин Дархан-Уул аймгийн ИТХ-ын хуралдааны дэгийн 1.6.-д “. . . хуралдаанаар хэлэлцэх баримт бичгийн төслийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж, ярилцлага, хэлэлцүүлэг явуулах зэргээр иргэдийн болон нийгмийн бүлгүүдийн санал дүгнэлтийг авч болно” гэж зохицуулсан нь иргэд болон нийгмийн бүлгүүдийн санал дүгнэлтийг авахгүй ч байж болох гэсэн санааг өөртөө агуулж байна.

Хурлын дэгүүдэд нэгэнт гаргасан хурлын шийдвэрийг олон нийтэд мэдээлэх заалт Баян-Өлгий болон Өвөрхангай аймгуудын хурлын дэгүүдээс бусад аймгуудын дэгүүдэд ямар нэгэн хэмжээгээр туссан нь ажиглагдлаа. Гэвч мэдээлэх хэлбэр болон цаг хугацааны хувьд харилцан адилгүй байна. Тухайлбал: зарим аймгуудын хурлын дэгт, хурлын шийдвэрийг телевиз, вэб сайт, орон нутгийн хэвлэл, номын санд байршуулах байдлаар иргэдэд мэдээлэхээр зохицуулсан бол Увс, Дархан-Уул, зэрэг аймгуудын хувьд аймгийн номын санд байршуулах байдлаар иргэдэд мэдээлэхээр зохицуулсан нь хүртээмж талаасаа хангалтгүй юм. Түүнчлэн цаг хугацааны хувьд хэдийд, хэн мэдээлэх нь тодорхойгүй зэрэг нийтлэг дутагдал ажиглагдаж байна. Мөн хурлын шийдвэрийг иргэдэд мэдээлэхдээ Хурлын дарга, ажлын алба зэргээр хянуулж, зөвшөөрөл авах заалт Улаанбаатар хотын ИТХ-ын хурлын нийтлэг дэгийн 17.3.-т байгаа нь Хурлаас гарсан шийдвэр нийтэд мэдээлэгдэхдээ ач холбогдолоо алдаж, үнэ цэнэгүй болох эрсдлээс гадна хувь хүний хүчин зүйл нөлөөлөх магадлалтай байна.

Зөвлөлдөх орчны шинжилгээ

Хурал өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах явцад иргэдийн байр суурийг тусгаж зөвлөлдсөн байх нь гарах шийдвэр оновчтой бөгөөд хэрэгжих явцад аливаа хүндрэл гарах эрсдлийг бууруулах учиртай. Нийслэлийн ИТХ-ын хуралдааны дэг нь шийдвэр гаргахын өмнөх шатанд иргэдтэй зөвлөлдөх, иргэдийн санаа бодлыг тусгах талаар бусад хурлын байгууллагуудын дэгээс харьцангуй сайн зохицуулалтуудтай байна. Тухайлбал; Нийслэлийн хурлын дэгийн дагуу орон нутгийн төсвийн төслийг иргэдээр заавал хэлэлцүүлсэн байх, иргэдийг хамруулан хэлэлцүүлэг зохиох, иргэдийн зүгээс хурлын хуралдаанд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлэх эрхтэй зэрэг нь шийдвэр гаргахаасаа өмнө иргэдийн санал санаачилгыг тусгах сайн зохицуулалт болжээ.

Бидний судалгаанд хамрагдсан ихэнх аймгийн ИТХ-ын хуралдааны дэгт иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс хурлаар асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болох заалт байгаа хэдий ч уг асуудлыг хурлын тэргүүлэгчдээр оруулж

хэлэлцэх эсэхийг шийдэхээр зохицуулсан нь эхний заалтаар зөвшөөрсөн зохицуулалтыг дараагийн заалтаар хязгаарласан байгаа нь харагдана. Нийслэлийн ИТХ-ын хуралдааны дэгт туссан шинэлэг зүйл нь орон нутгийн төсвийг хэлэлцэхдээ иргэдийн байр суурь, саналыг авахаар тусгасан нь өмнө нь хэрэгжүүлж байгаагүй туршлага юм. Зөвлөлдөх оролцооны нэг чухал зарчим нь эргэх холбоо юм. Иргэдийн зүгээс хэлэлцүүлгийн явцад болон бусад хэлбэрээр шийдвэр гаргахын өмнөх шатанд оруулсан санал шийдвэрт хэрхэн туссан эсэхийг эргэн мэдээлэх механизм бидний судалгаанд хамрагдсан 13 аймгийн ИТХ-ын хуралдааны дэгт зохицуулагдаагүй орхигдсон байна. Харин Нийслэлийн ИТХ-ын дэгт төсвийн төсөлтэй холбоотой иргэдээс бичгээр ирүүлсэн саналд хурлын төлөөлөгч заавал хариу өгөхөөр туссан байна.

Идэвхтэй оролцооны шинжилгээ

Хуралдаанд иргэд ажиглагчаар оролцож болно гэсэн заалт Баян-Өлгий аймгийн ИТХ-ын дэгээс бусад бүх аймгийн хурлын дэгт байгаа боловч хурлаар хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор асуулт асууж, санал, шүүмжлэл хэлэх эрхийг гурав аймгаас бусад аймгийн хуралдааны дэгт оруулаагүй байна. Өөрөөр хэлбэр Баянхонгор, Өвөрхангай, Ховд аймгаас бусад бидний судалгаанд хамрагдсан аймгийн ИТХ-д урилгаар оролцож буй иргэд зөвхөн ажиглах эрхтэй тус хуралдаанд суух аж. Дээрх аймгуудаас бусад аймгийн хурлын дэгийн дагуу хуралд оролцох иргэдийн төлөөлөл нь үг хэлж, асуулт асуух, санал шүүмжлэл хэлэх эрх олгогдоогүй зөвхөн ажиглагчийн байр сууринаас хуралд суухаар байгаа нь хурлын явцад иргэдийн идэвхтэй оролцоо тун хангалтгүй зохицуулалттай байгааг харуулж байна.

Орон нутгийн хурлын байгууллагуудын хуралдааны нийтлэг дэгүүдээс Иргэдийн оролцоог хангах чиглэлээр хамгийн олон заалт бүхий хурлын дэг нь Нийслэлийн ИТХ-ын хуралдааны дэг юм.

- Нийслэлийн ИТХ-ын хурлын хуралдаанд иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болох ба Тэргүүлэгчид уг асуудлыг Хурлын хуралдаанд оруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- Хурлын шийдвэрийг ёсчлон баталсан даруйд олон нийтэд мэдээлнэ. /9.3./
- Иргэд хурлаар хэлэлцэх асуудлын баримт бичгүүдтэй урьдчилан танилцах боломжийг хангах зохилгоор тусгай албан тасалгаа гаргаж өгнө. /11.9./
- Хэлэлцэх асуудлыг урьдчилан олон нийтийн нээлттэй вэб сайтад байршуулна. /11.9./, /12.10/
- Нээлттэй хуралдаанд ажиглагчаар оролцож болно. /13.3./
- Хуралдааны тэмдэглэл нээлттэй байх бөгөөд хувилж авах эрхтэй. /16.2./
- Хурлын төлөөлөгчид нийслэлд тулгамдаад байгаа асуудлаар олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулна. /18.1./
- Нийслэлийн төсвийг хэлэлцэхдээ иргэдийн саналыг урьдчилан авна. /19.3./
- Иргэдээс дэвшүүлсэн санал шийдвэрт хэрхэн туссан талаар заавал хариу өгнө. /19.3./

Орон нутгийн хурлын байгууллагын нийтлэг дэгийг нэгтгэн дүгнэвэл иргэдийн оролцоог бий болгох зарим зохицуулалтууд бий хэдий ч иргэдийн зүгээс шийдвэр

гаргалтанд оролцох эрхийг зөвшөөрөл авдаг тогтолцоогоор хязгаарлаж өгсөн байдал ажиглагдлаа. Түүнчлэн хурлын дэгүүдэд бүрэн эрхийн хугацаанаас хамаарч Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн адил нааштай өөрчлөлт байна.

Иргэдийн хяналт тавих боломж

Орон нутгийн ИТХ-ын хуралдааны нийтлэг дэгт хийсэн шинжилгээгээр иргэдийн зүгээс ИТХ-ын хуралдааны дэгийн дагуу хийгдсэн аливаа ажлын үр, дүн гүйцэтгэлд хийх хяналтын чиглэлийн ямар нэг зохицуулалт алга байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааг дүгнэхэд Орон нутгийн эрх зүйн баримт бичгүүдэд иргэд, олон нийтийн оролцоо тодорхой хэмжээгээр хангагдсан нааштай өөрчлөлтүүд хийгдэж буй шилжилтийн үе гэж тодорхойлох боломжтой юм. 2012 оны орон нутгийн сонгуулиар байгуулагдсан ИТХ болон Засаг даргын зүгээс Хурлын дэг, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр багагүй санаачилга орсон байна.

Гэсэн хэдий ч ялангуяа Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан иргэдийн оролцооны заалтууд нь хэрэгжих боломж нь тодорхойгүй, Засаг даргын зүгээс иргэдийн санал санаачилгыг “дэмжиж” ажиллах заалт цөөн байна. Иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс санаачилга гаргаагүй тохиолдолд орон нутгийн түвшинд иргэдийн оролцоо хангагдахгүй эрсдэл харагдаж байна.

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх “Нийслэлийн төсвийг иргэдээр хэлэлцүүлж, санал авах”, “Хот төлөвлөлтийг иргэдээр хэлэлцүүлж, санал авах” зэрэг заалт нь иргэдийн оролцоог орон нутгийн шийдвэр гаргах шатанд хангаж буй зоригтой шийдэл болсон бөгөөд өмнө нь ийм туршлага байгаагүй гэдгийг дурдах хэрэгтэй юм.

Бидний судалгаанд хамрагдсан ИТХ-ын хуралдааны дэгүүдэд ажиглагдсан нэг сөрөг зохицуулалт нь “болно”, “шаардлагатай бол” зэрэг хувь хүний хүсэл зоригоос шалтгаалах заалтууд багагүй байна. Аливаа “болно” гэсэн томъёолол нь сайн дурын үндсэн дээр хэрэгжих шинжтэйн зэрэгцээ тухайн зохицуулалтыг хэрэгжүүлээгүй тохиолдолд үүсэх хариуцлагаас зайлсхийх боломжийг олгож байна. Иймд хойшид хурлын дэгүүдэд “болно” гэсэн томъёоллоор зохицуулалт хийхээс аль болох зайлсхийх нь чухал юм. Орон нутгийн хурлын байгууллагаас хуралдаж шийдвэр гаргахын өмнө олон нийтэд энэ талын мэдээлэл өгч, иргэд байр сууриа илэрхийлэх боломжоор хангасны үндсэн дээр шийдвэрээ гаргадаг, гарсан шийдвэрийг иргэдэд цаг алдалгүй мэдээлдэг зохицуулалт, түүнчлэн орон нутгийн төсвийг иргэдээр хэлэлцүүлдэг, эргэн тайлагнадаг тогтолцоо орон нутгийн ИТХ-ын хурлын дэгүүдэд шаардлагатай байна.

**ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ШИЙДВЭР ГАРГАХ ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ САЙН
ЖИШЭЭ: ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ СУМ**

“Хүний эрхийг баталгаажуулж, ардчилсан засаглалыг бэхжүүлэх” Мянганы хөгжлийн 9 дэх зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2009-2010 онд Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын иргэдийн оролцоог хөгжүүлэх, улмаар иргэд нь төр, хувийн хэвшилтэй тэгш эрхтэйгээр түншлэн, засаглалын үйлчилгээний чанарыг сайжруулах, орон нутгийн хөгжилд олон талын оролцоог бодитой хангах төслийг НҮБ-ын Глобал хөтөлбөрийн дэмжлэгээр “Хил хязгааргүй алхам” ТББ хэрэгжүүлж байсан.

Орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хяналт тавих бүхий л шатанд малчид, эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд, ахмад настан болон залуучуудын хөгжих эрх, оролцоог хангах замаар тэднийг шийдвэр гаргахад бодитой оролцуулах нь маш чухал ач холбогдолтой юм. Учир нь тэд өөрийн нутгийн уламжлал, ёс заншлаасаа урган гарсан өвөрмөц туршилага мэдлэгтэй байдаг төдийгүй өөрийн нутгийн хэрэгцээ, нөөц бололцоогоо мэддэг, түүндээ үндэслэн нарийн мэдрэмжтэй санал санаачилгыг гаргаж чаддаг. Өөрсдийн гаргасан шийдвэрээ өөрсдөө хэрэгжүүлж үр дүн гартал тууштай байж чаддаг. Үүний тулд оролцогч талуудын тэгш эрхийн зарчимд суурилсан, албажсан Түншлэл чухал юм. Түншлэл нь талууд орон нутгийнхаа нийтлэг эрх ашгийн төлөө санаа зовоож байгаа асуудлаар нэгдэх үйл ажиллагаа бөгөөд өөрчлөлт хийх гэж байгаа хүмүүс, байгууллагыг олируулах, тэдний чадавхийг нэмэгдүүлж сэтгэл санаа, оюун ухаан, хүч чадлын дэм өгөхөөс гадна мэдлэг, мэдээлэл, сургамж хуваалцах, нөөцөө хуваарилах талбар болдог давуу талтай.

Түншлэлийг бий болгох үндсэн үйл ажиллагаа нь богино, урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө, нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл боловсруулах, нийтийн эрх ашигтай холбоотой асуудлаар шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд иргэдийг оролцуулах, бодлогын хэрэгжилт, үйлчилгээний чанарыг иргэдээр үнэлүүлэх явдал бөгөөд энэ нь иргэдийн оролцооны хамгийн үр дүнтэй хэлбэр болдог.

Иргэдийн бодит оролцоо, төлөөллийн ардчиллыг хангахдаа хүний эрх, ардчилсан засаглал, оролцооны эрх, түүний ач холбогдол сэдвүүдээр малчид, ажилгүй иргэд, багш, эмчийн төлөөллөөс идэвхтэй манлайлах хэсгийг сонгосон зорилтот сургалтуудыг үе шаттайгаар 2009-2010 онуудад зохион байгуулсан. Сургалтуудын гол онцлог нь үйл ажиллагаанд суурилсан буюу “хийнгээ суралцах” сургалтуудын хөтөлбөрийг Мянганы Хөгжлийн 9 дэх зорилгод дэмжлэг үзүүлэх төслийн туслалцаатайгаар боловсруулан зохион байгуулсан. Үүний үр дүнд сонгосон иргэдийн төлөөлөл нь иргэний боловсрол олж иргэнлэг чанар, иргэний соёл эзэмшиж цаашид бусад иргэддээ нөлөөлж манлайлах чадварт суралцсан юм.

Иргэдийн оролцоогоо үр дүнтэй, тууштай бий болгоход нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж, үнэн зөв, хүртээмжтэй мэдээллээр хангаж өгөх нь чухал байдаг. Иймээс сумын ИТХ хурлын төлөөлөгчид, Засаг даргын тамгын газрын иргэдтэй өдөр тутам шууд харьцаж үйлчилгээ үзүүлдэг албан хаагчид, мэргэжилтнүүдэд яг ижил сэдвээр сургалт зохион байгуулсан. Мөн иргэдэд хүнс, бараа, тээвэр зэрэг өдөр тутмын хэрэгцээт үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийнхэнд иргэдэд зохион байгуулсан сургалтыг зохион байгуулж иргэд та бүхнээс авч байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар аюулгүй байдалд үнэлгээ өгч хянаж байх эрхтэй гэдгийг ойлгуулж, сумын тогтвортой хөгжилд оруулж байгаа хувь нэмэр тань хүний төлөө, таньж мэддэг ах дүүс, нутгийнхны төлөө юм гэдгийг ойлгуулахыг зорьсон. Иймд хувийн хэвшлийнхэн ардчилсан засаглалын тэгш, шударга боломжоор хангагдах, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэхдээ иргэд, ИНБ-тай түншилж ажиллах замаар үр дүнд

хүрнэ гэдгийг ойлгуулсан. Талуудад нэг зорилготой сэдэв, агуулга бүхий сургалтыг хийнгээ суралцах аргаар, орон нутгийн бодлогын ололт алдааны бодит кейс жишигэнд суурилан зохион байгуулсан тул бүх талууд сургалтын төгсгөлд түншилж ажиллах саналд хүрч “Хөгжлийн түншилэл” байгуулж ажиллах эхлэл тавигдсан.

Сургалтуудын зорилго, цаашидын үр нөлөөний талаар сумын FM радиогоор танилцуулах, сургалтад оролцсон иргэдээр яриулах, сургалтын үр дүнг сурталчлах, сургалтын үеийн фото зургаар самбар гаргаж сурталчлах, аль болох энгийн олон иргэдэд мэдээлэл хүргэж тэдгээрийн сонирхлыг татах замаар оролцоог өрнүүлэхийг зорьж байсан.

Жилийн эцсийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцэх асуудлын материалтай иргэдийн бүлэг Түншилэлээрээ танилцаж тодорхой саналуудлыг боловсруулж оруулж хэлэлцүүлэх хүртэл үр дүнтэй ажиллаж чаддаг болсон. Энэ бүх сургамж туршилагыг тус сумын Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон ЗДТГ хуримтлуулж иргэдтэйгээ хамтран ажилласнаар тус сумдад залуучуудын “Эрдэнэдалайн хөгжил” ТББ, ахмад настнуудын “Ивээл хавтага” ТББ байгуулагдсан бол багийн түвшинд малчдын “Дэвжих тэнхлэг” ТББ, суманд үйл ажиллагаа явуулдаг нийт 30 гаруй хувийн хэвилийн ААН байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчид нийлж сумын “Хувийн хэвилийн холбоо”-г тус тус байгуулагдан идэвхтэй ажиллаж байна.

Хөгжлийн түншилэлийн үр дүнд цагдаагийн өрөө, үйлчилгээний төв байгуулан иргэд хаашаанд нь ногоон бүс байгуулсан байна. Тус суманд олборлох үйлдвэрлэл эрхэлдэг “Хан дээж” болон “Хатан цацал” ХХК-дын үйл ажиллагааг хянах үүргийг ТББ-ууд нь хэрэгжүүлдэг байна. 2011 онд архинаас хамааралтай байсан 53 иргэн өөрсдийн санаачилгаар нэгдэн “Архинаас гарах хөдөлгөөн” өрнүүлж, сумын төвд ногоон байгууламж барих ажилд оролцох, иргэд өөрсдийн санаачилгаар уран сайхны тоглолт хийх зэрэг олон санал санаачилга өрнөж байна.

Ажилгүй, орлого багатай эмэгтэйчүүд эсгий, гар урлалын бүлэг байгуулан ажиллаж байна. ЗДТГ нь иргэддээ төсвийн мэдээллээ ил тод нээлттэй мэдээлдэг болж тухайн жилийн нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд туссан зарим чиг үүргийг ИНБ-аар гүйцэтгүүлдэг болсон ба төрийн албан хаагчийн утас, албан тушаал, ажил үүргийн хуваарийг нээлттэй болгосон зэрэг иргэд, ИНБ-ын оролцоог хангасан, мэдээллийг ил тод болгосон ажлууд тогтмолжоод байна. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын төлөөлөгчид жил бүр хүний эрх, засаглалын асуудлаар сургалт авч мэдлэг чадавхиа нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллаж байна.

Иргэдийн оролцоотой төлөвлөлт хийснээр Эрдэнэдалай сум нь махны чиглэлийн хонь, үхэр өсгөх, говийн бүсийн махны зорьтой болох зэрэг хэтийн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тус суманд байгуулагдсан олон талт Хөгжлийн түншилэлийн үр дүнд нийтлэг эрх ашгийнхаа төлөө үзэл бодлоороо ялгаатай янз бүрийн хүмүүс нэгдэж, хамтран ажилласанаар үр дүнд хүрэх боломжтойг баталж чадсан.

Мэдээлэл өгсөн: Н.Баярсайхан “Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн

Хоёрдугаар хэсэг

ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ИНСТИТУЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Л.Отгонтуяа

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Монгол улсад төсвийн харилцааг зохицуулж байсан хуулиудад 2010 оноос өөрчлөлт оруулан төсвийн шинэчлэлийг хийж эхлээд байгаа билээ. Энэ хүрээнд УИХ, Засгийн газраас Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Концессын тухай хуулиудад холбогдох журам, зааврыг батлан гаргаж, хэрэгжүүлж эхэлснээр төсвийн үйл явцад иргэдийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалт бүрдээд байна. Төсвийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн үйл явцад иргэдийг оролцуулах талаар дараах зарчмын шинжтэй заалтуудыг тусган хуульчилжээ. Үүнд:

- Төсвийн удирдлагын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх, төсвийн төвлөрлийг сааруулж орон нутагт төсвийн эрх мэдлийг шилжүүлэх үйл явцыг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн.(Хавсралт 4)
- Төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмын хүрээнд “төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах”-тай холбоотой 6 заалт бүхий зүйлийг оруулснаас гадна орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах асуудлаар 4 заалтыг тусгаж, мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай болон төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах чиглэлээр Засгийн газраас тусгайлсан журмуудыг гарган мөрдөж эхлээд байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулах эрх зүйн цоо шинэ зохицуулалтыг хуулинд оруулж сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах 20 сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болохоос гадна худалдан авах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийг өргөнөөр оролцуулах зарчмыг баримтлан ажиллах болсон юм. Энэхүү худалдан авах ажиллагааны журам, заавар, жишиг баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж мөрдүүлэхээр болж саяхан энэ журмыг батлаад байна.
- Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг заавал оролцуулах эрх зүйн нөхцлийг бүрдүүлсэн. Үүний зэрэгцээ хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах замаар захиалагчийн зүгээс явуулж буй худалдан авах үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилт, чанарт хяналт шинжилгээ, аудит хийлгэх ажлыг гүйцэтгүүлж болох бөгөөд журмыг төсвийн асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яамнаас тогтоож мөрдүүлэхээр болжээ.

- Орон нутгийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, иргэдийнхээ санал, хүсэлтийг авч тусган ИТХ-даа танилцуулж байх эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байна.

МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ БА ИЛ ТОД БАЙДАЛ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Төсвийн харилцааг зохицуулж буй суурь хууль болох Төсвийн тухай шинэ хуулинд төсвийн ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх үндсэн зарчмуудыг тодорхойлж эдгээр зарчмыг хэрэгжүүлэхдээ төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх, төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр танилцуулж байхыг үүрэг болгосон байна.

Хуулийн энэ зохицуулалтын дагуу Засгийн газрын 2012 оны 1 дугаар сарын 18-ны өдрийн 17 тоот тогтоолоор “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ыг баталжээ. Төсөв, санхүүгийн мэдээллийг олон нийтэд ил тод болгохтой холбоотой харилцааг зохицуулах энэ журамд “мэдээлэл нь иргэд, олон нийтэд нээлттэй байх бүхий л боломж, арга хэрэгслээр хангагдаж, төсвийн байгууллага мэдээллийг олон нийтэд тогтмол хугацаанд, тогтоосон стандартын дагуу үнэн зөв, ил тод байдлаар хүргэх, мэдээлэл нь тухайн жилийн батлагдсан төсөв болон Төсвийн тухай хуульд нийцсэн байх” зэрэг зарчмыг тусгаж өгсөн байна. Үүнээс гадна төсвийн байгууллагаас гаргах мэдээллийн бүтэц, мэдээллийг олон нийтэд хүргэх хугацаа, давтамжийг тогтоосон бөгөөд мэдээллийг олон нийтэд хүргэх арга хэрэгслийг тодорхойлж хэн, ямар мэдээллийг, хэзээ, ямар арга хэрэгслээр олон нийтэд мэдээлэхийг зохицуулсан юм. Гэвч журмын зорилго нь бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (төсвийн байгууллага)-ийн батлагдсан жилийн төсөв, түүний гүйцэтгэлийг олон нийтэд нээлттэй байлгах харилцааг зохицуулахад чиглэсэн тул төсвийн явцын мэдээлэл, тайланг ил тод болгох цаг хугацаа Төсвийн хуулийн зарим заалттай зөрчилдөхөд хүргэж байна.

Төсвийн төсөл, төлөвлөгөө, тайлантай холбоотой мэдээллийг нийтэд мэдээлэх хугацаа, арга хэрэгсэл нь удирдлагын түвшин бүрээр нарийвчлан гараагүй, төсвийн байгууллага мэдээллээ цахим хуудсаар олон нийтэд хүргэх нь эдийн засгийн хувьд харьцангуй хэмнэлттэй, үр ашигтай боловч орон нутгийн иргэдэд хүртээмж багатай байх талтай. Харин мэдээллийн самбар, хэвлэмэл хуудас, мэдээллийн бусад хэрэгслээр төсөв, санхүүгийн мэдээлэл хүргэх нь хүртээмжтэй байж болох ч хэвлэх, олшруулах, түгээх зардал их шаардахаас гадна мэдээлэл хуучирах, цаг хугацаандаа олон нийтэд хүрэхгүй байх эрсдэлийг мөн дагуулахаар байна. Төсвийн тогтвортой

байдлын тухай хуулинд нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг гаргах, тайлагнах, батлах, төсвийн богино, дунд хугацааны бодлого, стратеги зорилт, урт хугацааны чиг хандлагын төсөөлөл, тэдгээрийн агуулга, хэрэгжилт нь ил тод байх шаардлага тусгагдсан ч хэнд, хэрхэн тайлагнах талаар тодорхой заалт байхгүй, өгч байгаа мэдээлэл нь хэт нарийн, энгийн бус байгаагаас иргэд уншиж ойлгоход төвөг учрахаар байгаа юм.

Концессын тухай хуулинд концессын зүйлийн жагсаалтыг нийтэд мэдээлэх үүргийг нутгийн захиргааны байгууллагад үүрэг болгосон, түүнчлэн уралдаант шалгаруулалтын зар мэдээг түгээх, энэ талаар танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах зэргээр нийтэд мэдээлэл өгөх зэргээр мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр, хамааралтай хүмүүст нь хүргэхээр зохицуулжээ. Энэ хуулинд хэн, ямар мэдээллийг, хэнд, ямар механизмаар хүргэхийг тодорхой заасан боловч мэдээлэх хугацааг тодорхой тогтоогоогүй байна.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд сүүлийн жилүүдэд хэд хэдэн удаа өөрчлөлт оруулсныг дүнд худалдан авах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах заалтууд улам тодорхой болж байгаа бөгөөд цахим хуудас ажиллуулах, цахим тендэр шалгаруулалт явуулах зэрэг заалтууд нь худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, энэ үйл явцад иргэдийн оролцоог хангах нөхцлийг бүрдүүлсэн давуу талтай юм. Энэ хууль нь худалдан авах үйл ажиллагаанд оролцогч талуудад чиглэсэн, үр шимийг хүртэгч иргэн, ТББ-ын оролцоо хамгийн их шаардах ёстой хууль хэдий ч түгээх мэдээлэл нь бүрхэг, тодорхой бус, цаг хугацаандаа нийтийн хүртээл болоогүй бол өрсөлдөөнийг хязгаарласан үйлдлийг хөхиүлэн дэмжсэн байдалтай харагдах болно. Захиалагч, худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага болон орон нутгийн нэгж нь шаардлагад нийцсэн хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендэрт оролцогчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах энэ талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод гаргах үүрэгтэй. Энэ мэдээллийг худалдан авах ажиллагааны үе шат бүрт олон нийтэд хэрхэн өгөх талаар хууль, журамд тодорхой тусгаагүй байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулинд иргэдийн оролцооны үндэс болсон мэдээлэл, түүний ил тод байдлыг төрийн байгууллагуудын үйл ажиллагааны, хүний нөөцийн, төсөв санхүүгийн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн 4 үзүүлэлтээр гаргасан нь чухал ач холбогдолтой болжээ. Энэ хуулийн хүрээнд төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах мэдээллүүд болох эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл, үйлчилгээний ажилтан, албан хаагчдын хаяг, утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, өөрсдийн мөрдөж буй хууль, дүрэм журам, төсөл, хөтөлбөр зэргийг нээлттэй байлгах аар заасан байна.

Ардчилсан нийгэмд иргэд засгийн эрх барих эрхийг хэрэгжүүлэхэд нэгэн чухал хүчин зүйл бол тэдэнд төсвийг захиран зарцуулах, хянах эрхийг өгөх явдал байдаг. Иргэдийн дээрх эрхийг хангах үүднээс төсвийн ил тод байдлыг хангах үүргийг төрийн байгууллагуудад хүлээлгэсэн байна. Концессийн хуулийн 3.1 дэх хэсэгт заасан төрийн байгууллагууд концессын гэрээ, концессын зүйлийн жагсаалт,

гүйцэтгэх ажил үүрэг, үзүүлэх үйлчилгээний харилцааг зохицуулсан заалтыг мөн оруулсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг нийтийн эрх ашгийн төлөө зарцуулах ёстой учир эдгээр өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах шаардлагыг тусгажээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19-р зүйл, Монгол улсын Үндсэн хуулийн 16.1.17-д заасан мэдээлэл хайх хүлээн авах эрхийг хэрэгжүүлэхэд энэхүү хуулийн мэдээлэл авахтай холбоотой заалт чухал үүрэгтэй. Мэдээлэл өгөх гэсэн 14-р зүйлд төрийн байгууллагуудын мэдээлэл өгөх үүрэг, заавал нээлттэй байлгах мэдээллийн төрлүүд, мэдээлэлд хариу өгөх хугацааг тодорхой тусгасан байна. Онцгой нөхцөлд тодорхой мэдээллийг бусдад задруулахыг хориглосон заалтыг оруулж, мэдээллийн нууцын тухай асуудлыг нарийвчлан зааж өгсөн.

Төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангах журмаар Сангийн яамны зүгээс төсвийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын биелэлтийг жилийн эцсийн байдлаар гарган Засгийн газарт танилцуулж, өөрийн цахим хуудсаар мэдээлэх үүрэг хүлээлгэсэн нь жилийн эцэст төсвийн мэдээллийг олон нийтэд ил тод болгосон байдлыг улс орны хэмжээнд нэгтгэн дүгнэх боломжийг олгож байгаа сайн талтай юм. Гэхдээ төсвийн байгууллагууд, удирдлагын түвшин бүр мэдээллийг олон нийтэд хэрхэн хүргэж, ил тод болгон ажиллаж байгааг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлт, түүний хэрэгжилтийг хянах зохицуулалт хууль, журмуудад бага тусгагджээ. Төсвийн мэдээллийн ил тод байдлыг хэрхэн хангасныг төсвийн шууд захирагчдын үр дүнгийн гэрээг дүгнэх үед л үнэлж дүгнэхээс өөрөөр дүгнэх, хариуцлага хүлээлгэх боломж байхгүй байгаа тул үүнд иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс хяналт тавих, хариуцлага тооцох зохицуулалтыг бий болгох хэрэгтэй байгаа юм. Мөн төсөв батлагдахын өмнө буюу төсвийн төслийг боловсруулах явцад иргэдийн оролцоо маш чухал байдаг хэдий ч үүнийг тодорхой, нарийвчлан зохицуулж өгөөгүй байна.

Үнэлгээ

Төсвийн харилцаа, төсөв, санхүүгийн ил тод байдлыг зохицуулж буй хууль тогтоомжид тусгагдсаны дагуу төрийн байгууллагууд үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөц, худалдан авах үйл ажиллагаа зэргээ нээлттэй байлгах үүрэг хүлээсэн билээ. Төсвийн хуулийн иргэдийн оролцооны үндсэн зарчим нь орон нутгийн буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийн үйл явцад иргэдийн шууд оролцоог хангах юм. Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний 244 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын дагуу аймаг, Нийслэл, сум, дүүргүүд 2013 оны төсвийн төслөө боловсруулж, ИТХ-д өргөн мэдүүлж, орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутагт үйл ажиллагаа явуулдаг тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээгээр санхүүжих улсын төсвийн байгууллагын төсвийн захирагч жилийн төсвийн төслөө болон батлагдсан төсвөө дээд шатны байгууллагадаа хүргүүлэх, олон нийтэд мэдээлэх үйл явцыг хэрэгжүүлж эхлээд байна.

Төрийн албан хаагчид төсвийн мэдээллийг хууль, журмын дагуу ил тод болгож, олон нийтийг мэдээллээр хангадаг гэж үзэж байгаа хэдий ч мэдээлэх үйл явцын зарчмууд хэрэгжихгүй байх нь элбэг байна. Мэдээлэл хүргэх цаг хугацаа, байршил, мэдээлэл түгээх арга зам тодорхой байх тусам мэдээлэл үнэ цэнэтэй,

чанартай, хүртээмжтэй байна. Төсвийн мэдээллийг эрх бүхий байгууллагаас баталж, хүчин төгөлдөр болсны дараа ажлын 3-10 хоногийн дотор, мөн хагас, бүтэн жилийн давтамжтай тайлагнадаг төсвийн гүйцэтгэлийн тайланг тодорхой цаг хугацаанд тайлагнах, ил тод болгох заалттай, гэтэл эдгээр заалтууд хангалттай хэрэгжихгүй байна.

Мэдээлэх явцын зарчмууд Монгол Улсын 2013 оны төсвийн үйл явцад мөрдөгдсөнгүй. 2013 оны улсын төсвийг хэлэлцэх хугацаанд буюу 10-11 дүгээр сард <http://www.iltod.gov.mn/>²⁷ цахим хуудсанд дараах мэдээлэл тавигджээ. Үүнд:

- 2013 оны төсвийн төслийн танилцуулга
- 2013 оны нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд гэсэн хоёр файлаас өөр мэдээлэл байгаагүй.

УИХ-ын чуулганы байнгын хороодын ба нэгдсэн хуралдааны үеэр, төсвийг хэлэлцэж эхэлсэн хойно, эсвэл хэлэлцэж дууссаны дараа хэвлэл мэдээллээр 2013 оны Монгол улсын төсвийн дэлгэрэнгүй мэдээлэл, задаргаа, хөрөнгө оруулалтын жагсаалт нээлттэй болж байв. Хэлэлцүүлгийн явц хэвлэл мэдээллээр нээлттэй байсан²⁸.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар төсвийн төслөө боловсруулж дуусаад ИТХ-д өргөн барихын зэрэгцээ орон нутгийн иргэддээ нээлттэй мэдээлэх үүрэгтэй хэдий ч мэдээлээгүй, тухайн шатны төсвийн төслийг боловсруулахаас эхлээд нээлттэй байлгах заалт бүх аймаг, нийслэлд хэрэгжээгүй. Нийслэлийн 2013 оны төсвийн үйл явцад иргэдэд мэдээлэх үйл явцыг тоймловол: 2012 оны 11 дүгээр сарын 20-нд Нийслэлийн иргэний танхимаар 2013 оны төсвийн төслийг хэлэлцүүлсэн боловч төсвийн “том” тоонууд, томоохон хөрөнгө оруулалтуудыг тоочиж танилцуулсан. Хэлэлцүүлсэн нь сайн боловч задаргаа, нарийвчлал хангалтгүй учраас төрийн бус байгууллагууд, иргэд тодорхой мэдээлэл аваагүй, санал хэлж чадаагүй. 2012 оны 11 дүгээр сарын 29-нд нийслэлийн ИТХ-ийн VI хуралдаан (мөн л урьдчилан мэдээлээгүй) болж Нийслэлийн 2013 оны эдийн засаг, нийгмийн зорилт, нийслэлийн өмчөөс хувьчлагдах эд хөрөнгийн жагсаалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Концессын зүйлийн жагсаалт болон ирэх оны нийслэлийн төсөв зэрэг асуудлыг хэлэлцэн баталсан. Харин UBS телевизээр шууд бөгөөд бүрэн дамжуулсан. Төсвийн хэлэлцүүлгийн хугацаанд зөвхөн “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилт” гэсэн ганц баримт бичиг нийтлэгдсэн. Бусад нь нийтлэгдээгүй. ИТХ-ын төлөөлөгч нар цахим хаягаараа эдгээр төсвийг ИТХ-ын хуралдааны урьд шөнө 23.45 минутад авсан. Өглөө 8 цагт хурал эхэлсэн²⁹. “Дараа нь Нийслэлийн хэвлэл мэдээллийн албанаас “Улаанбаатар хотын ирэх оны төсвийн төслийг <http://www.ulaanbaatar.mn/>³⁰ цахим хуудаснаа иргэдэд нээлттэй мэдээлж, Нийслэлийн

²⁷<http://www.iltod.gov.mn/>

²⁸ Д.Цэрэнжав: Төсөв: Иргэдийн оролцоо ба Ил тод байдал “Төсвийн шинэтгэл, ил тод байдал, иргэдийн оролцоо” дугуй ширээний хэлэлцүүлэгт тавьсан илтгэл. 2013.01.22.

²⁹ ИТХ-ын төлөөлөгч Ц.Нарантуяагийн ярилцлага. UBS телевиз. 2012.11.29.

³⁰ <http://www.ulaanbaatar.mn/>

Иргэний танхимд хэлэлцүүлэг зохион байгуулж иргэдийн санал бодлыг авч нэгтгэсэн” гэж мэдээлсэн нь ташаа байсан юм³¹.

Харин сайн жишээний хувьд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл гадаад томилолтын зардлаа нийтэд мэдээлдэг болсон. Мэдээллийг цахим шууданд байршуулсан байдлыг Нийслэлийн хувьд судлан үзвэл 2013 оны төсвийг бүрэн эхээр нь <http://www.cityhall.mn/>³² сайтаас үзэж болохоор, ойлгомжтой хэлбэрээр байрлуулсан байна.

Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журмын мэдээлэх оролцоотой холбоотой заалтуудын хэрэгжилт эхлэлийн байдалтай. Аймаг, нийслэл, дүүргүүдийн сайтад төсвийн мэдээлэл дутуу орсон, заавал байршуулах ёстой самбарыг хийгээгүй, самбар байгаа ч түүндээ төсвийн мэдээллээ байрлуулаагүй байгууллагууд байсаар байна.

Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 264 тоот тушаалаар “Төрийн болон болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг батлан мөрдүүлж байгаа. Энэ журмаар хуулийн хүрээнд тухайн жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явцыг захиалагч байгууллага цаг хугацаа алдалгүй, шуурхай, үр ашигтай зохион байгуулахад шаардлагатай зохицуулалтаар хангаж байгаа юм. Журамд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө буюу тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг нийтэд зарлан мэдээлэх, тендэрийн урилга бэлтгэх, зарлан мэдээлэх, захиалагч байгууллагуудаас ирүүлсэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг <http://www.e-procurement.mn/>³³ цахим хуудсанд байрлуулах талаар тусгасан хэдий ч хэрхэн, яаж зохион байгуулах, худалдан авах ажиллагааны явцыг ямар хугацаанд мэдээлэх зэрэг зохицуулалтуудыг оруулаагүй байна.

Холбогдох цахим хуудсууд ажиллаж, мэдээлэл тавигдсан хэдий ч голдуу хуучин мэдээ байна. Хуулийн заалтуудыг зөрчин ил тод, нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр зарлан мэдээлэх үүргээ биелүүлээгүй байгууллага, ажилтанд тооцох хуулийн хариуцлага бусад хуулиар зохицуулагддаг ч гэсэн олон нийт үүнийг мэддэггүй. Эдгээр хуулийн заалтуудыг ил тод мэдээлэх, тухайн орон нутагт ямар ч үнийн дүнтэй худалдан авалт зарлагдаж байгааг ил тод болгох ажиллагаа хангалтгүй, худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын үүрэг хариуцлага, иргэдийн оролцоо, иргэний нийгмийн хяналтын талаар сайтар мэдээлж хэвшихгүй байна.

Орон нутагт мэдээллийг хязгаарлагдмал хүрээнд түгээдэг, нийтийн зар мэдээний самбар байхгүй, газар нутгийн байршлаас шалтгаалан тухайн худалдан авалтын зарыг сонсоогүй аж ахуйн нэгж, иргэн худалдан авах ажиллагаанд оролцож чадахгүй байх зэрэг олон дутагдлууд оршсоор байна. Шинээр байгуулагдсан

³¹ Д.Цэрэнжав: Төсөв: Иргэдийн оролцоо ба Ил тод байдал “Төсвийн шинэтгэл, ил тод байдал, иргэдийн оролцоо” дугуй ширээний хэлэлцүүлэгт тавьсан илтгэл. 2013.01.22.

³² <http://www.cityhall.mn/>

³³ <http://www.e-procurement.mn/>

Худалдан авах ажиллагааны газрын цахим хуудсанд сүүлийн 1 дүгээр сарын байдлаар “Шалгарсан тендерийн үр дүн” цонх ажиллахгүй, ойрын үед ямар тендер шалгаруулалт болсон талаар мэдээлэл авах боломжгүй байна.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны [http:// www.e-procurement.mn/](http://www.e-procurement.mn/) цахим хуудсанд 2012 оны 12-р сарын 13-нд шалгаруулсан тендерийн үр дүн өнөөдрийг хүртэл нийтлэгдээгүй байна³⁴.

Энэ бүгдээс дүгнэхэд улс, орон нутгийн төсвийг батлахаас нь өмнө буюу төлөвлөгөө, төслийг нь боловсруулахаас эхлэн олон нийтэд ил тод болгох эрмэлзэл, соёл, механизм дутагдаж байгаагаас иргэдийн оролцоо хангалтгүй байна гэж үзэж болох юм.

ЗӨВЛӨЛДӨХ ОРОЛЦООНЫ ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Төсвийн харилцаа, төсөв санхүүгийн мэдээллийг ил тод болгохтой холбоотой харилцааг зохицуулжбуй хуулиудыг шинжилж үзэхэд төсөвтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд иргэдээс санал авах талаар зөвхөн Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд, түүнчлэн баг, хорооны иргэдийн нийтийн хурлаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод нээлттэй санал асуулга явуулах, иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэх талаар зөвхөн Төсвийн тухай хуулийн 63-р зүйлд тусгасан байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 60.3.6.-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”-г орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг хориглосон, мөн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 7.1.4-т “олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ыг батлан мөрдүүлэхээрболсон нь иргэдийн оролцоог хангах талаарх шинэлэг зүйл болжээ. Зөвлөлдөх оролцооны механизм хуульд тусгагдсанаар орон нутгийн иргэд төсвийн үйл явцад зөвлөлдөх оролцооны эрх нь нээгдэж байгааг харуулж байна.

Зөвлөлдөх оролцооны явцад гарсан санал, хамтаараа гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхгүй бол хуулийн заалтууд үнэ цэнэгүй болох тул иргэдтэйгээ зөвлөлдөхгүй, тэднээрхэлэлцүүлэх шийдвэр гаргасан этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх заалт хууль тогтоомжид тусгагдаагүй юм. Үүнийг мөн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хуулийн заалтуудтай уялдуулахгүй бол хэрэгжихгүй байх үндэслэлтэй.

Төсвийн хөрөнгөөр гол санхүүжилтийг нь хийж байгаа Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Концессын хуулинд зөвлөлдөх оролцооны талаар тодорхой заалт тусгаагүй байна.

³⁴ Г.Цэцгээ: Худалдан авах үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо хяналтыг бий болгох “Төсвийн шинэтгэл, ил тод байдал, иргэдийн оролцоо” дугуй ширээний хэлэлцүүлэгт тавьсан илтгэл. 2013.01.22

Үнэлгээ

Шууд зөвлөгөөнөөр иргэдийн санал хүсэлтийг шууд мэдэх боломжтой, гэхдээ хүмүүсийн санал тэр бүр шийдвэрт тусгагдахгүй байх явдал их байна. Зөвлөлдөх оролцооны хэлбэр Улаанбаатар хотод сайн хэрэгжиж байна. Тухайлбал, хороод дээр иргэдийг оролцуулан “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн 2013 оны төсвийг хэлэлцэхэд Хан-Уул дүүргийн 16-р хорооны иргэд хамтаараа өөрсдийнхөө асуудлыг хэнээс ч асуухгүй шийдэж чадсан байна. Хан-Уул дүүргийн нийт 16 хороо 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилттэй “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгийг хорооны Иргэдийн Нийтийн Хурлаараа хэлэлцэн шийдвэрлэсэн байна³⁵.

Энэ мэтчилэн анхан шатны нэгжид төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төсөвлөх, орон нутагтаа тавигдах замыг хаагуур явуулах вэ гэдгийг иргэдээсээ сонсдог иргэдийн шууд оролцооны хэлбэрүүдийг илүүтэй хэрэглэж эхэлсэн байна. Харин салбарын яам, агентлаг, төрийн өмчит компаниудын төсөв хөрөнгийг төсөвлөх, оролцох “олон нийт” гэж байхгүй, иймээс төсвийн зарцуулалтанд хөндлөнгийн оролцоо, асуух зөвлөлдөх иргэн байдаггүй. Энэ тохиолдолд тухайн салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй судлаачид, ТББ, судалгааны байгууллагын санал, зөвлөмжийг авах нь зүйтэй³⁶.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн *гомдол гаргах, гомдлыг хянан шийдвэрлэх* талаарх заалтанд холбогдох хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор зарим аж ахуй нэгж, байгууллага өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх журмыг баримтлан мөрддөг. Ихэвчлэн эдгээр хуулиар энэ харилцааг зохицуулдаг. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Монгол улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудаар энэхүү заалтын хэрэгжилт зохицуулагдаж байна.

Төсвийн тухай хуулийг дагаж гарах журмууд (сумын дүрэм, баг хорооны дүрэм, ИНХ-ын журам, орон нутгийн хөгжлийн сангийн журам, иргэдийн санаачилгаар явуулах санал асуулгын үлгэрчилсэн журам)-ыг яаралтай батлуулан мөрдүүлж, зөвлөлдөх оролцооны механизмыг бий болгохгүй бол төрийн байгууллага, албан хаагчид зөвлөлдөх гэдгийг өөр өөрөөр ойлгож, янз бүрийн арга замаар хэрэгжүүлж байна. Иймээс 2013 оны эхний улиралд багтаан хэлэлцүүлэн батлах албан даалгаврыг гаргаж аймаг, орон нутгуудад хүргүүлэх, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэгт төлөөллийг зөв оролцуулах, ямар асуудлаар хэлэлцүүлэг хийхэд хүн амын ямар төлөөлөл байх, хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настан, тэтгэврийн иргэд, хүүхдээ асарч байгаа эхчүүд, ажилгүй иргэд зэрэг нийгмийн болон насны бүлгээс тэгш оролцоог хангахгүй бол хэлэлцүүлэг үр дүнгүй болно, мэдээллийг зөв, тэнцвэртэй, тодорхой цаг хугацааны нөөцтэй түгээж байж олон нийтийн нээлттэй

³⁵ <http://www.news.mn/>. 2013.02.06

³⁶ Д.Цэрэнжав: Төсөв: Иргэдийн оролцоо ба Ил тод байдал “Төсвийн шинэтгэл, ил тод байдал, иргэдийн оролцоо” дугуй ширээний хэлэлцүүлэгт тавьсан илтгэл. 2013.01.22

санал асуулга явуулахгүй бол эрэмбэлж буй асуудлууд зөв бодитой гарахгүй, оролцооны ач холбогдол байхгүй болно.

ИДЭВХИТЭЙ ОРОЛЦООНЫ ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Төсвийн үйл явц дахь иргэдийн идэвхитэй оролцооны асуудал нь Төсвийн хуулийн 6.5.2, 6.5.6 дахь заалтуудад төсвийн ил тод байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэх, мөн 63.1, 63.2 дахь заалтад орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах асуудлаар ИНХ-д саналаа өгөхтэй холбоотой асуудал тусгагдсан байна. Харин Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2011 онд орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд “Худалдан авах ажиллагаан дахь олон нийтийн оролцоо” гэсэн 7 дахь зүйл, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг зохицуулсан 47.4 дэх заалтуудад тусгалаа олжээ. Концессын тухай хуульд уралдаант шалгаруулалтад оролцогчидтой холбоотой заалт тусгагдсан боловч иргэдийн идэвхитэй оролцооны талаар зохицуулалт тусгагдаагүй байна.

Бодит байдал дээр хамгийн чухал гэж үздэг орон нутгийн төсвийг хэлэлцэж батлах, улсын төсвийг хэлэлцэн батлах, зарцуулах үйл явцад, түүнчлэн ИТХ-ын хуралдаанд иргэд биечлэн оролцох эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Иргэд өөрсдийн сонгосон УИХ-ын гишүүд, иргэдийн хурлын төлөөлөгчдөөр дамжуулах буюу төлөөллийн ардчиллын зарчмаар л төсвийг хэлэлцэн батлах үйл явцад оролцох боломжтой юм. Хууль, журам тогтоох, төсөв батлах эрх бүхий хүмүүст иргэд, иргэний нийгмийн төлөөлөл хандаж санал хүсэлтээ илэрхийлж, тэдгээрийг цааш уламжлан шийдвэр гаргахдаа харгалзан үзэх нь уламжлалт практик бөгөөд үүнийг орон нутагт шууд оролцооны хэлбэрээр өөрчлөх ажлыг эхлээд байгаа билээ.

Иргэд орон нутгийн төсвөө төлөвлөхөд оролцон саналаа илэрхийлж, хэлэлцүүлэгт орсноор мэдээлэлтэй болно, чадваржина, улмаар эрх мэдэлтэй болно. Гэвч Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад орсон шинэ заалтууд дөнгөж хэрэгжиж эхлэх шатандаа байгаа тул төсвийн цаглабарын дагуу төсвийн үйл явц, худалдан авах ажиллагаанд оролцох боломжууд нь зарим талаараа хязгаарлагдмал байна.

Түүнчлэн иргэд Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжилт авч, бага хэмжээний өртөгтэй ажлыг гэрээгээр гүйцэтгэх эрх зүйн үндэс баталгаажсан хэдий ч худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилтийг хангахад иргэдийн нэг баг оролцох нь ашиг сонирхолын зөрчил үүсгэх магадлалтай юм. Иймээс тухайн орон нутгийн худалдан авах ажиллагаан дахь нийт иргэд, олон нийтийн идэвхитэй оролцоог хангах нь чухал ач холбогдолтой болно.

Үнэлгээ

2009 оноос зарим аймгуудын иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ нь ЗДТГ, ИТХ-тай түншлэлийн гэрээ байгуулж, төлөөллөө үнэлгээний хороонд оруулж эхэлсэн байна. Үүнд хандивлагч орнууд, манай улсад үйл ажиллагаа хэрэгжүүлж буй олон улсын байгууллагуудын хүчин чармайлт, хэрэгжүүлж буй төслүүд гол үр нөлөө үзүүлсэн. “Худалдан авах ажиллагааны төлөө түншлэл” сүлжээ 2010 оны 5 дугаар

сард “Нийгмийн хариуцлагын төлөөх түншлэл” Сүлжээний дэд сүлжээ болон байгуулагдсанаас эхлэн арав гаруй ИНБ-ыг нэгтгэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Орон нутагт хийгдэх зарим ажлууд, тухайлбал явган зам тавих, гэрэлтүүлэг тавих гэх мэт ажлуудад тэнд амьдардаг иргэд өөрсдөө оролцож, тодорхой цалин хөлс авах гэх мэт зохицуулалтууд орон нутгуудад хийгддэг. Энэ нь Тогтвортой амьжиргаа төслийн хүрээнд 5 хүртэл сая төгрөгийн өртөгтэй ажлыг иргэдийн бүлгээр гүйцэтгүүлж ирсэн туршлагаас улбаатай. Үүнийг улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилттэйгээр гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн учир иргэдийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмыг эхнээс нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах нь чухал болоод байна.

ХЯНАЛТЫН ОРОЛЦООНЫ ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Төсвийн тухай хуулийн 6.5.3, 6.5.4-т “төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэх, төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах”, 10.2-т “Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын төлөвлөлтийг сайжруулах, түүний тайлагналт, ... олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зорилготой татвар төлөгчдийн төлөөлөл бүхий төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод болон салбарын эрдэмтдээс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус төсөв, санхүү, эдийн засгийн үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд байгуулж ажиллуулна” гэж заасан байна. Хуулийн энэ заалтад тусгагдсан үндэсний зөвлөл нь төсвийн төсөл болон улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ Засгийн газарт хүргүүлэх үүрэгтэй бөгөөд хийх ажлыг нь тодорхой зааж өгчээ.

Үүнээс гадна иргэд ИТХ-аараа дамжуулан Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн төсвийн төслийн хэрэгжилтэд хяналт тавих эрхийг хэрэгжүүлж болох талтай. Гэвч өнөөгийн байдлаар энэ төрлийн хяналт хангалттай түвшинд хэрэгжихгүй байгаа юм. Харин Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52.3 дахь заалтын дагуу хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагууд сонгон шалгаруулалтад оролцож, захиалагчийн худалдан авах ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, аудит хийж болохоор болсон. Ийнхүү худалдан авах ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангаснаар худалдан авах ажиллагааны ил тод байдал, үр дүн сайжирч, авлига буурах, төрийн үйлчилгээний чанар дээшлэх, Засгийн газарт итгэх иргэдийн итгэл нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Түүнчлэн Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 301 тоот тушаалаар “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ыг шинэчлэн баталж гаргасан бөгөөд энэхүү журмын 2.2-д “Хуулийн 47.6-д заасны дагуу Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах

ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх бөгөөд хуулийн 47.4-т заасан төлөөллийг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд заавал оруулна” гэж заасан байна. Энэ нь худалдан авах ажиллагаанд иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах замаар төсвийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын үр ашиг, үр дүн, ашиг тусыг нэмэгдүүлэхэд тустай арга хэмжээ болох нь дамжиггүй. Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах, захиалагчийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, аудит хийх иргэний нийгмийн төлөөллийг чадавхижуулах нь нэн тэргүүний зорилт болоод байна.

Үнэлгээ

2008 онд “Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газрын 93 тоот тогтоол батлагдсан. Үүнд “Засгийн газраас Иргэний нийгмийн зөвлөлтэй хамтран ажиллах гэрээ”-г зарчмын хувьд дэмжиж, түүнд гарын үсэг зурахаар шийдвэрлэснээс гадна Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсвийн гүйцэтгэлд мониторинг хийх үйл ажиллагаанд төрийн бус байгууллагуудыг оролцуулах нөхцөл бүрдүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, түүний явц, үр дүнг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тогтоолын хэрэгжилтийг улсын хэмжээгээр нэгтгэн, дүнг жил бүрийн II улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад тус тус даалгажээ. Ийнхүү Төрийн бус байгууллагууд төсвийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж гэрээ, түншлэлийн хэмжээнд биеллээ олсон байна³⁷.

Иргэд, ИНБ-ууд хяналт, мониторинг хийх замаар төсвийн үйл явцад оролцох талаар 2006 оноос эхлэн донор байгууллагууд, олон улсын төсөл, хөтөлбөрийн шугамаар олон ажлууд хийгдэж байна. Үүнд маш олон хүний цаг хүч хөдөлмөр, ихээхэн хөрөнгө зарцуулсан. Арав орчим жилийн үйл ажиллагааны үр дүнд “мониторинг, хяналт гэдэг нь татвар төлөгч иргэний хувьд байх ёстой зүйл нь, эдлэх ёстой эрх нь юм” гэдгийг төрийн байгууллага, албан хаагчид ухамсарлан ойлгож байна. Гэвч хэрэгжилт хангалттай сайн биш. Иргэдийн хяналт, оролцооны талаар хуульд “боломжоор хангах” гэдэг утга илүү тусгаж өгсөн байна. Иргэдийн хяналт оролцооны талаар хэрэгжиж буй үйл ажиллагаа, гарч буй санаачлагууд:

- *Төрийн бус байгууллагуудын мониторинг:* Иргэний нийгмийн идэвхитэй хэсэг болсон төрийн бус байгууллагууд тодорхой аргачиллын дагуу төсвийн мэдээлэл цуглуулж дүгнэлт, зөвлөмж гаргах нь оролцооны ихээхэн үр дүнтэй арга юм. Манайд орон нутгийн төрийн бус байгууллагууд амжилттай ажиллаж байна.
- *Иргэн төсвөө хянана” сүлжээ, “Ил тод байдал” сан ТББ* төсөвт шинжилгээ хийх замаар оролцдог.
- *ТАН (төлсөн авснаа нийтэл) эвсэл* байгалийн баялаг ашиглаж байгаа уул уурхайн компаниудын орон нутгийн төсөв, татвар, хураамж, хандивт төлсөн мөнгө, орон

³⁷ Д.Цэрэнжав: Төсөв: Иргэдийн оролцоо ба Ил тод байдал “Төсвийн шинэтгэл, ил тод байдал, иргэдийн оролцоо” дугуй ширээний хэлэлцүүлэгт тавьсан илтгэл. 2013.01.22

нутгийн засаг захиргаа, төрийн байгууллага, албан хаагчид дээрх хэлбэрээр авсан мөнгөө ил тод болгож, нийтэд мэдээлэхийн төлөө нөлөөлөл, мониторингийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

- “Шилэн түрийвч” аян. Гол төлөв сургууль, цэцэрлэг, эмнэлэг, мөн төсвийн зарим байгууллагын төсвийг эцэг эх, эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдэд нээлттэй болгон танилцуулж хяналт тавих боломж олгодог. Хэдэн жилийн өмнө нийслэлийн Баянзүрх, Багануур дүүрэг, зарим аймагт амжилттай хэрэгжүүлсэн туршлага бий.
- *Иргэний танхимын хэлэлцүүлгүүд*: 2010 оноос Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Төрийн ордноос эхлээд нийслэл Улаанбаатар, түүнийг дүүрэг, аймаг, суманд байгуулагдсан Иргэний танхимуудад төсвийн бодлого, төлөвлөлтийн асуудлаар янз бүрийн түвшний хэлэлцүүлэг болж иргэд, судлаачид голлон оролцдог болсон.

Ийнхүү иргэд татвар төлөгчдийнхөө хувьд оролцоот хяналтын арга хэлбэрүүдийг ашиглаж эхэлсэн. Төсөвт ихээхэн хувь нэмэр оруулдаг бизнес эрхлэгчдийн зүгээс ч сонирхол, хүчин чармайлт сул байна.

Үнэлгээний хороонд ажиллах Иргэний нийгмийн төлөөлөл худалдан авах ажиллагааны сургалтад сууж сертификат авсан байна. Мөн иргэний нийгмийн төлөөлөл нь үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах буюу саналын эрхтэй байна. Үнэлгээний хороонд захиалагч Иргэний нийгмийн төлөөллийг яаж сонгож оруулах нь тодорхой бус байна. Өнөөдрийн байдлаар УБ хот, 12 аймагт хийсэн судалгаагаар 110 орчим ИНБ-ууд ХАА-ны анхан шатны мэдлэг олгох, сертификаттай сургалтад хамрагдсанаас 64 хүн сертификат авсан байна. Гэтэл аймаг, нийслэл, дүүргүүд, төсвийн байгууллагууд, төрийн өмчит байгууллагууд, яамд, ХААГ дээр тендэр зарлагдаж, үнэлгээний хороонд ажиллах шаардлага хангасан Иргэний нийгмийн төлөөллийг хаанаас, яаж авахаа мэдэхгүйд хүрч байна. Иргэн энэхүү үнэлгээний хороонд орж ажиллах эрх нээлттэй бөгөөд энэ тохиолдолд гэрчилгээ авсан байхыг шаардаж байгаа юм. Мөн журмын 3.10-д “Захиалагч үнэлгээний хороонд ажилласан төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлд ажилласан цагийг нь харгалзан урамшуулал олгож болно” гэсэн заалтыг оруулж өгсөн ч урамшууллыг ямар эх үүсвэрээс хэрхэн зохицуулах талаарх асуудал бүрхэг хэвээр байгаа ба захиалагч хүсэхгүй бол урамшууллыг өгөхгүй ч байх тохиолдол харагдаж байна.

Хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр хуулийн 52.3 дахь хэсэгт “Хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагыг энэ хуулийн 35-39 дүгээр зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж, захиалагчийн үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, аудит хийлгэж болно” гэсэн заалт орсон байгаа нь хувийн хэвшлийн болон мэргэжлийн ТББ-ыг “Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам”-ын дагуу сонгон шалгаруулж, захиалагчийн худалдан авах ажиллагаанд болон тендэрт шалгарсан компанийн гэрээний гүйцэтгэлийн үе шатанд, эсвэл гэрээгээр ажил гүйцэтгэж дууссаны дараа тухайн ажил, үйлчилгээний чанарт мониторинг хийнэ гэсэн үг юм. Гэвч одоогоор энэ заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдож, мониторингийг хэрхэн, яаж төлөвлөх, хичнээн тендерийн хэдэд мониторингийг зөвлөх үйлчилгээний гэрээгээр хийлгэх, төсвийг нь хаана тусгах,

батлах талаар ямар нэг дагаж мөрдөх журам байхгүй бүрхэг хэвээр байна. Засгийн газар энэ үйл ажиллагааг зохион байгуулах журмыг нарийвчлан гаргаж мөрдсөн тохиолдолд худалдан авах ажиллагааны үйл явцад иргэд, эцсийн хэрэглэгчийн оролцоо, хяналтын механизм бий болж, төрийн зарим чиг үүргийг Иргэний нийгэм, хувийн хэвшлээр гэрээлэн гүйцэтгүүлэхэд бодит алхам болохын хамт төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжрахад ихээхэн ач холбогдолтой.

Дүгнэлт

Монгол улс дахь төсвийн харилцаа, төсвийн мэдээллийн ил тод байдлыг хангах харилцааг зохицуулж буй хууль, журмуудыг бүхэлд нь авч үзвэл иргэдийн оролцоонд тулгуурласан төсвийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн боловч хуулийн заалтууд нэлээд ерөнхий, тэдгээрт нийцүүлэн гаргасан журмуудыг хэрэгжүүлэх механизм хангалтгүй байна.

Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журмын мэдээлэх оролцоотой холбоотой заалтуудын хэрэгжилт эхлэлийншатандаа байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн цахим хуудсанд байрлуулсан төсвийн мэдээлэл дутуу орсон, хуучирсан, төсвийн байгууллагууд заавал байршуулах ёстой самбарыг хийгээгүй, самбар байгаа ч түүндээ төсвийн мэдээллээ байрлуулаагүй байх нь элбэг байна. Энэ нь төсвийн мэдээллийг цахим хуудсанд байрлуулах талаар хууль, журамд тусгасан хэдий ч хэрхэн, яаж зохион байгуулах, худалдан авах ажиллагааны явцыг ямар хугацаанд мэдээлэх зэрэг зохицуулалтуудыг оруулаагүй, хуулийн заалтуудыг зөрчин ил тод, нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр зарлан мэдээлэх үүргээ биелүүлээгүй байгууллага, ажилтанд тооцох хуулийн хариуцлага тодорхой бус, улсын болон орон нутгийн төсвийн төслийг боловсруулах, батлуулахаар өргөн барихаас эхлэн олон нийтэд ил тод болгох эрмэлзлэл, соёл, механизм дутагдаж байгаатай холбоотой.

Зөвлөлдөх оролцооны механизм Төсвийн тухай хуульд тусгагдсанаар орон нутгийн иргэд төсвийн үйл явцад оролцож саналаа илэрхийлэх эрх нь нээгдэж байгаа ч иргэдээс гарсан санал, хамтаараа гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхгүй бол хуулийн заалтууд үнэ цэнэгүй болох юм. Түүнчлэн иргэдтэйгээ зөвлөлдөхгүйгээр шийдвэр гаргасан этгээдэд хүлээлгэххариуцлагын талаарх заалт хууль тогтоомжид тусгагдаагүй бөгөөд үүнийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хуулиудтай уялдуулан зохицуулалт хийхгүй бол хэрэгжихгүй байх үндэслэлтэй.

Идэвхтэй оролцооны хувьд авч үзвэл бодит байдал дээр хамгийн чухал гэж үздэг улсынболон орон нутгийн төсвийг хэлэлцэж батлах, зарцуулах үйл явцад, түүнчлэн ИТХ-ын хуралдаанд иргэд биечлэн оролцох эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Иргэд өөрсдийн сонгосон УИХ-ын гишүүд, иргэдийн хурлын төлөөлөгчдөөр дамжуулах буюу төлөөллийн ардчиллын зарчмаар л төсвийг хэлэлцэн батлах үйл явцад оролцох боломжтой юм. Үүнийг цаашид иргэдийн шууд оролцооны хэлбэрээр өөрчлөх ажлыг орон нутагт эхлүүлээд байна. Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад

орсон шинэ заалтууд дөнгөж хэрэгжиж эхэлж байгаа тул төсвийн цаглабарын дагуу төсвийн үйл явц, худалдан авах ажиллагаанд оролцох боломжууд нь хэрэгжүүлэх механизм, иргэн, ИНБ-ын чадавхи талаасаа хязгаарлагдмал байна.

Иргэд, ИНБ-ууд хяналт, мониторинг хийх замаар төсвийн үйл явцад оролцох талаар сүүлийн жилүүдэд донор байгууллагууд, олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр олон ажлууд хийгдэж байна. Эдгээр ажлуудыг хэрэгжүүлсний үр дүнд төрийн байгууллага, албан хаагчид хяналтын оролцоо чухал гэдгийг ухамсарлан ойлгож байгаа нь сайшаалтай ч хяналтын оролцооны хэрэгжилт хангалттай сайн биш байна. Иргэдийн хяналт, оролцоог хангахад чадавхижсан байгууллагуудыг илүүтэй ажиллуулах, төсвийг хянах үйл ажиллагаанд оролцох байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгдөг байх, судлаачид, шинжээчид, иргэд, ИНБ-уудыг судалгаа, шинжилгээний ажилд өргөнөөр оролцуулах, худалдан авах ажиллагааны үйл явцад хяналт шинжилгээ, аудит хийх мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудыг чадавхижуулах ажлыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Төсвийн үйл явцад иргэдийн оролцоог хангахтай холбоотойбатлан мөрдөж буй хууль, журмуудын хэрэгжилтийг хянах, үнэлэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог нарийвчлан тодорхойлоогүй бөгөөдхуулиуд хоорондын уялдаа бүрэнхангагдаагүйбайна. Төсвийн мэдээллийг ил тод болгосноор иргэдээс санал авах боломжийг олгох зарчмыг баримтлахаар хуульчилсан ч оролцоог хангах талаар төсвийн тухай хуульд зөвхөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зориулалтын талаар иргэдээс санал авч, ИНХ-аар хэлэлцэж эрэмбэлэх зохицуулалт л тусгагджээ.

Цаашид төсвийн үйл явцад иргэдийн оролцоог үр дүнтэй хангахын тулд өмнө авч үзэж судалсан иргэдийн оролцооны 4 элементийг төсвийн болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох хууль тогтоомжид иж бүрнээр оруулж, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг нарийн тодорхой хуульчилж өгөх шаардлагатай байна. Ялангуяа төсвийн асуудлаар шийдвэр гаргахад мэдээлэл авах, шийдвэр гаргах үйл явц дахь олоннийтийн оролцоо, төсвийн үйл явцын ил тод байдлыг хангах ажлыг цогц байдлаар хоорондоо зөрчилгүйгээр зохион байгуулдаг болох нь чухал юм.

Санал, зөвлөмж

- Төсвийн төсөл, төлөвлөгөө, явцын мэдээлэл, тайланг олон нийтэд ил тод болгох цаг хугацаа, хариуцах этгээд, хэлбэр, агуулгыг төсвийн тухай болон бусад хууль тогтоомжид тодорхой, хоорондоо зөрчилгүйгээр тусган хуульчилж холбогдох журам, зааврыг гарган ягштал хэрэгжүүлдэг болох;
- Төсвийн мэдээллийг олон нийтэд цаг хугацаанд нь, хүртээмжтэй, зардал багатайгаар хүргэх арга хэрэгслийг төв, орон нутагт ялгаатай байхаар тодорхойлох;
- Төсвийн мэдээллийг эхний удаад хууль тогтоомжид заагдсаны дагуу ил тод болгосны дараа иргэдэд энгийн ойлгомжтой, хялбар байдлаар хүргэдэг болох;

- Төсвийн талаар хэвлэлийн хурал, танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах зэргээр нийтэд мэдээлэл өгөх замаар мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр, хамааралтай хүмүүст нь хүргэх зохицуулалтыг бий болгох;
- Захиалагчийн зүгээс зохион байгуулж байгаа худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг худалдан авах ажиллагааны үе шат бүрт олон нийтэд хэрхэн өгч ил тод байдлыг хангах талаар хууль, журамд илүү тодорхой тусгах;
- Яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, төсвийн байгууллагуудын цахим хуудсан дахь төсвийн мэдээллийг хуульд тусгагдсан цаг хугацаанд нь болон тухай бүр шинэчлэн өмнөх мэдээлэлтэй харьцуулан үзэх боломжоор хангахын зэрэгцээ мэдээллийг ил тод болгосон эсэхийг хянаж үнэлэх үүргийг хэн, хэрхэн гүйцэтгэхийг тодорхойлж, мэдээллийг ил тод болгоогүйн төлөө хүлээлгэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид нарийвчлан оруулах;
- Төсвийн тухай хуульд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зориулалтын талаар иргэдээс нээлттэй санал асуулга авах, ИНХ-аар хэлэлцэж эрэмбэлж шийдвэр гаргах зохицуулалтыг л тусгасан байгаа тул санал асуулга, хурал болон хэлэлцүүлэгт тухайн баг, хорооны иргэдийн, эсвэл өрхийн хэдэн хувь нь оролцож саналаа өгвөл хүчинтэй байх талаар тодорхой журамлах;
- Зөвхөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зориулалтын талаар иргэдээс санал авахаас гадна орон нутгийн суурь орлогыг бүрдүүлэх, суурь зарлагыг төлөвлөх асуудлаар иргэдэд тодорхой мэдээлэл, танилцуулгыг хүргүүлж, чухам ямар чиглэлээр саналыг нь авахыг урьдчилан мэдэгдэж, тодорхой хугацааны (0.5-1 сарын) дараа санал авах ажлыг зохион байгуулдаг болох;
- Улсын болон орон нутгийн төсвийн төсөлд иргэд, ИНБ-ууд, судлаачдын саналыг авч, тэднээр хэлэлцүүлэх журмыг тодорхой болгож, журамлах;
- Төсвийн төслийг боловсруулах, бэлтгэх явцад иргэдийг өргөнөөр оролцуулан тодорхой асуудлаар саналыг нь авах цаг хугацаа, механизмыг ялангуяа орон нутгийн түвшинд нарийвчлан тодорхойлж, хэрэгжүүлэх;
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах захиалагчийн зүгээс үнэлгээний хороог ажиллуулахад бүрэлдэхүүнд нь мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, тухайн чиглэлийн төрийн бус байгууллагыг төлөөлж оролцох гишүүн, орон нутагт ИТХ-аас санал болгон оруулах иргэнийг худалдан авах ажиллагаагаар мэргэшүүлэн чадавхийг нь дээшлүүлэхэд холбогдох байгууллагууд дэмжлэг үзүүлэх;
- Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцлийг хангахын зэрэгцээ иргэдэд холбогдох мэдээллийг өгч энэ чиглэлээр өмнө нь Тогтвортой амьжиргаа төслийн хүрээнд ажиллаж байсан туршлага бүхий иргэд, идэвхижүүлэгч, хянагчдыг дайчлан ажиллуулахад сум, дүүргийн удирдлагууд анхаарах;
- Төрийн бус байгууллага, иргэдийн зүгээс төсвийн үйл явцад хяналт, мониторинг хийх өмнөх сайн туршлагауудад тулгуурлан чадавхижсан байгууллагуудыг ажиллуулах, шинээр энэ үйл ажиллагаанд оролцох байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгүүлэх замаар хяналт тавих оролцоог өргөжүүлэх;

- Улсын болон орон нутгийн төсөв, байгууллагын төсөвт шинжилгээ хийх замаар иргэдийн хяналтыг бий болгох;
- Судлаачид, шинжээчид, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын хийж гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний тайлан, зөвлөмжийг олон нийтэд танилцуулан хэлэлцүүлж, үр дүнг холбогдох этгээдүүдэд хүргүүлэн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлж, шийдвэр гаргуулдаг болох;
- Захиалагчийн худалдан авах үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, аудит хийх мэргэжлийн холбоод, ТББ-уудыг чадавхижуулах ажлыг Сангийн яам болон Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагууд хариуцан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах;
- Төсвийн үйл явц, худалдан авах ажиллагаанд хяналт тавих ажлыг гэрээлэн гүйцэтгүүлэхэд шаардагдах төсвийн санхүүжилтийг холбогдох байгууллагуудын жил бүрийн төсөвт тусган баталдаг болох нь зүйтэй.

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Б.Баярмаа

Монгол улсын шинэ Үндсэн хууль 1992 онд батлагдаж “Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, ан амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, “...байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” гэж заасан нь иргэдийн байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, түүний талаар зөвлөлдөж, шийдвэр гаргахад оролцох, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх, байгаль орчныг хамгаалахад оролцох үүргийг хуульчлах суурийг тавьсан юм. 1992 онд Бразилийн Рио-де-Жанейрод чуулсан “Байгаль орчин ба хөгжил” сэдэвт НҮБ-ын дээд хэмжээний чуулганаас батлан гаргасан “Даян дэлхийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-т үндэслэн Монгол улс өөрийн орны онцлогт нийцсэн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр боловсруулж баталсан.

Ийнхүү шинэ Үндсэн хуулиа баталж, байгаль орчны олон улсын конвенцид нэгдэн орж эхэлснээр Монгол улсын байгаль орчны бодлого, хууль эрх зүйн орчны шинэчлэлт эхэлсэн гэж судлаачид үздэг. 1992-1996 онд Байгаль орчныг хамгаалах тухай, газар, ус, байгалийн ургамал, ан агнуур, агаарын тухай зэрэг 15 хуулийг УИХ баталж, улмаар тэдгээр хуулийг хэрэгжүүлэх УИХ-ын тогтоолын дагуу холбогдох журам, дүрэм зэрэг 160 гаруй эрх зүйн актыг батлан мөрдүүлснээр байгаль орчны эрх зүйн тогтолцоо цоо шинээр бүрдсэн юм. Үүнээс хойш Монгол улсын хэмжээнд байгаль орчны чиглэлээр 30 гаруй хууль, 26 бодлого, хөтөлбөр хэрэгжиж байгаагийн зэрэгцээ энэ чиглэлээр 10 гаруй олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон буюу соёрхон баталсан байна. Ийнхүү байгаль орчны салбарын голлох суурь хуулиуд 1990-ээд оны дундуур батлагдаж, түүнээс хойших хугацаанд бодлогын дорвитой өөрчлөлт ороогүй байсан бөгөөд өнөөг хүртэл мөрдөгдөж ирсэн хуулиар байгаль орчныг хамгаалах бүх үүрэг хариуцлагыг дан ганц төр үүрч байв.

Монгол Улсын эдийн засагт уул уурхайн үйлдвэрлэл тэргүүлэх чиглэлээр эрчимтэй хөгжихийн хэрээр байгалийн нөөц баялаг хомсдож, байгаль орчны төлөв байдал бохирдон доройтох сөрөг үр дагаврууд гарах болсон бөгөөд эдийн засгийн үр ашгаас илүүтэй экологийн тэнцвэртэй байдлыг хангах, нийгмийн тогтвортой байдлыг хадгалах асуудал тулгарах болсон. Нөгөөтээгүүр ардчилсан, шударга, нээлттэй, хариуцлагатай, хяналттай төрийг төлөвшүүлэх, төр, засаг шийдвэр гаргах, шийдвэрээ хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах үйл явцдаа иргэдээ оролцуулдаг нийтийн удирдлагын зарчимд хууль тогтоомжоо нийцүүлэх шаардлага урган гарсан юм. Иймд БОАЖЯ 2008 оноос эхлэн “бохирдуулагч нь төлбөр төлөгч байх”, “ашиглагч нь хамгаалагч байх” суурь зарчимд үндэслэн иргэдийн оролцоо, хяналтад тулгуурласан байгаль хамгааллыг хөгжүүлэх үзэл баримтлалаар байгаль орчны салбарын хуулиа багцаар нь шинэчлэх ажлыг хийж эхэлжээ. Ингээд “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2009 оны 38 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн

орчинг 2009-2012 он хүртэл боловсронгуй болгох төлөвлөгөөний хүрээнд эхний ээлжийн 18 хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган эдгээр хуулийг системчлэн 8 хууль болгож, шинээр хоёр хуулийн төслийг боловсруулан Засгийн газраас өргөн мэдүүлснийг УИХ 2012 оны 5 дугаар сарын 17-нд нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн 70 хувийн саналаар баталсан байна.

Байгаль орчны эдгээр багц хуулийн гол үзэл баримтлал нь улс үндэстнийхээ тогтвортой хөгжлийг хангах, эдийн засгийн үр ашигтай, нийгэмдээ хариуцлагатай, байгаль орчиндоо зохистой хөгжлийг дээдлэх үүднээс “байгаль орчны аудитыг олон улсын туршлагын дагуу нэвтрүүлэх”, “бохирдуулагч нь хохирлыг нөхөн төлөх”, “нутгийн иргэд байгалиа хамгаалах”, “байгалийн нөөц баялгийн үнэлэмжийг нэмэгдүүлэх”, “байгаль хамгаалах ажлын тогтвортой эх үүсвэрийг бий болгох”, “нөөцийн тогтвортой менежментийг төлөвшүүлэх” зэрэг байв. Ийнхүү нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль орчны менежментийг нэвтрүүлэх, иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчны стратегийн үнэлгээ болон аудитын тогтолцоог шинээр нэвтрүүлэх, ногоон эдийн засгийн хөгжлийн үндсийг тавьснаар байгаль хамгааллын цоо шинэ эрх зүйн орчин бүрдлээ гэж бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид үзэж байна. Иргэдийн оролцоонд түшиглэсэн байгаль хамгааллын үзэл баримтлалд тулгуурлан боловсруулж баталсан гэх байгаль орчны багц хуулиудад иргэдийн оролцоог хангахад чиглэсэн дараах зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд орсныг тэмдэглэх нь зүйтэй. (Хавсралт 6)

Үүнд:

- Иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, нөхөрлөл байгуулах замаар өөрийн нутгийнхаа байгалийн нөөц баялгийг хариуцан хамгаалж, давуу эрхтэйгээр эзэмшиж, ашиглах шинэлэг хэлбэр болох “Байгалийн нөөцийн хамтын менежмент”-ийн зарчмыг хэрэгжүүлэх боломжийг хангасан. */Байгаль хамгаалах тухай хууль/*
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог, ялангуяа нутгийн иргэдийн оролцоог хангах зорилгоор олон нийтийн оролцооны талаар тусгай бүлэг оруулж, олон нийтийн оролцооны журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар шинээр оруулсан. */Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль/*
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний явцыг олон нийтэд мэдээлэх, стратегийн болон нөлөөллийн үнэлгээний тайланд олон нийтийн санал авах, хэрэгжилтэд хяналт тавих, хянан магадлагаа хийх зэргээр олон нийтийн оролцоог хангасан. */Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль/*
- Агаарын бохирдлыг бууруулахад иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлж, урамшуулах, төрөөс болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн. */Агаарын тухай хууль/*
- Агаарын чанарын алба нь агаарын бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд холбогдох байгууллага, олон нийтэд шуурхай мэдээлж, эрүүл мэндийн зөвлөгөө өгч байхаар тусгасан. */Агаарын тухай хууль/*

- Ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж, ойгоо өөрийн зардлаар арчлан хамгаалж, ашиглах боломж олгосон. /Ойн тухай хууль/
- Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хэмнэх, зохистой ашиглах олон талын оролцоог хангасан менежментийг бүрдүүлж ажиллах зохицуулалт хийсэн. /Усны тухай хууль/
- Иргэн, нөхөрлөл, амьтны чиглэлийн мэргэжлийн болон ТББ-ыг амьтны нөөцийг хамгаалахад оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. /Агаарын тухай хууль/

Эдгээр хуулиудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай 60 гаруй журмыг олон талын төлөөлөл оролцсон ажлын хэсгээс боловсруулан олон нийтээс санал авахаар хэлэлцүүлж байна.

МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ БА ИЛ ТОД БАЙДАЛ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Саяхан батлагдан гарсан Байгаль орчныг хамгаалах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Ойн тухай, Амьтны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Агаарын тухай, Хог хаягдлын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль зэрэг байгаль орчны 10 багц хууль болон бусад хуулиудад байгаль орчны асуудлаар иргэд, олон нийтийн мэдээлэл авах эрхийг хэрхэн хангадаг талаар шинжилгээ хийлээ. Байгаль орчны салбарын мэдээлэл ил тод, нээлттэй байх нь иргэд, олон нийтийн байгууллагын оролцоог идэвхижүүлэх үндсэн нөхцлийг бүрдүүлээд зогсохгүй улмаар байгаль орчны асуудлыг зөв оновчтой шийдвэрлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулахад чухал нөлөө үзүүлэх үндсэн хүчин зүйл болдог.

Байгаль орчныг хамгаалах тухай суурь хуульд иргэдийг холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах эрхтэйг баталгаажуулахын зэрэгцээ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны бүх шатны байгууллагууд мэдээллийн сан бүрдүүлж, иргэдийг мэдээллээр хангаж байх үүрэг хүлээлгэсэн байна. Иргэд холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах эрхийг Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай, Усны тухай, Агаарын тухай, Ургамлын хамгааллын тухай, Хог хаягдлын тухай, Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай зэрэг 7 хуульд тусгасан байна. Харин иргэдийг байгаль орчинтой холбоотой мэдээллээр хангах үүргийг төрийн холбогдох байгууллагуудад даалгасан заалтыг Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Агаарын тухай, Амьтны тухай, Химийн хортой болон аюултай бодисын тухай зэрэг 6 хуульд оруулжээ. Үүнээс үзвэл одоогоор хүчин төгөлдөр мөрдөж буй байгаль орчны 10 багц хуульд иргэдийн мэдээлэл авах эрхийг бүрэн хуульчлаагүй ба төрийн холбогдох байгууллагад байгаль орчны мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг бараг талд нь орхигдуулжээ. Мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг хуулиар даалгасан боловч хэн, ямар мэдээллийг, хэзээ, ямар арга замаар нийтэд хүргэх талаар тодорхой механизмыг заалгүй “нийтэд мэдээлнэ”, “нийтэд нээлттэй байлгана”, “мэдээллээр

хангана” гэх мэт тунхаглалын шинжтэй, хариуцах эзэнгүй, нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэхийг тусгалгүй орхижээ.

Ямар мэдээллийг нийтэд ил тод мэдээлж байхыг жагсаан хуульчлаагүйгээс байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнийг шийдвэрлэсэн шийдвэр, БОНБҮ-ний тайланд нутгийн иргэдийн өгсөн санал зэрэг иргэдэд өөрт нь хамааралтай, хэрэгцээтэй чухал мэдээллийг хүссэн цагтаа хүндрэл чирэгдэлгүй авч ашиглах нөхцөл бүрдээгүй хэвээр байна. БОНХЯ болон сум, дүүрэг, аймаг, нийслэл нь байгаль орчны мэдээллийн сан байгуулан ажиллуулж, иргэдийг байгаль орчны мэдээллээр хангаж байх үүргийг хуулиар хүлээсэн. Энэ санд газар, түүний хэвлий, агаар, ус, ургамал, амьтан зэрэг байгалийн бүх нөөц баялгийн талаар судалгаа, шинжилгээний ажлын тайлан, БОНБҮ-тэй холбоотой материалуудыг байршуулан нийтэд нээлттэй ашиглуулах бөгөөд улсын мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн үйлчилгээг яамны дэргэдэх Байгаль орчны мэдээллийн төв эрхлэн гүйцэтгэхээр хуульчилжээ. Тус төв нь байгаль орчны мэдээллийн сангаас мэдээлэл авах иргэдийн эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах /Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4/ чиг үүрэгтэй Байгаль орчны мэдээллийн сан <http://geodata.mne-ngic.mn/>³⁸ болон цахим хуудас <http://mne.mn/>³⁹-ыг тогтмол ажиллуулж, нийтэд мэдээлэл түгээж байна.

Мөн Ойн тухай, Рашааны тухай, Байгалийн ургамлын тухай, Амьтны аймгийн тухай, Химийн хортой болон аюултай бодисын тухай зэрэг байгаль орчны салбар хуулиудад ч байгаль орчны мэдээллийн сан байгуулах тухай заасан. Байгаль орчны суурь болон салбар хуулиудад зааснаар ийнхүү иргэд мэдээллийн сангаас цахим хэлбэрээр мэдээлэл авах нөхцөл бүрдсэн хэдий ч энэ нь мэдээллийн хүртээмжтэй байх зарчмыг хангаж чадахгүй байна. Учир нь интернэтийн сүлжээнд холбогдоогүй, цахим сүлжээ ашиглаж сураагүй хөдөө, орон нутгийн иргэдэд дан ганц ийм хэлбэрээр мэдээлэл хүргэх боломжгүй юм. Харин 2012 оны 5 дугаар сарын 17-нд батлагдсан БОНБҮ-ний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д “Төслийг хэрэгжүүлэгч салбарын яам болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн үнэлгээний дүгнэлтийн талаарх мэдээллийг нийтэд мэдээлж, өөрийн цахим хуудсанд байрлуулах бөгөөд хэвлэмэл хувилбартай танилцах боломжийг бүрдүүлнэ” гэж заасан нь өмнөхөөсөө бага зэрэг ахицтай зохицуулалт болжээ. Гэхдээ хэвлэмэл хувилбартай хаана, хэдийд хэрхэн танилцах, үүнийг хэн хариуцах талаар бас л бүрхэгдүүлжээ.

Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болохуйц эд зүйлс, үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, техник, технологийн талаарх мэдээллийг ямар ч тохиолдолд нууцлахыг Байгууллагын нууцын тухай хуульд хориглосон байдаг. Гэтэл Ашигт малтмалын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т “Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан ТЭЗҮ зэрэг баримт бичгийг түүний хүсэлтээр нууцад хамааруулах бөгөөд мэдээ тайланг хүлээлгэн

³⁸ <http://geodata.mne-ngic.mn/>

³⁹ <http://mne.mn/>

өгөхдөө нууц хадгалах талаар гэрээ байгуулж болно”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Нууцад хамааруулсан мэдээллийг Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуульд заасан үндэслэл, журмаас гадуур задруулах, нийтлэх, нийтэд мэдээлэхийг хориглоно” хэмээн заасан нь байгаль орчны мэдээллийг нууцлахыг хориглосон Байгууллагын нууцын тухай хуультай зөрчилддөг байна. Мөн газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээг Байгууллагын нууцын тухай хуулийн заалтыг үндэслэн байгууллагын нууцын жагсаалтад оруулсан байдгаас тус гэрээнд байгаль орчныг хамгаалах талаар аж ахуйн нэгжүүд ямар үүрэг хүлээсэн болохыг иргэд, ТББ-ууд мэдэх боломжгүй болдог байна. Түүнчлэн Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа эхний 5 жилд 50 саяас дээш америк доллартой тэнцэх хөрөнгө оруулалт хийх, тэр хэмжээгээр байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй томоохон төслүүдэд хийдэг Хөрөнгө оруулалтын гэрээний ил тод байдлыг хангах эрх зүйн зохицуулалт Ашигт малтмалын тухай хуульд алга байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 57 дугаар зүйл нь бүхэлдээ мэдээллийн ил тод байдлыг хангахад чиглэсэн боловч мэдээллийн ил тод байдлыг хангах үүргийг зөвхөн төрийн захиргааны төв байгууллагуудад оногдуулсан ба тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн хэвшлийн байгууллагад энэ талаар ямар нэг үүрэг, хариуцлагыг хуулиар оногдуулаагүй байна.

Үнэлгээ

Байгаль орчны суурь болон салбарын 6-7 хуульд иргэдийн байгаль орчны талаар үнэн зөв мэдээлэл авах эрхтэйг заахын хамт иргэдийг мэдээллээр хангах, байгаль орчны мэдээллийг нээлттэй болгох үүргийг төрд хүлээлгэсэн боловч иргэд байгаль орчны ямар мэдээллийг, ямар хүрээнд, ямар хугацаанд, хэрхэн олж авах процедурыг хуульчлаагүй, мэдээллээр хангах үүргийг тодорхой байгууллага, албан тушаалтанд хариуцуулан оногдуулаагүй, үндэслэлгүйгээр мэдээлэл өгөхөөс татгалзсан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын механизмыг суулгаж өгөөгүйгээс байгаль орчны мэдээлэл авах эрхийн хэрэгжилт хангалтгүй байна. Иргэдэд шаардлагатай чухал мэдээллийн олдоц муу, хэрэгцээтэй үедээ түргэн шуурхай авч чаддаггүй, мэдээллээр тогтмол хангадаггүй учраас байгаль орчны бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо сул байна. Иргэд байгаль орчны төрийн байгууллагуудаас мэдээлэл авахад тулгардаг гол бэрхшээл нь хүнд суртал /24%/ байдаг тул байгаль орчны талаарх мэдээллийг гол төлөв телевиз /79.5%/, сонин сэтгүүл /60%/, бусдын яриа /31.9%/-наас авдаг байдал нь төрийн байгууллагууд үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг ил тод тайлагнах, үйл ажиллагаагаа таниулах механизм муу байгааг харуулж байна.⁴⁰

⁴⁰ “Байгаль орчны салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, байгалийн баялгийн нөөцийг ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын бодлого, шийдвэр үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтэд мэдээлэх үүргийн хэрэгжилтийг хангах, мэдээллээ ил тод тайлагнах механизмыг сайжруулах нь “ сэдэвт судалгааны тайлан. 2008. НҮБ-ын “Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх” төсөл, МҮНХ-ний “Ногоон шинжээч” судалгааны баг,

БОНХЯ дэргэдээ иргэд, олон нийтийн мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх зорилгоор “Байгаль орчны мэдээллийн төв”-ийг ажиллуулж цахим хэлбэрээр мэдээлэл түгээж байгаа. Гэвч энэ төвийн мэдээлэл алслагдмал хөдөө орон нутагт оршин суудаг иргэдэд хүртээмжгүй байна. Цахим хэлбэрээр байгаа мэдээллийг хэрхэн олж авах аргын танилцуулгыг урьдчилан тодорхой өгдөггүй, мэдээллийн санд шаардлагатай чухал мэдээллийг оруулдаггүй, мэдээллээ шинэчилдэггүй, тавьсан мэдээллээ иргэдэд зориулан энгийн ойлгомжтой хэллэг, хэлбэрээр тусгайлан боловсруулдаггүй болохоор “Байгаль орчны мэдээллийн төв” мэдээллийн найдвартай, эрэлт хэрэгцээ хангахуйц хүртээмжтэй эх үүсвэр болж чадахгүй байна. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд “байгаль орчны мэдээллийн төв ...иргэн, хуулийн этгээдээс шаардлагатай мэдээллийг худалдан авч болно” гэж заасан боловч төсвийн хүрэлцээ хангалтгүйгээс тэр бүр хэрэгтэй шинэ мэдээллийг худалдан авах боломжоор хязгаарлагдмал байна. Иймд мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх ажиллагаанд эрдэм шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах талаар хуулийн зохицуулалт бий болгох⁴¹ шаардлагатай байна. Ийм учраас өөрт шаардлагатай мэдээллээ хайсан иргэд, байгаль орчны ТББ-ууд албан бичиг барин төрийн холбогдох байгууллагад ханддаг уламжлалт ганц аргаа хэрэглэдэг байна. Гэвч энэ нь чирэгдэлтэй, урт хугацаа шаарддаг, авсан хариуд нь хүссэн мэдээлэл нь байдаггүй бөгөөд сүүлийн үед “яамны вэб сайтаас ав” гэсэн хариултаар мухардалд орох болжээ.

Түүнчлэн төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж мэдээлэл хүссэн албан бичиг явуулахад хариу өгдөггүй явдал хэвээр байгаа бөгөөд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль батлагдан гараад ч энэ байдал өөрчлөгдөхгүй байна. Төрийн байгууллагууд хүссэн мэдээллийг түргэн шуурхай гаргаж өгдөггүй, цаг хугацаа их алдуулдаг, маргаантай асуудлын талаар мэдээлэл өгөхөөс зайлсхийдэг болохыг “Петрочайна Дачин Тамсаг” компанийн байгаль орчны нөхөн сэргээлтийг хуулийн дагуу хийлгэхийг шаардах, газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээг нийгэд нээлттэй байлгахыг хүсч төрийн холбогдох 21 байгууллага, албан тушаалтанд мэдээлэл хүссэн албан бичиг явуулаад 6 хариу авсан монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвслийн жишээнээс харж болно. Түүнчлэн мэдээлэл гаргаж өгөөгүй байгууллага, албан тушаалтны талаар дээд шатны байгууллагад нь гомдол, хүсэлт гаргаад ч хариу өгдөггүй дутагдал оршоор байгааг 9 удаа гомдол, хүсэлт гаргасан боловч нэг ч хариу аваагүй дээрх байгууллагын жишээ нотолно. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд болон жижиг төслийн багууд гол төлөв санаачилга гарган өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр иргэдэд зориулсан гарын авлага, зөвлөмж, мэдээллийн хуудас, плакат зэрэг материал бэлтгэн тараадаг ч хөрөнгө мөнгөний хомс байдлаас шалтгаалан тогтмол бус, хүрэлцээ нь хангалтгүй байдаг байна.

Албан шийдвэрийг иргэдэд мэдээлэх ажил хөдөө орон нутагт тодорхой хэмжээнд хийгдэж байгаа боловч түүнийг гарахын өмнө иргэдэд мэдээлэх, санал

⁴¹ Байгаль орчны зарим хуулийг шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, зөвлөмж боловсруулах зөвлөх багийн ажлын тайлан. 2009.

хүсэлт авч оролцуулах явдал маш хангалтгүй байна. Ялангуяа нийт иргэдийн эрүүл мэнд, аж амьдралд нөлөө бүхий газар, ус, ашигт малтмал, байгалийн бусад баялаг ашиглахтай холбоотой зөвшөөрөл олгоходоо иргэдэд мэдээлж, саналыг авах механизм байхгүй байна. Тухайлбал, газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах, ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олгох, газар, ус, ой мод ашиглах зөвшөөрлийн талаар иргэд урьдчилан мэдэх боломжгүй байна.⁴²

2006 онд Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн найруулж, хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход ИТХ-аас 30 хоногийн дотор санал авах заалт оруулсан боловч ИТХ, түүний тэргүүлэгчид нь иргэдийн эрх ашгийг жинхэнээр төлөөлж чаддаггүй. ИТХ-ын тэргүүлэгчид уул уурхайн компани болон улс төрчдийн нөлөөнд орж, худалдагддаг тул тухайн газар нутагт оршин суугаа иргэдэд мэдээлдэггүй. төвөөс ч ИТХ болон Засаг дарга ямар санал өгснийг иргэдэд эргэж мэдээлдэггүй, иргэдийнхээ эрх ашгийн эсрэг санал өгсөн албан тушаалтнуудтай хариуцлага тооцдоггүй болохоор орон нутгийн ИТХ иргэдийнхээ эрх ашгийн эсрэг шийдвэр гаргах явдал хавтгайрч, иргэд болон орон нутгийн төр, захиргааны байгууллагын хооронд эцэс төгсгөлгүй маргаан гарах болжээ. Нөгөө талаар орон нутгаас санал авах 30 хоногийн хугацаанд ялангуяа хөдөөгийн алслагдмал сумын ИТХ саналаа амжуулж ирүүлдэггүй бөгөөд хугацаандаа ирүүлээгүй бол зөвшөөрсөнд тооцдог хуулийн зохицуулалтаар нутгийн иргэдийн эрх ашиг хохирч, идээшиж дассан нутаг, өвөлжөө, хаваржаа, бэлчээр, усаа уул уурхайн компаниудад эвдүүлэн сүйтгүүлэх үр дагаварт хүрч байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар нарийвчилсан үнэлгээний тайланд орон нутгийн иргэдийн саналыг авахаар заасан боловч тухайн төслийн талаарх мэдээллийг иргэдэд урьдчилан өгч, иргэд ямар хугацаанд хэрхэн оролцох нь тодорхойгүй, эерэг, сөрөг талыг нь үнэн зөвөөр хэрхэн ойлгуулах тухай зохицуулалт байдаггүй учраас хуулийн дээрх заалт амьдралд бүрэн хэрэгжиж чаддаггүй. Үүнээс шалтгаалан байгаль орчны үнэлгээнд өгч буй иргэдийн санал тэр бүр бодитой, ач холбогдолтой байж чаддаггүй ба үнэлгээ батлагдсаны дараа орон нутгийн иргэд компаний хооронд зөрчил үүсч байна. Нөгөө талаар иргэд үнэлгээг сонирхоод судалъя ч гэсэн хэдэн зуун хуудас, ойлгомжгүй үг хэллэгтэй тул жирийн иргэд төдийгүй байгаль орчны байцаагч нар ч ойлгоход бэрхшээлтэй материал байдаг. Иймээс БОНБНУ-нд хүмүүс санал өгөхдөө юу болохыг нь бараг ойлголгүй өгдөг учраас санал бодитой бус байдаг. Мөн хувийн хэвшлийн байгууллагууд явуулах гэж байгаа үйлдвэрлэл, үйл ажиллагааныхаа тухай бодит мэдээллийг орон нутгийн иргэдэд өгөхгүйгээр, хууран мэхэлж санал авах, цөөн тооны иргэдээс санал авч, бусдын гарын үсгийг хуурамчаар үйлдэх, БОАЖЯ иргэдийн саналыг тусгаагүй үнэлгээг батлах гэх мэт зөрчлүүд гардаг. Түүнчлэн иргэд тухайн үйл ажиллагааны талаар эсрэг санал өгсөн атал харгалзан үзэлгүй зөвшөөрөл өгөх тохиолдол ч байна.

⁴² Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо судалгааны тайлан. 2011. Хүний эрх хөгжил төв.

Иймээс ямар үйлдвэр хаана явагдах гэж байгаа, ямар сөрөг нөлөө үзүүлж, яаж нөхөн сэргээх талаар мэдээлэл өгөх хэрэгтэй.⁴³

Хуулиар байгаль орчны мэдээллийг нээлттэй болгох үүргийг төрийн байгууллагуудад ямар нэгэн хэмжээгээр оногдуулсан боловч хувийн хэвшлийн байгууллагуудад энэ талаар хүлээлгэсэн үүрэг, хариуцлага байхгүй нь бэрхшээл үүсгэж байна. Тухайлбал: Нийтийн эрх ашгийг хөндсөн, байгаль орчинтой холбоотой шийдвэрүүдээ “Байгууллагын нууц” гэдэг нэрээр халхавчилж, мэдээлэл хүссэн иргэд, ТББ-д гаргаж өгдөггүй явдал түгээмэл болсныг зохицуулах шаардлагатай болжээ.

ЗӨВЛӨЛДӨХ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Энэ хэсэгт төр, засаг байгаль орчны асуудлыг шийдвэрлэхдээ иргэд, ИНБ-уудын саналыг авах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, тэдний саналыг гаргасан шийдвэртээ тусгах, тусгаагүй бол шалтгаанаа тайлбарлаж эргэх холбоо тогтоох зэргээр байгаль орчны зөвлөлдөх эрхийг хангаж буй байдалд дүн шинжилгээ хийлээ.

Байгаль орчны суурь болон салбар хуулиудыг шинжилж үзэхэд байгаль орчинтой холбоотой асуудлыг шийдвэрлэхэд иргэдээс санал авах талаар зөвхөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд тусгагдсан байгаа нь хангалтгүй байна. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хуулиудад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийхдээ тухайн орон нутгийн иргэдийн санал бодлыг хэрхэн тусгаж, харгалзан үзэх талаар хуулийн тодорхой зүйл, заалт алга байна. Эл байдлаас шалтгаалан сүүлийн үед уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч болон орон нутгийн иргэдийн хооронд гомдол, маргаан их гарах болсон⁴⁴.

Шинэчлэн найруулж батлагдсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д Засгийн газрын хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үндэсний болон бүс нутгийн хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд стратегийн үнэлгээ хийхэд болон төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулах тухай тусгасан. Гэвч ямар арга механизм ашиглан иргэдийн санал авахыг тодорхой тусгаагүй бөгөөд ямар тохиолдолд иргэдийн саналыг хүчинтэй гэж үзэх, иргэдээс санал аваагүй тохиолдолд үнэлгээний тайланг хүчин төгөлдөр гэж үзэх эсэхийг гүйцэд зохицуулаагүй орхижээ. Мөн иргэд, олон нийтийн саналыг хэрхэн тусгаж, түүнийг гаргасан шийдвэртээ хэрхэн харгалзан үзэх талаар хуулийн тодорхой зүйл, заалт алга байна.

Олон нийтийн оролцооны асуудлыг БОНХ-ийн сайдын баталсан журмаар зохицуулахыг хуульд заасан бөгөөд одоохондоо батлагдаагүй олон нийтээс санал авах хэлэлцүүлгийн шатанд байгаа аж. Газрын хэвлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-д “Иргэд нь газрын хэвлийн хамгаалалт, ашиглалтыг сайжруулах

⁴³ Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо судалгааны тайлан. 2011. Хүний эрх хөгжил төв.

⁴⁴ Мөн тэнд

тодорхой санал санаачилга гаргаж, энэ талаар илэрсэн зөрчлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлж, таслан зогсоох болон төрийн байгууллагаас зохиож байгаа бусад ажилд идэвхтэй оролцож байвал зохино”, 44.3-т “Төрийн байгууллага газрын хэвлийг хамгаалах, ашиглах арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхдээ олон нийтийн байгууллага, хөдөлмөрийн хамт олон, иргэдийн саналыг өргөнөөр авч аль болохоор харгалзан үзэж байх үүрэгтэй” гэжээ. Газрын хэвлийг хамгаалах, ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэхэд иргэдийн саналыг өргөнөөр авах, төрийн байгууллага түүнийг аль болохоор харгалзаж үзэхээр ийнхүү заасан ч саналыг хэн ямар хугацаанд хэрхэн авч, ямар шалгуур үзүүлэлтээр харгалзан үзэж эцэслэн шийдвэрлэх механизм, хүлээлгэх хариуцлагыг тодорхой заагаагүй тунхаг төдий болжээ.

Усны тухай хуульд иргэдийн тодорхой тооны төлөөлөл оролцсон Сав газрын зөвлөл нь ус хамгаалах, зохистой ашиглах шийдвэр гаргахад иргэдийн саналыг тусгуулах, усны нөөцийг хуримтлуулах, ашиглах, томоохон уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх болон далан, суваг барих төсөлд санал өгөх, усны барилга байгууламжийн зураг төсөл усны нөөцөд сөрөг нөлөөтэй нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр батлагдвал барьж байгуулах ажлыг түдгэлзүүлэх саналыг эрх бүхий байгууллагад гаргах, ус ашиглахтай холбогдсон сав газрын захиргааны дүгнэлтийг хүчингүй болгох саналыг эрх бүхий байгууллагад гаргах эрхтэй байна. Гэвч Сав газрын зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны төлөөлөл, байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын алба, төрийн бус байгууллага, сум, дүүргийн иргэн, ус ашиглагч, эрдэмтэн, судлаач, усны мэргэжлийн байгууллагын төлөөлөл орсон байгаа учраас иргэдийн саналыг тусгасан, нийтийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах эсэх нь бас эргэлзээтэй юм.

Ойн тухай хуульд ТББ ойн санг хамгаалахад оролцохын тулд саналаа холбогдох төрийн байгууллага болон зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад уламжлах, Амьтны тухай хуульд иргэн, нөхөрлөл, амьтан хамгаалах чиглэлийн мэргэжлийн болон ТББ нь амьтны нөөцийг хамгаалахад оролцохын тулд амьтны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаарх саналаа холбогдох төрийн байгууллага болон зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн болон иргэдийн Нийтийн Хурал, Засаг даргад уламжлах эрхтэй гэж заажээ. Дээр дурдсан хуулиудад иргэдийн гаргасан саналыг төр, захиргааны холбогдох байгууллагууд хэрхэн хүлээж авч ямар хугацаанд шийдвэрлэх, шийдвэрийн хариуг хэрхэн мэдээлэх талаар тодорхой механизмыг тусгаагүй байна.

Харин Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8-д баг, хорооны Хурал нь иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай хүсэлтийг хэлэлцэж саналаа сум, дүүргийн Хуралд уламжлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан нь иргэд өөрөө удирдах ёсны байгууллагаараа асуудлаа хэлэлцэн шууд ардчиллын зарчмаар шийдвэр гарган өөрсдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ хамгаалахад ихээхэн ач холбогдол бүхий заалт болсон. Гэвч иргэдийн нийтийн Хурлын шийдвэр эцсийнх байж чадахгүй дараагийн дээд

шатны хуралд шилжиж байгаа нь асуудлыг шуурхай шийдвэрлэхэд чирэгдэл учруулдаг учир дутагдалтай юм.

Үнэлгээ

Байгаль орчны суурь болон салбар хуулиудад иргэдээс санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Газрын хэвлийн тухай, Усны тухай, Ойн тухай болон Амьтны тухай хуульд тусгагдсан заалтууд нь тунхаг шинжтэй, хэт ерөнхий, дүрэм журам нь тодорхой бус, эргэх холбоогүй, санал авах асуудал, арга, хугацаагаа урьдчилан иргэдэд мэдээлдэггүй, хариуцах тодорхой эзэнгүй, хүлээлгэх хариуцлагын тогтолцоогүй зэрэг шалтгаанаас үр дүнтэй хэрэгжихгүй байна. Байгаль орчны хуулиудад "... олон нийтээс санал авна" гэсэн маш бүрхэг заалт олон удаа орсон байдаг бөгөөд санал авах механизмыг нарийн тодорхой заахгүй орхидгоос холбогдох албан тушаалтнууд санал авсан нэр зүүж, хэлбэрийн төдий хандаж, гол төлөв өөрийн үзэмжээр асуудлыг зохицуулдаг хэвшил тогтсон. "Олон нийт" гэдэг ойлголтын хамрах хүрээ нь үндэсний хэмжээнд үү, эсхүл тухайн орон нутагтын түвшинд үү, хэн авах, хаанаас, ямар арга хэлбэрээр, ямар хугацаанд, яаж санал авах, саналын дүнг шийдвэрт хэрхэн харгалзан үзэх, саналыг шийдвэрт тусгаснаа хэрхэн эргэн мэдээлэх нь тодорхойгүй байна.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах явцад иргэд, олон нийтийн саналыг авдаг боловч нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлыг ихэвчлэн хасчихдаг ба иргэдийн саналаас тэс өөр, заримдаа бүр эсрэгээр батлан гаргадаг тал бий. Тухайлбал, саяхан шинэчлэгдэн батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн төслийг иргэний нийгмийн байгууллагуудаар олонтоо хэлэлцүүлж, саналыг нь авч хуулийн төсөлд тусган Засгийн газарт хүргүүлсэн боловч эцэст нь УИХ-аар батлагдаад гарахдаа олон нийтийн оролцооны талаар тусгасан заалтууд хасагдсан жишээ байна. Тодруулбал, стратегийн болон байгаль орчин нөлөөлөх байдлын ерөнхий, нарийвчилсан үнэлгээний талаар төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээ хийх хуулийн этгээд төслийн дэлгэрэнгүй танилцуулга, төслөөс байгаль орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөлөл зэрэг мэдээллийг ил тод байлгана гэсэн хэсгийг хассан байна. Түүнчлэн стратегийн үнэлгээг хийж буй эрх бүхий төрийн байгууллага нь олон нийтийн саналыг олон нийтийн телевизээр хэлэлцүүлэг хийх замаар авах, санал авах уулзалтыг 2-оос доошгүй хийх, төсөл хэрэгжих орон нутгийн иргэдийн төлөөлөл ороцсон уулзалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах зэрэг хэлбэрээр авна гэснийг хасч "олон нийтээс санал авна" гэж бас л ерөнхийлөн баталсан байна.⁴⁵ Ийнхүү хуулийн хэрэгжилтийг сайжруулахын тулд нөлөөллийн үнэлгээний ямар мэдээллийг ил тод байлгах, иргэдийн саналыг ямар механизмаар авах талаар хуульд тодорхой зааж оруулах талаарх иргэдийн гаргасан саналыг хэлэлцэж, батлахдаа төрийн ямар байгууллага, албан тушаалтан ямар үндэслэлээр хассан талаар тайлбарлаж, эргэж

⁴⁵ Л.Долгормаа: Байгаль орчныг хамгаалах хуулиудад иргэдийн оролцооны зохицуулалт "Байгаль орчны салбар дахь иргэдийн оролцооны эрх зүйн орчин, институци" сэдэвт дугуй ширээний хэлэлцүүлэгт тавьсан илтгэл. 2013.01.17

мэдээлдэггүй орхидог нь хууль боловсруулахад иргэдийн цаашид оролцох идэвхийг бууруулах сөрөг үр дагавартай байдаг.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар БОНБНУ-нд зөвхөн орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг авах зохицуулалттай ч зарим үед иргэдээс огт санал авахгүй байх, эсхүл төслийн нөлөөлөлд гол өртөгсөд бус цөөн тооны хамаарал багатай хүмүүсээс санал авах, тухайн төслийг дэлгэрэнгүй танилцуулж, тодорхой ойлголт өгдөггүй, ТЭЗҮ, байгаль, нийгэмд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг үнэн зөв тайлбарлан хэлдэггүй, хий хоосон мөрөөдлөөр төөрөгдүүлж, хууран мэхэлсэн амлалт өгдгөөс иргэд саналаа бодитой өгч чадахгүйд хүрдэг байна. Тухайлбал: БОНБНУ-нд иргэдийн саналыг авч тусгах явдал маш хангалтгүй байгааг БОНБНУ-ний 47 тайланг шалгахад 10 буюу (22%) нь иргэдийн саналыг огт аваагүй, 33 буюу (70%) нь зохих журмын дагуу аваагүй, 4 буюу дөнгөж (8%) нь иргэдийн саналыг зохих түвшинд авсан мониторингийн дүнгээс харж болно.⁴⁶

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд зааснаар “байгаль орчны улсын байцаагч нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах үүрэгтэй” хэмээн олон нийтийн оролцоог хуульчилсан байна. Гэхдээ иргэдээс байгаль орчны зөрчлийн мэдээллийг авах тогтсон арга, хэрэгсэл байхгүй, утсаар ярих, биечлэн уулзах зэргээр мэдээлэл авдаг байна. Мэдээлэгчийг нууцалж чаддаггүй учраас хүмүүс бичгээр гарын үсэг зурж мэдээлэл өгөхийг хүсдэггүй. Нэгэнт гарын үсэг бүхий мэдээлэл байхгүй учраас мэдээлэл өгсөн хүнийг урамшуулах боломжгүй болдог.

Мэдээлэл өгсөн иргэдийг урамшуулах хуулийн заалт хэрэгждэггүй, мэдээлэгч буюу мэдээллийн эх сурвалжийг нууцлах боломжгүй учраас нэг удаа мэдээлэл өгсөн хүн дахин мэдээлэл өгөхийг хүсдэггүй байна. Учир нь сум орон нутгийн хувьд хүн болгон бие биенээ таньдаг, цуу яриа амархан тардаг учраас хэн мэдээлэл өгснийг бусад хүмүүс маш хурдан мэддэг, тэдэнд нэр хоч өгдөг, заналхийлэх явдал гардаг байна.⁴⁷

ИДЭВХТЭЙ ОРОЛЦООНЫ ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Энэ хэсэгт байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг ашиглах үйл ажиллагаанд хамтын менежментийн зарчим, түүнийг хэрэгжүүлэх институцийн бүтэц, байгаль орчны шийдвэр гаргах, хэрэгжүүлэх эрх мэдлээ иргэний нийгэмд хэрхэн шилжүүлж байгаа, төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг ТББ-д хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлэх эрх зүйн орчин хэрхэн бүрдэж байгаад голлон анхаарч шинжилгээ хийлээ. 2005 онд Шинэчлэн батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд байгалийн нөөцөөс амьжиргаа нь шууд хамааралтай иргэдийн байгаль хамгаалах, байгалийн нөөц ашиглах чадвар, тогтолцоог бий болгох зорилгоор нутгийн иргэд сайн дурын үндсэн

⁴⁶ БОНБНУ дэх иргэдийн оролцоо мониторингийн тайлан. 2010. Хүний эрх хөгжил төв.

⁴⁷ Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо судалгааны тайлан. 2011. Хүний эрх хөгжил төв.

дээр нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа газар нутгийнхаа байгаль орчин, түүний тодорхой төрлийн нөөц баялгийг гэрээгээр хариуцан хамгаалж, давуу эрхээр эзэмшиж, ашиглах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр зориудаар бий болгосон усан сан, тарьж ургуулсан ой, өсгөж үржүүлсэн амьтнаа өмчилж болох зарчмын ач холбогдолтой нэмэлт өөрчлөлтийг оруулсан байна. Ингэснээр байгаль хамгаалах төрийн бодлогыг үндсээр нь өөрчилж, олон нийт, нутгийн иргэдэд түшиглэсэн менежментийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

Байгаль орчны хуулиудад Байгаль хамгаалах нөхөрлөл, Ойн нөхөрлөл, Сав газрын зөвлөл, Орчны бүсийн зөвлөл зэрэг байгаль хамгаалахад иргэдийн оролцоог хангах бүтэц, зохион байгуулалтын хэлбэрийг хуульчилж өгсөн. Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай болон Ойн тухай хуульд тухайн орон нутгийн харьяат бөгөөд байнга оршин суудаг иргэд сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, байгаль орчныг хамгаалах Нөхөрлөл байгуулж, байгалийн тодорхой баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших замаар байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг тусгажээ. Түүнчлэн Усны тухай хуульд усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад нутгийн иргэдийг оролцуулах, хяналт тавих боломжийг анх удаа хуульчилж өгсөн. Уг хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Сав газрын захиргааны дэргэд сав газрын усны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд дүгнэлт, зөвлөмж өгөх, хяналт тавих, олон талын оролцоог хангах үүрэг бүхий орон тооны бус усны Сав газрын зөвлөлийг байгуулна” гэж зааснаар иргэд Сав газрын зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцож, гол мөрнөө эзний ёсоор хамгаалах эхлэл тавигдсан. Гэвч Сав газрын зөвлөл нь нутгийн иргэд, эрдэмтэн, судлаачдаас бүрдэж, тухайн орон нутгийн иргэдийн эрх, ашгийг илэрхийлж хамгаалдаг тэдний төлөөллийн байгууллага байх ёстой байтал нийт гишүүдийн дийлэнх нь төрийн захиргааны албан тушаалтан байхаар хуулиар зохицуулсан. Энэ нь сав газрын зөвлөлийн зорилго, ашиг сонирхолдоо нийцсэн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хязгаарлаж, улмаар усны нөөцийн ашиглалтад тавих хяналтыг бодитой хийх, хариуцлага тооцох боломжийг бууруулсан зохицуулалт болсон. Ингэснээр Сав газрын зөвлөл нь ус ашиглагчийн үүргийн биелэлтийн талаар дүгнэлт гаргах, усны нөөцөд сөрөг нөлөөтэй тохиолдолд усны барилга, байгууламжийн ажлыг түдгэлзүүлэх санал гаргах, ус ашиглах талаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй этгээдийн ус ашиглах эрхийг түдгэлзүүлэх, зогсоох зэрэг хуулиар олгогдсон чухал эрх мэдлээ хэрэгжүүлж чадахгүйд хүрчээ. Мөн Усны сав газрын зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг шийдэх эрх зүйн орчин байхгүйгээс Сав газрын зөвлөлүүд дээрх эрх, үүргээ хэрэгжүүлэн ажиллах боломжгүй байсаар байна.

Мөн Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд нутгийн иргэдийн оролцоог өргөжүүлэх зорилгоор орон тооны бус Орчны бүсийн зөвлөл байгуулах, түүнд орон нутгийн иргэдийн 3-аас доошгүй төлөөлөл, байгаль орчны чиглэлээр ажилладаг ТББ оролцож болох заалттай байна. Засгийн газар “Ашиглагч нь хамгаалагч байх”,

”Байгалийн нөөцийн хамтын менежментийн зарчимд үндэслэн байгаль орчныг хамгаалах талаарх төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий ТББ-д эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан нь байгаль орчны бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх эрх мэдлээсээ ИНБ-уудад хуваалцаж, байгаль хамгаалах үүргээ санхүүгийн эх үүсвэрийн хамт иргэд, ТББ-уудад гэрээлэн шилжүүлэх эрх зүйн үндсийг тавьсан юм.

Мөн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн ИТХ болон Засаг дарга, байгаль орчны улсын байцаагчид нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих, гэрээ байгуулж, биелэлтийг хянах, шаардлагатай төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах болон байгаль орчныг хамгаалахад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх үүргийг хуулиар хүлээлгэжээ. Тухайлбал, аймаг, нийслэлийн ИТХ-ын болон Засаг даргад нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулахыг хуулиар баталгаажуулсан байна. Харин сум, дүүргийн ИТХ болон Засаг даргад байгалийн тодорхой төрлийн баялгаас зохих болзол, хугацаатайгаар хууль, журмын дагуу нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байгуулж, биелэлтэд нь хяналт тавих, Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үр дүнг сумын ИТХ-д тайлагнах эрх, үүргийг хуулиар хүлээлгэжээ.

Мөн байгаль орчныг хамгаалах тухай хуулиар байгаль орчны улсын байцаагчид байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах үүрэгтэй.

Байгаль орчны зөрчлийн талаар үнэн зөв мэдээллийг холбогдох байгууллагад мэдээлсэн, байгальд ээлтэй шинэ технологи нэвтрүүлсэн зэрэг байгаль орчныг хамгаалах талаар санаачилгатай ажиллаж, хувь нэмэр оруулсан иргэд, байгууллагыг урамшуулах тухай Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай болон Ойн тухай, Амьтны тухай хуулиудад заасан байна. Тодруулбал, Амьтны тухай хуулийн 38-р зүйлд зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах тухай шинэлэг заалт тусгасан боловч мэдээллийг хэрхэн нууцалж иргэний эрх ашгийг хамгаалах талаар тодорхой заалт оруулаагүй байна.

Мөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар байгаль орчныг хамгаалах, түүний нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг орон нутагт хэрэгжүүлэх үүрэг бүхий идэвхтэн байгаль хамгаалагчийг томилон ажиллуулж болохыг тогтоож, ажлынх нь үр дүнгээр урамшуулах журам боловсруулан батлахаар хуульчилсан нь иргэдийн идэвх оролцоог дээшлүүлэхэд хөшүүрэг болж өгчээ. УИХ-д

суудалтай улс төрийн хүчнүүд 2012 оны УИХ-ын сонгуульд байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцоог дэмжихэд чиглэгдсэн дараах амлалт авчээ. Үүнд:

- Уул уурхайн салбар дахь төрийн зохицуулалт, хяналтыг чангатгаж, төрийн өмчийн оролцоог хязгаарлаж, үндэсний аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог дэмжинэ.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийг нөхөн сэргээх ажилд иргэн, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог өргөжүүлж, ажлын байр, иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, эрх зүй, эдийн засаг, удирдлага зохион байгуулалтыг шинэчилнэ.
- Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хууль батлуулж, иргэний нийгмийн байгууллагын санхүүжилтийн шинэ хувилбаруудыг бий болгоно.
- Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг бодитойгоор хэрэгжүүлнэ.
- Нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, байгаль хамгаалал, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч, дэд бүтэцтэй холбоотой асуудлыг шүүхэд нэхэмжлэн хамгаалах стратегийн өмгөөлөл, бодлогын нөлөөллийг бүх талаар дэмжинэ.
- Өвөг дээдсээс өвлөгдөн ирсэн байгалийн баялаг, газар нутгаа харь хэлтэнд барьцаалан зээлдэх биш харин үе үеийн монголчуудын амьдралыг дээшлүүлэх даацтай буюу олон тулгуурт, тогтвортой, иргэдийн оролцоотой “ногоон” эдийн засгийн бүтцийг бий болгоход зориулна гэжээ.

Дээр дурдсан амлалтуудаас Засгийн Газрын мөрийн хөтөлбөрт нийтэд тустай үйл ажиллагааны тухай хууль батлуулах, төрийн зарим чиг үүргийг ТББ, мэргэжлийн холбоодод шилжүүлэх, нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилтууд тусгасан нь өмнөх Засгийн Газрын мөрийн хөтөлбөртэй харьцуулахад байгаль орчныг хамгаалахад иргэдийг оролцуулах зорилт нь илүү тодорхой, бодитой, залгамж шинжтэй, олон тоотой болсон нь анзаарагдаж байна.⁴⁸

БОАЖЯ Монгол Улсын “Засгийн газрын тухай” хуулийн 19-р зүйл, Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 4-р зүйл, 32-р зүйлийн 32.2 дахь хэсэг, “Төрийн бус байгууллагын тухай” хуулийн 9-р зүйлийг үндэслэж байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудыг нэгтгэсэн МБОИЗ-тэй 2008 оноос Хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Энэхүү гэрээнд талууд хууль дээдлэх, харилцан бие биенээ хүндэтгэх, эрх тэгш байх, нээлттэй, ил тод байх зарчим баримтлан төр, ТББ-уудын түншлэлийн хүрээнд байгаль орчны салбарын хэмжээнд төрийн гүйцэтгэх дараах чиг үүргийг МБОИЗ-өөр гүйцэтгүүлнэ гэж тохиролцсон байдаг. Үүнд:

- Байгаль орчны үнэлгээний тайланг хэлэлцэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд МБОИЗ-ийн төлөөлөл оролцуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

⁴⁸ Г.Уранцоож: Иргэний оролцоог хангах амлалт, зорилт, хэрэгжилтээс “Байгаль орчны салбар дахь иргэдийн оролцооны эрх зүйн орчин, институци” сэдэвт дугуй ширээний хэлэлцүүлэгт тавьсан илтгэл. 2013.01.17

- Болзол нөхцөлийг хангасан ТББ-аар байгалийн нөөцийн судалгаа, ой, ангийн нөөцийн зохион байгуулалт хийх;
- Байгалийн нөөцийг ашиглах, хамгаалахтай холбогдуулан яамнаас гаргаж буй шийдвэр, байгаль орчны хуулиудын хэрэгжилт, түүнийг шийдвэрлэсэн байдалд мониторинг хийх;
- Сургалт, сурталчилгаа, судалгаа, шинжилгээ, уулзалт, семинарт оролцох, зохион байгуулах;
- Байгалийн нөхөн сэргээх, ой, ургамал, амьтныг өсгөн үржүүлэх төсөл шалгаруулахад оролцох;
- Зөвлөлд дээрх үүргүүдийг гэрээгээр гүйцэтгүүлэн түүнд шаардагдах санхүүжилтийг шийдэж болох ба шаардлага хангасан ТББ-д мэргэжлийн байгууллагын эрх олгох;
- Орон нутагт байршилтай ТББ-ууд тухайн аймгийнхаа БОАлбадтай холбогдох хууль тогтоомж энэхүү гэрээний хүрээнд гэрээ байгуулан зохих үүргийг хэрэгжүүлэх;
- Орон нутгийн хамгаалалтад авсан зарим газар нутгуудын хамгаалалтын менежментийг ТББ-д хариуцуулах зэрэг болно.

Үнэлгээ

Ашиглагч нь хамгаалагч байх, нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын үзэл баримтлалд үндэслэн иргэд сайн дурын үндсэн дээр Нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа газар нутгийнхаа байгаль орчин, түүний тодорхой төрлийн нөөц баялгийг гэрээгээр хариуцан хамгаалж, давуу эрхээр эзэмшиж, ашиглаж болох эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь иргэдийг байгалийн нөөц баялагт эзний ёсоор хандаж харьцах, байгаль хамгаалах үйл хэрэгт идэвхтэй оролцохыг дэмжсэн чухал алхам болсон. Тухайлбал, ойн санг нутгийн иргэдэд түшиглэн эзэмшүүлэх замаар ойн нөөцийг хамгаалах талаар төр, засгаас баримталж байгаа бодлого, гаргасан шийдвэр нь ойн менежментийн шинэлэг арга болж байна. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 227-р тогтоолоор батлагдсан “Ойн санг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлыг тухайн орон нутгийн онцлог, хүн амын суурьшмал байдал, ойн сангийн байршил зэргийг харгалзан оновчтой арга хэлбэрээр зохион байгуулах асуудал сүүлийн үед чухлаар тавигдаж байна.

1990 оны сүүлээр Монголд ойн нөхөрлөлүүд байгуулагдаж эхэлсэн ч сүүлийн жилүүдэд ялангуяа, 2007 онд Ойн хууль шинэчлэгдэн батлагдсанаас хойш нөхөрлөлийн тоо хурдацтай нэмэгдсээр 2011 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар Монгол улсын хэмжээнд 2011 оны байдлаар 631 ойн нөхөрлөл 1843723 га, 59 ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж 311732 га бүхий ойн санг тус тус эзэмшиж байна.⁴⁹

Гэвч бэлчээр, ой, амьтан, ургамал, рашаан зэрэг байгалийн тодорхой төрлийн нөөцийг хамгаалах чиг үүргийг ИНБ-д төр шилжүүлэх тухай зохицуулалт нь тодорхой бус хэт ерөнхий, бэлэгдлийн шинжтэй, санхүүжилтийг хамт шилжүүлэх

⁴⁹ <http://www.Forestry.gov.mn/>

үүргийг төрд даалгаагүй “санхүүжүүлж болно” гэдгээр заавал хэрэгжүүлэх шаардлагагүй болгож “гэрээлэх дүр үзүүлэх” маягаар иргэдийн оролцоог оромдсон хандлагатай байна.

Түүнчлэн байгалийн нөөцийн хамгаалалтыг гэрээлэх талаар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шууд ардчиллын зарчмаар гаргасан шийдвэр эцсийн хүчин чадалтай байж чадахгүй, дараагийн шатны хурлаар хэлэлцүүлж шийдэхээр шилжиж байгаа нь чирэгдэл, хүнд суртлыг бий болгохын хамт иргэдийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх мэдэл, нэр нөлөө, ач холбогдлыг сулруулж, цаашилбал ардчилсан ёс, иргэний нийгмийн төлөвшилтэд саад учруулж байна. Усны тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай зэрэг хуулиудад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий голын Сав газрын зөвлөл, тусгай хамгаалалттай газар нутгийн Орчны бүсийн зөвлөл байгуулж, түүнд орон нутгийн иргэд, ТББ-ын төлөөллийг оролцуулахаар заасан нь байгаль хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чухал зохицуулалт болсон. Гэвч иргэдийн оролцоотой хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх зөвлөлүүдийг орон нутагт байгуулах үйл явц удаан, төрийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудаас санал, санаачилга гаргадаггүй, гол төлөв донор байгууллагуудын төслийн хүрээнд, эсхүл ТББ-уудын шахалт шаардлагаар цөөн тоогоор байгуулагдсан байдаг. Тухайлбал, Сав газрын зөвлөл гэхэд л Ховд, Бороо, Хараа, Туул, Орхон зэрэг голуудынх л байгуулагдсан байдаг. Гэвч эдгээр зөвлөлүүдийн үйл ажиллагаа явуулах дүрэм журам боловсронгуй бус, санхүүгийн эх үүсвэрийг нь хууль тогтоомжоор нэг мөр шийдэж чадаагүй учраас тавьсан зорилгодоо хүрэхээр төдийлөн үр дүнтэй ажиллаж чадахгүй байна.

БОАЖЯ-ны санаачилгаар 2008 онд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 700 шахам ТББ-ын хүчийг нэгтгэн “Монголын байгаль орчны иргэний зөвлөл”-ийг байгуулж, байгаль орчны ТББ-уудын зөвлөгөөнийг гурван удаа зохион байгуулж, улмаар МБОИЗ-тэй жил бүр хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Сүүлийн 4 жилийн хугацаанд БОАЖЯ төрийн байгууллагын гүйцэтгэх зарим ажил үүргийг 150 ТББ-аар гүйцэтгүүлж, 900 гаруй сая төгрөгийн санхүүжилт олгожээ. МБОИЗ-ийн ажлын албыг чадавхижуулахад жил тутам 20-51 сая төгрөгийн санхүүжилт олгож, “Цэнгэг усны нөөц” байгаль хамгаалах төвд ажлын байртай болгож, шаардагдах техник хэрэгслээр хангажээ.⁵⁰ Гэвч 2012 онд гэрээгээр гүйцэтгүүлсэн ногоон байгууламжийн заавар боловсруулах /0.5 сая/, Байгаль орчны тухай хуулиудын төслийг Байгаль орчны парламентаар хэлэлцүүлэх /5.0 сая/, суулгац үржүүлэх арга зүйн туслалцаа үзүүлэх /0.5 сая/, орлогын эх үүсвэр нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах /5.0 сая/, адал явдалт спорт аяллын тэмцээн зохион байгуулах /13.5 сая/, бодлогын хөтөлбөр боловсруулах /3.0 сая/, Туул голын дагуу ногоон зурвас байгуулах /100 сая/, хуулиудын хэрэгжилтэд мониторинг хийх /40.0 сая/, ойн түймэртэй холбоотой стандарт боловсруулах /5.0 сая/ зэрэг хурал, семинар, сургалт, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн зохион байгуулах, мод зүлэг, жимс ногоо

⁵⁰ Б.Батболд: Байгаль орчны салбар дахь иргэдийн оролцооны эрхзүйн орчин, хэрэгжилтийн байдал “Байгаль орчны салбар дахь иргэдийн оролцооны эрх зүйн орчин, институци” сэдэвт дугуй ширээний хэлэлцүүлэгт тавьсан илтгэл. 2013.01.17

тариулах элдвээр хуурч аргалсан, тайвшруулсан, хурц асуудлаас холдуулсан, шахалт шаардлагыг саармагжуулсан шинжтэй, хэсэгчилсэн үйл ажиллагааг богино хугацаанд бага мөнгөөр хийж гүйцэтгүүлэх төсөл шалгаруулан тэтгэлэг олгох хэлбэртэй байгааг өөрчилж, түншлэлийн дараагийн шатанд шилжих алхам хийх цаг нь болсон гэж үзэж байна. Иймд цаашид БОНХЯ-ны гүйцэтгэх зарим тодорхой чиг үүргийг ТББ-ууд санхүүжилтийн хамт шилжүүлэн авч урт хугацаанд тогтвортой гэрээлэн гүйцэтгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Олон улсын байгууллагуудтай хамтран зарласан төслүүдэд 134 ТББ шалгаран байгаль хамгаалах ажлыг гүйцэтгэсэн байна. Тухайлбал, Нидерландын Засгийн газрын санхүүжилтээр БОАЖЯ, Дэлхийн банк, Нээлттэй нийгэм хүрээлэнгээс зарласан “Байгаль орчны шинэчлэл” төсөлд 2009 онд 280,4 сая төгрөгийн санхүүжилт бүхий 35, 2010 онд 360 гаруй сая төгрөгийн 52, 2011 онд 345,1 сая төгрөгийн 36 жижиг төсөл шалгарсны дийлэнхийг ТББ-ууд хэрэгжүүлжээ.⁵¹ МБОИЗ-ийн дэргэд Монголын байгаль орчны парламент ажиллаж, байгаль орчны хуулиудын төслийг хэлэлцэн саналаа нэгтгэн БОНХЯ, БОХХААБХ болон УИХ-д өгдөг болсон байна.

Байгаль орчны ТББ-ууд хамтран өөрсдийн санаачилгаар хуулийн төсөл боловсруулан УИХ-ын гишүүдээр өргөн бариулж, батлуулахад нөлөөлөх, хэрэгжилтийг хангуулахын тулд Засгийн газар, Шүүхийн байгууллагад хандаж бодитой үр дүн гарган ажиллаж байна. Тухайлбал, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сангийн хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх олборлохыг хориглох тухай хуулийг санаачлах, батлуулах, хэрэгжүүлэхэд “Гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн” ТББ бусдыгаа зохион байгуулан ажиллаж амжилтанд хүрсэн төдийгүй гол, нууруудын хамгаалалтын бүс тогтоох 54 ажлын хэсэгт орж хяналт тавин ажиллажээ. Түүнчлэн аймаг, орон нутгийн БОАЖГазар МБОИЗ-ийн төлөөллүүдийн оролцоотойгоор мэргэжлийн байгууллагын удирдлага дор 2011 онд усны тооллогыг орон даяар амжилттай зохион байгуулсан байна. МБОИЗ-өөр дамжуулан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо, Монголын Мянганы сорилтын сангийн удирдах зөвлөл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын Үнэлгээний комисс, Яам, харьяа агентлагуудын худалдан авах үйл ажиллагааны тендэрийн үнэлгээний хороо, Яамны шинжлэх ухаан техникийн зөвлөл, Байгаль хамгаалах сан, Цэвэр агаар сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд ТББ-ын төлөөлөл ажиглагчийн хувиар оролцож, мэдээлэл авч, санал бодлоо илэрхийлдэг болжээ.

Гэхдээ БОНХЯ болон байгаль орчны ТББ-уудын түншлэлийг зохицуулж буй МБОИЗ, Байгаль орчны парламентын статус, бүтэц, эрх хэмжээ, чиг үүрэг, хүлээх хариуцлага нь ч баталгаажаагүй, албан бус байдалтай, БОНХЯ болон МБОИЗ-ийн хамтын ажиллагааны гэрээ нь хуулийн үндэслэл султай, Яамны сайд болон Зөвлөлийн тэргүүний хүсэл зориг, үзэмж, улс төрөөс ихээхэн хамааралтай байгаа нь энэхүү түншлэлийн харилцааны цаашдын тогтвортой хөгжилд сорилт болж байна.

МБОИЗ нь БОНХЯ-аас санхүүждэг, Удирдах зөвлөлийн гишүүд нь улсын байцаагчийн эрхтэй зэрэг нь байгаль орчны ТББ-уудын бие даасан хараат бус

⁵¹ <http://www.Mne.mn/>

байдлыг алдагдуулж, төрийн үйл ажиллагааг хянадаг, үнэлж дүгнэдэг, буруутай үйлдлийг илчилдэг, хариуцлага тооцдог “сонирхлын бүлэг”, “шахалтын бүлэг”-ийн чухал чиг үүргээс нь хазайлган “төрийн хармааны байгууллага” болон хувирахад нөлөөлж болзошгүйг анхаарах нь зүйтэй. Төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр ТББ-д хариуцуулан гүйцэтгүүлж, зардлыг нь хэсэгчлэн санхүүжүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хуульд зааснаар төр, ТББ-ын түншлэлийн харилцааны эрх зүйн үндэс бүрдсэн. Гэвч “Хустай төв” ТББ нь Хустайн нурууны байгалийн цогцолбор газрын хамгаалалтын менежментийг гэрээлэн авч амжилттай хэрэгжүүлж байгаа бусдад үлгэр дуурайлал болохуйц сайн туршлагыг эс тооцвол БОАЖЯ-ны дэмжлэгтэйгээр МБОИЗ-ийн хийж гүйцэтгэсэн олон ажлууд нь төслийн тэтгэлэг төдий байгаа нь байгаль орчны ТББ-уудын төлөвшилт, тогтвортой хөгжилтөд дорвитой нөлөө үзүүлж, үйл ажиллагаа болон санхүүгийн бие даасан байдлыг бий болгож чадахгүй хэвээр байгаа юм.

ИРГЭДИЙН ХЯНАЛТ ТАВИХ БОЛОМЖ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Энэ хэсэгт байгаль орчны бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд иргэд, олон нийтийн байгууллагууд хяналт тавих, хариуцлага тооцуулах эрх зүйн орчин хэрхэн бүрдсэн байдалд дүн шинжилгээ хийлээ. Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай, Усны тухай, Амьтны тухай зэрэг дөрвөн хуульд иргэд, олон нийт хяналт тавих эрх, үүргээ хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, үзлэг хийх арга хэлбэрээр хэрэгжүүлэхээр зохицуулжээ. Харин иргэд, олон нийт хариуцлага тооцох эрхээ хэрэгжүүлэх хэлбэрийг Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай, Хөрсний тухай, Усны тухай, Цөмийн энергийн тухай, Газрын хэвлийн тухай зэрэг 8 хуульд илэрсэн зөрчлийг арилгах, үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргах, байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байх, хууль зүйн хариуцлага хүлээлгэх болон учирсан хохирлыг төлүүлэхийг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, санал хүргүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хэмжээгээр хязгаарласан байна.

2006 онд шинэчлэн найруулагдсан Ашигт малтмалын тухай хуульд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаанд олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн нилээд заалтууд оржээ. Тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих бие төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж, ИНХ-аар тайланг нь сонсох тухай заалтыг Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нь уул уурхайн компаниудын байгаль, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд нөлөө үзүүлэх тустай юм. Гэвч хуулийн дээрх хэм хэмжээ нь олон нийтийн оролцоог хангахыг үүрэг болгосон бус

зөвлөмжилсөн шинжтэй байгаа төдийгүй иргэдээс сонгогдсон төлөөлөгчид хяналтаа хэрэгжүүлэх механизм, эрх зүйн боломжийг олгоогүй дутагдалтай байна.⁵²

Байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн санаачлан боловсруулж, идэвхитэй оролцоо, хүчтэй нөлөөллийн үр дүнд 2009 оны 7 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон. Энэ уг хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орон нутгийн удирдлага болон нутгийн иргэдээс бүрдсэн олон нийтийн хяналтан дор хоёр жилийн хугацаанд хийж дуусгах ба олон нийтийн хяналтыг ИТХ-ын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах зорилго, чиглэл бүхий ТББ-уудад гэрээний үндсэн дээр хариуцуулж болохоор зохицуулсан.

Байгаль орчинд хохирол учирч, төрийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд одоогийн үйлчилж байгаа хуулийн дагуу төрийн нэрийн өмнөөс прокурор болон Засаг дарга шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байсан. Гэтэл прокурор зөвхөн төрийн байгууллагын хүсэлтээр нэхэмжлэл гаргадаг, харин Засаг дарга нар өөрийн орон нутагт байгаль орчны сүйдсэн асуудалтай өөрсдөө холбоотой, эсхүл байгаль орчны хуулийн хэрэгжилтийг хангах үүргээ биелүүлээгүйн улмаас өөрийнхөө эс үйлдлийн эсрэг нэхэмжлэл гаргах шаардлагатай болдог зэрэг шалтгаанаар хуулийн энэхүү зохицуулалт амьдралд хэрэгжиж ач холбогдлоо өгдөггүй байсан. Харин байгаль орчны ТББ-уудын санаачилгаар байгаль орчны асуудлаар нэхэмжлэл гаргах энэхүү хязгаарлагдмал эрхийг нээж Байгаль орчныг хамгаалах тухай болон Ойн тухай хуульд байгаль орчны ТББ-ууд болон иргэд байгаль орчны хохирлыг шүүхээр нэхэмжлэх эрхтэй болсон.

Гэвч байгаль орчны нөхөн сэргээлт хийлгэхийг даалгах, хууль бус лицензийг цуцлуулах, уул уурхайн компаниудын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоолгох, хууль бус үнэлгээг хүчингүй болгуулах зэрэгт байгаль орчны ТББ-ууд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй хэвээр байна. Түүнчлэн байгаль орчны хохирлыг нөхөн төлөх хэрэгт ихээхэн хэмжээний тэмдэгтийн хураамж төлөх, өмгөөлөгчийн хөлс төлөх, хохирол тооцох мэргэжлийн шинжээчдийн хөлс төлөх асуудлыг хэн хариуцахыг хуулиар зохицуулаагүй байна.

Үнэлгээ

Иргэдийн байгаль хамгаалах үйл явцад хяналт тавих хариуцлага тооцох эрх нь хүчин төгөлдөр үйлчилж буй байгаль орчны хуулиудад хяналт тавих, үзлэг хийх, холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, эрх бүхий байгууллагад санал хүргүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах төдийгөөр хязгаарлагдсан байдаг. Иргэд, олон нийтийн зүгээс байгаль орчны хуулиудын хэрэгжилтэд хяналт тавих, үзлэг хийх арга механизмыг хуульд тодорхой

⁵² Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо судалгааны тайлан. 2011. Хүний эрх хөгжил төв.

тусгаагүй тунхаг шинжтэй, хяналт, үзлэгийн зардлыг хэн хариуцан санхүүжүүлэх асуудлыг зохицуулаагүй байгаа нь уг заалтыг хэрэгжүүлэхэд түвэг учруулдаг. Өнөөгийн практикт ТББ-ууд өөрийн тойрогт сонгогдсон УИХ-ын гишүүд, УМХЕГ, БОНХЯ-нд гол төлөв хандаж, бүрэн эрхийнхээ хүрээнд хамтарсан ажлын хэсэг байгуулан байгаль орчны тулгамдсан асуудалтай газар дээр нь танилцах, хянаж шалгаж, дүгнэлт гаргах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох хүсэлт тавьсны дагуу хяналт шалгалтыг хийж ирсэн. Энэ нь зарим тохиолдолд үр дүнтэй болдгийн нэг жишээ нь “Ариун суварга” ТББ нь Орхон голын ай савд алт олборлож байсан бичил аж ахуйн нэгжүүдэд УМХЕГ, Улсын мөрдөн байцаах газрын байгаль ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх тасагтай хамтран шалгалт хийж, хууль бус үйлдлийг нь таслан зогсоож, эрүүгийн хэрэг үүсгэсэн явдал юм.⁵³

ТББ-ууд байгаль орчны хууль зөрчсөн үйлдлийг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргуулах, байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байх, хууль зүйн хариуцлага хүлээлгэх болон учирсан хохирлыг төлүүлэхийг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах үйл ажиллагаа зэрэг хуульд заасан оролцооны үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан хэвлэлийн бага хурал зохион байгуулах, өргөх бичиг барих, сонинд шаардлага, мэдэгдэл гаргах, телевизээр мэдээ, нэвтрүүлэг цацах, холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж албан бичиг илгээх зэрэг хуульд нийцсэн хэлбэрээр хэрэгжүүлдэг боловч үр дүнд хүрдэггүй. Иймээс арга мухардсан ард иргэд, байгаль орчны хөдөлгөөнүүд эсэргүүцэл тэмцлийн дараагийн хэлбэр болох жагсаал, цуглаан зохион байгуулах, суулт хийх, өлсгөлөн зарлах, морьт жагсаал хийх, Засгийн газрын ордонг гороолох, цонх руу нь нум сумаар харвах, замын хөдөлгөөнийг хаах, галт зэвсэг хэрэглэн хууль бус үйл ажиллагааг хүчээр таслан зогсоох зэрэг иргэдийн оролцооны нийцгүй, эрсдэлтэй, хүчирхийллийн аргыг сонгоход хүрдэг байна.

Ийм аргаар байгаль хамгаалахын төлөө хийсэн эсэргүүцэл тэмцэл нь эцэстээ ТББ-уудын манлайлагчдыг хэрэгтний ширээнд суулгахад хүргэж буй жишээ нь “Онги голынхон” хөдөлгөөний уул уурхайн компаниудын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоохын тулд явуулсан ажиллагаа юм. Энэ нь байгаль хамгаалагчдын хувьд болгоомжлох, айдаст автах, идэвх нь суларч, итгэл нь мөхөхөд нөлөөлж болзошгүй юм. Сүүлийн үед эрх мэдэлтэй, эд хөрөнгөтэй улс төр, бизнесийн бүлэглэлийн эсрэг байгаль хамгаалах чиглэлээр тууштай, зоригтой, хүчтэй эсэргүүцдэг ТББ-ын удирдагчдын амь нас, нэр төрийг хамгаалах хэрэгцээ шаардлага бий боллоо. Үүний нэг жишээ нь Монгол оронд явагдаж буй цацраг идэвхт ашигт малтмалын олборлолтыг эсэргүүцэн тэмцдэг ТББ-ын тэргүүнийг заналхийлсэн явдал болно⁵⁴. Түүнчлэн уул уурхайн компаниуд нийгмийн нэр нөлөө бүхий зүтгэлтнүүдийг хөлслөн өдөр тутмын сонингуудаар зорилго, зохион байгуулалттай гүтгэлэг, доромжийн өнгө аястай нийтлэлийг захиалгаар тогтмол гаргаж, байгаль орчны чиглэлээр үйл

⁵³ Монголын байгаль орчны хууль тогтоомжуудын үнэлгээ. 2010 оны намар, 2011 оны хаврын чуулган.

⁵⁴ “Байгаль орчны салбар дахь иргэдийн оролцооны эрх зүйн орчин, институци” сэдэвт дугуй ширээний хэлэлцүүлэгт оролцогчдын хэлсэн үгнээс. 2013 он

ажиллагаа явуулдаг 600 гаруй байгууллагыг “600 шантаажчин” гэж цоллох болсон нь байгаль орчин, нутаг ус, эх орныхоо эрдэнэс баялгийг эзний ёсоор хамгаалах хүсэл эрмэлзэлтэй иргэдийг мохоох, ТББ-уудын нэр хүндийг унагаах, нийгмийн сэтгэл зүйд сөрөг ойлголт бий болгох, нийгмийн дэмжлэгийг үгүй болгох гэсэн оролдлого болж байна.

Шүүхийн бус захиргааны аргаар байгаль орчны хууль бус үйлдэлтэй хариуцлага тооцох оролдлого хийгээд үр дүнд хүрдэггүй байгаль орчин, хүний эрхийн төлөө ажилладаг ТББ-ууд сүүлийн үед нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах стратегийн өмгөөллийн үйл ажиллагаа явуулах болсон. Гэвч ийм аргаар төр, засгийн байгууллага, албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагаатай хариуцлага тооцоход нэхэмжлэгч ТББ, тэдний өмгөөлөгчдийн хувьд дараахь бэрхшээл учирдаг байна.

Үүнд:

- Нэхэмжлэх эрхийн хязгаарлагдмал байдлаас байгаль орчны хэргүүдийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгодог.
- Өмгөөлөгч болон шинжээчийн хөлс төлөх, тэмдэгтийн хураамж төлөх мөнгөгүй.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулдаг нөлөөллийн ажиллагааны зардал өндөр байдаг.
- Экологийн хохирол тогтоох хөндлөнгийн шинжилгээний байгууллагууд хомс, чадавхи, дадлага, туршлага, материаллаг бааз дутмаг байгаа нь ТББ-ын хувьд нэхэмжлэлийн шаардлагыг тодорхой болгоход хүндрэл учруулдаг.
- Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа маш удаан тул нөхцөл байдал өөрчлөгдөж, тухайн үед тогтоосон экологийн хохирлын хэмжээ өөрчлөгдөх, хохирлыг дахин тогтоох шаардлага гарах эрсдэл учирдаг. Энэ нь тухайн хэрэг дээр ажиллаж буй ТББ-д сэтгэл зүй, эдийн засгийн давхар хохирол учруулдаг байна. Шүүгчдийн харьцаа, хандлага шударга бус, нэхэмжлэгч болон хариуцагч талд багагүй зүйл дээр ялгавартай ханддаг. Тодруулбал, шүүгчид эрх мэдэлтэй төрийн байгууллага, эд мөнгөтэй хувийн компаниудыг илүүд эрхэмлэн үздэг ба ТББ-ыг үл тоомсорлон ихэмсэг хандлах нь жирийн иргэдийн шүүхэд итгэх итгэлийг сулруулдаг.
- Шүүгчид хэргийн газар дээр үзлэг, туршилт хийдэггүй тул нэхэмжлэгч тал нотлох баримтыг хангалттай гаргахын тулд зардал их гаргадаг.
- Шүүх хурлыг хэргийг шийдвэрлэхэд нөлөөлөх онцын шалтгаангүйгээр хариуцагч талын үл ялиг шалтгаар олон удаа хойшлуулдаг нь ТББ-д чирэгдэл учруулдаг. Гэрчийг орон нутгаас зардал гаргаад авчирсан байхад хүртэл шүүх хурлыг хойшлуулах шийдвэр гаргах тохиолдол байдаг.
- Шүүх хурлыг нээлттэй хийж байгаа нэртэй ч жижигхэн танхимд сэтгүүлчдийг оруулахгүй байгаагаас шүүхийн шийдвэрийг олон нийтэд хүргэх боломжгүй болдог.

Иргэний нийгмийн байгууллагууд төр, засагтаа шууд хариуцлага тооцон ажилладаг нийгмийн хариуцлагын механизмыг өөрсдийн санаачилгаар хэрэгжүүлэх болсон. Үүний нэг жишээ нь байгаль орчинд ээлтэй эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор Монголын хамгаалах иргэдийн хөдөлгөөнүүдийн эвслийн 2006 оноос эхлэн

хэрэгжүүлж буй байгаль орчинд ээлтэй улс төрчдийг дэмжих, халтай улс төрчдийг сонгуульд дэмжихгүй байх замаар хариуцлага тооцдог “Ногоон од” хөтөлбөр юм. Тус байгууллага энэхүү хөтөлбөрийнхөө хүрээнд УИХ-ын ээлжит чуулганаар батлагдан гарч буй хууль тогтоомжид анализ хийж төрийн түшээд байгаль орчны талаар хэр зэрэг хүчин чармайлт гарган ажиллаж байгаа талаарх өөрсдийн үнэлэлт дүгнэлтийг “Монголын байгаль орчны хууль тогтоомжуудын үнэлгээ” тайландаа тусган сонгогч-иргэдэд хүргэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулсаар ирсэн юм. Энэ хугацаанд тус байгууллага УИХ-ын чуулганы үйл ажиллагааг үнэлж дүгнэсэн 5 тайлан гаргаж, монгол, англи хэлээр нийт 17900 хувь хэвлүүлж, эвслийн гишүүн хөдөлгөөнүүд болон бусад ТББ-уудаар дамжуулан давхардсан тоогоор төр, засгийн 1162 байгууллага, олон улсын болон төрийн бус 4111 байгууллагад хүргүүлж, 21 аймгийн 206 сумын 13627 сонгогч-иргэдэд түгээсэн байна.

Харин 2008-2012 оны УИХ-ын гишүүд бүрэн эрхийнхээ хугацаанд байгаль орчны төлөө юу хийв гэдгийг нэгтгэн дүгнэж, УИХ-ын ээлжит сонгуулийн өмнө 6 дахь тайлангаа гаргаж сонгогч-иргэдэд хүргэх зорилгоор байгаль орчны төлөө хуулиудад УИХ-ын гишүүн бүр ямар санал өгсөн тухай мэдээлэл авах хүсэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад удаа дараа гаргаж, олонтоо хандсан боловч хариу авч чадаагүй тул 2012 оны сонгуулиар байгаль орчинд халтай гишүүдтэй хариуцлага тооцож чадаагүй байна.

Дүгнэлт

Монгол орны байгалийн бүх баялаг “ард түмний мэдэлд байдаг” учраас иргэд байгалийн нөөц баялгаа байнга хянаж, үнэлж цэгнэж, түүний үр дүнг төрийн бодлого, шийдвэрт тусгуулж байх ёстой. Байгаль орчны салбар бол өөрөө нийтийн эрх ашгийн салбар учраас байгалийн баялгийнхаа хишгийг нэг хэсэг нь биш нийт иргэд тэгш хүртэж, тогтвортой хөгжих үүднээс нийтийн эрх ашигт нийцсэн бодлого боловсруулах, шийдвэр гаргуулахын тулд төрийг удирдах үйл хэрэгт иргэд тогтмол идэвхтэй оролцох шаардлагатай байдаг. Гэтэл Монгол улсын байгаль орчны суурь болон салбарын хуулиудыг бүхэлд нь авч үзвэл, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийн менежментийн асуудлаарх иргэдийн оролцоог маш ерөнхий, хэрэгжих механизм, зохицуулалтгүй, тунхгийн шинжтэй хуульчилсан байна.

Байгаль орчны мэдээлэх үйл явцад ахиц гарч байгаа хэдий ч зөвлөлдөх, идэвхтэй оролцох, хянах, хариуцлага тооцох зэрэг оролцооны нэн чухал үндсэн элментүүдийг хуульд цогцоор нь бүрэн гүйцэд, нарийн тусгаагүй, хэрэгжүүлэх процессыг журамлаж тодорхой болгоогүй байна. Тодруулбал, санал өгөх, үзлэг хийх, шаардлага тавих төдийхнөөр иргэдийн оролцоо, байгаль орчны эрхийг хязгаарласан формаль, бэлэгдлийн шинжтэй байгаа бөгөөд үүнийг хэрхэн хэрэгжүүлэх арга механизмыг хууль болон захиргааны шийдвэрээр баталгаажуулж өгөөгүй хэвээр байна. Иймээс байгалийн баялгийг Үндсэн хуулиар тунхагласан жинхэнэ эзэд нь болох иргэдийн оролцоотой хамгаалах үйлсийн хэрэгжилт хангалтгүй, хуулийн хийдэл, цоорхойтойгоо нэгэн адил алаг цоог, эрээвэр хураавар байна гэж дүгнэн үзэж болно.

Байгалийн баялгаа эдийн засгийн эргэлтэнд оруулж, уул уурхайн салбар үсрэнгүй хөгжиж, улс орны ирээдүй, эдийн засаг үүнээс ихээхэн хамааралтай болсон энэ цаг үед баялгийн менежментэд иргэдийн оролцох хүсэл сонирхол маш их нэмэгдэж байгаа хэдий ч оролцох арга замаа мэдэхгүй хэвээр байна. Үүнийг уул уурхай, ашигт малтмалын орлогыг хэрхэн зарцуулах талаар санал бодлоо илэрхийлэхийг судалгаанд оролцогчдын 68.9 хувь нь хүсч байгаа, байгалийн баялгийн орлогыг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах талаар шийдвэр гаргахад оролцохыг судалгаанд оролцогчдын 62.8 хувь нь хүсч байгаа дүн нотлон харуулна.⁵⁵

Дээр дурдсан бүхнийг нэгтгэн “Шерри Арнштейний оролцооны хөгжлийн шатлал”⁵⁶-аар авч үзвэл Монгол орны байгаль хамгаалах салбар дахь иргэдийн оролцооны хөгжил нь “оролцооны эхний буюу оромдсон үе” шатандаа байна гэж дүгнэж болно. Ийм учраас цаашид байгаль орчны салбарт хамтын шийдвэр гаргах, эрх мэдэл шилжүүлэх, иргэдийн хяналт тогтоох зэргээр иргэдийн “идэвхтэй оролцооны үе” шатанд нэн даруй шилжих эрх зүйн орчин болоод институцичиллыг бүрдүүлэх, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна. Энэ бол цаг үеийн шаардлага, нийгмийн захиалга, иргэдийн хүссэн хүлээлт юм.

Жинхэнэ оролцоо бол иргэд эрх мэдэлтэй байх буюу төрд хяналт тогтоох, иргэдэд төрийн зарим эрх үүргийг шилжүүлэх, төр нь иргэдтэйгээ эрх тэгш түншлэн ажиллах, хамтын шийдвэр гаргадаг болсон үед л бодитойгоор биеллээ олдог байна. Тодруулбал, иргэд байгаль орчны хууль тогтоомж болон байгаль орчны томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд бүрэн хяналт тавьж чаддаг байх, иргэдэд эрх мэдлийг шилжүүлж, байгаль орчны чиглэлийн төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлдэг байх, байгаль орчны төрийн төв байгууллага нь бодлого, хөтөлбөр боловсруулах, шийдвэр гаргах чиглэлээр иргэний нийгмийн байгууллагатай эрх тэгш түншлэх, хамтын шийдвэр гаргах зэрэг болно. Иймд цаашид төр, засаг иргэдийн байгаль орчны оролцоог хангахын тулд дээр дурдсан иргэдийн оролцооны 4 элементийг байгаль орчны хуулиудад цогцоор нь суулгаж, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг тодорхой хуульчилж өгөх шаардлагатай байна. Ялангуяа байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргах үйл явц дахь олон нийтийн оролцоо, шүүхээр хамгаалуулах боломжийн тухай конвенци буюу Аархусын конвенцид нэгдэн орох нь зүйтэй гэж үзэж байна.

Мэдээллийн хүртээмж ба ил тод байдлын талаар санал, зөвлөмж

- Нийтэд ил тод байлгах мэдээллийн жагсаалт гаргаж, түүний дагуу мэдээллээ тогтмол түгээх;⁵⁷

⁵⁵ Хүний хөгжил сангийн хишиг, хувийн хэлбэр, тайлагнал, үйлчилгээ, үр нөлөөний үнэлэмж судалгааны дүн. 2011. “Хөвсгөл далайн эзэд” хөдөлгөөн.

⁵⁶ 1969 онд Шерри Арнштейн хэмээх судлаач эмэгтэй иргэдийн оролцооны хөгжлийн үе шатыг оролцоог оромдох үе, оролцооны эхний үе, идэвхтэй оролцооны үе гэж 3 шатлалаар тодорхойлсон.

⁵⁷ Байгаль орчны салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, байгалийн баялгийн нөөцийг ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын бодлого, шийдвэр үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтэд мэдээлэх үүргийн хэрэгжилтийг хангах, мэдээллээ ил тод тайлагнах механизмыг сайжруулах нь судалгааны тайлан. 2008. НҮБ-ын “Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх” төсөл, МҮНХ-ний “Ногоон шинжээч” судалгааны баг,

- Байгаль орчны мэдээллийг ил тод болгох талаар төр болон хувийн хэвшлийн байгууллагын хуулиар хүлээх үүргийг тодорхой болгон үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх;
- Байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндийн асуудалтай холбоотой мэдээллийг байгууллагын нууцад хамааруулахгүй байх талаар Ашигт малтмалын тухай болон байгаль орчны хуулиудад тодорхой зааж өгөх;
- Нууцын тухай болон байгаль орчин, ашигт малтмалын тухай хууль тогтоомжуудыг өөрчлөн байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх шийдвэр, үйл ажиллагааны тухай мэдээлэл олон нийтэд хэзээд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх. Ялангуяа байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний ТЭЗҮ-г агуулсан БОНБНУ-ний тайланг бүхэлд нь олон нийтэд ил тод болгох;⁵⁸
- Байгалийн аливаа баялгийг эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх хөгжлийн төсөл хөтөлбөр, үйлдвэр үйлчилгээний газарт зөвшөөрөл олгохоос өмнө дээрх асуудлаар зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргах БОНБҮ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр зэрэг баримт бичгүүдийг олон нийтэд нээлттэй болгох тодорхой механизмыг байгаль орчны хуулиудад тусгах;⁵⁹
- Байгаль орчны суурь болон салбар хуулиудад иргэд, ТББ-ууд ямар мэдээллийг хэзээ, хэрхэн, хаанаас олж авах механизмыг нарийн тодорхой тусгах. Ингэхдээ ямар нэгэн шийдвэр гарахаас өмнө тухайн шийдвэрийн агуулга, үр дагаврын талаар дэлгэрэнгүй мэдээллийг иргэдэд тогтмол өгч, санал авах механизмыг бүрдүүлэх;⁶⁰
- Төрийн байгууллагууд мэдээллийг иргэдийн эрэлт шаардлагад нийцүүлэн энгийн ойлгомжтой хэллэг, хэлбэртэй тусгайлан боловсруулж тогтмол хүргэдэг байх;
- Цахим хэлбэрээр мэдээлэл өгөх тохиолдолд мэдээлэл олж авах аргын талаар танилцуулгыг урьдчилан тодорхой өгөх;
- Интернэтийн сүлжээгүй газарт мэдээлэл түгээхдээ хүртээмжтэй байдлыг хангасан тусгайлсан кампанит ажлыг сонирхолтой олон хэлбэрээр зохион байгуулах;
- Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орон нутгийн гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ олон нийтэд ил тод байх, түүнд иргэдийн санал хүсэлтийг тусгах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай, Ойн тухай хуулиудад заасан
- Байгаль орчны мэдээллийн сан, Ашигт малтмалын тухай хуульд заасан Тусгай зөвшөөрлийн болон зураг зүйн бүртгэлийн сангийн мэдээллийг нийтэд нээлттэй болгохыг хуульд тусгах; Мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх ажиллагаанд эрдэм

⁵⁸ Г.Уранцоож: Иргэний оролцоог хангах амлалт, зорилт, хэрэгжилтээс “Байгаль орчны салбар дахь иргэдийн оролцооны эрх зүйн орчин, институци” сэдэвт дугуй ширээний хэлэлцүүлэгт тавьсан илтгэл. 2013.01.17

⁵⁹ Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо судалгааны тайлан. 2011. Хүний эрх хөгжил төв.

⁶⁰ Мөн тайланд

шинжилгээний байгууллага, ТББ-уудтай хамтарч ажиллах хуулийн зохицуулалт бий болгох,⁶¹

Зөвлөлдөх орчны талаар санал, зөвлөмж

- Байгаль орчны шийдвэр гаргахад иргэдийн санал хүсэлтийг авч, гаргасан шийдвэртээ харгалзан үздэг тодорхой механизмуудыг байгаль орчны хуулиудад тусгах;
- Сав газрын зөвлөл болон Орчны бүсийн зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны төлөөлөл, байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын алба, ус ашиглагч байгааг эргэн харж, зөвхөн нутгийн иргэд, эрдэмтэн судлаачдаас бүрдүүлэх;⁶²
- Усны салбарын орон нутаг дахь бүтцийг бий болгож чадавхижуулах арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай. Ялангуяа сав газрын зөвлөлийг орон нутагт байгуулах нь онцгой чухал бөгөөд түүнийг ажиллах эрх зүй, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, төрийн бодлого үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд оролцох оролцоог өргөжүүлэх шаардлагатай. Сав газрын зөвлөлийг усны нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувиар санхүүжүүлэн ажиллуулахаар зохион байгуулах;⁶³
- Олон нийтээс авсан саналыг хууль боловсруулах үйл явцад хэрхэн ашигласан талаар эргэн хариу өгөх, тайлбар хийх;
- Газар нутгийг улс, орон нутгийн тусгай хамгаалалтад авах, гаргах асуудлыг шийдвэрлэхэд иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн иргэдээр хэлэлцүүлж, санал хүсэлтийг нь харгалзан үздэг байх зохицуулалтыг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай болон бусад холбогдох хуулиудад тусгах;

Идэвхтэй оролцооны талаар санал, зөвлөмж

- ИНБ, ТББ, нийгэмд үйлчилдэг байгууллага, гишүүддээ үйлчилдэг байгууллага, ашгийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зэрэг өөр хоорондоо холилдсон ойлголтын зөрүүг арилгаж, нэр томъёоны тодорхойлолт хийсний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг ТББ, мэргэжлийн холбоодод шилжүүлэх чиг үүргийг зааглан зохицуулах;
- Байгаль хамгаалах чиглэлээр төр ба ТББ-ын гүйцэтгэх чиг үүргийг хуулиар нарийн зааглаж, тодорхой зохицуулалттай болгох. Төр байгаль орчныг хамгаалах чиглэлээр юу хийх, юу хийхгүй байхыг тодорхой зааж өгөх;
- Байгалийн тодорхой төрлийн нөөцийн хамгаалалтын менежментийг гэрээлэхдээ санхүүжилтийг хамт шилжүүлэхийг төрд заавал хэрэгжүүлэх үүрэг болгон хуульчлах. Энэхүү үүргийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульд тодорхой заах;

⁶¹ Байгаль орчны зарим хуулийг шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, зөвлөмж боловсруулах зөвлөх багийн ажлын тайлан. 2009.

⁶² Мөн тайланд

⁶³ Мөн тайланд

- Гэрээлэх асуудлыг шат дамжлагагүй шуурхай шийдэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Нийгэмд үйлчилдэг ТББ-уудын хувьд төрийн тодорхой үүргийг гэрээлэх замаар дэмжих бодлого, зорилготой эрх зүйн орчныг бүрдүүлж, төрөөс санхүүжүүлэх, чадавхижуулах зэрэг арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх;
- Байгаль хамгаалагчийг ИТХ-аар сонгогддог, тухайн орон нутгийн иргэдийн төлөөлөл болсон, төрийн бус харъяалалтай албан тушаалтан болгох, мөн төрийн зарим үйлчилгээ, чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж цалин, хөлс авдаг байхаар хуульчилж өгөх;⁶⁴
- Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтад нутгийн иргэд, тэдний үүсгэл санаачлагаар байгуулагдсан иргэдийн нөхөрлөлийг өргөнөөр оролцуулах. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны үүргийг санхүүжилтийн хамт ТББ, аж ахуйн нэгж, хамтлаг, нөхөрлөлд бүрэн болон хэсэгчлэн хариуцуулах замаар төрийн ачааллыг хөнгөрүүлэх;⁶⁵
- БОНХЯ, байгаль орчны ТББ-уудтай зөвлөлдөж гэрээгээр шилжүүлэх чиг үүргийн жагсаалтыг гаргах;
- ТББ-уудын хувьд байгалийн нөөцийн менежмент, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжууд, замын цэвэрлэгээ, хог хаягдлын менежмент, экологи болон эрх зүйн боловсрол, ховор амьтныг үржүүлэх, булаг шанд, худаг, бэлчээрийг хамгаалах, цөлжилтийг бууруулах, байгаль орчны сурталчилгааны төвүүд, “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хэрэгжилт, орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газруудын хамгаалалт, хуулийн хэрэгжилтэд мониторинг үнэлгээ хийх, байгаль орчны суурь судалгаа хийх зэрэг төрийн зарим чиг үүргийг ТББ-уудаар гэрээлэн гүйцэтгүүлэх саналтай байгаа болно⁶⁶;

Иргэдийн хяналт тавих боломжийн талаар санал, зөвлөмж

- УИХ-ын гишүүдийн байгаль орчны хуулиудад өгсөн саналыг нэрээр нь УИХ-ын цахим хуудсанд байрлуулж, сонгогч-иргэд нь чөлөөтэй танилцах боломжоор хангахыг хуульд заах;
- Төрийн байгууллага, албан тушаалтан хүссэн мэдээлэл болон мэдээлэл өгөхөөс татгалзсан шалтгааныг заавал бичгээр өгдөг байхыг хуулиар үүрэгдэх;
- Байгаль орчны эрх нь зөрчигдсөн бол түүнийг сэргээн хамгаалах шүүхийн болон бусад хууль зүйн арга хэрэгсэл, тогтолцоог бүрдүүлэх;
- Байгаль орчны асуудлаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан хууль бус актын талаар сонирхсон этгээдүүд нэхэмжлэх нээлттэй эрхийг холбогдох хууль тогтоомжид тусгах⁶⁷;

⁶⁴ Мөн тайланд

⁶⁵ Байгаль орчны зарим хуулийг шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, зөвлөмж боловсруулах зөвлөх багийн ажлын тайлан. 2009.

⁶⁶ Байгаль орчны ТББ-уудад гэрээгээр шилжүүлэн гүйцэтгүүлэх чиг үүргийн жагсаалт гаргах уулзалтанд оролцогчдоос гаргасан санал. 2013.

⁶⁷ Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо судалгааны тайлан. 2011. Хүний эрх хөгжил төв.

- ТББ гомдлоо үнэ төлбөргүй, эсхүл хямд зардлаар шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Нийтийн эрх ашгийн төлөө шүүхэд нэхэмжлэл гаргасан ТББ-ыг тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, шүүхийн зардлыг төрөөс хариуцдаг болгох;
- Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нөлөөллийн ажиллагааг олон нийтийн статустай хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй явуулах;
- Байгаль орчны үнэлгээний компаниудын чадавхийг дээшлүүлэх, тоног төхөөрөмж, лабораторитой болгох, шинжээчдийг нь экологийн хохирол тогтоох аргачилалд суралцуулж, мэргэшүүлэх;
- Нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргасан тохиолдолд экологийн хохирол тогтоох зардлыг төр хариуцаж, төсвөөс гаргадаг байх;
- Нийтийн эрх ашгийг өмгөөлж буй өмгөөлөгчдийг төрөөс дэмжин урамшуулах замаар сайн дураараа үнэ төлбөргүй өмгөөлөл хийх санаачилгыг өрнүүлэх;
- Байгаль орчны холбогдолтой иргэний хэрэгт прокурор зөвхөн төрийн байгууллагын хүсэлтээр бус өөрийн санаачилгаар болон иргэд, ТББ-ын хүсэлтээр нэхэмжлэл гарган оролцох эрх зүйн боломжийг бий болгох;⁶⁸
- Байгаль орчны зөрчилд гомдол, нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацааг уртасгах үүднээс захиргааны журмаар шийдвэрлэгдэх байгаль орчны хэрэгт хөөн хэлэлцэх тусгай хугацаа тогтоох;⁶⁹
- Иргэдийн байгаль орчин, хүний эрхийн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт сурталчилгааг системтэйгээр зохион байгуулах үүргийг төрийн холбогдох байгууллагуудад оногдуулан, үйл ажиллагааны зардлыг төсөвт тусгах;⁷⁰ зэрэг болно.

⁶⁸ Мөн тайланд

⁶⁹ Мөн тайланд

⁷⁰ Мөн тайланд

НИЙГМИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮДЭД ОРОЛЦООГ ХАНГАСАН БАЙДАЛ

Б.Батхуу

Нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн салбарын эрх зүйн баримт бичгүүдийг судлах замаар мэдээлэх, зөвлөлдөх, идэвхтэй болон хяналтын оролцоог хангасан байдлыг тодорхойлох зорилготой. Энэ хэсгийн судалгаагаар зөвхөн нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн салбарын эрх зүйн баримт бичгүүдэд оролцоог хангасан байдлыг судалсан. Төрийн захиргааны нийтлэг эрх зүйн баримт бичгүүдэд тусгасан оролцооны зүйл, заалтуудыг энэ хэсэгт судлаагүй билээ. Түүнчлэн судалсан эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийн талаар тусгайлсан, бие даасан судалгааг хийгээгүй. Зөвхөн салбарын төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоотой зохион байгуулсан хэлэлцүүлгийн явцад үнэлж, дүгнэж байсан байр суурийг ерөнхийд нэгтгэсэн болно. Нийгмийн халамжийн салбарын 4 хууль, 6 сайдын тушаал, 3 бодлогын баримт бичиг, боловсролын салбарын 5 хууль, 4 бодлогын баримт бичиг, эрүүл мэндийн салбарын 10 орчим хууль, 4 бодлогын баримт бичиг, 3 сайдын тушаалыг хамруулан баримт бичгийн судалгааг явуулж, бэлтгэсэн хүснэгтийг бөглөсөн. Хэрэгжилтийн түвшинг тодорхойлохын тулд салбар, салбарын оролцооны талаар иргэд, олон нийт, төрийн байгууллагуудыг хамруулсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Эцэст дээрх үйл ажиллагаануудын үр дүнд цуглуулсан мэдээлэлд суурилан энэ тайланг бичсэн болно. (Хавсралт 7)

МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ БА ИЛ ТОД БАЙДАЛ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Нийгмийн халамжийн салбарт мэдээлэх оролцооны элементүүдийг тодорхойлсон гол хууль бол Нийгмийн халамжийн тухай хууль юм. Энэ хуулийн 25 дугаар зүйлд “Мэдээллийн нэгдсэн сүлжээнд нийгмийн халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудыг хамруулах”-аар заасан байна. Мөн төрийн захиргааны байгууллага хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдсон иргэд, байгууллагын санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үүргийг хүлээхээр заажээ. Хууль, тогтоомжийн хэрэгжилт гэдэг агуулга нэлээд өргөн боловч түүнийг нарийвчлан тайлбарласан тайлбар алга. Мөн хуулийн 28 дугаар зүйлд Нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх үүрэгтэй нийгмийн ажилтан нь иргэн, төр болон төрийн бус байгууллагыг мэдээллээр хангах үүргийг хүлээхээр заасан. Нийгмийн ажилтны хувьд ямар мэдээллийг, ямар байдал, агуулгатай, ямар арга замаар мэдээллээр хангах вэ гэсэн асуулт гардаг. Өнөөдөр ч хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дээд шатны даргын зөвшөөрөл практик байсаар байна. Энэ нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй төлөө хариуцлага хүлээх боломжийг хязгаарлах шалтгаан болно. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлд эцэг эх, асран халамжлагч нь хүүхдийнхээ эрүүл мэнд, өсөлт хөгжил, боловсролын асуудлаар мэдээлэл зөвлөгөө авах, хүүхдийнхээ сургалттай холбоотой хувийн зүгээс гаргасан зардлынхаа талаар мэдээлэл авах, сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаатай холбоотой санал гаргах эрхийг тодорхойлжээ. Харин

“Сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас баримтлах чиглэл бодлого” баримт бичигт бага насны хүүхдийн хөгжилд эцэг эх, гэр бүл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд байгууллагын нөөц бололцоо, түүнийг ашиглах стратеги, байгууллагын дүрэм журам, зорилго, зорилт зэрэг маш өргөн хүрээний асуудлаар эцэг эх, олон нийтийг мэдээллээр хангах үйл ажиллагааг тусгасан байна. Иргэн өөрийнхөө эрүүл мэнд, эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийн талаар болон эрүүл мэндийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор мэдээлэл авах эрхтэй гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан. Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, хүнсний хангамж, аюулгүй байдал, тамхины хэрэглээ, дам тамхидалтын сөрөг үр дагаврын талаарх мэдээллийг иргэн, олон нийт, аж ахуйн байгууллагад мэдээлэх үүргийг салбарын холбогдох хуулиудад баталгаажуулсан байна. Орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрт хүн амын дунд явуулах экологи, орчны болон нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглахаар заасан нь тодорхой арга хэрэгслийг тодорхойлсон ганц заалт байв.

Үнэлгээ

Мэдээлэл авах эрх нь иргэн хүний хамгийн суурь эрхүүдийн нэг боловч хэрэгжилт нь нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсролын салбарт хангалтгүй байгааг уулзалт, ярилцлагын явцад болон үнэлгээний баримт бичгүүдэд тэмдэглэж байв. Нийгмийн халамжийн салбарын дугуй ширээний ярилцлагын үед нийгмийн халамжийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах, шинэ дүрэм боловсруулах явцад зорилтот бүлгийн иргэдийн оролцоо хангалтгүй байсан талаар дурдаж байв. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн /ХБХ/ нийгмийн үйлчилгээний асуудал манай улсад дөнгөж эхлэлийн төдийхөнд байгаагаар холбоотой. Монгол улс нэлээн олон эрх зүйн баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар тусган өгсөн нь эхлэн харахад сайшаан дэмжүүштэй. Гэвч хуулийн заалтуудаас зарим нь хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй, зөвхөн тунхагийн шинжтэй байхад зарим эрхийн талаар зохицуулсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хариуцлагын механизм сул, хууль хэрэгжүүлэх эрмэлзэл төрийн зүгээс шаардлагын төвшинд хүрэхгүй байна. Монгол улсын хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрх бүхий этгээд гэж хандлагын үүднээс бус харин тусламж, халамж, өглөг хүртэгчид гэсэн хандлагын үүднээс ихэнх нь хандан үзсэн байдаг. Гэвч нийгмийн халамжийн салбарт мэдээлэл авах, өгөх эрх нь нөгөө хоёр салбартай харьцуулахад харьцангуй нээлттэй байна. Сургуулийн өмнөх боловсролын салбарт эцэг эх, асран халамжлагчид өөрийн хүүхдийнхээ талаар болон хувиасаа гарсан зардалтай холбоотой цэцэрлэгийн багш, ажилчдаас тодорхой мэдээлэл авах, эрүүл мэндийн салбарт өөрийн эрүүл мэндийн талаар тодорхой мэдээллийг авах эрхээр хангагдсан байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгоход цэцэрлэгийн үйл ажиллагаа, бодлого, төлөвлөлт, санхүүжилт, боловсон хүчний төлөвлөлтийн талаар илүү өргөн хүрээний мэдээлэл, мэдлэг эцэг эхэд шаардагдаж байгаа ч одоогоор авч чадахгүй байна.

Иргэд тухайн яамны хариуцсан үйлчилгээний чанар, үйл ажиллагаа зэрэг чиг үүргийн хүрээнд холбоотой асуудлаар өргөдөл гомдлыг яамдад гаргаж байдаг.

Өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх болон шаардлагатай бол дараагийн шатны байгууллагад иргэн хандах харилцааг нийтэд нь тусдаа хуулиар зохицуулсан байдаг. Эрүүл мэндийн яам 2012 онд 175 гомдол хүлээн авч шийдвэрлэснээс 78 буюу 44,5% нь НЭМГ-ын харьяа байгууллагуудтай холбоотой байжээ. Эдгээр 78 гомдлын 18 буюу 23,1% нь өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой, 41 буюу 52,5% нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой, 9 буюу 11,5% нь ёс зүй харьцаа хандлагатай холбоотой, 10 буюу 12,9% нь хүүхдийн түргэн тусламжтай холбоотой байв. Нийслэлийн хэмжээнд төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтаран сургалт, сурталчилгаа өдөрлөг, бусад үйл ажиллагаанууд хэрэгжүүлэх замаар нийслэлийн хүн амын 80-90%-д нийгмийн эрүүл мэндийн тодорхой сургалт, сурталчилгааг хүргэсэн гэсэн танилцуулгыг холбогдох байгууллагууд хийсэн. Нийслэлийн харьяа байгууллагаас 96,7% нь байгууллагын цахим хуудастай болсон ба 16 байгууллагын цахим хуудасны үйл ажиллагаа нь тогтворжиж, эдгээр байгууллагууд өөрийн цахим хуудсаар иргэдэд шаардлагатай бүх төрлийн мэдээ мэдээллийг өгч байна. Зөвхөн нийслэлийн эрүүл мэндийн газрын вэб сайт 2012 оны байдлаар нийтдээ 220 мэдээ мэдээллээр шинэчлэн баяжуулж 12 дугаар сарын 15-ны байдлаар хандалт 2,250,120 болсон нь өмнөх оны мөн үеийхээс 7 дахин өссөн үзүүлэлттэй байна. Гэвч иргэдийн хувьд мэдээлэл, үйлчилгээ хангалттай бус, хүртээмж багатай гэж үзэж байв.

Нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн орчин бий болгох, үйлчилгээ үзүүлэгч болон оролцогч, үйлчилгээ хүлээн авагч талуудын мэдээлэл өгөх, авах харилцааг илүү нээлттэй эрх зүйн хувьд зохицуулсан нь сайшаалтай. Цаашид олон улсын гэрээ конвенцид нийцүүлэн сайжруулах ёстой. Оролцогч, үйлчилгээ хүлээн авагч талуудын мэдээлэл өгөх, авах харилцааг зохицуулсан байгаа ч түүнийг хэрэгжүүлэх механизм, аргачилал, хариуцлагын тогтолцоо зэрэг тодорхойгүй нь эрх зүйн нэмэлт зохицуулалт шаардаж байна. Боловсрол, эрүүл мэндийн салбарт иргэн, эцэг эх, асран халамжлагчид хувь хүний хязгаарагдмал мэдээллийг авах боломжтой байна. Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, хүнсний хангамж, аюулгүй байдал, тамхины хэрэглээ, дам тамхидалтын сөрөг үр дагаврын талаарх мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах үүргийг эрүүл мэндийн байгууллага хүлээж байна.

ЗӨВЛӨЛДӨХ ОРОЛЦООНЫ ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах гол хэрэгсэл нь амьжиргааг дэмжих зөвлөл юм. Зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн үйл ажиллагааны хүрээг Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд дараахь байдлаар тодорхойлсон байна. Үүнд: Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл нь сум, хороонд ажиллах бөгөөд нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх талаар шийдвэр гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэгтэй. Зөвлөл нь нийгмийн ажилтан, төрийн байгууллагын төлөөлөл, иргэний төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөлөл гэсэн нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг 9-11 хүний бүрэлдэхүүнтэй, гурван жилийн хугацаагаар сонгож байхаар Боловсролын тухай хуульд заасан байна. Зөвлөл нь багш ажилтан, эцэг эх, сурагчийн төлөөлөлтэй байна. Энэ зөвлөл нь сургууль, цэцэрлэгийн дэг журам, дотоод зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох, үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үнэлгээ өгөх, сургалтын чанар, үйлчилгээг сайжруулах талаар удирдлага, үүсгэн байгуулагчид шаардлага тавих, захирал, эрхлэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих эрхтэй байна. Мөн эцэг эх, сурагчид хөтөлбөр, дүрэм, журам боловсруулах, шийдвэр гаргахад оролцох эрхтэй.

Бүх шатны боловсролын үйл ажиллагаа явуулах байгууллагын эрхийг баталгаажуулах үүрэг бүхий магадлан итгэмжлэх байгууллагад олон нийтийн төлөөллийг хангах зорилтыг Төрөөс боловсролын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгасан байна.

Хувиргасан амьд организмын тухай хуулийн 4 дүгээр зүйлд био аюулгүй байдлын үндэсний зөвлөл байгуулахад, мөн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг зохицуулах салбар зөвлөлийн журманд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг зохицуулах салбар зөвлөлүүдэд төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулахаар заасан байна. Эрүүл мэндийн салбарын үндсэн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, олон нийт, төрийн бус байгууллагуудын оролцох эрх зүйн боломж хязгаарагдмал байна. Хүний эрүүл мэндэд харш үйлчилгээ явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн талаар холбогдох байгууллагад өргөдөл, гомдол гаргах эрхийг эрүүл мэндийн тухай хуулийн 43.1.5 заалтад баталгаажуулсан байна.

Үнэлгээ

Засаг захиргааны анхан шатны нэгжид нийгмийн халамжийн зарим үйлчилгээг үзүүлэх, түүнтэй холбоотой өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагааг сум хорооны амьжиргааг дэмжих зөвлөл хэрэгжүүлж байна. Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийг сонгох үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар хэлэлцүүлэгт оролцогчид ярьж байв. Хэлэлцүүлэгт оролцогч Амьжиргааг дэмжих зөвлөл нь хуулинд асуудлыг шийднэ гэсэн том заалттай ч зөвхөн материал бүрдүүлэлтийг хянах байгууллага мэт үйлчлүүлэгч нарт харагддаг. Ер нь хорооны нийгмийн ажилтан энэ Зөвлөлийн нэрийн өмнөөс ажилладаг мэт санагддаг гэж дүгнэсэн байна. Гэхдээ Амьжиргааг дэмжих зөвлөл нь 2011 оны жилийн эцсийн байдлаар нийт 392 сум, хороонд 904 үүсгэл санаачилгын бүлгийг дэмжиж 1 сая хүртэлх төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд түүнд 2995 өрхийн 4846 иргэн хамрагдсан. Түүнчлэн яамдын сайдын зөвлөл болон тодорхой асуудлаар байгуулагдсан ажлын хэсгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл оролцох туршлага нэмэгдсэн талаар хэлэлцүүлэгт оролцогчид танилцуулж байв.

Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг тухайн сургууль, цэцэрлэгийн нийт хамт олны хурлаас сонгож байна. Энэ зөвлөлийг хамт олны хурлаас сонгож байгаа хуулийн зохицуулалт нь оновчтой бус юм. Энэ зөвлөлийн эрх мэдлийг өргөжүүлэх, сургуулийн удирдлагыг томилох, төсвийг хуваарилалтыг хэлэлцэх эрхтэй болгох шаардлага байна. Энэ нөхцөлд энэ зөвлөлийг тухайн байгууллагын нийт ажиллагсдын

хурлаас биш тухайн нутаг дэвсгэрт нээлттэй сонгон шалгаруулалт явуулах замаар сонгох нь тохиромжтой байж болох юм. Санхүүжилт нь тодорхой байх ёстой. Эрүүл мэндийн чанарын хяналтын Нийслэлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Нийслэлийн Засаг даргын 2012 оны 04 сарын 09 өдрийн А/240 дугаар захирамжаар баталсан ба зөвлөлийг төр болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй байгуулжээ. Мөн төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх Тусгай зөвшөөрөл олгох нийслэлийн комисс, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, хэсгийн хороод үйл ажиллагаагаа явуулж байна.

Амьжиргааг дэмжих зөвлөл, сургууль, цэцэрлэгийн зөвлөлд иргэд, олон нийт оролцож, тодорхой шийдвэрийг хамтран гаргах бололцоо бүрдсэн байна. Гэхдээ эдгээр зөвлөлийн гишүүдийг сонгож байгаа арга хэлбэр, зарчим тодорхойгүй байна. Ялангуяа сургууль, цэцэрлэгийн хамт олны хурлаас сонгоно гэж ерөнхийлөн заасан нь тухайн байгууллагын удирдлага өөрсдийн үйл ажиллагааг дэмждэг төлөөллийг өөрсдийн үзэмжээр сонгуулах боломжийг бүрдүүлж байна. Эрүүл мэндийн салбарт зөвлөлдөх, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах механизм бусад хоёр салбартай харьцуулахад хамрах хүрээ хязгаарагдмал байна.

ИДЭВХТЭЙ ОРОЛЦООНЫ ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хүргэхэд иргэн, зорилтот бүлгийн гишүүд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах, мэргэжил арга зүйгээр хангах, тэдний үйл ажиллагааг удирдах, зохицуулах чиг үүргийг асуудал хариуцсан төрийн байгууллагад хүлээлгэсэн байна. Дараах олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээг дээр дурдсан байгууллагууд хүргэхээр заасан байна. Үүнд:

- Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох авьяасыг дэмжих сургалт зохион байгуулах;
- Зөвлөгөө өгөх;
- Сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
- Түр байрлуулан асрамжлах;
- Өдрийн үйлчилгээнд хамруулах;
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
- Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
- Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах;

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн зохих байгууллагууд санхүүжүүлнэ. Халамжийн үйлчилгээг хүргэх байгууллагыг аймаг, нийслэл, дүүргийн

нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага сонгон шалгаруулна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар болон үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал, зааврыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн ашгийг хамгаалах болон ахмадуудын санаачилгын байгууллагууд тодорхой ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх, санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх бодлогыг боловсруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай болон өндөр настны нийгмийн хамгааллын тухай зэрэг холбогдох хуулиудад нарийвчлан тусгажээ. Түүнчлэн нийгмийн халамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд олон нийт болон төрийн бус байгууллагуудад мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүргийг төрийн захиргааны байгууллага хүлээж байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, мөн хуулийн 13 дугаар зүйлд бодлого, арга хэмжээг төрийн бус байгууллага, олон нийт, иргэний хамтын үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, боловсролыг хамтран хүргэх, өрхийн эмнэлгийн үйлчилгээг гэрээгээр хүргүүлэх зэрэг идэвхтэй оролцооны олон хэлбэрийг тодорхойлсон байна. Мөн эх сүү орлуулагч бүтээгдэхүүн тухай болон тамхины хяналтын тухай хуульд эдгээр үйл ажиллагааг төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр заасан байдаг. Түүнчлэн эрүүл мэндийн салбарын 2010 – 2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөний 7 дугаар чиглэлд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангахаар тусгажээ.

Боловсролын салбарын хуулиудад идэвхтэй оролцооны талаар тодорхой зүйл, заалт байхгүй. Харин боловсролын салбарын зарим баримт бичгүүдэд цөөхөн тооны заалтууд байна. Төрөөс боловсролын талаар баримтлах үндсэн чиглэлд “хүүхэд, залуучуудын үүсгэл санаачилгын байгууллагыг дэмжих, тэдэнд туслалцаа үзүүлэх, эрх ашгийг хамгаалах” гэж тусгажээ. Мөн 2007 онд “Бага насны хүүхдийн хөгжилд эцэг, эх, гэр бүл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас баримтлах чиглэл” баримт бичгийг БСШУЯ гаргасан байна. Уг баримт бичигт эцэг эх, олон нийтийн оролцооны хүрээг нэмэгдүүлэх олон асуудлыг тусгасан байна. Гэхдээ оролцооны арга хэрэгсэл, хэрэгжүүлэх аргачлалын талаар тодорхойлсон байдал хангалтгүй байна.

Үнэлгээ

Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настны эрх ашгийг хамгаалах болон санаачилгын байгууллагууд нилээд хэмжээгээр нэмэгдсэн байна. Эдгээр байгууллагууд өөрсдийн санаачилга, Монголд үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагуудын тусламжтайгаар тодорхой үйл ажиллагаануудыг идэвхтэй явуулах болсон байна. Үүний үр дүнд эдгээр байгууллагуудын чадавхи, туршлага мэдэгдэхүйц сайжирч байна. Гэвч олон нийт, төрийн бус байгууллагуудын оролцоог хангах талаар бодлого, хуулийн олон тооны

заалт, зохицуулалт байгаа ч бодит амьдралын хэрэгцээг хангахгүй байна. Дугуй ширээний ярилцлага хэлэлцүүлгийн үеэр тавьсан илтгэлүүдээ тодорхой жишээтэйгээр танилцуулж байв. Өнөөдөр Ази-Номхон далайн бүсийн орны Бие даан амьдрах төвийн сүлжээ, Европын бие даан амьдрах төвийн сүлжээ хэмээх бүс нутгийг хамарсан сүлжээ байгууллагууд үүсэн ажиллахын зэрэгцээ АНУ-д 700 гаруй⁷¹, Японд 238, Солонгост 220-н Бие Даан амьдрах төв гэх зэргээр улс орон бүр уг системийг хөгжүүлэн ажиллаж байна. Бусад хүмүүсийн нэгэн адил өөртөө холбоотой аливаа асуудлаа өөрөө бие даан шийдвэр гаргах эрх мэдэл, боломжтой, өөрийгөө хүндэтгэдэг, бусадтай адил тэгш боломжоор хангагдах үзэл баримтлалыг бие даан амьдрах үзэл хэмээн нэрлэж байна⁷². Энэ үзэл баримтлал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийнхөө хэрэгцээ шаардлагыг өөрсдөө хамгийн сайн мэдэх хүмүүс буюу “Бидэнгүйгээр бидний асуудлыг шийдэхгүй” гэсэн уриатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлгөөний үзэл баримтлал юм.

Монгол Улсад бие даан амьдрах үзэл баримтлалыг дэмждэг хэсэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс анх 2010 онд Түгээмэл хөгжил төв Бие даан амьдрах төвийг байгуулан ажиллаж байна. Тус төв нь байгуулагдсан үеэсээ эхлэн төрийн байгууллагатай хамтран ажиллах саналыг хэд хэдэн удаа тавьсан ч Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн ХХҮХ 2011 онд 4 сар, Чингэлтэй дүүргийн ХХҮХ 3 сар хамтран ажилласныг эс тооцвол ямар ч дэмжлэг аваагүй учир хүнд хэлбэрийн ХБХ-т туслах хүн илгээн ажиллах үйлчилгээ хийгдэхгүй байна. Гэвч зарим төрлийн үйлчилгээ, үйл ажиллагааг янз бүрийн олон улсын байгууллагын тусламж, гишүүдийн дэмжлэгтэй тасралтгүй явуулж байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд 2007 онд 468.6 сая төгрөгийг зарцуулсан бол 2012 онд 3.776.4 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн байна. Мөн үйлчилгээнд 2007 онд 7611 хүн хамрагдсан бол 2011 онд 22718 хүн хамрагдсан байв. Өвөрхангай аймгийн олон нийтийн оролцсон түшиглэсэн үйлчилгээг 2007 оноос эхлэн амжилттай хэрэгжүүлж иржээ. 2012 онд нийт 14 суманд иргэдийн үүсэл санаачилгаар 30 бүлэг байгуулагдан тэдгээрт ахмад настан-26 өрх толгойлсон эцэг, эх 15, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 48 байна. Бүлгүүдийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл оёдлын 9, гэрийн модон эдлэл, мужааны 4, гутал засвар 1, эсгий эдлэл, сүлжмэл, гар урлалын 3, хүнсний ногоо 3, цайны газар 2, Шахмал түлш үйлдвэрлэх 1, гар утас засвар 1, байшин барих 1, асаргаа сувилгааны 1 бүлгүүд бий болсон бөгөөд нийт 30 сая төгрөгний санхүүжилт олгосон байна. Дэмжлэг авсан бүлгийн өрх, иргэд тогтмол орлоготой болж амьжиргааны түвшин дээшилж, үйл ажиллагаа нь өргөжиж байна. Бүлгийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс зөвхөн ХХҮХ, нийгмийн ажилтан бус сумдын удирдлагуудын зүгээс анхааран хяналт тавьж ажиллаж байгаа нь төслийг амжилттай хэрэгжих нөхцлийг бүрдүүлсэн байв.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйл буюу “төрийн зохих байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус

⁷¹ <http://www.ncil.org/about/aboutil/>

⁷² http://en.wikipedia.org/wiki/Independent_living/

байгууллагаар гүйцэтгүүлэх” гэсэн асуудлыг амьдралд бодитоор хэрэгжүүлэхийг хүсэж байв. Оролцогчид тухайн хуулийн зүйл, заалтын хэрэгжилт хязгаарагдмал, далд хүрээнд байна гэж үзэж байв. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам жил бүр дунджаар 40 -50 төрийн бус байгууллагаар тодорхой судалгаа, шинжилгээ, үйлчилгээ үзүүлэх гэрээг шууд байгуулж, ажиллаж ирсэн байна. Үүнийг ил тод, нээлттэй болгохыг тулд холбогдох яам жил бүр гэрээгээр гүйцэтгүүлэх, зөвлөх болон нийгмийн халамжийн /мэргэжлийн бус/ үйлчилгээний жагсаалтыг гаргаж, зарладаг байх, сонгон шалгаруулалтыг нээлттэй хийдэг байх, үйл ажиллагааны санхүүжилт тодорхой байх, сонгон шалгаруулах ажлын хэсэгт зорилтот бүлгийн төлөөллийг оролцуулах шаардлагатай гэсэн саналыг тавьж байв.

Нийгмийн эрүүл мэндийн олон тооны ажил, үйлчилгээг хувийн хэвшил, мэргэжлийн төрийн бус байгууллагууд хэрэгжүүлэх санал санаачилга гарч байна. Тухайлбал: 2010 онд Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын “Хүн амын эрүүл мэндийг хамгаалахад хороо, өрхийн эмнэлэг, иргэд хамтдаа” хөдөлгөөн өрнүүлж, сайн дурын идэвхтэнүүдийн тоог нэмэгдүүлэх, сургаж бэлтгэх, идэвхжүүлэх арга хэмжээний дагуу Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл VSO Олон улсын байгууллагатай хамтран 50 эрүүл мэндийн сайн дурын идэвхтэнг бэлтгэн төгсгөж, хувцас, цүнхээр хангажээ. Цаашид эдгээр үйлчилгээний хэлбэрийг боловсронгуй болгох, хөгжүүлэх шаардлага байгаа талаар салбарын ярилцлага оролцогч талууд өгүүлж байв. Боловсролын салбарт хүүхдийн санаачилгын байгууллагуудын үйл ажиллагаа хөгжсөн байдаг ч эдгээрийг хуульчилж, зохицуулсан заалт судалсан эрх зүйн баримт бичгүүдэд ховор байв.

Идэвхтэй оролцоог хүлээн зөвшөөрсөн ч бодит амьдралд хэрэгжих бололцоо янз бүрийн шалтгаанаар гурван салбарт хангалтгүй байна. Нийгмийн халамж, эрүүл мэндийн салбарт оролцооны хамгийн үр дүнтэй хэлбэрийн нэг болох идэвхтэй оролцооны хэлбэрийг ашиглах боломжийг нэлээд нээлттэй тодорхойлсон нь сайшаалтай. Ялангуяа олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөл, санхүүжилт, үйлчилгээний стандарт, шалгуур үзүүлэлт зэрэг олон асуудлыг Нийгмийн халамжийн тухай шинэчилсэн хуулиар нарийвчлан тодорхойлсон нь сайшаалтай. Мөн энэ үйлчилгээний төсөв жилээс жилд өсөж байгаа ч энэ төрлийн үйлчилгээний хэрэгцээ өндөр байгааг нотолсон үзүүлэлт юм.

ИРГЭДИЙН ХЯНАЛТ ТАВИХ БОЛОМЖ

Эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон байдал

Төрийн байгууллагын үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээний харилцааг бие даасан эрх зүйн баримт бичгээр нийтлэг байдлаар зохицуулсан байдаг. Үүнтэй холбоотой хяналтын оролцооны заалтууд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбарын хуулиудад цөөн байв. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, багшийн үйл ажиллагаанд хяналт тавих, иргэд өөрийн хандивласан хөрөнгийнхөө зарцуулалт, ашиглалтанд хяналт тавих эрх, үүргийг эцэг эх, асран хамгаалагчид олгосон бол Эрүүл мэндийн тухай хуульд эрүүл мэндийн хууль, тогтоомжийн биелэлтэнд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах эрхийг төрийн бус байгууллагад олгосон

заалтууд байна. Харин нийгмийн халамжийн зарим нэг журмуудад салбарын сангийн зарцуулалт, хуваарилалт, хэрэгжилтэнд хяналт тавих боломжоор иргэд, олон нийтийг хангахаар тусгасан байна.

Үнэлгээ

Хэдийгээр зарим салбарын хуулинд хяналтын талаар ерөнхий заалт байгаа ч бодит амьдрал дээр хэрэгжилт бүрхэг байна. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хяналт тавих гэдэг нь маш өргөн ойлголт боловч хяналтыг яаж, хэзээ, ямар хэлбэрээр хийх вэ гэдэг нь тодорхойгүй байна. Мөн хяналтын үйл ажиллагааны санхүүжилт байхгүй байна. Нийслэлийн Эрүүл мэндийн газар харьяа байгууллагуудын хэмжээнд 2011 оноос Алдаа зөрчлийн Сайн туршлагын сан үүсгэн ажиллаж байна. 2012 онд улирал бүр бүртгэгдсэн алдаа/зөрчлийн мэдээг хүлээн авч нэгтгэн дүгнэлт хийж байгаа ба нийт 11 нотлогдсон алдаа / мэргэжлийн хяналтын байгууллага болон өөрийн байгууллагын чанарын алба, ёс зүй хорооноос тогтоосон /, 750 гаруй зөрчил бүртгэгдсэн байв. Бүртгэгдсэн зөрчлийн бүтцийг авч үзвэл ихэнх хувийг анхан шатны бичиг баримтын хөтлөлт, өвчний түүх бичилтийн стандартын зөрчил, эмч эмнэлгийн ажилтаны ёс зүй, харьцаатай холбоотой зөрчлүүд эзэлж байжээ. Энэ үйлчилгээний чанарын хяналтын сайн туршлага болж байна.

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбарын хяналтын оролцооны зохицуулалт нь салбарын хуулиудаар бус төрийн захиргааны нийтлэг хууль, дүрэм, журмын хүрээнд явагдаж байна. Иймд төрийн захиргааны нийтлэг зохицуулалтын эрх зүйн баримт бичгийн судалгаа хийсэн ажлын хэсгийн дүн шинжилгээтэй танилцах нь зүйтэй.

Дүгнэлт

Нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн салбарын эрх зүйн зарим баримт бичгүүдийг судалж, дугуй ширээний ярилцлага хийх замаар мэдээлэл, зөвлөлдөх, идэвхтэй, хяналтын оролцоог хангасан байдалд дүн шинжилгээг хийв. Нийгмийн салбарын эрх зүйн баримт бичгүүдэд оролцооны олон хэлбэрийн үйл ажиллагааг тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн салбарт иргэд, олон нийтийн оролцоо эрх тодорхой хэмжээнд хангагдсан гэж үзэх боломжтой. Оролцоо эрх хэр түвшинд хангагдсан, хэр хангагдаж байгааг бүрэн хэмжээгээр энэ судалгаагаар бүрэн тодорхойлох бололцоогүй юм.

Дээрх гурван салбарт мэдээлэл, зөвлөлдөх, идэвхтэй, хяналтын оролцоог эрх зүйн баримт бичгийн хүрээнд нилээд ялгаатай тодорхойлсон байна. Энэ нь салбарын онцлог, салбарын төрийн бус байгууллагуудын хөгжил зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Мэдээлэх оролцооны хувьд боловсрол, эрүүл мэндийн салбарт иргэн, эцэг эх, асран халамжлагчид хувь хүний хязгаарлагдмал мэдээллийг авах боломжтой байгаа бол нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн орчин бий болгох, үйлчилгээ үзүүлэгч болон оролцогч, үйлчилгээ хүлээн авагч талуудын мэдээлэл өгөх, авах харилцааг илүү нээлттэй эрх зүйн хувьд зохицуулсан нь сайшаалтай. Зөвлөлдөх оролцооны хувьд амьжиргааг дэмжих зөвлөл, сургууль, цэцэрлэгийн зөвлөлд иргэд, олон нийт оролцож, тодорхой шийдвэрийг хамтран гаргах бололцоо бүрдсэн байна.

Харин эрүүл мэндийн салбарт зөвлөлдөх, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах механизм бусад хоёр салбартай харьцуулахад бага хөгжсөн байна. Идэвхтэй оролцооны хувьд нийгмийн халамж, эрүүл мэндийн салбарт оролцооны хамгийн үр дүнтэй хэлбэрийн нэг болох идэвхтэй оролцооны хэлбэрийг ашиглах боломжийг нэлээд нээлттэй тодорхойлсон нь сайшаалтай. Хяналтын оролцооны хувьд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбарын хяналтын оролцооны зохицуулалт нь салбарын хуулиудаар бус төрийн захиргааны нийтлэг хууль, дүрэм, журмын хүрээнд зонхилон явагдаж байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн олон нийтэд түшиглэсэн үйлчилгээний талаарх зүйл, заалт, Боловсролын тухай хуулийн сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн талаарх зүйл заалтууд нь бусад хуулийн зүйл, заалтуудтай харьцуулахад илүү хэрэгжих боломжтой томъёологдсон байна. Мөн оролцоог хэрэгжүүлэхэд түүнийг хариуцах албан тушаалтан, санхүүжилтийн хэлбэр зэрэг тодорхой байх нь чухал юм. Хуулийн заалтыг хэрэгжүүлэх дүрэм, журам, стандартуудын зохих түвшинд боловсруулах шаардлагатай байна. Нийгмийн салбарын эрх зүйн баримт бичгүүдэд оролцоог тодорхой түвшинд хангасан байгаа ч салбарын хэмжээнд бүрэн хэмжээгээр тодорхойлохын тулд төрийн захиргааны нийтлэг харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүдийн үр дүнтэй нэгтгэн харах хэрэгтэй.

Дүгнэлт

Монгол улсын суурь болон салбарын хуулиудыг бүхэлд нь авч үзвэл иргэдийн оролцоо түвшин, салбаарас хамааран адилгүй байна. “Шерри Арнштейний оролцооны хөгжлийн шатлал”¹-аар авч үзвэл Монгол орны иргэдийн оролцооны хөгжил нь мөн адилгүй: зарим салбар “оролцооны эхний буюу оромдсон үе” шатандаа байхад зарим нь жишээлбэл, байгал орчны салбарын адил идэвхитэй оролцооны шатанд орсон байна. Үүнийг суурь болон салбар хуулиар авч үзвэл:

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн 1-р бүлгийн 3-р зүйл, 2-р бүлгийн 16.9,10,12,16,17-д иргэдийн оролцооны үндсийг бүрдүүлж холбогдох зарим хуулиудаар зохицуулж байна. Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ иргэдийн оролцоотой хамгаалах асуудлын хэрэгжилт хангалтгүй, хуулийн хийдэл алаг цоог, эрээвэр хураавар байна.
2. Одоогийн мөрдөгдөж байгаа зарим хуулиудын зүйл заалтууд нь оролцуулж болно, шаардлагатай гэж үзвэл, үндэслэлтэй гэж үзвэл гэх зэргээр хэрэгжихэд төвөгтэй олон янз байна.
3. Иргэдийн оролцооны үндсийг гаргаж ирсэн ч хэрэгжүүлэх арга механизмуудын талаар тусгаж өгөөгүй, эсвэл холбогдох дүрэм журмууд гараагүй байна.
4. Хууль тогтоомжуудын хэрэгжилт муу байна.
5. Орон нутгийн эрх зүйн баримт бичгүүдэд иргэд, олон нийтийн оролцоо тодорхой хэмжээгээр хангагдсан нааштай өөрчлөлтүүд хийгдэж буй шилжилтийн үе гэж тодорхойлох боломжтой юм. 2012 оны орон нутгийн сонгуулиар байгуулагдсан ИТХ болон Засаг даргын зүгээс Хурлын дэг, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр багагүй санаачилга орсон байна. Гэсэн хэдий ч ялангуяа Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан иргэдийн оролцооны заалтууд нь хэрэгжих боломж нь тодорхойгүй, Засаг даргын зүгээс иргэдийн санал санаачилгыг “дэмжиж” ажиллах заалт цөөн байна. Иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс санаачилга гаргаагүй тохиолдолд орон нутгийн түвшинд иргэдийн оролцоо хангагдахгүй эрсдэл харагдаж байна. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх “Нийслэлийн төсвийг иргэдээр хэлэлцүүлж, санал авах”, “Хот төлөвлөлтийг иргэдээр хэлэлцүүлж, санал авах” зэрэг заалт нь иргэдийн оролцоог орон нутгийн шийдвэр гаргах шатанд хангаж буй зоригтой шийдэл болсон бөгөөд өмнө нь ийм туршлага байгаагүй гэдгийг дурдах хэрэгтэй юм.
6. Монгол улс дахь төсвийн харилцаа, төсвийн мэдээллийн ил тод байдлыг хангах харилцааг зохицуулж буй хууль, журмуудыг бүхэлд нь авч үзвэл иргэдийн оролцоонд тулгуурласан төсвийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн боловч хуулийн заалтууд нэлээд ерөнхий, тэдгээрт нийцүүлэн гаргасан журмуудыг

¹ 1969 онд Шерри Арнштейны иргэдийн оролцооны хөгжлийн үе шатыг оролцоог оромдох үе /үгүйсгэх, тайвшруулах, дүр үзүүлэх/, оролцооны эхний үе /мэдээлэх, зөвлөлдөх/, идэвхитэй оролцооны үе /хамтын шийдвэр гаргах, эрх мэдэл шилжүүлэх, иргэдийн оролцоо/ гэж 3 шатлалаар тодорхойлсон байдаг.

хэрэгжүүлэх механизм хангалтгүй байна. Үүний зэрэгцээ хууль, журмын хэрэгжилтийг хянах, үнэлэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог нарийвчлан тодорхойлоогүй, хуулиуд хоорондын уялдааг сайтар хангахад анхаарах шаардлагатай байна. Тухайлбал, төсвийн мэдээллийг ил тод болгосноор иргэдээс санал авах боломжийг олгох зарчмыг баримтлахаар хуульчилсан ч оролцоог хангах талаар Төсвийн тухай хуульд зөвхөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зориулалтын талаар иргэдээс санал авч, ИНХ-аар хэлэлцэж эрэмбэлэх зохицуулалт л тусгагджээ.

7. Байгаль орчны мэдээлэх үйл явцад ахиц гарч байгаа хэдий ч зөвлөлдөх, идэвхитэй оролцох, хянах, хариуцлага тооцох зэрэг оролцооны нэн чухал үндсэн хэлбэрүүдийг хуульд цогцоор нь бүрэн гүйцэд, нарийн тусгаагүй, хэрэгжүүлэх процессыг журамлаж тодорхой болгоогүй байна. Тодруулбал, санал өгөх, үзлэг хийх, шаардлага тавих төдийхнөөр иргэдийн оролцоо, байгаль орчны эрхийг хязгаарласан формаль, бэлэгдлийн шинжтэй байгаа бөгөөд үүнийг хэрхэн хэрэгжүүлэх арга механизмыг хууль болон захиргааны шийдвэрээр баталгаажуулж өгөөгүй хэвээр байна.

8. Нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн салбарт мэдээллийн хүртээмж, ил тод байдал, зөвлөлдөх, идэвхитэй, хяналтын оролцоог эрх зүйн баримт бичгийн хүрээнд нилээд ялгаатай тодорхойлсон байна. Энэ нь салбарын онцлог, салбарын төрийн бус байгууллагуудын хөгжил зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Мэдээлэх оролцооны хувьд боловсрол, эрүүл мэндийн салбарт иргэн, эцэг эх, асран халамжлагчид хувь хүний хязгаарлагдмал мэдээллийг авах боломжтой байгаа бол нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн орчин бий болгох, үйлчилгээ үзүүлэгч болон оролцогч, үйлчилгээ хүлээн авагч талуудын мэдээлэл өгөх, авах харилцааг илүү нээлттэй эрх зүйн хувьд зохицуулсан нь сайшаалтай. Зөвлөлдөх оролцооны хувьд амьжиргааг дэмжих зөвлөл, сургууль, цэцэрлэгийн зөвлөлд иргэд, олон нийт оролцож, тодорхой шийдвэрийг хамтран гаргах бололцоо бүрдсэн байна. Харин эрүүл мэндийн салбарт зөвлөлдөх, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах механизм бусад хоёр салбартай харьцуулахад бага хөгжсөн байна. Идэвхитэй оролцооны хувьд нийгмийн халамж, эрүүл мэндийн салбарт оролцооны хамгийн үр дүнтэй хэлбэрийн нэг болох идэвхитэй оролцооны хэлбэрийг ашиглах боломжийг нилээд нээлттэй тодорхойлсон нь сайшаалтай. Иргэдийн хяналтын хувьд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбарын хяналтын оролцооны зохицуулалт нь салбарын хуулиудаар бус төрийн захиргааны нийтлэг хууль, дүрэм, журмын хүрээнд зонхилон явагдаж байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн олон нийтэд түшиглэсэн үйлчилгээний талаарх зүйл, заалт, Боловсролын тухай хуулийн сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн талаарх зүйл заалтууд нь бусад хуулийн зүйл, заалтуудтай харьцуулахад илүү хэрэгжих боломжтой томъёологдсон байна. Мөн оролцоог хэрэгжүүлэхэд түүнийг хариуцах албан тушаалтан, санхүүжилтийн хэлбэр зэрэг тодорхой байх нь чухал юм.


Бидний шинжилж үзсэн мэдээллийн хүртээмж, ил тод байдал, зөвлөлдөөн, хамтын ажиллагаа ба идэвхтэй оролцоо, хянах, хариуцлага тооцох иргэдийн оролцооны үндсэн

4 хэлбэрийг иж бүрэн цогцоор нь бүрэн гүйцэд, нарийн тодорхой тусгасан нэг ч хууль алга байна.

Дээр дурдсан бүхнийг нэгтгэн судлаачдын хийсэн хууль эрх зүйн шинжилгээн дээр тулгуурлаж (хавсралтаас харна уу) иргэдийн оролцооны эрх зүйн орчны зураглалыг гаргахыг хичээсэн болно. Үүний тулд судлаачдын боловсруулсан хүснэгтээс иргэдийн оролцооны 4 хэлбэрт тохирох хуулийн заалтыг тоолж хүснэгтэд нэгтгэн давтамжийг тоолсон болно. Зураглал 1-ээс иргэдийн оролцооны эрх зүйн орчны төлөвшлийг суурь хийгээд салбар, өөрөөр хэлбэл түвшин болон салбараар харж болно. Эдгээрийг судалгааны тайлангийн явцад нилээдгүй ярьсан учраас дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагагүй гэж үзлээ.

Зураглал 1. Иргэдийн оролцооны үндсэн 4 хэлбэр суурь ба салбар хуульд хэрхэн хангагдсанг Үндсэн хууль хийгээд хууль, бодлого боловсруулах, орон нутгийн түвшин болон салбар хууль эрх зүйн баримт бичигт тусгагдсан байдлаар үзүүлсэн зураглал

(Хууль болон аймгүүдийн Засаг дарга нарын мөрийн хөтөлбөр, ИТХ-ын журам зэрэгт иргэдийн оролцооны 4 хэлбэр тусгагдсан байдал, зүйлийн давтамжийн тоогоор)



Эдгээрээс үзэхэд иргэдийн оролцоо төсөв, байгаль орчны салбар болон орон нутгийн эрх зүйн баримт бичгүүдэд нилээд тусгагдаж сүүлийн жилүүдэд ахиц гарсан байна.

Санал, зөвлөмж

Иргэдийн оролцоог үр дүнтэй хангахын тулд өмнө авч үзэж судалсан иргэдийн оролцооны 4 хэлбэрийг хууль тогтоомжид цогцоор, иж бүрнээр оруулж, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг нарийн тодорхой хуульчилж өгөх шаардлагатай байна. Тухайлбал, төсвийн асуудлаар шийдвэр гаргахад мэдээлэл авах, шийдвэр гаргах үйл явц дахь олон нийтийн оролцоо, төсвийн үйл явцын ил тод байдлыг хангах ажлыг цогц байдлаар хоорондоо зөрчилгүйгээр зохион байгуулдаг болох нь чухал байна.

Мэдээллийн эрх зүйн орчинг сайжруулахын тулд:

- Төрийн болон байгууллагын нууцын зэрэглэлийг сайтар тогтоох, нарийвчлан гаргах,
- Мэдээлэл олж авах үйл явцад дэмжлэг үзүүлэх: мэдээлэл авах хүсэлт шаардлагыг аль болох шуурхай, шударга биелүүлэх, мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд энэ шийдвэрийн эсрэг хараат бус байгууллагад хандан давж заалдах эрхээр хангах,
- Мэдээллийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйлдлийн талаарх эргэж мэдэгддэг тогтолцоог хуульчилж өгөх шаардлагатай байна.

Зөвлөлдөөний эрх зүйн орчинг сайжруулахын тулд:

- Аливаа бодлого шийдвэр гаргахын өмнө олон нийттэй зөвшилцдөг жишиг тогтоох,
- Зөвлөлдөөнд сонирхогч талуудын оролцох боломжийг нээлттэй болгох,
- Иргэдийн санал, хүсэлт гомдлыг шийдвэрлэх хугацаа болон хэрхэн яаж шийдвэрлэсэн үйл явц, хариу үйлдлийг тодорхой ил тод байлгах зэрэг ордог.

Иргэдийн идэвхитэй оролцоог дэмжих эрх зүйн орчинг сайжруулахын тулд:

Монгол Улсын Засгийн газраас санаачилж буй хууль, тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон бусад актын төслийг боловсруулахад иргэдийг оролцуулах дүрэм журмыг батлаж, мөрдүүлэх, орон нутгийн ИТХ-ын бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийг оролцуулах, удирдлагын ил тод байдлыг дээшлүүлэх, орон нутгийн зарим чухал асуудлыг хэлэлцэхэд (төсөв гм) олон нийтийг оролцуулдаг жишгийг тогтоож, хуралдааны дэгд шинээр оруулах нь зүйтэй байна. Хууль болон УИХ-ын бусад шийдвэрийг боловсруулахад хэрэгжүүлж эхлээд байгаа Нээлттэй сонсголын механизмыг (Хүний эрхийн дэд хорооны “Нээлттэй сонсгол”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Иргэний танхим”) цаашид өргөжүүлэн бусад Байнгын хороод мөн Засгийн газар, орон нутгийн ИТХ-уудын үйл ажиллагаанд нэвтрүүлж, дээрх нээлттэй сонсголын тухай УИХ-ын Чуулганы дэгийн тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль зэрэгт нэмж оруулах нь зүйтэй юм. Иргэд өөрсдийг нь төлөөлөн төрийг удирдах эрхийг хэрэгжүүлж буй субъектүүдийг нийтийн эрх ашиг сонирхолыг илэрхийлэн хамгаалж чадахгүй байна хэмээн тодорхой хувийн санал гарсан тохиолдолд эргүүлэн татдаг эрхийг олгох хэрэгтэй байна. Орон нутгийн болон үндэсний түвшинд иргэдийн санал асуулгуудыг явуулдаг болж, зайлшгүй санал асуулга явуулах шаардлагатай асуудлуудыг хуульчилах хэрэгтэй байна.

Эдгээр санал зөвлөмжийг дараах түвшинд хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүнд:

1. *Ерөнхийлөгчийн түвшинд:*

- Иргэний танхимын статус, үйл ажиллагааг хуульчлах
- Нийтийн эрх ашиг сонирхолын асуудлаар иргэдийн гаргасан санал санаачилгыг дэмжих, хэрэгжүүлэх, уламжлах үүргийг хуульчлах.

2. Улсын Их Хурлын түвшинд:

- Нээлттэй сонсгол, нээлттэй хэлэлцүүлэгийг бодлого шийдвэр батлан гаргахын өмнө зохион байгуулахаар хуульчлах. Ингэхдээ байгалийн баялаг, үндэсний аюулгүй байдал, хүний эрхийн талаар шийдвэр гаргахын өмнө заавал нээлттэй сонсгол хэлэлцүүлэг хийдэг байх.
- Иргэдийн санаачилга буюу хориг тавих эрхийг баталгаажуулах. УИХ-аас батлан гаргасан хууль, бодлого шийдвэрийг сонгогчдын тодорхой хувийн гарын үсэг зурснаар буцааж дахин хэлэлцдэг болох.
- УИХ-аар иргэдийн санал бодлыг заавал асууж байж шийдвэр гаргадаг шийдвэрийн жагсаалтыг гаргах.
- Иргэдийн эрх ашиг сонирхолыг хамгаалж чадахгүй, тэдний төлөөлөл болж чадахгүй байна гэж иргэдийн тодорхой хувь үзсэн тохиолдолд УИХ-ын гишүүнийг эргүүлэн татах санал гаргах эрхийг иргэдэд олгох.

3. Засгийн газрын түвшинд:

- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудалд иргэд санал өгөх, шинээр хэлэлцэх асуудал оруулах эрхийг баталгаажуулах хэрэгтэй бөгөөд энэ нь Засгийн газрын гишүүдийн санаачилсан төслийн адилаар хэлэлцүүлдэг болох.
- Иргэдийн чуулган зохион байгуулах. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, байгаль орчин уул уурхайн асуудлаар иргэдийн чуулганыг зохион байгуулдаг болох.
- Иргэдэд үйлчилгээ үзүүлж буй төрийн байгууллагууд үйлчилгээний стандартыг батлан мөрдүүлэх.
- Иргэдээр үнэлүүлдэг тогтолцоог хуульчлах.
- ИНБ-уудаар төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг сайжруулах.

4. Орон нутгийн түвшинд:

- Хурал болон Засаг даргын дангаар шийдвэрлэх эрхгүй асуудлуудыг хуульчлах. Үүнд тухайн орон нутагт мөрдөгдөх дүрэм журам, байгалийн баялаг ашиглах, эзэмших зөвшөөрөл олгох, орон нутгийн санал асуулга, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө зэргийг оруулах.
- Иргэдийн эрх ашиг сонирхолыг хамгаалж чадахгүй, тэдний төлөөлөл болж чадахгүй байна гэж иргэдийн тодорхой хувь үзсэн тохиолдолд хурлын төлөөлөгч, засаг даргыг эргүүлэн татах санал гаргах эрхийг иргэдэд олгох.
- Хурлын зар түгээх тогтолцоог хуульчлах.
- Хурлын хуралдааны нээлттэй ил тод байдал, иргэд хуралдаанд ажиглагчаар орж суух эрхийг хуульчлах.
- Хөршийн холбоо, иргэдийн өөртөө туслах бүлгүүд, өөрийн удирдлагыг дэмжсэн эрх зүйн зохицуулалтууд бий болгох.

Хавсралт 1

№	ХӨТӨЛБӨР, ЖУРМЫН НЭР	КОД
1	Засгийн газрын 1998 оны 74 дүгээр тогтоол - ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ДҮРЭМ	ЗГТ-1998/74
2	Байгаль орчны сайд, Сангийн сайдын 1999 оны 154/201 тоот тушаал - БАЙГАЛЬ ОРЧНЫ УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ САНГИЙН МЭДЭЭГ АШИГЛУУЛАХ, ТҮГЭЭХ, ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ, ОРЛОГЫГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ ЖУРАМ	БОСТ-1999/154/201
3	Монгол Улсын Их Хурлын 2000 оны 21 дүгээр тогтоол - МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙН 2010 ОН ХҮРТЭЛХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	УИХТ-2000/21
4	Засгийн газрын 2001 оны 82 дугаар тогтоол – МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ	ЗГТ-2001/82
5	Монгол Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоол - АВЛИГАЛТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	УИХТ-2002/41
6	Засгийн газрын 2002 оны 233 дугаар тогтоол - МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ	ЗГТ-2002/233
7	Монгол Улсын Их Хурлын 2004 оны 21 дүгээр тогтоол - МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО	УИХТ-2004/21
8	Шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө - МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРҮҮД	ШУТХ-2007-2020
9	УИХ-ын 2007 оны 87 дугаар тогтоол - МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2008 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	УИХТ-2007/87
10	Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоол - МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО	УИХТ-2008/12
11	Улсын Их Хурлын 2008 оны 36 дугаар тогтоол - МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2009 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	УИХТ-2008/36
12	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 2 дугаар тогтоол - МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2009 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ	ЗГТ-2009/2
13	Монгол Улсын Их Хурлын 2009 оны 79 дүгээр тогтоол - МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2010 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	УИХТ-2009/79
14	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 120 дугаар зарлиг - АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ОЛОН НИЙТИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ	МУЕЗ-2009/120
15	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 69 дүгээр тогтоол - МОНГОЛ УЛСАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2009-2010 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	ЗГТ-2009/69
16	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 2 дугаар тогтоол - МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2009 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ	ЗГТ-2009/2
17	Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 141 дүгээр тогтоол - МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	ЗГТ-2010/141
18	Улсын Их Хурлын 2011 оны 39 дүгээр тогтоол - МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2012 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	УИХТ-2011/39
19	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 81 дүгээр тогтоол - МОНГОЛ УЛСАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2011-2012 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	ЗГТ-2011/81
20	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ 2011	МУЗГ-ИНЗ-2011

Хавсралт 1

21	Засгийн газрын 2012 оны 64 дүгээр тогтоол - ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР	ЗГТ-2012/64
22	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР	ЗГМХ 2012-2016
23	МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬ, 2000	ХЭҮК-2000
24	ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ, 2002	ШТ-2002
25	2008-2012 ОНЫ ЗАСГИЙН ГАЗРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР	ЗГМХ 2008-2012
26	АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД БАРИМТЛАХ ХУРАЛДААНЫ ДЭГ /Дорноговь Аймгийн ИТХ-ын 2012.12.05 өдрийн хоёрдугаар хуралдаанаар батлав/	ДгоИТХД-2012
27	ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД БАРИМТЛАХ ХУРАЛДААНЫ НИЙТЛЭГ ДЭГ /Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2008.02.01 дүгээр тогтоолын хавсралт/	ДаИТХД-2008
28	АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ, 1995	АНСАТ-1995
29	МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ, 2011	МИТБМАЭТ-2011
30	МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙН 2010 ОН ХҮРТЭЛ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	МУТХТХҮЗ-2010
31	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ, 1993	МУЕТ-1993
32	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, 2006	МУИХТ-2006
33	ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ, 1995	ТНТ-1995
34	БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ, 1995	БНТ-1995
35	ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ, 1995	ХХНТ-1995
36	ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ, 1995	ИТБАТГӨГШТ-1995
37	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ, 1993	МУЗГТ-1993
38	ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ, 2001	ХУИХБШТБӨМЖТ-2001
39	МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, 1996	МУХҮБ-1996
40	МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ, 2006	МУЗЗНДНТУТ-2006
41	Засгийн газрын 1998 оны 74 дүгээр тогтоол - ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ДҮРЭМ	ЗГТ-1998/74
42	Засгийн газрын 2010 оны 85 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, БОЛОВСРУУЛАХ, ТҮГЭЭХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ ЖУРАМ	ЗГТ-2010/85
43	БОАЖСайдын тушаал-2010.07.22-ны өдөр дугаар А-250 “ЖУРАМ, ГЭРЭЭ, ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР БАТЛАХ ТУХАЙ” /Байгалийн тодорхой баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар иргэдийн нөхөрлөлийн баримтлах журам/	БОАЖСТ-2010/А-250

Хавсралт 1

44	Засгийн газрын тогтоол 2009.07.22/227-ОЙН САНГ ГЭРЭЭГЭЭР ЭЗЭМШҮҮЛЭХ ЖУРАМ	ЗГТ-2009/227
45	Засгийн Газрын Тогтоол -1998/188-БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН	ЗГТ-1998/188
46	Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2010.4.27-ний өдрийн А-115 дугаар тушаалын хавсралт ИДЭВХТЭН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ АЖИЛЛУУЛАХ, АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР НЬ УРАМШУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ	БОАЖСТ-2010/А-115
47	БОАЖсайдын тушаал-2008.01.29/30-ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ДЭМЖИХ ТУХАЙ	БОАЖСТ-2008/30
48	Засгийн Газрын Тогтоол -2010.04.14/90 ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	ЗГТ-2010/90
49	Байгаль орчны сайд, Сангийн сайдын 1999 оны 154/201 тоот тушаалын хавсралт БАЙГАЛЬ ОРЧНЫ УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ САНГИЙН МЭДЭЭГ АШИГЛУУЛАХ, ТҮГЭЭХ, ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ, ОРЛОГЫГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ ЖУРАМ	БО/ССТ-1999/154/201
50	Засгийн газрын 2001 оны 248 дугаар тогтоол Ойн тухай үндэсний хөтөлбөр	ЗТГ-2001/248
51	БОАЖ-ын сайдын тушаал, 2012.04.12, Дугаар А-123) ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛТЭЙ ТЭМЦЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ	БОАЖСТ-2012/А123
52	Монгол Улсын Засгийн газрын тогтоол-2011.04.13-ний өдрийн 113 дугаар тогтоол ОЙН ТУХАЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	ЗГТ-2011/113
53	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009.10.23-ний өдрийн 307 дугаар тушаалын хавсралт -ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ЖУРАМ	БОАЖСТ-2009/307
54	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2009.07.16-ны өдрийн 190 дүгээр тоот тушаал - ОЙД АРЧИЛГААНЫ ОГТЛОЛ ЯВУУЛАХ ЖУРАМ	БОАЖСТ-2009/190
55	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 1998.1.27-ны өдөр дугаар 13 тушаал БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ӨДРИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ	БОСТ-1998/13
56	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2009.12.01-ны өдрийн 370 дүгээр тоот тушаалын хавсралт - УСАН САН БҮХИЙ ГАЗРЫН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН БҮСИЙГ ТОГТООЖ ТЭМДЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ	БОАЖС-2009/370
57	УИХ-ын 2010.5.20-ны өдөр 24 тоот тушаал - УС ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	УИХТ-2010/24
58	ЗГТ-2010.04.14/90 ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	ЗГТ-2010/90
59	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 131 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ХЯЗГААРЛАЛТЫН БҮСЭД ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ	НИТХ-2011/131
60	Байгаль орчны сайдын 1998 оны 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРЧНЫ БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙГ БАЙГУУЛЖ АЖИЛЛУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ	БОС-1998/112
61	Засгийн газрын 2012.1.18-ны өдрийн 17-р тогтоолын хавсралт “ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХАД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ”	ЗГТ-2012/17
62	Сангийн сайдын 2012.12.28-ны өдрийн 301 тоот тушаал “ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, УРАМШУУЛЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ”	ССТ 2012/301

Хавсралт 2

1. Монгол улсын Үндсэн хууль

Хуулийн зүйл	Залтын утга	Холбогдох журам, хөтөлбөр	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал			
<p style="text-align: center;"><i>Арван зургадугаар зүйл.</i></p>	<p><i>16.1.17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалах зөвхөн нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хийх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор зогруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;</i></p>	<p><u>МИТБМАЭТ-2011</u>: Бүтцийн хувьд 6-н бүлэг, 25 зүйлтэй. Энэхүү хууль нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төрийн байгууллагуудын мэдээллийг ил тод болгох, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахад чиглэгдсэн байна. Тухайлбал: мэдээллийн ил тод байдал, үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүүгийн ил тод байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал, мэдээлэл авах эрх, мэдээллээр хангах чиг үүрэг зэрэг олон чухал асуудлуудыг багтаасан байна. <u>ХЭҮК-2000</u> – 19.6. Комиссын гишүүн нь гаргасан шаардлага, зөвлөмжөө хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх, мэдээлэх эрхтэй. <u>МУТХТХҮЗ-2010</u>: “...төрийн мэдээллийг нээлттэй болгох, иргэдийн төрийн үйл ажиллагаанд хяналт тавих..., санал асуулга, нийгмийн судалгаанд мэдээлэл холбооны технологийг өргөн хэрэглэх ...”, <u>ЗГМХ 2008-2012</u>: “...олон нийтийн мэдээллийн эрх чөлөөг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно...” <u>МУЕТ-1993</u>. 10.1. Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зөвшөөрснөөр төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэхээс гадна хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ. <u>МУИХТ-2006</u>. 3.2. Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь хараат бус, нээлттэй, ил тод, харуцлагатай, иргэдэд хүртээмжтэй байх бөгөөд асуудлыг тал бүрээс нь хэлэлцэж цөөнхийн саналыг хүндэтгэн үзэж олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд тулгуурлана. /Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн/ 7.1.20. төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг чанд хадгалж задруулахгүй байх бүх арга хэмжээ авах; <u>ТНТ-1995</u>. 3.1. “Төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ. /Энэ хэсэгт 2001 оны 12 дугаар сарын 27, 2004 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт орсон/ <u>БНТ-1995</u>. 6 дугаар зүйл. Нууцлахыг хориглох мэдээллийн хүрээ. Байгууллага дор дурдсан мэдээллийг нууцалж болохгүй: 1/ тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл; 2/ тухайн байгууллагын мэдээлэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл; 3/ гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл, <u>ХХНТ-1995</u>. 2 дугаар зүйл. Хувь хүний нууцын тухай ойлголт. “Хувь хүний нууц” гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илгэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ. <u>ТӨСВИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2011</u> - 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх; 6.5.6.төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх.</p>	<p>Мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалт нь төр, байгууллага, хувь хүний нууцын тухай (1995) хууль юм. Төрийн нууцын тухай хуулиар 59 төрлийн мэдээллийг нууцад хамруулж нэг бүрчлэн нэрлэн заасан. Байгууллагын нууцын тухай (1995) хуулиар тухайн байгууллага нууцаа өөрөө тогтоож, нууц мэдээллийг хамгаалах журам батлах үүрэг хүлээлгэсэн нь мэдээллийн эрх чөлөөг зүй бусаар хязгаарлаж байна. Цаашид төрийн нууцад хамруулах мэдээллийг нууцлах шаардлагатай эсэхийг үнэлж, нууцлах мэдээллийг аль болох цөөрүүлэх, байгууллагын нууцад хамаарах мэдээллийг хуулиар нэрлэн тогтоох шаардлагатай байна. Мэдээллийн нээлттэй байдал төдийлөн хангалттай биш байгаа талаар зарим судалгаануудад дурьдсан байна. Тухайлбал, Глоб Интернэшнл ТББ, Олон улсын “ARTICLE 19” байгууллага хамтран хийсэн “Монгол Улс шилжилтийн үед: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй МУ-ын хуулиудад хийсэн задлан шинжилгээ” судалгааны тайланд: ... Монгол Улсын төрийн байгууллагуудын нээлттэй байдал хангалтгүй хэмээн дүгнэжээ. Мөн 2006 онд “Авилагын эсрэг хууль”-ийг баталж АТГ-аас 18 зүйл бүхий зөвлөмжийг гаргасан бөгөөд түүний 16-р зүйлд “Төрийн байгууллага тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн санал бодлыг авч, анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй байлгана” гэсэн заалтын хэрэгжилт 2008 оны 08 сард 47% байснаа 10 сард 43% болж буурчээ. Глоб Интернэшнл ТББ-ын 2008 онд хийсэн “Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал” Мониторингын тайланд мөн мэдээллийн нээлттэй байдал хангалтгүй байгаа талаар бичжээ.</p>

Хавсралт 2

Зөвлөлдөх орчин			
Арван зургадугаар зүйл.	16.1.12. төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;	<u>ИТБАТГӨГШТ-1995</u> . - Энэ хууль нь иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдол гаргах, түүнийг байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулах зорилгоор батлагдсан бөгөөд нийт 4 бүлэг, 21 зүйлтэй. <u>МУИХТ-2006</u> . 7.1.15. иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэж хариуг нь шууд өгөх, эсхүл хариуцан шийдвэрлэх эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлж энэ тухай хариу мэдэгдэх; <u>МУЗГТ-1993</u> .33.11/ Засгийн газарт иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ;	Хамгийн их өргөдөл гомдол санал ирсэн он бол 2005 он бөгөөд нийт 6112 байна. 2011 онд 1728 өргөдөл, гомдол, санал ирснээс 97,8% нь хяналтанд орж түүний 86,2% нь шийдвэрлэгдсэн байна. 2012 оноос УИХ-ын дэргэд Өргөдөл гомдлын байнгын хороо ажиллаж байна. Мөн төрийн байгууллагын удирдлага ажилтнуудын нэгэн чиг үүрэгт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, саналыг хүлээн авч шийдвэрлэх асуудал багтдаг.
Хорин тавдугаар зүйл.	25.1.16. ард нийтийн санал асуулга явуулах. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ;	<u>АНСАТ-1995</u> -ийн 3.1. Санал асуулгад Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд оролцож, санал асуулгаар шийдвэрлэх асуудлын талаар саналаа нууцаар гаргана. 3.2. Санал авах өдөр эх орондоо байгаа 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр санал асуулгад оролцож саналаа өгөх эрхтэй. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн санал асуулгад оролцохгүй. 4.1-д: Санал асуулгыг төрийн дотоод, гадаад бодлогыг тодорхойлохтой холбогдсон тодорхой асуудлаар ард нийтийн сонголт хийлгэх шаардлага гарсан тохиолдолд явуулна. <u>МҮЕТ-1993</u> . 12.10. Ард нийтийн санал асуулга явуулах саналыг хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хуралд оруулна.	Хууль батлагдсанаас хойш 18 жил өнгөрчээ. Энэ хугацаанд төрийн гадаад, дотоод бодлогыг тодорхойлоход нэг ч удаа иргэдээрээ сонголт хийлгээгүй байна.
Хорин зургадугаар зүйл.	26.2. Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна.	<u>ХУИХБШТБӨМЖТ-2001</u> 3.2.Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид бичгээр уламжлах бөгөөд тэрээр уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно. 6.1. Хууль санаачлагч нь хуулийн төсөл боловсруулах талаар дараахь бүрэн эрх эдэлнэ: 6.1.5.хуулийн төсөл, түүний үзэл баримтлал болон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх, цахим хуудсанд байршуулах зэрэг бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлэх; 6.1.6. иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг Улсын Их Хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах; 9.2. Хуулийн төслийн үзэл баримтлалыг хууль санаачлагчаас өгсөн чиглэлийн дагуу тухайн хуулийн төсөл боловсруулах ажлыг хариуцаж байгаа ажлын хэсэг, хуулийн этгээд, иргэн боловсруулж болно. 9.9. Хуулийн төсөл боловсруулах явцад холбогдох мэргэжлийн байгууллага, шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага болон бусад байгууллага, иргэдээс санал авч төсөл боловсруулахад харгалзан үзэж болно.	

Хавсралт 2

		<p>18.3. Хууль санаачлагч хуулийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага, иргэний саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгана.</p> <p>18.4.Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдээ санал авах ажиллагааг дараахь хэлбэрээр зохион байгуулна:</p> <p>18.4.1.Хуулийн төслийг бүрэн эхээр нь байгууллагынхаа цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулах;</p> <p>18.4.2.Хуулийн төслийг иргэн, хуулийн этгээдэд нэр зааж хүргүүлэх, эсхүл уулзалт, ярилцлага зохион байгуулж болно.</p>	
<p>Хорин зургадугаар зүйл.</p>	<p>26.2.Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна.</p>	<p><i>19 дүгээр зүйл. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх.</i></p> <p>19.1. Шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч нь нийгмийн нэн чухал харилцааг зохицуулахаар санаачилсан хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай саналаа УИХ-д оруулж болно.</p> <p>19.2. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай оруулсан саналыг Улсын Их Хурал чуулганаар хэлэлцэж, гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд төслийг ард нийтээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хэлэлцүүлэх хүрээ болон түүнтэй холбогдон гарах зардлыг хэрхэн санхүүжүүлэхийг тодорхой заасан байна.</p> <p>19.3. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэхдээ дараахь хүрээнд хэлэлцүүлж болно:</p> <p>19.3.1.нийт ард түмнээр;</p> <p>19.3.2.нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүрээнд;</p> <p>19.3.3.тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд.</p> <p>19.4.Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай Улсын Их Хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газар энэ ажлыг зохион байгуулж, дүнг нэгтгэн Улсын Их Хурлын чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэхэд танилцуулна.</p> <p>19.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай1 хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтад заасны дагуу хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулна.</p> <p><i>МУЗГТ-1993-ийн 29 дүгээр зүйл. Засгийн газрын хуралдаан.</i></p> <p>4.5 хэлэлцэх асуудлыг Засгийн газрын гишүүн эрх хэмжээний дотор санаачлах эрхтэй. Бусад байгууллага, албан тушаалтан, иргэд хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын тухай саналаа Засгийн газрын холбогдох гишүүнээр уламжлан тавьж болно; <i>Засгийн газрын хүний аюулгүй байдлыг хангах Сайн засаглал хөтөлбөр 2000-д:</i> "...Засгийн газар яамдын хувьд тэрчлэн төрийн бодлого боловсруулах явц ба үйлчлүүлэгчдийн хооронд болон нийгмийн санал бодол ба түүнийг бүрдүүлэгчдийн хооронд зөвшилцөл бий болгох нь нэн чухал..." 2004-2006 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр. "...Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй болгож, дээрх асуудлыг ашиг сонирхол нь зөрчигдөж байгаа тал болон иргэдийн санал бодолд тулгуурлан шийддэг жишиг тогтооно..."</p>	<p>УИХ-ын байнгын хорооноос 2006 оны 2 дугаар сарын 5-нд “Нээлттэй сонгол” (УИХ-ын Чуулганы дэгд ийм нэр томъёо байхгүй харин иргэд олон нийтээс ирүүлсэн саналынх нь дагуу асуулга хийж болно хэмээн заасан байдаг) хийжээ. Байнгын хороод Авлигын эсрэг хууль, Ашигт малтмалын тухай хууль зэрэг хэд хэдэн хуулиудын асуудлаар иргэд олон нийтээс асуулга авч байсан. УИХ-ын Хүний эрхийн дэд хорооноос 2008 оны 07 сарын 1-ний асуудлаар холбогдох хүмүүсээс тодруулга авч, 2010 оны 05 сарын 12 нд “Хөрөнгө орлогын мэдүүлгийн тухай” хуулийн хэрэгжилтийн талаар нээлттэй сонгол хийсэн. Эдгээр үйл ажиллагаанд Хүний эрхийн дэд хороо нь Хууль зүйн байнгын хорооны 2009 оны 16-р тогтоолоор 7 хэсэг 35 зүйл бүхий “Нээлттэй сонгол зохион байгуулах журам”-ыг батлан явуулжээ. Энэ нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 зүйлийн 21.4 дэх заалт буюу “Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж, хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ” гэсэн зүйлд үндэслэжээ.</p>



Хавсралт 2

Идэвхтэй оролцоо			
Гуравдугаар зүйл.	<p>3.1. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт иүүд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.</p>	<p>МУЗНДНТУТ-2006 - 17.1. Баг, хорооны Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.1.1. Хурлын хуралдааны дарга, Хурлын Тэргүүлэгчдийг сонгох, чөлөөлөх; 17.1.2. баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлөх, огцруулах санал болон Засаг даргын огцрох тухай хүсэлтийг хүлээж авах эсэхтэй холбогдсон саналыг хэлэлцэн сум, дүүргийн Засаг даргад уламжлах; 17.1.3. Хурлын дотоод зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх; 17.1.4. баг, хорооны Засаг даргын тайланг хэлэлцэж ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх; 17.1.5. баг, хорооны иргэдийг шагнаж урамшуулах, дэмжлэг, тусламж үзүүлэх саналыг сум, дүүргийн Хурал, Засаг даргад уламжлах; 17.1.6. өрхийг албан татвар, бусад ногдол үүргээс түр чөлөөлөх буюу хөнгөлөлт үзүүлэх тухай саналыг сум, дүүргийн Хурал, Засаг даргад оруулах; 17.1.7. харьяалах баг, хорооны иргэний үндсэн ба журамт үүргийн биелэлтийг хангуулах; 17.1.8. иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай хүсэлтийг хэлэлцэж саналаа сум, дүүргийн Хуралд уламжлах; 17.1.9. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. 17.2. Баг, хорооны Хурлын энэ хуулийн 17.1.1-17.1.3, 17.1.8-д зааснаас бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.</p>	<p>Монгол Улсын иргэд төрийн үйл хэрэгт шууд оролцох эрхээ баг, хорооны Иргэдийн Нийтийн Хуралд оролцон эдэлж, мөн өөрсдын төлөөллийн байгууллага болох бүх шатны ИТХ, Ерөнхийлөгч, УИХ болон түүнээс байгуулагддаг Засгийн газраар дэмжуулан оролцох эрхээ эдэлж байна.</p>
Гуравдугаар зүйл.	<p>3.1. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт иүүд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгийн дэргэдэх Иргэний танхимын журам: 2.1. Иргэний танхимын зорилго нь хууль болон дүрэм журам, шийдвэрүүдийн төсөлд иргэд, байгууллагаас санал, шүүмжлэл, нэмэлт өөрчлөлтийн санаа, мэдээлэл хүлээн авах замаар төр, засгийн түвшинд гарах шийдвэрийг сайжруулах, шийдвэр гаргахад олон нийтийг оролцуулах явдал юм. 2.2. Иргэний танхимын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байна. 2.3. Иргэний танхимд болох аливаа хэлэлцүүлэг нь тодорхой шийдвэр, баримт бичгийн төслийг үндэслэн шийдвэр гаргахын өмнөх шатанд явагдана. Төсөлд өөрчлөлт оруулах, төслийг шийдвэр болгон гаргахдаа Иргэний танхимд болсон хэлэлцүүлэгт үндэслэнэ</p> <p>Хүний эрхийн дэд хорооны нээлттэй сонголт зохион байгуулах журам: 1.1. Энэхүү журмын зорилт нь Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо /цаашид “Дэд хороо” гэх/ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэлэлцэж буй асуудлаар тодорхой мэдээлэл авах зорилгоор нээлттэй сонголт зохион байгуулах /цаашид “сонголт” гэх/, түүнд дэг тогтооход оршино. 1.2. Дэд хороо хэлэлцэж буй асуудлынхаа хүрээнд шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл өгөх боломжтой гэрч, шинжээч, сонирхлын бүлгүүдийн төлөөлөгчид болон холбогдох бусад хүмүүсийг сонголт урьж оролцуулна. 1.6. Сонголт Дэд хорооны гишүүдийн цөөнхийн саналаар зохион байгуулагдсан бол цөөнхийн санал болгосон этгээдүүдийг заавал сонсоно. Хэрэв Дэд хороо сонсох этгээдүүдийн тоог хязгаарлавал цөөнх Дэд хорооны нийт гишүүдийн тоотой өөрийн харьцах хэмжээний этгээдүүдийг сонсохоор нэрлэн, сонгох эрхтэй. 1.9. Дэд хороо сонголт дурдагсан үйл, баримтад үндэслэн шийдвэр гаргана. Дэд хорооны шийдвэр гаргах хуралдаан тусдаа байна.</p> <p>ТӨСВИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2011 - 63.1. Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна. 63.2. Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно. 63.3. Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ. 63.4. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална.</p>	<p>Бодлогын үйл явцад оролцох иргэдийн эрхийг хангах, эрх ашиг нь хөндөгдөж буй болон сонирхогч талуудын санаа бодол, байр суурийг шийдвэр гаргахад өмнө сонсох албан ёсны тогтмол суваг механизм бий болгох зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Иргэний танхим байгуулагдан ажиллаж байна. Иргэний танхимаас нээлттэй хэлэлцүүлгүүдийг явуулж байгаа бөгөөд анх 2009 оны 12 дугаар сарын 15-нд Иргэний танхим анхны хэлэлцүүлгээ “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль”-ийн төслөөр хийсэн. Үүнээс хойш олон арван хуулийн төслөөр хэлэлцүүлэг хийж нэг хэлэлцүүлэгт дунджаар 150 орчим иргэн бүртгүүлж тэднээс 90 орчим нь хэлэлцүүлэгт оролцож тэдний дунджаар 27 иргэн санал бодлоо илэрхийлдэг байна.</p>
		<p>МУХУБ-1996. “...Хууль тогтоох байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгож, төрийн үйл хэрэгт олон түмний шууд болон төлөөллийн байгууллагаар дамжуулан оролцох арга хэлбэрийг төгөлдөржүүлнэ. Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлэх замаар нийгмийн янз бүрийн давхарга, бүлгүүдийн сонирхолыг төрийн бодлогод тусгах бололцоог хангана”</p>	

Хавсралт 2

Арван дөрөвдүгээр зүйл.	14.1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.	ШҮҮХИЙН ТУХАЙ 2002. ХОЁРДУГААР БҮЛЭГ , 8.1. Монгол Улсад хvн бүр vндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хvйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шvтлэг, vзэл бодол, боловсрол болон бусад байдал, тvчvнчлэн аж ахуйн нэгж, байгууллага өмчийн хэлбэр, эрх хэмжээний ялгаваргvйгээр хууль, шvvxийн өмнө эрх тэгш байна. 11.1. Шvvx хуралдааныг нээлттэй явуулна. 11.2. Хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэг, маргааныг шvvx хуралдаанаар хаалттай хянан шийдвэрлэнэ.	
Арван зургадугаар зүйл.	16.1.10. нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.	ҮЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ /шинэчилсэн найруулга/ 2005 , 3.1. Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль болон тухайн намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нийцүүлэн улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ 1997 , 5.6. Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасан журмын дагуу төрийн бус байгууллага байгуулах буюу төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдэж болно. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ 2011 - 8.1. Улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллагад гишүүнээр эвлэлдэн нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай 1991 – 3.1. Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй. 3.2. Үйлдвэрчний эвлэлд гишүүнээр элсэх буюу гишүүнээс гарахыг тулган шаардаж болохгүй. 3.3. Үйлдвэрчний эвлэлийн гишүүн мөн эсэхтэй холбогдуулан иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах буюу тэднийг ялгаварлан гадуурхахыг хориглоно.	Өнөөдөр Монгол Улсад албан ёсны бүртгэлтэй 22 улс төрийн нам байгаа бөгөөд хамгийн сүүлд 2012 онд Эх орончдын нэгдсэн нам, Монголын Консерватив нам байгуулагджээ. 2011 онд нийт 6000 Төрийн бус байгууллага, МҮЭХ-ны бүтцэд Үндэсний төв, 21 аймаг, нийслэл, 13 салбарын ҮЭХ, 2065 анхан шатны ҮЭХ ажиллаж байна .
Арван зургадугаар зүйл.	16.1.11 улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн х а р и л ц а а н д эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй.	ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ 2011 - 5.1.1. жэндэрийн тэгш эрхийн зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах; 7.2.2. улс төрийн ба удирдах албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүний тэнцвэртэй төлөөллийг хангах зорилгоор суудал хадгалах зэргээр квотын хэлбэрийг хэрэгжүүлэх; 8.3. Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна. 10.1.1. томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх; 10.1.2. төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх; 10.1.3. зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх; 12.1. Эрэгтэй, эмэгтэй хүн сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших, албан ба албан бус сургалтад хамрагдах ба мэргэжил дээшлүүлэх, мэргэших, арга зүйн зөвлөгөө авах, мөн сургалтын тэтгэлэг авах тэгш эрх, тэгш боломжтой байна. 14.4. Эх, эцэг хүүхэддээ нийгмийн үүрэг, хариуцлага, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хамтын эрх тэгш оролцоо болон жэндэрийн эрх тэгш байдлын тухай ойлголт, хүнийг хүйсийн шинжээр үл ялгаварлах үзэл, зан үйлийг өөрсдийн үлгэр дууриал, гэр бүлийн хүмүүжлээр олгох үүрэгтэй.	Монгол улсад их дээд сургуульд суралцагчдын дийлэнхи буюу 70% орчим нь эмэгтэйчүүд байдаг ч бодит амьдрал дээр албан тушаал ахих тусам эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага байна. Мянганы хөгжлийн зорилтод 2015 он гэхэд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог 30% болгоно хэмээн зорилт дэвшүүлсэн хэдий ч 2012 оны 10 сарын байдлаар дөнгөж 12% байгаа юм.

Хавсралт 2

<p>Арван зургадугаар зүйл.</p>	<p>16.1.16. <i>итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.</i></p>	<p><u>ГЭР БҮЛИЙН ТУХАЙ 1999</u> - 10.1. Гэрлэгчид нь гэр бүлийн дотор тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ. <u>ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ 1994</u>. 3.1. Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг цуглаан гэнэ. 3.2. Иргэд хот суурингийн гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг жагсаал гэнэ. 4.1. Жагсаал, цуглааныг Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага зохион байгуулах эрхтэй. /Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/ 4.2. Хууль Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд оролцох эрхтэй. <u>ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ 1998</u>. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.</p>	<p>1992 оноос хойш МУ-д олон арван жагсаал цуглаан зохион байгуулагдаж түүнд оролцох иргэдийн оролцоо буурахгүйгээр өнөөдрийг хүрсэн. 2005-2007 онд төрийн байгууллага албан тушаалтны эсрэг хатуу шаардлага, шүүмжлэл гаргасан 1 жагсаал, 1 цуглаан, 1 өлсгөлөнг шөнийн цагаар албадан тараасан, тараахыг оролдсон байна.</p>
<p>Арван зургадугаар зүйл.</p>	<p>16.1.9. <i>шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа ул амжилт ан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдлэнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалт тавих аргыг харгалзан хуулиар тогтооно</i></p>	<p><u>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2012</u>. 5.1. Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж Ерөнхийлөгчийг сонгоно. 5.2. Анхан шатны сонгууль бүх нийтийн байх бөгөөд түүнд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн /цаашид “сонгуулийн эрх бүхий иргэн” гэх/ бүр оролцох эрхтэй. 5.3. Сонгогч анхан шатны сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө гаргана. 6.1. Сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй. 6.2. Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар /цаашид “Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар” гэх/ байрладаг гадаад улсад байгаа, улсын бүртгэлд бүртгэгдсэн сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож санал өгөх эрхтэй. 6.3. Дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэн Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй. <u>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2011</u>. 5.2. Сонгууль бүх нийтийн байх бөгөөд түүнд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн /цаашид “сонгуулийн эрх бүхий иргэн” гэх/ бүр оролцох эрхтэй. 5.3. Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө гаргана. 5.4. Сонгууль нь чөлөөтэй байх бөгөөд сонгогчоос сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно. 6.1. Сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй. 6.2. Энэ хуульд заасан шаардлагыг хангасан хорин таван нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй. <u>УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай (2007) хуулийн 7.1</u>. Нээлттэй хуралдаанд хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид оролцож болно. <u>УИХ-ын тухай хууль (2006)</u> 29.1. Хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. 29.2. Хэлэлцэх асуудлын шинж байдал, гишүүдийн саналыг харгалзан 29.1-д зааснаас бусад асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно. 29.3. Энэ хуулийн 29.1, 29.2-т зааснаас бусад тохиолдолд нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг нээлттэй хийнэ. 29.4. Нам, эвслийн бүлгийн хуралдааны журмыг тэдгээрийн дүрмээр зохицуулна. 29.12-т: Иргэд, гадаад, дотоодын зочид төлөөлөгчид чуулганы ажиллагаатай танилцах, эсвэл хэвлэл мэдээллийн байгууллага, мэдээлэл сурвалжлага хийх эрхтэй бөгөөд энэ талаар мөрдөх журмыг УИХ-ын дарга гаргана хэмээн тус тус заажээ. <u>АЙМАГ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ 2012</u> - 5.1. Сонгуулийн үндсэн зарчим нь сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох эрхийг хангахад үндэслэнэ. 5.2. Сонгогч шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө гаргана. 6.1. Тухайн аймаг, сум, дүүрэгт байнга оршин суугч сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгох эрхтэй. 6.2. Аймаг, сум, дүүргийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь тухайн аймаг, сумын Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь тухайн суманд, дүүргийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь тухайн дүүрэгт санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн сонгуулийн эрх бүхий иргэн тухайн шатны Хуралд сонгогдох эрхтэй.</p>	<p>Монгол улсын иргэний Үндсэн хуулиар олгогдсон сонгох болон сонгогдох эрхийн хэрэгжилт нилээд амжилтыг олсон хэдий ч хүндрэл бэрхшээлүүд гарсаар байгаа юм. Тухайлбал, иргэдээс өөрсдөөс хамаарахгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр энэхүү эрхээ эдлэхэд хүндрэл учирч байгаа юм. Үүнд: иргэний бүртгэлийн системийн алдаатай байдал, улс төрийн намуудын дотоод ардчилал муу, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хязгаарлагдмал, иргэдийн төрд итгэх итгэл суларсан, улс төрийг сонирхох байдал буурсаар байна. Мөн улс төр, нийгэм, эдийн засаг, байгаль цаг уурын зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөгөөр сонгогчдын оролцоо жил ирэх тусам буурсаар байна.</p>

Хавсралт 2

2. Монгол улсын Засгийн газрын тухай хуулинд хийсэн дүн шинжилгээ

Зүйл	Утга	Эерэг	Сөрөг	Холбогдох журам, хөтөлбөр	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
14 дүгээр зүйл. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрх	14.6. Төрийн удирдлагын хүрээн дэх мэдээллийн албыг зохион байгуулж, хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах нөхцөл бүрдүүлнэ.	Иргэдийг мэдээллээр хангах үүрэг бүхий бие даасан мэдээллийн бүтцийг бий болгох, ард иргэдийг мэдээллээр хангах нөхцөл боломжийг бүрдүүлж өгсөн	Хэрхэн ямар арга замаар хэрэгжүүлэх механизм нь тодорхойгүй	<u>ЗГТ- 1998\74-</u> 3.Хэвлэл мэдээллийн алба нь үйл ажиллагаандаа Засгийн газрын эрх ашгийг баримтлан нийгмийн өмнө хүлээх хариуцлага, улс үндэснийхээ эрх ашгийг дээдлэн, мэдээллийн ил тод, үнэн бодитой, шуурхай байдлыг хангах зарчмыг баримтална. <u>УИХТ-2000\21-</u> 1.Төр-эрх зүйн хүрээнд: Төр нь мэдээлэлжсэн нийгмийн тогтолцоог бүрдүүлэгч, мэдээллийн нээлттэй эх үүсвэрээр хангагч үндсэн үйлчлэгч болох. <u>ЗГТ-2001\82-</u> 2/мэдээллийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох, төрийн мэдээллийн тогтолцоог мэдээлэл, холбооны технологиор дэмжин хөгжүүлэх; <u>УИХТ-2002\41-</u> 3/ Төрийн албыг боловсронгуй болгох чиглэлээр: 3/мэдээллийн орчин үеийн технологид суурилсан, үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод явуулах чиглэлээр төрийн байгууллагын тогтолцоог бүрдүүлэх; <u>ЗГТ-2002\233-</u> 1.3. Нээлттэй засаглалыг хөгжүүлэх, засаглалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, засаглалын үйл ажиллагааг түргэн шуурхай болгох үүднээс электрон засаглалд шилжих бэлтгэл ажлыг хийж дуусгах, төрийн мэдээллийн найдвартай дэд бүтцийг бий болгох, програм хангамжтай болох, төрийн мэдээллийн электрон сан байгуулах, мэдээллийн хадгалалт, урсгалыг электрон хэлбэрт оруулах загвар, журмыг боловсруулан нэвтрүүлэх; <u>УИХТ-2007\87-</u> 89.Мэдээллийн технологийн программ хангамжийн түвшинг сайжруулж, “Цахим засаглал” хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын мэдээллийн төв байгуулах, уг хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах <u>УИХТ-2008\12</u> –Стратегийн зорилт 5. Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, бодитой, үнэмшилтэй цахим мэдээллийн тогтолцоо, сан байгуулна: <u>УИХТ-2009\79-15.2</u> Орон нутаг, томоохон хот, суурин газруудын засаг захиргааны байгууллагуудыг төрийн нэгдсэн мэдээллийн сан, сүлжээнд холбож, үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх; 34.11. Цахим засаглал хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, цахим засаглалын EGOV.MN хөтөлбөр боловсруулах; <u>ЗГТ - 2012\64-</u> 2.5.7.1. Засгийн газрын бодлого, Засгийн газар, Ерөнхий сайдын үйл ажиллагааны талаар олон нийтийг нээлттэй, шуурхай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах, <u>ЗГХ-2012-2016</u> - Зорилт. Хүний жам ёсны заяагдмал эрх, хувийн өмч, төрийн хязгаарлагдмал оролцоо, төрийн нээлттэй, иргэдэд хянагдах тогтолцоо, иргэний нээлттэй нийгэм, жендерийн тэгш байдал зэрэг тулгуур үнэт зүйлсийг шалгуур болгон,	Засгийн Газар, яамдууд, аймаг нийслэлийн Засаг даргын тамгын газрууд, бусад агентлаг төрийн байгууллагууд өөрсдийн мэдээллийн бие даасан бүтэц болох тогтмол хэвлэн гаргадаг сонин сэтгүүл, цахим хуудас зэрэгтэй болсон байна. УИХ-ын http://www.parliament.mn сайтанд хуулийн төслийн ерөнхий мэдээлэл болон 17 нэмэлт мэдээллийг оруулсан, Нийслэлийн Засаг даргын 226 тоот захирамж, Мэдээллийн технологийн газрын 87 тоот албан бичгүүдээр “Вэб сайтуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, вэб сайтуудад зайлшгүй байх мэдээллийн жагсаалт”-ыг боловсруулан гаргаж нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлэн, мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх үйлчилгээний талаарх мэдээллүүдийг холбогдох байгууллагуудын вэб сайтуудаар “Үйлчилгээ” гэсэн булангаар иргэд олон нийтэд хүргэж байна. Мөн www.ulaanbaatar.mn вэб сайтаар Төрийн үйлчилгээ гэсэн булан нээж нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлдэг нийт 322 төрийн үйлчилгээг 14 чиглэлд багцлан хувааж үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг онлайнаар хүргэж байна. Нийслэлийн нутгийн захиргааны 64 байгууллагуудын вэб сайтууд нэгдсэн серверт байрлан 24 цагийн турш тасралтгүй бүрэн ажиллаж байна. Ингэснээр нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны болон төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэдэд нээлттэй хүргэж байна.
29 дүгээр зүйл. Засгийн газрын хуралдаан	4. Хуралдааныг Ерөнхий сайдын ишидвэрлэснээр нээлттэй буюу хаалттай явуулж болох бөгөөд хуулиар хамгаалсан нууцад хамаарахаас бусад ишидвэрийг олон нийтэд мэдээлнэ.	Засгийн газрын хуралдааны талаарх мэдээлэл иргэдэд ил тод байхаар хуульчилсан.		<u>ЗГТ2009\2-</u> 2.11. Засгийн газрын худалдан авах ажиллагааг олон нийтэд ил тод болгох хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах бэлтгэлийг хангах, энэ тухай бүх мэдээллийг цахим хуудсаар мэдээлэх ажлыг эрчимжүүлэх, 21.2. Иргэдэд шинжлэх ухааны мэдлэг, иргэний улс төр, эрх зүйн боловсрол олгох, амьдрах арга ухаанд сургах, эх оронч үзэл төлөвшүүлэх, ардчилал, шударга ёсны үнэт зүйлсийг иргэн бүрийн итгэл үнэмшил болгон хэвшүүлэхэд чиглэсэн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг дэмжих,	Төрийн мэдээлэл сэтгүүл тогтмол хэлбэрээр албан ёсоор гарч байна. Хууль тогтоол зэрэг эрх зүйн актуудыг дээрх сэтгүүлд хэвлэгдсэн хувилбарыг эх сурвалж болгон ашиглаж байна.

Хавсралт 2

Зөвлөлдөх орчин					
7 дугаар зүйл.	7.6. Шаардлагатай бол нам, олон нийтийн байгууллага, хувийн өмчийн аж ахуйн нэгжийн удирдлагын хүсэлтийг үндэслэн тэдгээрийн мэдээллийг хэлэлцэж болно.		шаардлагатай бол гэдэг нь энэхүү заалтын утгыг бүдгэрүүлж байна.	<u>ЗГТ-2009/2-</u> 3.1. Засгийн газар, хувийн хэвшлийн зөвлөлдөх тогтолцоог боловсронгуй болгож, хэрэгжүүлэх механизмыг нь бий болгож мөрдүүлэх 3.1.1. Засгийн газар, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх эрх зүйн үндсийг Улсын Их Хурлаар батлуулан мөрдөх 3.1.2. Засгийн газар, хувийн хэвшлийн түншлэлийн чиглэлүүдийг тогтоож, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Монгол Улсын 2007-2008 оны Засгийн газар: Иргэний нийгмийн байгууллагууд болон Засгийн газар хооронд харилцан ажиллах түншлэлийн гэрээ байгуулсан. Гэрээгээр төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийхээр болсон. 2011/02/11 МУЗГ “Иргэний нийгмийн тогтвортой хөгжлийг хангах төрийн бодлого”-ын үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Засгийн Газрын хэрэг эрхлэх газар иргэдээс ирсэн өргөдөл гомдол санал түүний шийдвэрлэлтийн байдлын талаар жил бүр аймаг, нийслэлээс тайлан илтгэл хүлээн авч нэгтгэдэг.
14 дүгээр зүйл.	4. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх ажлыг нэгтгэн удирдана.		нэгтгэн удирдах арга механизм тодорхой бус байна.	<u>ЗГТ-2009/79-</u> Зорилт 33. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулна: Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хянах цахим, нээлттэй системийг бий болгох;	2008 оноос төр, иргэний нийгмийн харилцаа, хамтын ажиллагаа өргөжин 2008 оны 2 сарын 1-ний өдрийн ТББ-уудын анхны зөвлөлдөх уулзалтаас Засгийн газартай хамтран ажиллах иргэний нийгмийн зөвлөл байгуулагдсан.
26 дугаар зүйл.	2. Засгийн газрын үйл ажиллагааны талаархи олон нийтийн санаа бодол, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн байр суурийг харгалзан шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Засгийн газар өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч холбогдох тогтоолын төслийг Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.		УИХ-д олонхийн суудал авсан нам эвсэл Засгийн газрыг байгуулдаг учир олон нийт Засгийн газарт итгэл үзүүлэхгүй байсан ч УИХ, Ерөнхийлөгч Засгийн газрыг авч үзэх боломжтой байна.	<u>ЗГТ-1998/74</u> - 2.Тус алба нь Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн бүх төрлийн байгууллагад нээлттэй, шуурхай болгох замаар олон түмэнд бодитой, зөв мэдээлэл хүргэх, түүнчлэн төр, засгийн харьяаллын болон чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээгдсэн Засгийн газрын бодлого, үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл судалгаа шинжилгээ хийж, гүйцэтгэх засаглалын гаргаж буй шийдвэрт хандаж буй олон нийтийн санал сэтгэгдлийн талаар дүгнэлт гаргана. <u>ЗГТ-2009/2</u> - 21.3. Нийтийн эрх ашгийг хөндсөн томоохон хуулиудыг Улсын Их Хурлаар батлахаас 45-аас доошгүй хоногийн өмнө иргэд, олон нийтээр нээлттэй хэлэлцүүлж санал авдаг журмыг хэвшүүлэх	2008 оноос төр, иргэний нийгмийн харилцаа, хамтын ажиллагаа өргөжин 2008 оны 2 сарын 1-ний өдрийн ТББ-уудын анхны зөвлөлдөх уулзалтаас Засгийн газартай хамтран ажиллах иргэний нийгмийн зөвлөл байгуулагдсан.

Хавсралт 2

28 дугаар зүйл.	3. Засгийн газар нь олон нийтийн байгууллагаас улс орныг хөгжүүлэх, төр, нийгмийн байгууллыг бэхжүүлэх, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангахад тус дөхөм үзүүлэх талаар гаргасан санал, санаачилгыг дэмжих шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар тэдгээр байгууллагатай харилцан ажиллана.		олон нийтийн байгууллага хэрхэн санал санаачлага гаргах, хэрхэн Засгийн газартай харилцах зэрэг асуудлууд тодорхой бус	<u>ЗГТ-2008/36-</u> 3.1.Засгийн газар, хувийн хэвшлийн зөвлөлдөх тогтолцоог боловсронгуй болгож, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх механизмыг нь бий болгож мөрдүүлэх; 3.2.төр болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулан, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог боловсронгуй болгох, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдсан объектуудыг тодорхой хугацаагаар ашиглуулсны дараа төрд шилжүүлж өгөх үйл ажиллагааг дэмжих;	http://opengovernment.mn –д ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудал болон хуулийн төслийн талаарх мэдээлэл нээлттэй болсон. Мөн орон нутгийн ИТХ-ууд ЗДТГ-ууд бие даасан вэб сайт болон сонин сэтгүүл зэргийг гаргаж бодлого шийдвэрийн талаар мэдээлдэг болж эхлээд байна.
29 дүгээр зүйл.	4. 5/хэлэлцэх асуудлыг Засгийн газрын гишүүн эрх хэмжээний дотор санаачлах эрхтэй. Бусад байгууллага, албан тушаалтан, иргэд хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын тухай саналаа Засгийн газрын холбогдох гишүүнээр уламжлан тавьж болно;		Засгийн газрын гишүүн иргэдийн саналыг заавал хүлээж авах тухай, хариуг хэрхэн өгөх зэрэг асуудлууд тодорхой бус байна.	<u>ЗГТ-2012/64-</u> 3.3.7. хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг - Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн долдугаар зорилтын хүрээнд Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны талаар олон нийтийг нээлттэй, шуурхай мэдээллээр тогтмол хангах, олон нийттэй харилцах үндсэн үүрэг хүлээж, түүний дотор гадаадад байгаа иргэдтэй харилцах ажлыг эрхлэх,	http://opengovernment.mn –д ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудал болон хуулийн төслийн талаарх мэдээлэл нээлттэй болсон. Мөн орон нутгийн ИТХ-ууд ЗДТГ-ууд бие даасан вэб сайт болон сонин сэтгүүл зэргийг гаргаж бодлого шийдвэрийн талаар мэдээлдэг болж эхлээд байна.
33 дугаар зүйл.	11/ Засгийн газарт иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ;		санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэдэг албан бүтцийг хуульчилж өгөөгүй байна.	<u>ЗГТ-2012/64-</u> 3.3.7. хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг - Засгийн газарт иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ. <u>ЗГМХ 2012-2016:</u> “...Иргэний хяналтын эрх зүйн орчныг бүрдүүлж нийтлэг эрх нь зөрчигдсөн иргэдийн гомдол гаргах, нэхэмжлэх эрхийг хангах бодлогыг хэрэгжүүлнэ...”	Монгол Улсын Засгийн Газарт 2011 онд 1728 өргөдөл, гомдол, санал ирснээс 97,8% нь хяналтанд орж түүний 86,2% нь шийдвэрлэгдсэн байна. Эдгээр он жилүүдээс 2008 онд хамгийн олон буюу 2383 өргөдөл, гомдол, санал ирснээс 89,8% нь хяналтанд орж 91,5% нь шийдвэрлэгджээ.

Хавсралт 2

3. Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд хийсэн дүн шинжилгээ					
Зүйл	Хуулийн заалтын утга	Эерэг тал	Сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр	Хэрэгжилтийн оноогийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх	29.1.6.хууль ёс, дэг журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах талаар: е/нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын үйл ажиллагааны талаар хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах;	Орон нутгийн түвшинд иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах үүрэг засаг дарга нарт өгөгдсөн.	мэдээллийн үнэн зөв эсэх, түгээх арга механизм тодорхой бус	ЗГТ-2002/233- 2.3. Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв буюу интернэт төвүүдийг (мэдээллийн нөөц төв) бүх аймаг, хот улмаар зарим боломжтой сумын төвүүдэд байгуулж эхлэх; УИХТ-2009/79- Зорилт 15. Хөдөө орон нутгийн хүн амын интернет хэрэглээг нэмэгдүүлж, төрөөс иргэдэд хүргэх мэдээллийг цаг алдалгүй, түргэн шуурхай хүрэх боломжийг бүрдүүлнэ: 15.2 Орон нутаг, томоохон хот, суурин газруудын засаг захиргааны байгууллагуудыг төрийн нэгдсэн мэдээллийн сан, сүлжээнд холбож, үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх; ЗГТ-2011/81- 1.1.4.1. Нутгийн захиргааны байгууллагуудаас хүний эрхийг хангаж байгаа байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний биелэлтийг жил бүр судалж, тайланг нь хурлаараа хэлэлцэн дүгнэж, нийтэд мэдээлж байх арга хэмжээ авна. Нийслэлийн ИТХ-ын 2010 оны үндсэн чиглэл: Хурлын цахим хуудасны ажиллагааг сайжруулж хэвлэл мэдээллээр иргэдэд мэдээлэх, тэдний санал хүсэлтийг хүлээн авах, хурлын тогтоол шийдвэрүүд болон үйл ажиллагааны талаар тогтмол мэдээллээр хангаж өөрчилж байна гэжээ.	Нутаг дэвсгэрийн удирдлагын нэгжүүд өөрсдийн мэдээллийн сувгуудаар дамжуулан иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах үүргээ гүйцэтгэдэг. Тухайлбал 2010 оноос НЗДТГ-ын хэрэгжүүлэгч агентлаг болон харьяа газрууд өөрсдийн цахим хуудастай болж иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр түргэн, шуурхай хүргэж байна. Тухайлбал: Нийслэлийн хөдөлмөрийн газар www.ubbirj.mn, Авто замын газар www.road.ub.gov.mn, Нийслэлийн цагдаагийн газар www.ubpolice.mn гэх мэт.
Зөвлөлдөх орчин					
12 дугаар зүйл. Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх	12.1.9.сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах.	иргэд орон нутгийн түвшинд өөрсдийг нь төлөөлж буй хүмүүст санал, өргөдөл, гомдлоо өгч шийдвэрлүүлэх боломж бүрдсэн	иргэдийн өргөдөл саналыг хэрхэн авч шийдвэрлэх, хариу мэдэгдэх механизм, өргөдөл гомдлыг шийдвэрлэхгүй үед хэрхэн хариуцлага тооцох нь тодорхой бус		
20 дугаар зүйл. Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрх	20.1.4.иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу судлан шийдвэрлэх;	ИТХ-ын тэргүүлэгчид байнга ажилладаг.	иргэдийн өргөдөл гомдол саналыг шийдвэрлэх эрхийг зөвхөн ИТХ-ын тэргүүлэгчдэд олгож байна.		

Хавсралт 2

20 дугаар зүйл. Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрх	20.1.10.олон нийтийн үүсгэл санаачилгыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тухайн нутаг дэвсгэр дэх төрийн бус байгууллага, сүм хийдтэй харилцах;	иргэд олон нийтийн үүсгэл санаачлагын ажлууд хэрэгжих боломж гарч ирж байна.	мөн иргэд олон нийтийн үүсгэл санаачлагыг дэмжих, тэдэнтэй харилцах асуудлыг зөвхөн ИТХ-ын тэргүүлэгчдэд олгосон байна.	Нийслэлийн ИТХ-ын 2010 оны үндсэн чиглэл: • Нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагын талаар иргэдийн дунд нээлттэй санал асуулга явуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах, дүгнэлт гаргах, • ИНБ, иргэдээс гаргасан бодитой санал санаачлагуудыг судлан хэрэгжүүлэх арга хэмжээ авах, • Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газар, алба болон дүүргүүдийн үйл ажиллагаа болон тэдгээрийн үзүүлж буй үйлчилгээтэй танилцаж, холбогдох арга хэмжээг авах гэж тодорхойлжээ.	Архангай аймагт “Мэдээлэл хүргэх сүлжээ”-г иргэдийн дунд, иргэн, иргэний нийгмийн байгууллагын орон тооны бус зөвлөлийг аймгийн ИТХ-ын дэргэд байгуулан ажиллуулж байна. Мөн иргэдийнхээ санаа бодлыг сонсох үүднээс аймгийн ИТХ-аас “1000 иргэний санал”-ыг авчээ.
22 дугаар зүйл. Хурлын даргын нийтлэг бүрэн эрх	22.1.13.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн Хуралд ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;	иргэдийн өргөдөл санал гомдлыг шийдвэрлэх боломж бүрдсэн.	энэ хуулийн 20.1.4 дэх заалттай утга давхцаж байна.		
24 дүгээр зүйл. Хуралд асуудал оруулах эрх	24.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, иргэн, дүүрэг, баг, хорооны Хуралд зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.	иргэд, төрийн бус байгууллагууд Хуралд асуудал оруулах эрх нээгдсэн.	иргэд, ТББ-ын Хуралд асуудал оруулах үйл явц, оруулсан асуудлыг хэрхэн хэлэлцэх, хариу мэдэгдэх тогтолцоог тусгаагүй.	Энэхүү заалтыг хэрэгжүүлэхээр аймгууд ИТХ-ынхаа дэгд нилээд хэмжээгээр тусгасан байдаг. Тухайлбал: <u>ДгоИТХД-2012</u> - 7. Төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, иргэн, Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно. <u>ДаИТХД-2008</u> - 4...Сум, багийн Хурал, аймгийн нутаг дэвсгэрт байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатархотын Захирагчийн үйл ажиллагаанд иргэдийн дунд сэтгэл ханамжийн судалгааг онлайн хэлбэрээр явуулж, 1000 гаруй хүний санал асуулга авч, санал асуулгын дүнг Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд танилцуулж, ЗГХЭГ-т хүргүүлээ. Судалгааны дүнг www.ulaanbaatar.mn сайтад байршуулснаар нутгийн захиргааны байгууллагад санал асуулгын дүнд дүн шинжилгээ хийж, цаашдынхаа ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллаж байна.
28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх	28.1.16.иргэдийн өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;	иргэдийн өргөдөл санал гомдлыг шийдвэрлэх боломж бүрдсэн.	иргэдийн өргөдөл санал гомдлын хариуг хэрхэн өгөх, шийдвэрлэх үйл явц тодорхой бус		
28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх	28.1.17.нутаг дэвсгэрийнхээ үйлчилгээний байгууллагын тайланг иргэдээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;	нутаг дэвсгэрийн хүрээнд ажилладаг байгууллагуудын тайланг хэлэлцэх боломж	иргэдээр хэлэлцүүлсний дараах арга хэмжээний талаар дурьдаагүй.		
33 дугаар зүйл. Засаг даргын ажлын алба	33.1.5.Тамгын газрын бичиг хэргийг хөглөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;	засаг даргын ажлын алба иргэдийн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхээр болсон	иргэдийн өргөдөл санал гомдлын хариуг хэрхэн өгөх, шийдвэрлэх үйл явц тодорхой бус		

Идэвхтэй оролцоо

15 дугаар зүйл. Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох	15.1.2.тухайн нутаг дэвсгэрийн нийт сонгогчийн дийлэнх олонхи нь Хурлын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох нь зүйтэй гэж санал гаргасан;	орон нутагт иргэд эзэн ёсоор байж хариуцлага тооцох механизм бүрдсэн.	сонгогчдын саналыг хэрхэн хураах үйл явцыг тусгаагүй.		
---	---	---	---	--	--

Хавсралт 2

15 дугаар зүйл. Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох	15.4.Багийн Хурлаар энэ хуулийн 15.1.1 ^[1] , 15.1.2 ^[2] -г заасан асуудлыг хэлэлцэхээр бол тухайн багийн нийт өрхийн гуравны хоёроос доошгүйн төлөөлөл оролцсон тохиолдолд Хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.	тодорхой хэсэг бүлэг хүмүүс хуйвалдан ирц бүрдүүлж Хурлыг татан буулгахаас сэргийлж чадсан.	иргэдийн оролцох ирцийн хувь өндөр \өөрөөр хэлбэл 75%\ учир хуралдаанын ирц бүрдэхэд ихээхэн хүндрэлтэй		
17 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх	17.1.1.Хурлын хуралдааны дарга, Хурлын Тэргүүлэгчдийг сонгох, чөлөөлөх;	Нутгийн удирдлагыг шууд сонгох боломж бүрдсэн	ямар тохиолдолд чөлөөлөх асуудал тодорхой бус		
17 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх	17.1.2.баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлөх, огцруулах санал болон Засаг даргын огцрох тухай хүсэлтийг хүлээж авах эсэхтэй холбогдсон саналыг хэлэлцэн сум, дүүргийн Засаг даргад уламжлах;	Нутгийн удирдлагыг шууд сонгох, өөрчлөх боломж бүрдсэн	иргэдийн шийдвэр эцсийнх байж чадахгүй дараагийн дээд шатны хуралд шилжиж байна.		
17 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх	17.1.3.Хурлын дотоод зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;	Иргэд өөрийн удирдлагын байгууллагынхаа дотоод зохион байгуулалтын асуудлыг бие даан шийдвэрлэх боломж бүрдсэн.			
17 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх	17.1.8.иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай хүсэлтийг хэлэлцэж саналаа сум, дүүргийн Хуралд уламжлах;	иргэд өөрсдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ хамгалаахад ихээхэн ач холбогдол бүхий заалт болсон.	иргэдийн шийдвэр эцсийнх байж чадахгүй дараагийн дээд шатны хуралд шилжиж байна.	<u>ЗГМХ-2012-2016</u> - ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход тухайн орон нутгийн иргэдийн оролцоог хангах;	Иргэд өөрсдийн амьдарч буй орон нутгийнхаа байгалийн баялагийг ашиглах, эзэмшихэд санал гаргах эрхтэй хэдий ч дээд шатны хуралд эрх нь шилжиж байгаа учир хэрэгжилтэнд нилээд төвөг учирдаг.
17 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх	20.1.6.эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн төсөл, төр, нийгмийн амьдралын чухал асуудлыг ард нийтээр хэлэлцүүлэх, санал асуулга явуулах ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;	иргэдэд бодлого боловсруулах, хэлэлцүүлэг хийх, нийтийн санал асуулгад оролцох зэрэг оролцооны үндсэн эрхээ эдлэх боломж гарч ирж байгаа юм.	зайлшгүй санал асуулга явуулах, хэлэлцүүлэг хийх салбарууд \ тодруулбал байгалийн баялаг, нийтээр дагаж мөрдөх журам, төсөв гэх зэрэг\, ямар салбарын бодлого боловсруулахад иргэдийг оролцуулах зэрэг нь тодорхой бус байна.	<u>АНСАТ-1995 - 5.3-д</u> : “Санал асуулга дангаар явуулж байгаа тохиолдолд нутаг дэвсгэрийн хороог Сонгуулийн ерөнхий хороо, хэсгийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тус тус байгуулна	

Хавсралт 2

23 дугаар зүйл. Хурлын хуралдаан	23.10.Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.	бүх иргэдийн тэнцүү оролцоог хангах боломж бүрдсэн	зарим баг маш цөөн хүнтэй байдаг учир хуралд цөөн хүн оролцож асуудлыг шийдэх магадлалтай		
23 дугаар зүйл. Хурлын хуралдаан	23.11.Засаг даргад нэр дэвшүүлэх, түүнийг чөлөөлөх, огцруулах буюу огцрох тухай хүсэлтийг нь хэлэлцэх тохиолдолд аймгийн төвийнхөөс бусад сумын багийн Хуралд багийн нийт өрхийн 50-иас доошгүй хувийн төлөөлөл оролцсон бол хүчинтэйд тооцно.	Нутгийн удирдлагыг шууд сонгох, өөрчлөх боломж бүрдсэн			

Иргэдийн хяналт

26 дугаар зүйл. Засаг дарга, түүнийг томилох	26.9.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ажлаа тухайн Хуралд, баг, хорооны Засаг дарга иргэдэд тус тус жил бүр тайлагнана.	баг хорооны иргэд засаг даргын ажлыг үнэлэх, түүний тайланд хяналт тавих боломж бүрдсэн.	тайланг хэлэлцүүлсний дараах алхамуудыг тодорхой тусгаж өгөөгүй \жишээ нь ямар нэгэн хариуцлага тооцох тохиолдолд хэрхэх талаар\		
28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх	28.1.12.захиргааны журмын биелэлтэд хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих;				

Хавсралт 2

4. Төрийн бус байгууллагын тухай хуулинд хийсэн дүн шинжилгээ

зүйл	Хуулийн заалтын утга	эерэг тал	сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх	29.1.6.хууль ёс, дэг журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах талаар: е/нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын үйл ажиллагааны талаар хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах;	Орон нутгийн түвшинд иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах үүрэг засаг дарга нарт өгөгдсөн.	мэдээллийн үнэн зөв эсэх, түгээх арга механизм тодорхой бус	ЗГТ-2002/233- 2.3. Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв буюу интернэт төвүүдийг (мэдээллийн нөөц төв) бүх аймаг, хот улмаар зарим боломжтой сумын төвүүдэд байгуулж эхлэх; УИХТ-2009/79- Зорилт 15. Хөдөө орон нутгийн хүн амын интернет хэрэглээг нэмэгдүүлж, төрөөс иргэдэд хүргэх мэдээллийг цаг алдалгүй, түргэн шуурхай хүрэх боломжийг бүрдүүлнэ: 15.2 Орон нутаг, томоохон хот, суурин газруудын засаг захиргааны байгууллагуудыг төрийн нэгдсэн мэдээллийн сан, сүлжээнд холбож, үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх; ЗГТ-2011/81- 1.1.4.1. Нутгийн захиргааны байгууллагуудаас хүний эрхийг хангаж байгаа байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний биелэлтийг жил бүр судалж, тайланг нь хурлаараа хэлэлцэн дүгнэж, нийтэд мэдээлж байх арга хэмжээ авна. Нийслэлийн ИТХ-ын 2010 оны үндсэн чиглэл: Хурлын цахим хуудасны ажиллагааг сайжруулж хэвлэл мэдээллээр иргэдэд мэдээлэх, тэдний санал хүсэлтийг хүлээн авах, хурлын тогтоол шийдвэрүүд болон үйл ажиллагааны талаар тогтмол мэдээллээр хангаж өөрчилж байна гэжээ.	Нутаг дэвсгэрийн удирдлагын нэгжүүд өөрсдийн мэдээллийн сувгуудаар дамжуулан иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах үүргээ гүйцэтгэдэг. Тухайлбал: 2010 оноос НЗДТГ-ын хэрэгжүүлэгч агентлаг болон харьяа газрууд өөрсдийн цахим хуудастай болж иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр түргэн, шуурхай хүргэж байна. Тухайлбал: Нийслэлийн хөдөлмөрийн газар www.ubbijr.mn, Авто замын газар www.road.ub.gov.mn, Нийслэлийн цагдаагийн газар www.ubpolice.mn гэх мэт.
Зөвлөлдөх орчин					
12 дугаар зүйл. Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх	12.1.9.сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах.	иргэд орон нутгийн түвшинд өөрсдийг нь төлөөлж буй хүмүүст санал, өргөдөл, гомдлоо өгч шийдвэрлүүлэх боломж бүрдсэн	иргэдийн өргөдөл гомдол саналыг хэрхэн авч шийдвэрлэх, хариу мэдэгдэх механизм, өргөдөл гомдлыг шийдвэрлэхгүй үед хэрхэн хариуцлага тооцох нь тодорхой бус байна.	Нийслэлийн ИТХ-ын 2010 оны үндсэн чиглэл: • Нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагын талаар иргэдийн дунд нээлттэй санал асуулга явуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах, дүгнэлт гаргах, • ИНБ, иргэдээс гаргасан бодитой санал санаачлагуудыг судлан хэрэгжүүлэх арга хэмжээ авах, • Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газар, алба болон дүүргүүдийн үйл ажиллагаа болон тэдгээрийн үзүүлж буй үйлчилгээтэй танилцаж, холбогдох арга хэмжээг авах гэж тодорхойлжээ.	
20 дугаар зүйл. Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрх	20.1.4.иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу судлан шийдвэрлэх;	ИТХ-ын тэргүүлэгчид байнга ажилладаг.	иргэдийн өргөдөл гомдол санлыг шийдвэрлэх эрхийг зөвхөн ИТХ-ынтэргүүлэгчдэд олгож байна.		Архангай аймагт “Мэдээлэл хүргэх сүлжээ”-г иргэдийн дунд, иргэн иргэний нийгмийн байгууллагын орон тооны бус зөвлөлийг аймгийн ИТХ-ын дэргэд байгуулан ажиллуулж байна. Мөн иргэдийнхээ санаа бодлыг сонсох үүднээс аймгийн ИТХ-аас “1000 иргэний санал”-ыг авчээ.
20 дугаар зүйл. Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрх	20.1.10.олон нийтийн үүсгэл санаачилгыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тухайн нутаг дэвсгэр дэх төрийн бус байгууллага, сүм хийдтэй харилцах	иргэд олон нийтийн үүсгэл санаачлагын ажлуудхэрэгжих боломж гарч ирж байна.	мөн иргэд олон нийтийн үүсгэл санаачлагыг дэмжих, тэдэнтэй харилцах асуудлыг зөвхөн ИТХ-ын тэргүүлэгчдэд олгосон байна.		
22 дугаар зүйл. Хурлын даргын нийтлэг бүрэн эрх	22.1.13.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн Хуралд ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;	иргэдийн өргөдөл санал гомдлыг шийдвэрлэх боломж бүрдсэн.	энэ хуулийн 20.1.4 дэх заалттай утга давхцаж байна.		

Хавсралт 2

24 дүгээр зүйл. Хуралд асуудал оруулах эрх	24.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, сум, дүүрэг, баг, хорооны Хуралд зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.	иргэд, төрийн бус байгууллагууд Хуралд асуудал оруулах эрх нээгдсэн	иргэд, ТББ-ын Хуралд асуудал оруулах үйл явц, оруулсан асуудлыг хэрхэн хэлэлцэх, хариу мэдэгдэх тогтолцоог тусгаагүй.	Энэхүү заалтыг хэрэгжүүлэхээр аймгууд ИТХ-ынхаа дэгд нилээд хэмжээгээр тусгасан байдаг. Тухайлбал: <u>ДгоИТХД-2012</u> - 7. Төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, иргэн, Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно. <u>ДаИТХД-2008</u> - 4...Сум, багийн Хурал, аймгийн нутаг дэвсгэрт байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагаанд иргэдийн дунд сэтгэл ханамжийн судалгааг онлайн хэлбэрээр явуулж, 1000 гаруй хүний санал асуулга авч, санал асуулгын дүнг Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд танилцуулж, ЗГХЭГ-т хүргүүллээ. Судалгааны дүнг www.ulaanbaatar.mn сайтад байршуулснаар нутгийн захиргааны байгууллагад санал асуулгын дүнд дүн шинжилгээ хийж, цаашдынхаа ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллаж байна.
28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх	28.1.16.иргэдийн өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;	иргэдийн өргөдөл санал гомдлыг шийдвэрлэх боломж бүрдсэн.	иргэдийн өргөдөл санал гомдлын хариуг хэрхэн өгөх, шийдвэрлэх үйл явц тодорхой бус		
28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх	28.1.17. нутаг дэвсгэрийнхээ үйлчилгээний байгууллагын тайланг иргэдээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;	иргэд өөрсдийн нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын тайланг хэлэлцэх боломж бүрдэнэ.	иргэдээр хэлэлцүүлсний дараах арга хэмжээний талаар дурьдаагүй. Тухайлбал ямар нэгэн арга хэмжээ авах, үйл ажиллагааг зогсоох санал гарсан үед хэрхэх талаар зохицуулаагүй		
33 дугаар зүйл. Засаг даргын ажлын алба	33.1.5.Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;	засаг даргын ажлын алба иргэдийн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхээр болсон	иргэдийн өргөдөл санал гомдлын хариуг хэрхэн өгөх, шийдвэрлэх үйл явц тодорхой бус		
Идэвхтэй оролцоо					
15 дугаар зүйл. Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох	15.1.2.тухайн нутаг дэвсгэрийн нийт сонгогчийн дийлэнх олонхи нь Хурлын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох нь зүйтэй гэж санал гаргасан;	орон нутагт иргэд эзэн ёсоор байж хариуцлага тооцох механизм бүрдсэн.	сонгогчдын саналыг хэрхэн хураах үйл явцыг тусгаагүй.		
15 дугаар зүйл. Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох	15.4.Багийн Хурлаар энэ хуулийн 15.1.1 ^[1] , 15.1.2 ^[2] -т заасан асуудлыг хэлэлцэхээр бол тухайн багийн нийт өрхийн гуравны хоёроос доошгүйн төлөөлөл оролцсон тохиолдолд Хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.	тодорхой хэсэг бүлэг хүмүүс хуйвалдан ирц бүрдүүлж Хурлын татан буулгахаас сэргийлж чадсан.	иргэдийн оролцох ирцийн хувь өндөр /өөрөөр хэлбэл 75%/ учир хуралдаанын ирц бүрдэхэд ихээхэн хүндрэлтэй		
17 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх	17.1.1.Хурлын хуралдааны дарга, Хурлын Тэргүүлэгчдийг сонгох, чөлөөлөх;	Нутгийн удирдлагыг шууд сонгох боломж бүрдсэн	ямар тохиолдолд чөлөөлөх асуудал тодорхой бус		

Хавсралт 2

17 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх	17.1.2.баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлөх, огцруулах санал болон Засаг даргын огцрох тухай хүсэлтийг хүлээж авах эсэхтэй холбогдсон саналыг хэлэлцэн сум, дүүргийн Засаг даргад уламжлах;	Нутгийн удирдлагыг шууд сонгох, өөрчлөх боломж бүрдсэн	иргэдийн шийдвэр эцсийнх байж чадахгүй дараагийн дээд шатны хуралд шилжиж байна.		
17 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх	17.1.3.Хурлын дотоод зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;	байгууллагынхаа дотоод зохион байгуулалтын асуудлыг бие даан шийдвэрлэх боломж бүрдсэн.			
17 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх	17.1.8.иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай хүсэлтийг хэлэлцэж саналаа сум, дүүргийн Хуралд уламжлах;	иргэд өөрсдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ хамгалаахад ихээхэн ач холбогдол бүхий заалт болсон.	иргэдийн шийдвэр эцсийнх байж чадахгүй дараагийн дээд шатны хуралд шилжиж байна.	ЗГМХ-2012-2016 -ашигтмалтмалын тусгай зөвшөөрөл олгоход тухайн орон нутгийн иргэдийн оролцоог хангах;	Иргэд өөрсдийн амьдарч буй орон нутгийнхаа байгалийн баялагийг ашиглах, эзэмшихэд санал гаргах эрхтэй хэдий ч дээд шатны хуралд эрх нь шилжиж байгаа учир хэрэгжилтэнд нилээд төвөг учирдаг.
20 дугаар зүйл. Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрх	20.1.6.эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн төсөл, төр, нийгмийн амьдралын чухал асуудлыг ард нийтээр хэлэлцүүлэх, санал асуулга явуулах ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;	иргэдэд бодлого боловсруулах, хэлэлцүүлэг хийх, нийтийн санал асуулгад оролцох зэрэг оролцооны үндсэн эрхээ эдлэх боломж гарч ирж байгаа юм.	зайлшгүй санал асуулга явуулах, хэлэлцүүлэг хийх салбарууд /тодруулбал байгалийн баялаг, нийтээр дагаж мөрдөх журам, төсөв гэх зэрэг/, ямар салбарын бодлого боловсруулахад иргэдийг оролцуулах зэрэг нь тодорхой бус	АНСАТ-1995 - 5.3-д : “Санал асуулга дангаар явуулж байгаа тохиолдолд нутаг дэвсгэрийн хороог Сонгуулийн ерөнхий хороо, хэсгийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тус тус байгуулна	
23 дугаар зүйл. Хурлын хуралдаан	23.10.Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.	бүх иргэдийн тэнцүү оролцоог хангах боломж бүрдсэн	зарим баг маш цөөн хүнтэй байдаг учир хуралд цөөн хүн оролцож асуудлыг шийдэх магадлалтай		
23 дугаар зүйл. Хурлын хуралдаан	23.11.Засаг даргад нэр дэвшүүлэх, түүнийг чөлөөлөх, огцруулах буюу огцрох тухай хүсэлтийг нь хэлэлцэх тохиолдолд аймгийн төвийнхөөс бусад сумын багийн Хуралд багийн нийт өрхийн 50-иас доошгүй хувийн төлөөлөл оролцсон бол хүчинтэйд тооцно.	Нутгийн удирдлагыг шууд сонгох, өөрчлөх боломж бүрдсэн			

Хавсралт 2

Иргэдийн хяналт					
26 дугаар зүйл. Засаг дарга, түүнийг томилох	26.9. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ажлаа тухайн Хуралд, баг, хорооны Засаг дарга иргэдэд тус тус жил бүр тайлагнана.	баг хорооны иргэд засаг даргын ажлыг үнэлэх, түүний тайланд хяналт тавих боломж бүрдсэн.	тайланг хэлэлцүүлсний дараах алхамуудыг тодорхой тусгаж өгөөгүй	АНСАТ-1995-5.3-д: “Санал асуулга дангаар явуулж байгаа тохиолдолд нутаг дэвсгэрийн хороог Сонгуулийн ерөнхий хороо, хэсгийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тус тус байгуулна	
28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх	28.1.12. захиргааны журмын биелэлтэд хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих;	бүх иргэдийн тэнцүү оролцоог хангах боломж бүрдсэн	зарим баг маш цөөн хүнтэй байдаг учир хуралд цөөн хүн оролцож асуудлыг шийдэх магадлалтай		

5. Мэдээллийн ил тод байдлын тухай хуулинд хийсэн дүн шинжилгээ

Зүйл	Хуулийн заалтын утга	Эерэг тал	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал			
6 дугаар зүйл.	6.1. Мэдээллийн ил тод байдал дараах төрөлтэй байна: 6.1.1. үйл ажиллагааны ил тод байдал; 6.1.2. хүний нөөцийн ил тод байдал; 6.1.3. төсөв, санхүүгийн ил тод байдал; 6.1.4. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал.	Төрийн байгууллагууд өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд энэхүү заалтыг мөрдөж байна.	энэ хуулийн хэрэгжилтийн талаар Нээлттэй Нийгэм Форум ТББ, IRIM Mongolia ТББ, Засгийн Газрын хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, НҮБ зэрэг газруудын судалгаагы үр дүнг ашиглалаа.

Хавсралт 2

Иргэдийн хяналт			
7 дугаар зүйл.	<p>7.1.1.эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p> <p>7.1.2.үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p> <p>7.1.3.үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p> <p>7.1.4.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p> <p>7.1.5.шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудасандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;</p> <p>7.1.6.үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</p> <p>7.1.7.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;</p> <p>7.1.8.тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудасандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p> <p>7.1.9.салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын эзэл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудасандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах мэдээллүүд болох эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл, үйлчилгээний ажилтан, албан хаагчдын хаяг утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, өөрсдийн мөрдөж буй хууль, дүрэм журам, төсөл хөтөлбөр зэргийг нээлттэй байхаар заасан.</p>	<p>Төрийн байгууллагын вэбсайтад хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан байгууллагын хувьд эрхэм зорилгоо тавьсан байдал 2010 онд 70.8 хувьтай байсан бол 2011 онд 53.1 хувь болж 17.7 хувиар буурчээ. Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг вэбсайтад мэдээлсэн байдал нь мөн өнгөрсөн оныхоос 12.1 хувиар багассан байна. Мөн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг мэдээлсэн байдал 35.4 хувиас 20.8 хувь болж буурчээ. Харин албан хаагчийн ёс зүйн дүрмийг нийтлэх нь өнгөрсөн онд дөнгөж 16.9 хувьтай байсан бол 2011 онд 45.8 хувьтай болж өсчээ. 2010 онтой харьцуулахад тухайн байгууллагын олон нийттэй харьцах мэргэжилтний овог нэрийг мэдээлэх байдал 26.2 хувиас 57.3 хувь болж сайжирчээ. Мөн тухайн байгууллагын шуудангийн хаяг нь тавигдсан байдал нь 6.2 хувиас 26 хувь болж нэмэгдсэн бол байгууллагын хаяг, байгууллагатай холбоо барих утас, факсын дугаар зэрэг нарийвчилсан мэдээлэл бага зэрэг өсчээ.</p>
Иргэдийн хяналт			
8 дугаар зүйл.	<p>8.1.1.сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;</p> <p>8.1.2.албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p> <p>8.1.3.хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудасандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p> <p>8.1.4.хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудасандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;</p> <p>8.1.5.албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудасандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;</p>	<p>Мэдээллийн ил тод байдлын амин чухал нэгэн хэсэг бол төрийн байгууллагын хүний нөөцийн ил тод байдал байдаг.</p>	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг бид тухайн байгууллага сул орон тооны зараа вэб сайтадаа хэрхэн тавьж байгааг хянаж үзсэн. Хэдийгээр сул орон тооны зарыг төрийн албаны холбогдох хуулиар тусгай вэбсайтад зарлах ёстой боловч мөн тухайн үндсэн байгууллагын вэб сайтад зарлахыг ач холбогдолтой гэж мониторингийн баг үзсэн.</p>

Хавсралт 2

<p>9 дүгээр зүйл.</p>	<p>9.1.1. тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг өөрийн цахим хуудас болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд дор дурдсан хугацаанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх; 9.1.1.а. тухайн жилийн төсвийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 9.1.1.б. өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор; 9.1.1.в. дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор. 9.1.2. жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангах; 9.1.3. санхүүгийн тайланд нь хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх; 9.1.4. тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 14 өдрийн дотор энэ тухай цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх; 9.1.5. зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; 9.2. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 7, 8 дугаар зүйл, 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлд зааснаас гадна дараах мэдээллийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээж, цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулна: 9.2.1. концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас нь хойш ажлын 14 өдрийн дотор; 9.2.2. концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг байгуулагдсанаас нь хойш ажлын 14 өдрийн дотор; 9.2.3. концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг ажлын 14 өдрийн дотор. 9.3. Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 7, 8 дугаар зүйл, 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлд зааснаас гадна нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэнэ.</p>	<p>Ардчилсан нийгэмд иргэд засгийн эрх барих эрхийг хэрэгжүүлэхэд нэгэн чухал хүчин зүйл бол тэдэнд төсвийн захиран зарцуулах хянах эрхийг өгөх нь чухал байдаг. Энэ заалтаар иргэдийг дээрх эрхийг хангах үүднээс төсвийн ил тод байдлыг хангах үүргийг төрийн байгууллагуудад олгосон. Төрийн байгууллагууд концессын гэрээ, зүйлийн жагсаалт, гүйцэтгэх ажил үүрэг, үзүүлэх үйлчилгээний харилцааг зохицуулсан байна.</p>	<p>Төрийн байгууллагын вэб сайтад байгууллагын төсөвтэй холбоотой зургаан баримт бичгийг тавьсан байгаа эсэхийг шалгасан бөгөөд хоёр оноор харьцуулан харахад дараахь байдалтай байна. Өнгөрсөн жилээс ялгаатай нь төслийн гүйцэтгэлийн биелэлт гэсэн баримт бичгийг 2011 онд нэмж шинжилсэн. Үүнд байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төслийн гүйцэтгэл ба дараа жилийн төсвийн төслийг тавих нь бага хувиар ч гэсэн өсчээ.</p> <p>Иргэдийн хувьд төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт өнгөрсөн оныхоос даруй 6.9 хувиар өссөн бол байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мөрдөж буй хууль тогтоомжийг вэб сайтад байрлуулсан байдал 66.2 хувиас 78.1 хувь хүртэл өссөн, дүрэм журам, заавар 70 хувиас 75 хувь болтлоо ихэсчээ.</p>
-----------------------	---	--	--

Хавсралт 2

<p>10 дугаар зүйл.</p>	<p>10.1.1.ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, энэ тухай цахим хуудсандаа байрлуулах болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлэх; 10.1.2.тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх; 10.1.3.тендерг оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; 10.1.4.тендерг шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг цахим хуудсанд байрлуулан тухай бүр шинэчлэх, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулах; 10.1.5.худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулан тухай бүр шинэчлэх; 10.1.6.тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх; 10.1.7.худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийг нийтийн эрх ашгийн төлөө зарцуулах ёстой учир тэдгээр өмчөөр бараа үйлчилгээ худалданавах, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг тусгасан.</p>	<p>Байгууллагын худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг таван үзүүлэлтээр авч шинжилсэн. 2010 оноос ялгаатай нь энэ удаад худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг харуулсан үзүүлэлтийг нэмж оруулсан. Хэдийгээр худалдан авалтын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь холбогдох хуулиар тусдаа вэбсайтад тавигдах ёстой боловч тухайн байгууллагын вэб сайтад холбогдох мэдээллийг тавихад хориглох зүйлгүй гэж үзлээ.</p>
<p>11 дүгээр зүйл.</p>	<p>11.1.Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад дараах мэдээллийг энэ хуулийн 3.1-д заасан байгууллагаас авах эрхтэй: 11.1.1.тухайн байгууллагын эзэмшилд байгаа бүх төрлийн мэдээ, баримт бичиг, гэрээ, контракттай холбоотой мэдээлэл; 11.1.2.тухайн байгууллагын эзэмшилд байгаа эд зүйлтэй холбоотой мэдээлэл; 11.1.3.тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл. 11.2.Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч байгаа энэ хуулийн 3.1-д заасан байгууллагын холбогдох албан тушаалтан иргэнд энэ хуульд зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно. 11.3.Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлт дараах шаардлагыг хангасан байна: 11.3.1.хүсэлт гаргагч нь иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын буюу цахим шуудангийн хаяг, утасны дугаар, иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, гарын үсгээ зурсан байх; 11.3.2.хүсэлт гаргагч нь хуулийн этгээд бол нэр, хаяг буюу цахим шуудангийн хаяг, улсын бүртгэлийн дугаараа бичиж, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсгээ зурсан байх. 11.4.Иргэн энэ хуулийн 11.3.1-д заасны дагуу хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зуруулж болох бөгөөд хүсэлтийг иргэд бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана.</p>	<p>Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19-р зүйл, Монгол Улсын Үндсэн Хуулийн 16.1.17-д заасан мэдээлэл хайх хүлээн авах эрхийг хэрэгжүүлэхэд энэхүү заалт чухал үүрэгтэй.</p>	<p>2010 онтой харьцуулбал 2011 онд эдгээр долоон үзүүлэлтээс тендерийн урилгыг л вэб сайтад мэдээлэх явдал 2.6 хувиар өссөн. Харин бусад дөрвөн үзүүлэлт буюу хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээ, тендер шалгаруулалтын талаарх мэдээлэл, худалдан авсан бараа үйлчилгээний тайлан зэрэг үзүүлэлт нь бараг хоёр дахин буурчээ.</p>

Хавсралт 2

14 дүгээр зүйл.	<p>14.4.Энэ хуулийн 3.1.10-т заасан байгууллага нь дор дурдсан мэдээллийг нийтэд заавал нээлттэй байлгана:</p> <p>14.4.1.тухайн байгууллагын явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл;</p> <p>14.4.2.тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл;</p> <p>14.4.3.нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл.</p> <p>14.5.Энэ хуулийн 3.1.10-т заасан байгууллага өөрийн байгууллагын нууцын жагсаалтыг батлан нийтэд мэдээлэх үүрэгтэй.</p> <p>14.6.Мэдээллийг амаар, бичгээр, цахим хэлбэрээр өгч болох бөгөөд иргэн, хуулийн этгээд нь мэдээлэлтэй биечлэн танилцаж болно.</p> <p>14.7.Хариуг нь шууд өгөх боломжтой хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж хариуг өгнө.</p> <p>14.8.Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын 7 өдрийн дотор өгөх бөгөөд хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол тэдгээрийн төлөөлөл болох нэг иргэнд мэдээллийг өгнө.</p>	<p>төрийн байгууллагуудын мэдээлэл өгөх үүрэг, заавал нээлттэй байлгах мэдээллийн төрлүүд, мэдээлэлд хариу өгөх хугацааг тодорхой тусгасан байна.</p>	<p>Байгууллагын худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг таван үзүүлэлтээр авч шинжилсэн. 2010 оноос ялгаатай нь энэ удаад худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг харуулсан үзүүлэлтийг нэмж оруулсан. Хэдийгээр худалдан авалтын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь холбогдох хуулиар тусдаа вэб сайтад тавигдах ёстой боловч тухайн байгууллагын вэб сайтад холбогдох мэдээллийг тавихад хориглох зүйлгүй гэж үзлээ.</p>	
Зөвлөлдөх орчин				
15 дугаар зүйл.	<p>15.1.Иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр мэдээлэл авах хүсэлт гаргаж болно.</p> <p>15.2.Цахим хэлбэрээр мэдээлэл авах хүсэлт гаргасан тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь цахим баримт бичиг үйлдэн, тоон гарын үсэг зурах бөгөөд түүнд өөрийн иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, холбогдох байгууллагад цахим шуудангаар ирүүлсэн байна.</p> <p>15.3.Мэдээллийг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд өгөх тохиолдолд тухайн байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурах бөгөөд хүсэлт гаргагчид мэдээллийг цахим шуудангаар хүргүүлнэ.</p>	<p>техник технологийн хөгжилтэй уялдан иргэд мэдээллийг цахим хэлбэрээр авах боломжийг олгосон.</p>	<p>мэдээллийг хүлээн авах, өгөх хугацааг нарийн тодорхойлж өгөөгүй.</p>	<p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудаар энэхүү заалтын хэрэгжилт зохицуулагдаж байна.</p>
17 дугаар зүйл.	<p>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.</p> <p>17.1.Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар дээд шатны байгууллага, албан тушаалтан, Хүний эрхийн Үндэсний Комисс, эсхүл шүүхэд гомдол гаргаж болно.</p> <p>17.2.Энэ хуулийн 17.1-д заасан гомдлыг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг дараах хуулиар зохицуулна:</p> <p>17.2.1.гомдлыг дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргаж байгаа бол Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;</p> <p>17.2.2.гомдлыг Хүний эрхийн Үндэсний Комисст гаргаж байгаа бол Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль;</p> <p>17.2.3.гомдлыг шүүхэд гаргаж байгаа бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,</p>	<p>Иргэдийн мэдээлэл авах эрх зөрчигдөхөд хаана хандах, ямар хуулиар шийдвэрлэхийг тодорхой заажээ.</p>	<p>Зарим аж ахуй нэгж байгууллагууд өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх журмыг баримтлан мөрддөг.</p>	<p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудаар энэхүү заалтын хэрэгжилт зохицуулагдаж байна.</p>
Идэвхтэй оролцоо				
12 дугаар зүйл.	<p>12.1.Мэдээлэл хүсэгч мэдээлэл авах талаар дараах эрх эдэлнэ:</p> <p>12.1.2.мэдээлэл авах хэлбэрээ сонгох;</p>			

Хавсралт 2

6. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулинд хийсэн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	эерэг тал	сөрөг тал	журам, хөтөлбөр	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
7 дугаар зүйл.	7.1.8/ иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаархи мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх;	иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг тогтмол мэдээлэх үүргийг тухайн байгууллага, албан тушаалтанд өгсөн	ямар хэвлэл мэдээллийн хэрэгслээр \өдөр тутмын\ ямар хугацаанд \жил, улирал, сар\ мэдээлэх нь тодорхой бус. Өөрөөр хэлбэл 3 жилд нэг удаа ч мэдээлж болохоор байна.	Энэхүү хуулийн хүрээнд дагаж мөрдөх байдлаар гарсан журам хөтөлбөрүүд байдаг ч ихэнхи байгууллага өргөдөлгомдлыг хуулийн дагуу шийдвэрлэж байна.	2010 оны жилийн эцсийн байдлаар Нийслэл хотын хэмжээнд иргэдээс ирсэн өргөдөл гомдлын 132305 буюу 27,5 хувийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлж, 342158 буюу 71,1 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг өгсөн ба хугацаа болоогүй 6541, хугацаа хэтэрсэн 19, нийт 6560 (1,3%) өргөдөл хүлээгдэж байгаа талаар нийслэлийн 2011 оны тайланд бичжээ.
	7.1.9/ хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах.	төрийн байгууллага, албан тушаалтны өргөдөл, гомдлыг хүлээн авах хүрээг ил тод болгосон	нийтэд мэдээлээгүйн улмаас гарах хариуцлагыг хэн хүлээх нь тодорхой бус		
	7.3. Байгууллагын удирдлага нь тухайн жилд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаархи дүн мэдээг жил бүр нийтэд тайлагнана.	өргөдөл гомдол шийдвэрлэлтийг тайлагнах болсон	ямар хугацаанд хэрхэн тайлагнах нь тодорхой бус		
Зөвлөлдөх орчин					
5 дугаар зүйл.	5.1. Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй. 5.2. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн өргөдөл, гомдол гаргах талаар Монгол Улсын иргэний адил эрх эдэлнэ.	өргөдөл гомдол гаргах эрхийг тодорхой заасан			2010 онд Баянгол, Налайх дүүрэгт “Нэг цонхны үйлчилгээ”-г шинээр нэвтрүүлж өргөдөл гомдол, иргэний бүртгэл, үйлдвэрлэл үйлчилгээний зөвшөөрөл олгох, хууль эрх зүйн зөвлөгөө, нийгмийн даатгал, хөдөлмөр халамж, газрын харилцаа, нотариатын үйлчилгээ зэрэг асуудлаар иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлж байна. Нийслэлийн 6 дүүрэг / Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Налайх/ энэ онд давхардсан тоогоор 26 нэр төрлийн үйлчилгээг 603779 иргэнд хүргэсэн.
7 дугаар зүйл.	7.1.2/ харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдлыг заавал хүлээн авах; 7.1.3/ өргөдөл, гомдолд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, үндэслэлтэй шийдвэрлэх; 7.1.4/ өргөдөл, гомдлыг хугацаанд нь барагдуулах; 7.1.5/ өргөдөл, гомдолд дурдсан төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах; 7.1.6/ өргөдөл, гомдолд үндэслэл бүхий хариу өгөх;	өргөдөл гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх үүргийг тодорхой заасан	өргөдөл гомдлын шийдвэрлэх боломжоос нь шалтгаалан хугацааг нь өөр өөр тавьж өгөөгүй.		

Хавсралт 2

9 дүгээр зүйл.	9.1. Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр буюу амаар гаргана. Өргөдөл, гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаболно. Байгууллага бүр цахим хаягтай байна. 9.4.Иргэд радио, телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр болон тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан өргөдөл, гомдол гаргаж болно.	өргөдөл, гомдлыг гаргах хэлбэрүүдийг амаар бичгээр, цахим хэлбэрээр, утсаар, шууд нэвтрүүлгээр өгөх боломжийг бий болгосон.		Төрийн байгууллагууд энэхүү заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр бие даасан дотоод журмуудыг батлан гаргах, эсвэл энэ хуулиар өргөдөл гомдлыг шийдвэрлэж байна.	2010 оны жилийн эцсийн байдлаар Нийслэл хотын хэмжээнд иргэдээс амаар 73726 (15,3%), бичгээр 391479 (81,3%), утсаар 15628 (3,2%), цахим хэлбэрээр 190 (0,03%), нийт 481023 өргөдөл, гомдлыг хүлээн авсан. 132305 буюу 27,5 хувийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлж, 342158 буюу 71,1 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг өгсөн ба хугацаа болоогүй 6541, хугацаа хэтэрсэн 19, нийт 3560 (1,3%) өргөдөл хүлээгдэж байна.
12 дугаар зүйл.	12.2. Иргэдийг хүлээн авах байранд ирж амаар гаргасан өргөдөл, гомдлыг түүнийг хүлээн авах үүрэг бүхий ажилтан тэмдэглэн авч, тусгай бүртгэлд бүртгэнэ. 12.3. Бичгээр болон цахим сүлжээгээр дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтан хүлээн авч, дарааллын дагуу бүртгэнэ. 12.4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар бүртгэсэн өргөдөл, гомдлыг түүнийг шийдвэрлэх албан тушаалтанд өдөрт нь багтаан шилжүүлнэ.				
Идэвхтэй орлоцоо					
12 дугаар зүйл.	12.2. Иргэдийг хүлээн авах байранд ирж амаар гаргасан өргөдөл, гомдлыг түүнийг хүлээн авах үүрэг бүхий ажилтан тэмдэглэн авч, тусгай бүртгэлд бүртгэнэ. 12.3. Бичгээр болон цахим сүлжээгээр дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтан хүлээн авч, дарааллын дагуу бүртгэнэ. 12.4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар бүртгэсэн өргөдөл, гомдлыг түүнийг шийдвэрлэх албан тушаалтанд өдөрт нь багтаан шилжүүлнэ.	Иргэдийн өргөдөл гомдлыг нэгдсэн бүртгэлд хүлээн авч холбогдох албан тушаалтанд шуурхай шилжүүлэх үүрэг бий болсон.			2010 онд Нийслэлийн удирдлагуудын иргэдтэй уулзах уулзалтын хуваарийг Нийслэлийн Засаг даргаар батлуулан 3 дугаар сараас эхлэн мөрдөж нийслэлийн Засаг даргын 4 орлогч, Улаанбаатар хотын ерөнхий менежер, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нийт 3941 иргэнийг хүлээн авч уулзаж, санал хүсэлтийг нь сонсон асуудлыг нь шийдлээ.
16 дугаар зүйл.	16.1. Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолдуг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ. 16.2. Саналын шинжтэй өргөдлийн хариуг 90 хоногт багтаан өгнө.	Иргэдийн өргөдөл гомдлыг нэгдсэн бүртгэлд хүлээн авч холбогдох албан тушаалтанд шуурхай шилжүүлэх үүрэг бий болсон.	өргөдөл гомдлын шийдвэрлэх боломжоос нь шалтгаалан хугацааг нь өөр өөр тавьж өгөөгүй.		
Иргэдийн хяналт					
17 дугаар зүйл.	Өргөдөл, гомдол гаргагч өргөдөл, гомдлын талаархи шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд гомдол гаргах эрхтэй. Хуульд өөрөөр заагаагүй бол гомдлыг зохих дээд шатны нь байгууллага, албан тушаалтанд гаргана.	иргэд өргөдөл гомдлын шийдвэрийг эсэргүүцэх боломжтой болсон			

Хавсралт 2

7. Ард нийтийн санал асуулгын тухай хуулинд хийсэн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал			
9 дүгээр зүйл.	9.1. Санал асуулга бэлтгэн явуулах ажил ил тод байна. 9.2. Төрийн байгууллагын харьяалал бүхий хэвлэл, мэдээллийн байгууллага санал асуулга бэлтгэн явуулах ажлын явц, санал асуулгын дүнг олон нийтэд шуурхай, үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.	санал асуулга явуулах үйл ажиллагаа болон тэдгээрийн талдаарх мэдээллийн ил тод байдлыг үүрэг болгосон.	мэдээлэх үйл ажиллагааг зөвхөн төрийн байгууллагын харьяа мэдээллийн байгууллагад өгсөн.
11 дүгээр зүйл.	11.2. Иргэд санал асуулга явуулах тухай саналаа Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурлын гишүүдэд уламжилна. Энэхүү саналд санал асуулга явуулах болсон үндэслэл, тооцоо, холбогдох бусад баримт бичгийг хавсаргана.	Иргэдэд санал асуулгыг санаачлах эрхийг өгсөн	Ямар тохиолдолд иргэдийн саналыг хүлээж авах, хүлээн авахгүй хэрхэн арга хэмжээ авах талаар тусгаагүй.
Зөвлөлдөх орчин			
4 дүгээр зүйл.	4.1. Санал асуулгыг төрийн дотоод, гадаад бодлогыг тодорхойлохтой холбогдсон тодорхой асуудлаар ард нийтийн сонголт хийлгэх шаардлага гарсан тохиолдолд явуулна. 4.2. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард нийтийн санал асуулга явуулж болно.	гадаад дотоод бодлого, Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар иргэд саналаа өгөх боломж бүрдсэн.	ямар тохиолдолд иргэдээр сонголт хийлгэх нь тодорхой бус байгаа юм.
Идэвхтэй оролцоо			
3 дугаар зүйл.	3.1. Санал асуулгад Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд оролцож, санал асуулгаар шийдвэрлэх асуудлын талаар саналаа нууцаар гаргана.	иргэдийн сонгуульд шууд оролцох эрхийг хангасан	

Хавсралт 3

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хуулинд хийсэн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
<i>Мэдээллийн хүртээмж ил тод байдал</i>				
10 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг нийтлэх	10.1. Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зөвшөөрснөөр төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэхээс гадна хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ.	Олон нийтэд мэдээлэхийг үүрэг болгосон нь чухал зохицуулалт болсон.	Нийтэд мэдээлэх хэлбэр нь вэб сайтаар дамжуулж байгаа нь хөдөө орон нутгийн иргэдэд хүрч байгаа эсэх нь эргэлзээтэй байгаа.	Ерөнхийлөгчийн Тамгын Газрын вэб сайтад Ерөнхийлөгчийн зарлиг захирамжуудыг нийтэд байнга мэдээлж байна. www.president.mn, www.irgen.org

2. Улсын Их Хурлын тухай хуулинд хийсэн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Эерэг тал	Сөрөг тал	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
<i>Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал</i>				
3 дугаар зүйл. УИХ-ын үйл ажиллагааны үндсэн зарчим	3.2. Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь хараат бус, нээлттэй, ил тод, хариуцлагатай, иргэдэд хүртээмжтэй байх бөгөөд асуудлыг тал бүрээс нь хэлэлцэж цөөнхийн саналыг хүндэтгэн үзэж олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд тулгуурлана.	нээлттэй ил тод байдлыг хангаж өгсөн.		УИХ-ын үйл ажиллагаа нь ардчиллын зарчимд тулгуурлагдан явагдаж байна. www.parlament.mn

Хавсралт 3

Зөвлөлдөх орчин				
3 дугаар зүйл. УИХ-ын үйл ажиллагааны үндсэн зарчим	7.1.14. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн талаар иргэд, байгууллагаас ирүүлсэн саналыг судлан үзэж, шаардлагатай гэж үзвэл төсөл санаачлах, шаардлагагүй бол энэ тухай хариуг бичгээр өгөх;	Иргэд эрх ашигтаа нийцүүлэн санаачлах боломж бүрдсэн.	Ш а а р д л а г а хангасан гэж ямар төслийг хэлэх нь тодорхойгүй	2013 оны 1 сарын байдлаар Улсын Их Хуралд 426 иргэд сонгогчдоос 290 захидал ирүүлсэн. Үүнээс 63 нь биечлэн шийдвэрлэж 27-г судлан шийдвэрлүүлэхээр харьяаллын дагуу шилжүүлж, 69-г судалж байна. УИХ-ын гишүүд төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан иргэд сонгогчдын төлөөлөл нийт 211 хүнийг албан болон хувийн хүсэлтээр төрийн ордонд хүлээн авч уулзан санал хүсэлтийг нь шийдвэрлэсэн байна.
7 дугаар зүйл: Гүшүүний бүрэн эрх	7.1.15. иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэж хариуг нь шууд өгөх, эсхүл хариуцан шийдвэрлэх эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлж энэ тухай хариу мэдэгдэх;	Иргэд эрх ашигтаа нийцүүлэн хууль санаачлах боломж бүрдсэн.		
19 дүгээр зүйл. Байнгын хороо	19.4.Өргөдлийн байнгын хороо нь энэ хуулийн 19.2-т заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 19.4.1.Улсын Их Хурал, түүний Байнгын болон дэд, түр хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судлах, шийдвэрлэх; 19.4.2.өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг сонсох, холбогдох албан тушаалтнаас тайлбар авах.	Өргөдлийн байнгын хорооны эрхийг тодорхой болгож өгсөн бөгөөд ажиллах	Өргөдөл гомдлын ш и й д в э р л э х хугацааг тодохой тусгаж өгөөгүй байна.	
20 дугаар зүйл. Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ	20.4.Өргөдлийн байнгын хороо: 20.4.1.иргэд, байгууллагаас Улсын Их Хурал, түүний Байнгын болон дэд, түр хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судлах, шийдвэрлэх асуудал.	Байнгын хороодын үйл ажиллагааг тодорхой болгосон		
39 дүгээр зүйл. УИХ-ын Тамгын газар, түүний эрхлэх ажил	39.1.11. гишүүдэд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг нэгтгэн дүгнэж Улсын Их Хурлын дарга, Өргөдлийн байнгын хороо, гишүүдэд мэдээлэх;	Мэдээлэх үйл ажиллагааг тодорхой тусгасан.		
29 дүгээр зүйл. Чуулганы хуралдааны нийтлэг журам	29.12.Иргэд, гадаад, дотоодын зочид төлөөлөгчид чуулганы ажиллагаатай танилцах, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл, сурвалжлага хийх эрхтэй бөгөөд энэ талаар мөрдөх журмыг Улсын Их Хурлын дарга батална.	Иргэд төрийн ордонтой танилцах боломж бүрдсэн.	Төрийн ордонд албаны болон үндэсний хувтастай нэвтрэх	

Хавсралт 3

3. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулинд хийсэн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	эерэг тал	сөрөг тал	Хэрэгжилт
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал				
6 дугаар зүйл. Хуулийн төсөл боловсруулах	6.1.5.хуулийн төсөл, түүний үзэл баримтлал болон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх, цахим хуудсанд байршуулах зэрэг бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлэх;	Мэдээлэх хэлбэрийг тодорхой болгож өгсөн.		www.president.mn , www.parliament.mn , болон холбогдох яамдуудын вэб сайт дээр хууль санаачлагчийн нэр болон хуулийн төсөл өргөн барьсан огноо, хэлэлцүүлэх өдөр зэргийг мэдээлж хуулийн төсөл бүрэн эхээрээ тавигдаж байна.
18 дугаар зүйл. Хуулийн төсөлд санал авах	18.4.1.хуулийн төслийг бүрэн эхээр нь байгууллагынхаа цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулах	Мэдээлэх хугацааг тодорхой тусгаж иргэдэд танилцах боломжийг олгосон.	Цахим хуудсанд байршуулах нь иргэдэд мэдээлэл хүртээмжгүй байна	
Зөвлөлдөх орчин				
18 дугаар зүйл. Хуулийн төсөлд санал авах	18.4.2.хуулийн төслийг иргэн, хуулийн этгээдэд нэр зааж хүргүүлэх, эсхүл уулзалт, ярилцлага зохион байгуулж болно.	Тухайн чиглэлээр мэргэшсэн мэдлэгтэй иргэдийн санал бодлыг сонсох боломж бүрдсэн.	зохион байгуулахгүй байж ч болох сул талтай байна.	Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимаар хуулийн төслийн хэлэлцүүлэг хийгдэж байгаа

Хавсралт 3

<p>19 дүгээр зүйл. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх</p>	<p>19.1. Шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч нь нийгмийн нэн чухал харилцааг зохицуулахаар санаачилсан хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай саналаа Улсын Их Хуралд оруулж болно</p> <p>19.2. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай оруулсан саналыг Улсын Их Хурал чуулганаар хэлэлцэж, гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд төслийг ард нийтээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хэлэлцүүлэх хүрээ болон түүнтэй холбогдон гарах зардлыг хэрхэн санхүүжүүлэхийг тодорхой заасан байна.</p> <p>19.3. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэхдээ дараахь хүрээнд хэлэлцүүлж болно:</p> <p>19.3.1. нийт ард түмнээр;</p> <p>19.3.2. нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүрээнд;</p> <p>19.3.3. тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд.</p> <p>19.4. Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай Улсын Их Хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газар энэ ажлыг зохион байгуулж, дүнг нэгтгэн Улсын Их Хурлын чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэхэд танилцуулна.</p>	<p>Хуулийн төслийн ард нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах тодорхой эзэнтэй бөгөөд холбогдох зардлыг хэрхэн санхүүжүүлэх талаар тусгаж өгсөн.</p>	<p>Ямар арга хэрэгслээр нийтэд мэдээлэхийг тодорхой заагаагүй</p>	<p>Ард нийтийн санал асуулга явуулж байгаагүй.</p>
Идэвхтэй оролцоо				
<p>3 дугаар зүйл. Хууль санаачлах эрхийг хэрэгжүүлэх</p>	<p>3.2. Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид бичгээр уламжлах бөгөөд тэрээр уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно.</p>	<p>олон нийтийг оролцуулах боломжийг бүрдүүлсэн.</p>	<p>Яг ямар нөхцөлд үндэслэлтэй гэж үзэх нь тодорхой бус</p>	<p>Хуулийн төслийг Иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байгаагүй</p>
<p>6 дугаар зүйл. Хуулийн төсөл боловруулах</p>	<p>6.1.6. иргэн, байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг Улсын Их Хуралд уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах;</p>			
<p>7 дугаар зүйл. Хуулийн төсөл боловруулах ажлыг зохион байгуулах</p>	<p>7.1.3. хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх.</p>	<p>Энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг судлаач нарт боломж нэмэгдсэн</p>		
<p>9 дүгээр зүйл. Хуулийн төслийн үзэл баримтлал,</p>	<p>9.9. Хуулийн төсөл боловруулах явцад холбогдох мэргэжлийн байгууллага, шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага болон бусад байгууллага, иргэдээс санал авч төсөл боловруулахад харгалзан үзэж болно.</p>	<p>Энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг судлаач нарт боломж нэмэгдсэн</p>	<p>Харгалзан үзэж болно гэсэн нь иргэдийн саналыг харгалзан үзэхгүй ч байж болох талтай байна.</p>	



Хавсралт 3

5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хийсэн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Хэрэгжилтийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал				
9 дүгээр зүйл. Сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим	9.1.Сонгууль зохион байгуулах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний албан тушаалтан, нэр дэвшигч, сонгуульд оролцогч улс төрийн нам, хамтарсан намууд болон бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн үйл явцыг зохион байгуулах, түүнд оролцохдоо дараах зарчмыг баримтална: 9.1.1.хууль дээдлэх; 9.1.2.ил тод байдлыг хангах; 9.1.3.шударга ёсыг сахих; 9.1.4.маргааныг шуурхай, үндэслэлтэй, хуулийн хүрээнд шударга шийдвэрлэх; 9.1.5.сонгогчдын эрх, сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хуулийн хариуцлага зайлшгүй хүлээлгэх.	Сонгуулийн үйл явцыг ил тод, шударга байлгаж сонгогчийн эрхийг баталгаажуулах, сонгуулийн үр дүн үнэн зөв бодитой байх зарчмыг хангах.		Хуулийн хугацаандаа хэвлэл мэдээллийн байгууллагууд хэрэгжүүлсэн.
	9.2.Сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан сонгуулийн хороодоос энэ хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр батлан гаргасан шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд албан ёсоор мэдээлсэн байна.	Мэдээлэх хэлбэр тодорхой	Мэдээлэх хугацаа тодорхой бус	
15 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, түүний бүрэн эрх	15.1.Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, аймагт долоо, нийслэлд таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ.	Мэдээлэх хугацаа тодорхой	Мэдээлэх хэлбэр тодорхой бус	Хуулийн хугацаандаа хэвлэл мэдээллийн байгууллагууд хэрэгжүүлсэн.
16 дугаар зүйл.Сум, дүүргийн сонгуулийн хороо, түүний бүрэн эрх	16.1.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүрэгт сум, дүүргийн сонгуулийн хороог санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.	Мэдээлэх хугацаа тодорхой	Мэдээлэх хэлбэр тодорхой бус	
17 дугаар зүйл. Хэсгийн хороо, түүний бүрэн эрх	17.1.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.	Мэдээлэх хугацаа тодорхой	Мэдээлэх хугацаа болон мэдээлэх хэлбэр тодорхой бус	Хуулийн хугацаандаа хэвлэл мэдээллийн байгууллагууд хэрэгжүүлсэн.
	17.2.Хэсгийн хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.2.1.хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;			
18 дугаар зүйл.	18.4.1.салбар комиссын хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;			
19 дүгээр зүйл. Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалт	19.8.Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга энэ хуулийн 19.1-д заасан хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуваарийг долоо хоногоор гаргаж, тухайн сонгуулийн хорооны ажиллах байрын мэдээллийн самбарт ил тавина.	Мэдээлэх хэлбэр хугацаа тодорхой	Мэдээлэх хугацаа болон хэлбэр тодорхой бус	
	19.16.Сонгуулийн хороодын хуралдааны шийдвэрийг нийтэд ил тод мэдээлнэ.			

Хавсралт 3

20 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилуулах	20.4.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.3-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор болон энэ хуулийн 12.1-д заасны дагуу байгуулсан хэсэг нэг бүрээр нь нэгтгэн гаргах бөгөөд уг жагсаалтыг сонгуулийн жилийн гуравдугаар сарын нэгний өдрөөс өмнө сонгууль дуустал өөрийн цахим хуудаст байрлуулна.	сонгогчдын бүртгэлийг зөвхөн бүртгэлийн байгууллага гаргахаар болсон нь ач холбогдолтой шийдэл болсон	Нийтэд мэдээлэх хэлбэр нь вэб сайтаар дамжуулж байгаа нь хөдөө орон нутгийн иргэдэд хүрч байгаа эсэх нь эргэлзээтэй.	Сонгуулийн хороо нь бүрэлдэхүүнд зөвхөн төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчийг томилон ажиллуулж байна.
	20.11.Хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн ажиллах байранд, өөрийн ажиллах байргүй бол сум, хорооны Засаг даргын тамгын газрын байранд, санал авах байр бэлэн болсны дараа санал авах байранд ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.		Хугацаандаа хэрэгжээгүй сонгуулийн хэсгийн хороод байгаа	
27 дугаар зүйл.Нэр дэвшигч, түүнийг бүртгэх	27.9.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 27.7-д заасны дагуу нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор нийт нэр дэвшигчийг улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ	Мэдээлэх хугацаа тодорхой	Мэдээлэх хэлбэр тодорхой бус	
28 дугаар зүйл.Нөхөн нэр дэвшүүлэх	28.1.Намаас нэр дэвшигч нас нөгчсөн, эсхүл шүүхээр ял шийтгүүлсэн тохиолдолд тухайн нам нь өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлэх шийдвэрээ Сонгуулийн ерөнхий хороонд санал авах өдрөөс 30 хоногийн өмнө ирүүлж, энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан журмын дагуу бүртгүүлж болох бөгөөд Сонгуулийн ерөнхий хороо энэ тухай нийтэд мэдээлнэ.	Мэдээлэх болон тодорхой	хэлбэр хугацаа	
29 дүгээр зүйл.Нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах	29.1.Нэр дэвшигч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлж, нийтэд мэдээлэгдсэний дараа түүнийг нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хасах талаарх энэ хуульд заасан үндэслэл тогтоогдвол Сонгуулийн ерөнхий хороо энэ тухай шийдвэр гаргаж, нийтэд мэдээлнэ.			
42 дугаар зүйл. Сонгуулийн зардлын данс	42.1.Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам нэр дэвшигчийг бүртгүүлснээс хойш тав хоногийн дотор сонгуулийн зардлын сан байгуулан банкинд данс нээлгэж, Сонгуулийн ерөнхий хороо болон Үндэсний аудитын газарт бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана.	Мэдээлэх тодорхой	хугацаа	Мэдээлэх хэлбэр тодорхой бус
44 дүгээр зүйл. Сонгуулийн зардлын тайлан гаргах	44.5.Сонгуулийн ерөнхий хороо зардлын тайланг хянаж, санал хураалт дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх ба нэг сая, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хорин сая, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана	Мэдээлэх тодорхой	хугацаа	СЕХ энэ тайланг хугацаанд нь нийтэд мэдээлсэн www.forum.mn .
45 дугаар зүйл.Санал авах газар, хугацаа	45.2.Хэсгийн хороо сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг уул өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ.	хугацаа тодорхой		
	45.9.Санал авах байрын байршлыг нийтийн эмх замбараагүй байдал, үер ус, гал түймэр зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас өөрчилж болох бөгөөд энэ тухай нэн даруй сонгогчид мэдээлнэ.			Мэдээлэх хэлбэр тодорхой бус
46 дугаар зүйл.Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах	46.2.Комисс болон салбар комисс нь сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг уул өдөр хүртэлх хугацаанд нийтэд зарлан мэдээлнэ.	Гадаадад сонгогчдод тусгасан	байгаа мэдээлэл ажлыг	Мэдээлэх хэлбэр нь тодорхойгүй байна.

Хавсралт 3

Зөвлөлдөх орчин				
15 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, түүний бүрэн эрх	15.2.7. харьяалах сонгуулийн хороодын шийдвэрийн талаарх өргөдөл, гомдлыг бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шийдвэрлэж бичгээр хариу өгөх			
17 дугаар зүйл. Хэсгийн хороо, түүний бүрэн эрх	17.2.8. сонгууль зохион байгуулах болон санал авах, санал тоолохтой холбогдсон асуудлаар гарсан өргөдөл, гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлах;	Өргөдөл гомдлын хариуг бичгээр өгөхөөр тодорхой тусгасан.	Өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заагаагүй	Ерөнхийд нь сонгогчдийн бүртгэлтэй холбоотой асуудлыг харахад Иргэний бүртгэлийн байгууллага эдгээр заалтуудыг зөрчсөн гэж харагдаж байна. Тодруулвал: хэсгийн хороонд ил тавьсан нэрийн жагсаалттай сонгогчийг тулгахад 7 хүний регистр буруу, 3 хүний нэр буруу, 12 хүн нас барсан, 1 хүн хорих ял авсан, Мөн зарим хүний нэр жагсаалтад байхгүй зарим нь давхар бүртгэгдсэн зэрэг асуудал гарч СЕХ-нд шалгуулах тухай албан тоот явуулсан. Энэ албан тоотын хариуг бид сонгуулийн дараа хүлээж авахад эдгээр сонгогчид шилжилт хөдөлгөөнөө цаг тухайд нь хийлгээгүй байна. Мөн сонгогчдын жагсаалтад давхар бүртгэгдээгүй байна гэсэн хариу ирүүлсэн.
18 дугаар зүйл. Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах комисс, салбар комисс, тэдгээрийн бүрэн эрх	18.4.6. сонгууль зохион байгуулах, сонгогчдын нэрийн жагсаалт болон санал авахтай холбогдсон асуудлаар гарсан өргөдөл, гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлах;			
19 дүгээр зүйл. Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалт	19.21. Хуульд өөрөөр заагаагүй бол доод шатны сонгуулийн хорооны шийдвэр, үйл ажиллагааны талаар дээд шатны сонгуулийн хороонд гомдол гаргаж болох бөгөөд зохих шатны сонгуулийн хороо гомдлыг хүлээж авснаас хойш гурван хоногийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ.	шийдвэрлэх хугацааг тодорхой зааж өгсөн	Хариу мэдэгдэх хугацаа тодорхой	
22 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг шийдвэрлэх журам	22.1. Сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн байвал өөрийн болон өөрийн гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс арваас доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.	Гомдол гаргах хугацааг тодорхой зааж өгсөн байна.		
	22.2. Улсын бүртгэлийн холбогдох байгууллага иргэний бүртгэлийн мэдээллийн улсын санг үндэслэн энэ хуулийн 22.1-д заасны дагуу гомдол гаргасан иргэний мэдээллийн талаар лавлагаа гаргах ба уг лавлагааг үндэслэн хэсгийн хорооны дэргэд ажиллах иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан тухайн сонгогчийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг гурав хоногийн дотор сонгогчдын нэрийн жагсаалтад оруулна	Асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой зааж өгсөн байна.		
67 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх	67.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол сонгуулийн зохион байгуулалтын асуудлаар гаргасан сум, дүүрэг, хэсгийн хорооны шийдвэр, үйл ажиллагааны талаар аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэр, үйл ажиллагааны талаар Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргаж болох бөгөөд гомдол хүлээн авсан сонгуулийн хороо хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэй.	Асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой зааж өгсөн байна.		

Хавсралт 3

Иргэдийн хяналт				
<i>9 дүгээр зүйл. Сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим</i>	9.5.Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага нь Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон журмын дагуу сонгуулийн хороод, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, түүнд эрхээ хэрэгжүүлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад туслалцаа үзүүлэх эрхтэй.			
<i>48 дугаар зүйл.Санал авах ажиллагаа</i>	48.9.Санал авах ажиллагаанд сонгуулийн ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.			
<i>50 дугаар зүйл. Сонгуулийг ажиглах</i>	50.6.Гадаадын болон олон улсын байгууллага сонгуулийг ажиглахад гадаад улсын иргэн ажиглагч байж болно. 50.11.Ажиглагч сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, санал авах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн тухай хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглан хянах бөгөөд дараах эрх эдэлнэ: 50.11.1.сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах; 50.11.2.саналын хуудасны битүүмжлэгдсэн байдалтай танилцах; 50.11.3.санал авах, тоолох ажлыг ажиглах; 50.11.4.зөврийн битүүмжилсэн саналын хайрцагар санал авах сонгогчдын нэрийн жагсаалт, тэднээс санал авах чиглэл, хуваарь, явцтай танилцах; 50.11.5.санал бэлтгэх бүхээг, зөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмж болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах; 50.11.6.санал авах байранд санал авах үйл явцыг бүхэлд нь ажиглаж болохуйц суудалтай байх; 50.11.7.санал авах үйл явцад зөрчил гарвал хэсгийн хорооны даргад мэдэгдэж, залруулахыг хүсэх, илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, баримтжуулах, гэрчээр гарын үсэг зуруулах; 50.11.8.дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах; 50.11.9.хэсгийн хорооны гишүүдээс холбогдох мэдээлэл авах, сонгуулийн хорооны хуралдааныг ажиглах; 50.11.10.ажиглалтын тайлангаа нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх; 50.11.11.саналын хуудасны зурган болон тоон үзүүлэлтийг цахим хэлбэрээр хуулбарлан авах; 50.11.12.хууль тогтоомжид заасан бусад.	Монгол төрийн үйл хэргийг удирдахад иргэдийн оролцоо, тэдний хяналтыг дээшлүүлэхэд ТББ-ын үүрэг ролийг дээшлүүлж тэдний хяналт шинжилгээ мониторинг хийх эрхийг баталгаа жуулж өгсөн		Сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад шинжилгээ хийх, сонгогчийн боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, туслалцаа үзүүлэх зорилгоор Сонгогчдын боловсрол төв болон бусад төрийн бус байгууллагуудын дүгнэлт шинжилгээ мониторинг хийлгэсэн. Мөн гадаад улсаас сэтгүүлчид ирж сонгуулийн үйл ажиллагааг сурвалжилсан. Ажиглагчид санал авах явцыг хянахад бэрхшээлтэй асуудал гарч байгаа ба тусгай ажиглагчийн суудал бэлтгэггүй, ажиглагч нарыг гадуурхах, холбогдох мэдээллийг өгөхгүй байх, хянах боломжийг хаах асуудлууд гарч байгаа.
<i>51 дүгээр зүйл. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглах</i>	51.5.Ажиглагч нь санал авах үед уг ажиллагааг сонгуулийн тухай хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглан хянах бөгөөд дараах эрх эдэлнэ: 51.5.1.сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах; 51.5.2.саналын хуудасны битүүмжлэгдсэн байдалтай танилцах; 51.5.3.санал бэлтгэх бүхээг, битүүмжилсэн саналын хайрцаг болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах; 51.5.4.санал авах байранд сонгуулийн санал авах үйл явцыг бүхэлд нь ажиглаж болохуйц суудалтай байх; 51.5.5.салбар комиссын гишүүдээс холбогдох мэдээлэл авах;	Гадаад улсад авч байгаа санал хураах үйл ажиллагаа будлиангүй явагдах нөхцөл бүрдсэн.		



Хавсралт 3

54 дүгээр зүйл. Сонгогч зөвөрийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал өгөх	54.8.Зөвөрийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал авах ажиллагаанд хоёроос доошгүй ажиглагчийг оролцуулна.	Ажиглагч байлцах нь санал будлиангүй байна.		Иргэний оролцох эрхийг хангаж өгсөн. Санал авах байранд очиж өгөх боломжгүй иргэний саналыг ажиглагч заавал байх нөхцөл бүрдэж байна.
55 дугаар зүйл.Санал тоолох	55.1.Хэсэгт санал тоолох ажиллагааг санал авах өдрийн 22.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.			
57 дугаар зүйл.Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох	57.2.Сонгуулийн ерөнхий хороо санал тоолох ажиллагааг өөрийн байранд санал авах өдрийн 22.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.	Сонгууль будлиангүй явагдах нөхцлийг бүрдүүлсэн.		Санал тоолох ажиллагаа нь ажиглалт хийсэн хэсгийн хороодын 60%-д санал авах ажиллагаа дуусгавар болсноор 20 цагт эхэлсэн бол 40%-д нь сүүлийн сонгогчдыг гаргах, тооллогод бэлтгэх мөн амарч цайлах шалтгаанаар сүүлийн хэсгийн хорооны тооллого 21 цагт эхэлсэн байна.

6. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулинд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал				
9 дүгээр зүйл Сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд батлах зарчим	<p>9.1.Сонгууль зохион байгуулах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний албан тушаалтан, сонгуульд оролцогч нам, эвсэл болон бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн үйл явцыг зохион байгуулах, түүнд оролцохдоо дараах зарчмыг баримтална</p> <p>9.1.1.хууль дээдлэх; 9.1.2.ил тод байдлыг хангах; 9.1.3.шударга ёсыг сахих; 9.1.4.маргааныг шуурхай, үндэслэлтэй, шударга шийдвэрлэх; 9.1.5.сонгогчдын эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хуулийн хариуцлага зайлшгүй хүлээлгэх.</p> <p>9.2.Сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан сонгуулийн хороодоос энэ хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд нийтгээр дагаж мөрдүүлэхээр батлан гаргасан шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд албан ёсоор мэдээлсэн байна.</p>	Сонгуулийн үйл явцыг илтөд,шударгабайлгаж сонгогчийн эрхийг баталгаажуулах, сонгуулийн үр дүн үнэн зөв, бодитой байх зарчмыг хангах үүднээс сонгуулийн болон бусад хууль тогтоомжийг зөрчиж сонгогчийг татах, санал худалдаж авахад чиглэсэн аливаа үйлдэл гаргасан этгээдэд зохих хариуцлага хүлээлгэхэд чиглэсэн зохицуулалтууд хуульд тусгагдсан.		Сонгуулийн үйл явцыг ил тод, шударга байлгаж сонгогчийн эрхийг баталгаажуулах, сонгуулийн үр дүн үнэн зөв, бодитой байх зарчмыг хангах үүднээс сонгуулийн болон бусад хууль тогтоомжийг зөрчиж сонгогчийг татах, санал худалдаж авахад чиглэсэн аливаа үйлдэл гаргасан этгээдэд зохих хариуцлага хүлээлгэхэд чиглэсэн зохицуулалтууд хуульд тусгагдсан.
				Хуулийн дагуу хугацаандаа явагдаж байна.

Хавсралт 3

16 дугаар зүйл. Тойргийн хороо, түүний бүрэн эрх	16.1. Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө тойргийн хороог дарга, нарийн бичгийн дарга, сондгой тооны 7-13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ.	Мэдээлэх хугацааг тодорхой заасан	Мэдээлэх хэлбэр тодорхой бус	Хуулийн дагуу хугацаандаа явагдаж байна.
	16.2.9. санал хураалтын дүнгийн тухай харьяалах салбар болон хэсгийн хороодын шийдвэрийг үндэслэн тухайн тойргийн сонгуулийн дүнг нэгтгэж, Сонгуулийн ерөнхий хороонд хүргэх, нийтэд мэдээлэх;			Мэдээлэх хугацаа тодорхой бус
17 дугаар зүйл. Салбар хороо, түүний бүрэн эрх	17.1. Тойргийн хороо нь суманд, шаардлагатай бол дүүрэгт салбар хороог санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, 5, эсхүл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ	Мэдээлэх хугацааг тодорхой заасан		Хуулийн дагуу хугацаандаа явагдаж байна.
	17.2.4. санал хураалтын дүнгийн тухай харьяалах хэсгийн хороодын шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн хэмжээгээр сонгуулийн дүнг нэгтгэж, харьяалах тойргийн хороонд хүргэх, нийтэд мэдээлэх;			Мэдээлэх хугацаа тодорхой бус
18 дугаар зүйл. Хэсгийн хороо, түүний бүрэн эрх	18.1. Тойргийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.	Сонгогчдыг саналаа өгөхөд түргэн шуурхай байх үүднээс хэсгийн хороодын тоог нэмэгдүүлсэн.	Санал авах хугацаа багассан.	УИХ-ын сонгуулийн явцад сонгогчдын санал авах үйл явц санал авах хугацаандаа ямар нэгэн будлиан маргаангүй явагдсан. Цаг хугацаандаа явагдсан.
	18.3.1. хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;			
19 дүгээр зүйл. Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалт	19.8. Сонгуулийн хороодын хуралдааны шийдвэрийг нийтэд ил тод мэдээлнэ.		хугацаа, хэлбэр тодорхой бус	Телевизийн нэвтрүүлэгээр мэдээлэл хийгдээд явсан.
20 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах	20.4. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.3-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээллийг <u>аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор</u> болон энэ хуулийн 13.1-д заасны дагуу байгуулсан хэсэг нэг бүрээр <u>нь нэгтгэн гаргах бөгөөд уг жагсаалтыг сонгуулийн жилийн гуравдугаар сарын 15-ны өдрөөс өмнө сонгууль дуустал өөрийн цахим хуудаст байрлуулна.</u>	Сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд зөвхөн төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчийг томилон ажиллуулж, сонгогчдын бүртгэлийг иргэний бүртгэлийн байгууллага хариуцан гаргахаар болсон нь зарчмын чухал ач холбогдолтой шийдэл болсон		Сонгуулийн явцад төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, сахилга өндөр байсан нь сонгууль элдэв будлиангүй болох нэг гол нөхцөл болж өгсөн.
	20.11. Хэсгийн хороо энэ хуулийн 20.9-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ хуулийн 20.10-т заасан сонгуулийн насны иргэдийн мэдээлэлтэй тулган хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө өөрийн байранд ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.			

Хавсралт 3

31 дүгээр зүйл. Нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах	31.1.Нэр дэвшигч энэ хуулийн 29.12, 29.13-т заасны дагуу бүртгүүлж, 29.17-д заасны дагуу нийтэд зарлагдсаны дараа түүнийг нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хасах талаарх энэ хуульд заасан үндэслэл тогтоогдвол Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо энэ тухай шийдвэр гаргаж, нийтэд мэдэвлэнэ.		Мэдээлэх хэлбэр тодорхой бус	Энэ сонгуулийн явцад сонгуулийн тойргийн хорооны эрх мэдлийг өндөржүүлж өгсөн нь асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэхэд ихээхэн тус дөхөм үзүүлсэн.
41 дүгээр зүйл. Санал авах газар, хугацаа	41.2.Хэсгийн хороо сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг уул өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдэвлэнэ.	Мэдээлэх хугацаа тодорхой		Телевизийн болон бусад мэдээллийн хэрэгслэлээр зарлан мэдээлж байсан.
	41.9.Энэ хуулийн 41.7-д заасан санал авах байрыг нийтийн эмх замбараагүй байдал, үер ус, гал түймэр зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас өөрчилж болох бөгөөд энэ тухай нэн даруй сонгогчид мэдэвлэнэ			
49 дүгээр зүйл. Сонгуулийн нэгдсэн дүн гаргах, суудал хуваарилах, мэдээлэх	49.3.Сонгуулийн ерөнхий хороо нам, эвслийн авсан суудлын тоо, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдогчдын нэрийн жагсаалтыг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор гаргаж, Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган нийтэд мэдэвлэнэ.	Мэдээлэх хугацаа тодорхой		УИХ гишүүнээр сонгогчдын нэрсийг хуулийн дагуу хугацаанд нь нийтэд мэдээлсэн.
Зөвлөлдөх орчин				
16 дугаар зүйл. Тойргийн хороо, түүний бүрэн эрх	16.2.8.харьяалах салбар болон хэсгийн хорооны шийдвэрийн талаарх өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж бичгээр хариу өгөх;		Хэд хоногт багтаах шийдвэрлэх нь тодорхой бус	“Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторинг тайлан” <i>Филантропи Хөгжлийн төлөө Төв ТББ</i> Судалгааны явцын дунд сонгогчын нэрсийн жагсаалтанд бүртгэгдээгүй болон давхар бүртгэгдсэн бүртгэлийг шалгаж өгөхийг хүсч Нийслэлийн Бүртгэлийн Газрын Хяналтын хэлтэс, СЕХ-нд давхар албан тоот явуулсан. Энэ албан тоотын хариуг сонгуулийн дараа хүлээж авахад эдгээр сонгогчид шилжилт хөдөлгөөнөө цаг тухайд нь хийлгээгүй байна. Мөн сонгогчдын жагсаалтад давхар бүртгэгдээгүй байна гэсэн хариу ирүүлсэн. Санал, гомдлын хариуг хэд хоногт багтаан шийдвэрлэх нь тодорхой бус учраас сонгууль дууссаны дараа албан тоотын хариуг өгч байна.
17 дугаар зүйл. Салбар хороо, түүний бүрэн эрх	17.2.3.Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гарсан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж бичгээр хариу өгөх;			
18 дугаар зүйл. Хэсгийн хороо, түүний бүрэн эрх	18.3.8.сонгууль зохион байгуулах болон санал авах, санал тоолохтой холбогдсон асуудлаар гарсан өргөдөл, гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлах;		Эрх бүхий байгууллагад уламжлах хугацаа тодорхой бус	
21 дүгээр зүйл. Сонгогчийн бүртгэлийн талаарх гомдлыг шийдвэрлүүлэх журам	21.1.Сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн байвал энэ тухай сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс арваас доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.	Өргөдөл гомдлыг бичгээр гаргах хугацааг тодорхой зааж өгсөн		
35 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаа	35.27.Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдалд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавьж, энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэнэ.		Өргөдөл гомдлыг Хэд хоногт шийдвэрлэх нь тодорхой бус	

Хавсралт 3

Иргэдийн хяналт				
9 дүгээр зүйл Сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд батлах зарчим	9.5.Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага нь Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон журмын дагуу сонгуулийн хороод, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, түүнд эрхээ хэрэгжүүлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад туслалцаа үзүүлэх эрхтэй.	Сонгуульд анх удаа дотоодын төрийн бус байгууллагууд хөндлөнгийн, бие даасан ажиглалт хийх нь сонгуулийн үйл явцын ил тод байдлыг жинхэнэ утгаар нь бодитой хангах боломжтой.		Сонгуулийн явцад нам эвслийн ажиглагч нар хуулийн дагуу ажиглалт хийсэн. Мөн сонгуулийн явцад Сонгогчдын Боловсрол төв, Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт Сүлжээний 200 ажиглагч мөн бусад төрийн бус байгууллагууд хяналт мониторинг хийж ажилласан.
43 дугаар зүйл. Санал авах ажиллагаа	43.6.Санал авах ажиллагаанд нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн томилсон сонгуулийн ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.	Санал авах ажиллагааны хяналт сайжирсан.		Хэсгийн хороо бүрд нам эвслийн ажиглагч байлцаж, хэвлэл мэдээллийн байгууллага сурвалжлага хийж байсан.
44 дүгээр зүйл. Сонгуулийн ажиглагч	44.1.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч өөрийн сонгуулийн ажиглагч /цаашид “ажиглагч” гэх/-ийг томилж ажиллуулна. 44.4.Ажиглагч нь сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, санал авах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн тухай хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглан хянах бөгөөд дараах эрх эдэлнэ: 44.4.1.сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах; 44.4.2.саналын хуудасны битүүмжлэгдсэн байдалтай танилцах; 44.4.3.санал тоолох ажлыг ажиглах; 44.4.4.бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчдын гарын үсэг цуглуулсан маягттай танилцах; 44.4.5.зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах сонгогчдын нэрийн жагсаалт, тэднээс санал авах чиглэл, хуваарьтай танилцах; 44.4.6.санал бэлтгэх бүхээг, зөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмж болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах; 44.4.7.санал авах байранд сонгуулийн санал авах үйл явцыг бүхэлд нь ажиглаж болохуйц суудалтай байх; 44.4.8.санал авах үйл явцад зөрчил гарвал хэсгийн хорооны даргад мэдэгдэж, залруулахыг хүсэх, илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан баталгаажуулах, гэрчээр гарын үсэг зуруулах; 44.4.9.хэсгийн хорооны гишүүдээс холбогдох мэдээлэл авах; 44.4.10.ажиглалтын тайлангаа нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх.	Ажиглагч байлцуулах нь сонгууль будлиангүй явагдах нөхцлийг бүрдүүлж байна.	Ажиглагч нь сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, санал авах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн тухай хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглан хянах нөхцөлтэй байна.	Ажиглагчид сонгогч хурууны хээ таниулахаас эхлээд саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид уншуулах хүртэл үйл явцыг бүхэлд нь ажиглах боломжгүй байх хүндрэл нийтлэг байв. Учир нь хэсгийн хороод ажиглагчдад зориулсан суудлыг ихэнх тохиолдолд хэт хол зассан, мөн намын ажиглагчдад суудал засч өгсөн ч дотоодын байгууллагын ажиглагчдад зориулсан ширээ, сандал хангалтгүйн улмаас манай ажиглагчид өвөр дээрээ шалгах хуудсаа бөглөх, зогсоогоороо ажиглалт хийх тохиолдлууд гарсан. Мөн ажиглагчдад мэдээлэх шаардлагатай зарим мэдээллийг дутуу хэлэх, орхих, санал тоолох төхөөрөмжийн гэрчилгээ, серийн дугаарыг тэмдэглэж, мэдээлэл авах боломжоор хангаагүй, намын ажиглагч нарт илүү нааштай хандах зэргээр ялгаварлах байдал нэлээд түгээмэл ажиглагдлаа. Гадаадын ажиглагч нар сонгуулийн үйл ажиллагаатай танилцаж байсан
46 дугаар зүйл. Санал тоолох	46.1.Хэсэгт санал тоолох ажиллагааг 20.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.	Сонгууль будлиангүй явагдах нөхцлийг бүрдүүлсэн.		Санал тоолох ажиллагаа нь ажиглалт хийсэн хэсгийн хороодын 60%-д санал авах ажиллагаа дуусгавар болсноор 20 цагт эхэлсэн бол 40%-д нь сүүлийн сонгогчдыг гаргах, тооллогод бэлтгэх мөн амарч цайлах шалтгаанаар сүүлийн хэсгийн хорооны тооллого 21 цагт эхэлсэн байна.

Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал

Аймаг нийслэл	Хурлын шийдвэрийг иргэдэд мэдээлэх эсэх
<i>Архангай</i>	9.4. Хуралдааны тухай мэдээлэл, тогтоол, шаардлагатай бусад материалыг ажлын 3 өдрийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, веб хуудас, номын санд байрлуулж нийт иргэдэд сурталчилна.
<i>Баянхонгор</i>	23.2. Хэвлэл мэдээллийн ажилтанг хаалттай хуралдаанаас бусад хуралдаанд чөлөөтэй оролцуулна. 31.1. Хурлын хуралдааны тухай дэлгэрэнгүй мэдээ, хуралд оруулсан илтгэл, хурлын тогтоол, шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлнэ. 31.3. Хуралдаанаар хэлэлцсэн илтгэл, хурлын тогтоол шийдвэр, хуралдааны тэмдэглэлийг нийтийн номын сан мэдээлэл, сурталчилгааны танхимд тавьж иргэдэд байнга нээлттэй байлгана.
<i>Булган</i>	3.1. . . . Хурлын тухай мэдээ, хуралдаанд оруулсан илтгэл, тогтоолыг хурлын Тэргүүлэгчид, ажлын алба 7 хоногийн дотор хэвлэлд нийтэлж, мэдээллийн бусад хэрэгслээр хүн амд хүргэж сурталчилна. 3.2. Хурлын тэргүүлэгчид хуралдаан дууссанаас хойш 10 хоногийн дотор хуралдааныг бэлтгэж, хийлгэсэн ажлын дүнг хэлэлцэх, хурлын тогтоолын биелэлтийг зохион байгуулах, төлөөлөгчдийн санал шүүмжлэлийн мөрөөр зохиох арга хэмжээний төлөвлөгөө баталж, тогтоолыг иргэдэд хүргэж таниулах түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. 2.7.з. Хуралдааны шийдвэрийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ. 3.5. Хуралдааны тэмдэглэлтэй Тургүүлэгчид шууд танилцаж болно. Бусад хүмүүс хурлын дарга, нарийн бичгийн даргын зөвшөөрөлтэй танилцана. 4.2. Нийтэд хүргэх шаардлагатай шийдвэрийг 3 хоногийн дотор хэвлэл мэдээллээр сурталчилах, тодорхой байгууллага, иргэдтэй холбоотой асуудлаар гарсан шийдвэрийг мөн хугацаанд хүргүүлэхийг ажлын алба хариуцаж гүйцэтгэнэ.
<i>Дархан-Уул</i>	7.1.й. . . . Хуралдааны тэмдэглэлийг эмхэтгэж хавтаслан аймгийн номын санд тавьж иргэд, хөдөлмөрчид, үзэж танилцах боломж олгоно.
<i>Дорноговь</i>	27. Хурлын шийдвэрийг сурталчилах, хэрэгжүүлэх ажлыг хурлын тэргүүлэгчид, төлөөлөгчид, Засаг дарга нар хариуцна.
<i>Дорнод</i>	4.22. . . . хуралдааны тухай сонсгол мэдээ, илтгэл, тогтоол, шаардлагатай бусад материалыг 3 хоногийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, веб хуудас, номын санд байрлуулж, иргэдэд нээлттэй байх, мэдээллийн бусад хэрэгслээр нийт иргэдэд сурталчилна.
<i>Завхан</i>	4.1. Хурлын шийдвэрийг мэдээлж, сурталчилах хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг тэргүүлэгчид, Хурлын төлөөлөгчид, Засаг дарга түүний тамгын газар хариуцна. Хуралдааны тухай мэдээ, илтгэл, тогтоол шаардлагатай бусад хэрэгслээр иргэд сонгогчид сурталчилна.
<i>Сэлэнгэ</i>	2.3. Хуралдаан зарласан шийдвэрийн тухай Хурлын төлөөлөгчдөд нэн даруй зарлан мэдэгдэж, нийтэд мэдээлнэ.
<i>Увс</i>	4.1. Хуралдааны шийдвэрт эцэсийн найруулга хийж Хурлын дарга гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж ёсчилсоны дараа ажлын 5 өдөрт багтааж холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ. Хуралдааны тогтоол бусад шийдвэрт хүчин төгөлдөр болох хугацааг тусгайлан заагаагүй бол гарсан цагаасаа хүчин төгөлдөр болно. Хориг тавихтай холбоотой асуудлаархи шийдвэр нь Засаг дарга хүлээн авсанаас хойш ажлын 3 өдөр өнгөрснөөр хүчин төгөлдөр болно. Хуралдааны шийдвэрийг Хурлын даргын зөвшөөрснөөр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бусад хэлбэрээр нийтэд сурталчилж болно. 4.2. Хуралдааны материалыг хуралдаан болсоноос хойш ажлын 5 өдөрт багтаан эмхэтгэж 1-р хувийг хурлын ажлын албанд хадгалж 2-р хувийг ЗДТГ-т хүлээлгэн өгч, 3-р хувийг МУ-ын ЗГХЭГ-т хүргүүлнэ. Аймгийн гомын санд дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлж нийтийн хэрэгцээнд ашиглуулж болно.
<i>Ховд</i>	6.5. Хуралдааны явцын тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлнэ. 6.6. Албан ёсны мэдээллийг олон нийтэд хүргэх үүргийг ИТХ-ын ажлын алба, аймгийн ЗДТГ хариуцна.

Хавсралт 4

<i>Улаанбаатар</i>	<p>17.3. Хуралдааны тухай мэдээ, хуралдаанд оруулсан илтгэл, тогтоолыг хурлын ажлын албанаас тав хоногийн дотор хэвлэлд нийтлэн, веб сайтад байршуулж сурталчилна. Хурлын шийдвэрийг хэвлэлд нийтлэх, холбогдох байгууллагад хүргэх асуудлыг Хурлын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр хийнэ.</p> <p>9.3. Хурлын шийдвэрийг ёсчлон баталсан даруйд Нийслэлийн Засаг даргад ажлын гурав хоногийн дотор нэг хувийг хүргүүлэх бөгөөд хэвлэн нийтэлж олон нийтэд мэдээлнэ.</p> <p>16.2. Хуралдааны тэмдэглэл нийтэд нээлттэй байх бөгөөд хувилж авахыг хүссэн иргэн нь хуулбарлах зардлыг өөрөө хариуцана.</p> <p>15.3. Хурлын хуралдааны явцыг Улаанбаатар телевиз болон бусад телевизээр дамжуулах, Тэргүүлэгчдийн хурал болон хороо, дэд хороодын хуралдааныг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлыг зохион байгуулна.</p>
--------------------	---

Хурлын хэлэлцэх асуудалтай иргэд танилцах боломжтой эсэх	
<i>Дархан-Уул</i>	1.6. . . . Хурлын хэлэлцүүлэх баримт бичгийн төслийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж, ярилцлага, хэлэлцүүлэг явуулах зэргээр иргэдийн болон нийгмийн бүлгүүдийн санал дүгнэлтийг авч болно.
<i>Улаанбаатар</i>	<p>11.9. Энэ зүйлийн 11,6 дахь хэсэгт заасан хурлын төлөөлөгчдөд тараасан хэлэлцэх асуудлын баримт бичгүүдтэй танилцах боломжийг иргэдэд олгох зорилгоор сандал, ширээ бүхий тусгай өрөө, танхимыг ажлын цагаар гаргаж өгөх ба иргэд хүсвэл хуулбарлаж өгнө. Мөн олон нийтэд нээлттэй цахим хуудсанд байршуулна.</p> <p>12.10. Хурлын тов хэлэлцэх асуудлыг хурлын веб сайтад байрлуулж, урьдчилан танилцах боломжийг бүрдүүлнэ.</p>
Хурлын тов болон хэлэлцэх асуудлыг иргэдэд урьдчилан мэдээлэх эсэх	
<i>Ховд</i>	4.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар хуралдааныг хурлын тэргүүлэгчид хуралдаан эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө зарлаж, бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулж, хурлын тов, хэлэлцэх асуудлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлаж төлөөлөгч нэг дүрд албан ёсоор мэдэгдэнэ.
<i>Улаанбаатар</i>	12.10. Хурлын тов, хэлэлцэх асуудлыг хурлын вебсайтад байрлуулж, урьдчилан танилцах боломжийг бүрдүүлнэ.

Зөвлөлдөх орчинг хангасан байдал

Иргэд болон бусад хамаарагч бүлгүүдийг оролцуулан хэлэлцүүлэг зохиох эсэх	
<i>Булган</i>	8.4. Иргэний нийгмийн байгууллагуудтай байнга харилцаж, дэмжлэг үзүүлж, тэдний гаргаж буй ажил хэрэгч санал санаачлагыг хүлээн авч дэмжиж, хамтран ажиллах.
<i>Увс</i>	2.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудал, оруулах төслийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж, иргэдийн болон нийгмийн бүлгүүдийн санал, дүгнэлтийг авах, шаардлагатай бол ярилцлага хэлэлцүүлэг явуулан гарсан санал дүгнэлтийг тусгасан байна.
<i>Улаанбаатар</i>	18.1. Хурлын төлөөлөгчид Нийслэлийн Засаг даргын хамтаар жил бүрийн 3 зугаар сарын эхний арав хоногт багтаан Улаанбаатар хотын эдийн засаг, нийгмийн байдлын талаар олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулна. 18.4. Жил бүрийн 5 ба 9 дүгээр саруудад асуулт, хариултын уулзалтыг Хурал ба Нийслэлийн Засаг дарга хамтран зохион байгуулах ба олон нийт чөлөөтэй оролцох, асуулт асуух боломжийг олгоно.
Иргэд хурлын хуралдаанд асуудал хэлэлцүүлэхээр оруулах боломжтой эсэх	
<i>Баянхонгор</i>	19.2. Багийн ИНХ, сумын ИТХ, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.
<i>Булган</i>	1.8. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, сум багийн хурал Аймгийн ИТХ-д асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.
<i>Дархан-Уул</i>	1.4. Хуульд зааснаар Хурлын тэргүүлэгчид, хороо, түүнчлэн Төлөөлөгч, тухайн нэгжийн Засаг дарга хуралдаанд хэлэлцүүлэхээр асуудал санаачлан оруулах эрхтэй. Сум багийн Хурал, аймгийн нутаг дэвсгэрт байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн аймгийн ИТХ-д асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.
<i>Дорноговь</i>	7. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.

Хавсралт 4

<i>Дорнод</i>	1.2. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид хуралд асуудал хэлэлцүүлэхээр оруулж болох бөгөөд бусад иргэд байгууллага Хурлын төлөөлөгчөөр дамжуулан асуудал оруулж хэлэлцүүлнэ.
<i>Завхан</i>	2.2. Аймгийн ИТХ-ын Хуралдаанд аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгчид, аймгийн ЗД асуудал оруулна. Мөн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, сумын ИТХ асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид тухайн асуудлын агуулга, гаргах шийдвэрийн төсөлтэй нь танилцаж, хуралдаанд оруулж хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.
<i>Сэлэнгэ</i>	4.3. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, сумын ИТХ, аймгийн ИТХ-д асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.
<i>Ховд</i>	3.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хуралдаанд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно. 3.3. Иргэдийн хувьд асуудал оруулах субъектээрээ дэмжуулан өөрийн санаачилсан ямар ч асуудлыг хэлэлцүүлэх эрх нь нээлттэй. 4.5. Төсөл, түүнд өгсөн Хорооны санал дүгнэлтийг Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.
<i>Улаанбаатар</i>	6.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно. 13.1. Нээлттэй хуралдаанд хэлэлцэж хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид, иргэдийн төлөөлөл ажиглагчаар оролцоно.

Аймаг нийслэл	Хуралд урилгаар болон саналаараа оролцож буй иргэд хэлэлцэж буй асуудлаар санал хэлэх эрхтэй эсэх
<i>Баянхонгор</i>	27.8. Хуралдаанд урилгаар оролцогсад зохион байгуулалтын асуудлаас бусад хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хуралдааны даргаас зөвшөөрөл авч санал бодлоо илэрхийлж болно. 27.9. Хуралдаанд урилгаар оролцогсад үг хэлэх зөвшөөрөл болон хэлэх санал бодлоо бичгээр илэрхийлж болно.
<i>Өвөрхангай</i>	5.4. Хурлын даргын хэлэлцүүлж буй асуудал тус бүрээр Төлөөлөгчид болон урилгаар оролцогчдоос асуулт гаргуулж, хариулт авхуулах ба дуусахад таслуулж санал дүгнэлт гаргуулна. Үүнд цаг тогтоохгүй. Төлөөлөгчид асуултаа амаар болон бичгээр гаргана. Асуулт хариулт явагдахад цаг тогтоохгүй ба санал дүгнэлт Төлөөлөгч тус бүрт тухайн асуудлаар 5 хүртэл, дахин удаа 3 хүртэл мин байна. 5.9. Урилгаар оролцогчид үг хэлэхдээ Хурлын даргаас гар өргөн зөвшөөрөл авна. Үүнд 5.4. дэх заалтыг нэг адил мөрдөнө.
<i>Ховд</i>	5.9. Хуралдаанд тавих илтгэл, хавсралт илтгэлийн хугацааг ИТХ-ын Тэргүүлэгчид тогтоож оруулна. Төлөөлөгчид асуулт асууж хариулт авсаны дараа урилгаар оролцогсад асуулт тавьж хариулт авна. Хуралдаанд төлөөлөгчид үг хэлсний дараа урилгаар оролцогсад үг хэлнэ. Үг хэлэх хугацааг тухайн хуралдааны дотоод журамд тусгана. Тогтоосон хугацааг хатуу баримтална. 5.3. Урилгаар оролцогсад үг хэлж, санал гаргах эрхтэй оролцож асуудлыг амаар буюу бичгээр тавьж хариуг сонсож, хэлэлцэж буй асуудал бүрт 5 минутад багтаан нэг удаа үг хэлж, санал, шүүмжлэл гаргаж болно.

Идэвхтэй оролцоог хангасан байдал

Аймаг нийслэл	Хэлэлцэх асуудлаар иргэдээс урьдчилан санал авах эсэх
<i>Булган</i>	1.10 Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулж иргэдийн санал судлах, хэлэлцүүлэг зохион байгуулах, хяналт шалгалт хийх, шийдвэрийн төслийг урьдчилан боловсруулахад хурлын хороод өөрийн чиг үүргийн дагуу оролцох ба шаардлагатай бол төлөөлөгчид, мэргэжилийн хүмүүс иргэдийн төлөөллөөс бүрдсэн ажлын түр хэсэг байгуулж ажиллаж болно. 5.4. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дэргэд социологийн судалгааны орон тооны бус ажлын хэсэг ажиллуулж, иргэдийн санал бодлыг судалж, дүгнэлт хийх бодлого шийдвэрт тусгах ажлыг жил улирлын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх. 5.5. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид улирал тутам тойргийнхоо сонгогчидтой уулзалт хийж, аймгийн ажил, амьдралын асуудлаар мэдээлэл өгч, иргэдийн санал авч ажиллах. 5.10. Иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй харилцах, хууль шийдвэр хүргэх, сурталчилах, санал авах үүрэг бүхий мэдээллийн төвийг байгуулж ажиллах
<i>Дархан-Уул</i>	1.6. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг боловсруулан бэлтгэхэд байнгын хороод, Төлөөлөгчид, мэргэжлийн байгууллага, иргэдийг оролцуулж болно.
<i>Дорнод</i>	1.2. Хурлын хуралдаанд хэлэлцэх асуудлыг сайтар бэлтгэх, судалгаа дүгнэлт гаргах, шийдвэрийн төслийг хянан боловсруулах, иргэдээр урьдчилан хэлэлцүүлж тэдний саналыг тусгах зорилгоор хуралдааны бэлтгэл ажлын хэсгийг ИТХ-ын Тэргүүлэгчдээс байгуулан ажиллуулж болно.

Хавсралт 4

<i>Завхан</i>	2.4. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг сайтар боловсруулж, судалгаа дүгнэлт гаргах, шийдвэрийн төслийг хянах, иргэдийн санаа бодлыг тусгах зорилгоор ажлын хэсгийг ИТХ-ын тэргүүлэгчид байгуулан ажиллуулж болно.
<i>Сэлэнгэ</i>	4.5.е. Шаардлагатай гэж үзвэл хэлэлцэх асуудалтай холбогдуулан иргэдээс санал авна.
<i>Увс</i>	2.4. Дунд, урт хугацааны болон төрөлжсөн хөтөлбөр, чиглэл, төлөвлөгөө зэрэг эдийн засаг, нийгэм соёлын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэгч байгууллага, албан тушаалтан нь уг асуудалд холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийн санал дүгнэлтийг тусган боловсруулж хурлын тогтоол, бусад шийдвэрийн төслийг хууль эрх зүйн хүрээнд бэлтгэж асуудал оруулах эрх бүхий этгээдээр дамжуулан Тэргүүлэгчдэд өргөн мэдүүлнэ.
<i>Ховд</i>	4.7. МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдалгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3. дахь заалтыг үндэслэн холбогдох тооцоо судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж хуралдаан болохоос 1 хоногийн өмнө хурлын төлөөлөгчдөд тараах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй. -Хуралдааны хэлэлцэх асуудлын төслийг иргэдээр хэлэлцүүлж, гарах шийдвэрт иргэдийн саналыг тусгах эсэхийг шийдвэрлүүлэхээр хуралдаанд мэдээлж болно. 5.6. Төлөөлөгчдөд хуралдаанд хэлэлцэх илтгэл, төлөвлөгөө, хөтөлбөр тогтоолын төслийг урьдчилан танилцуулсан бол дахин илтгэж, танилцуулалгүйгээр Хороо, намын бүлгийн санал, иргэдээр хэлэлцүүлсэн дүгнэлтийг нэгтгэн сонсгож, гарах шийдвэрт оруулсан засвар өөрчлөлтийг хэлэлцүүлж болно.

Аймаг нийслэл	Хурлын хуралдаанд иргэд ажиглагчаар оролцох боломжтой эсэх
<i>Архангай</i>	1.2. Хурлын хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан тухайн салбар, байгууллагын удирдлага, ажилтан мэргэжилтэн, холбогдох албан тушаалтнууд, иргэд оролцож болно.
<i>Баянхонгор</i>	4.1. Хуралдааныг нээлттэй хийнэ 4.5. Хуралдаанд иргэд, албан тушаалтан, судлаачдыг саналаар нь оролцуулж болно
<i>Булган</i>	1.14. Тухайн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын гишүүд, төр, нам, аж ахуй, хоршоолол, олон нийтийн байгууллагын ажилтан, хэвлэл мэдээллийн албаны хүмүүс, иргэдийг оролцуулах асуудлыг Хурлын тэргүүлэгчдээс зохион байгуулж болно.
<i>Дархан-Уул</i>	1.10. Тухайн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын гишүүд, төр, нутгийн захиргаа, нам, төрийн бус байгууллагуудын удирдлага, хэвлэл мэдээллийн ажилтан, иргэдийг урилгаар оролцуулах асуудлыг Тэргүүлэгчид шийдвэрлэнэ. Шаардлагатай гэж үзвэл хурлын хуралдааныг телевизээр шууд дамжуулж болно.
<i>Дорноговь</i>	8. Хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан УИХ-ын гишүүд, төр, нутгийн захиргаа, нам, төрийн бус байгууллагуудын удирдлага, хэвлэл мэдээллийн ажилтан, иргэдийг урилгаар оролцуулах асуудлыг тэргүүлэгчид шийдвэрлэнэ. Урилгаар оролцогсод хуралдааны дэгийг биелүүлнэ.
<i>Дорнод</i>	1.5. Хурлын хуралдаанд төр, нам, олон нийт, аж ахуйн байгууллага, хэвлэл мэдээллийн ажилтнуудаас оролцуулж болно. Хуралдаанд оролцох зөвшөөрлийг Хуралдааныг даргалагч олгох ба оролцох журмыг дотоод журмаар тогтоож болно.
<i>Завхан</i>	2.7. Хуралдаанд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн ажилтнууд, ИТХ-д суудалтай улс төрийн намуудын удирдлага урилгаар оролцож болно.
<i>Өвөрхангай</i>	2.3. Хуралдааныг нээлттэй хийх ба аймгийн Засаг дарга, түүний тамгын газар, холбогдох хэлтэс, албаны дарга нар, төр, улс төрийн намууд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллүүд урилгаар оролцож болох ба төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд чөлөөтэй оролцоно. Хуралдааны хэлэлцэх асуудалтай холбоотойгоор иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулж болно. Энэ тохиолдолд хурлын ажлын албанд урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсан байна. Ийм тохиолдолд хуралдаанд оролцогсод дэгийг хатуу баримтална. Шаардлагатай тохиолдолд хуралдааныг хаалттай хийж болно.
<i>Сэлэнгэ</i>	5.4. Хуралдаанд иргэдийг урилгаар болон ажиглагчаар оролцуулж болно. 5.5. Хуралдаанд урилгаар болон ажиглагчаар оролцох хүний тоог хуралдааны байр танхимын багтаамж, суудлын тоо зэргээс хамааран тухайн хуралдааны өмнө хурлын тэргүүлэгчид тогтооно.
<i>Увс</i>	2.13. Хуралдааныг аль болох нээлттэй хийж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудыг урилгаар оролцуулах, хуралдааны явцыг телевизээр дамжуулах, улс төрийн болон ТББ-ууд, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд ажиглах, сурвалжлах нөхцөл бүрдүүлэн гарсан шийдвэр, баримт бичгийн ил тод нээлттэй байдлыг хангаж өгнө.

Хавсралт 4

<i>Ховд</i>	5.1. Хуралдаанд УИХ, ЗГ-ын төлөөлөгчид, Аймгийн ЗД, төр захиргааны байгууллага, сум, албан газар, аж ахуйн нэгжийн удирдлага, нам, эвсэл, олон нийтийн байгууллагын сонгуультан, хэвлэл мэдээллийн ажилтан, иргэдийн төлөөллийг урилгаар оролцуулж болно
<i>Улаанбаатар</i>	13.1. Нээлттэй хуралдаанд хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид, иргэдийн төлөөлөл ажиглагчаар оролцож болно.
Төсөв хэлэлцэх явцад иргэдийн саналыг тусгах эсэх	
<i>Улаанбаатар</i>	19.3. Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө ба жилийн төсвийн төслийг боловсруулахдаа есдүгээр сарын нэгний өдрөөс аравдугаар сарын 15-ны өдөр хүртлэх хугацаанд иргэдийн саналыг нээлттэй авсан байх ёстой бөгөөд Хурлын төлөөлөгчөөс бичгээр өгсөн саналыг хэрхэн тусгасан талаар хариу заавал мэдэгдэнэ.

Иргэдийн хяналт тавих боломжийг хангасан байдал

<i>Аймаг нийслэл</i>	Төсөв болон ИТХ-ын шийдвэрийн гүйцэтгэлийг иргэдэд мэдээлэх эсэх
<i>Булган</i>	6.6. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс шаардлагатай үед ИТХ-ын төлөөлөгчид, иргэдийн хамтарсан үзлэг зохион байгуулах.
<i>Увс</i>	5.8. Шалгалтын дүнг шалгагч байгууллага, хороодын хурлаар хэлэлцэн дүгнээд хурлын болон тэргүүлэгчдийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж, шалгуулагчдад болон шаардлагатай бол иргэдэд мэдээлнэ.
Иргэдийн зүгээс оруулсан санал шийдвэрт хэрхэн туссаныг эргэн мэдээлэх эсэх	
<i>Улаанбаатар</i>	19.3. Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө ба жилийн төсвийн төслийг боловсруулахдаа есдүгээр сарын нэгний өдрөөс аравдугаар сарын 15-ны өдөр хүртлэх хугацаанд иргэдийн саналыг нээлттэй авсан байх ёстой бөгөөд Хурлын төлөөлөгчөөс бичгээр өгсөн саналыг хэрхэн тусгасан талаар хариу заавал мэдэгдэнэ.

Хавсралт 5

1. Төсвийн тухай хуулинд хийсэн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
5 дугаар зүйл. Төсвийн зарчим	5.1.4. Ил тод байдлыг хангасан байх; 5.1.5. Хариуцлагатай байх.	Иргэдийг төсвийн мэдээллээр хангах, оролцоог нэмэг-дүүлэх боломж бүрдсэн	Одоогоор төсвийн талаарх мэдээллийг хэрхэн ил тод болгох нь нарийвчлан зохицуулагдаагүй	ЗГТ, 2012, №17 2.1. Мэдээлэл нь иргэд, олон нийтэд нээлттэй байх бүхий л боломжит арга хэрэгслээр хангагдсан байх. 2.2. Мэдээллийг тогтмол хугацаанд, тогтоосон стандартын дагуу үнэн зөв, ил тод байдпаар олон нийтэд хүргэх. 2.3. Мэдээлэл нь тухайн жилийн батлагдсан төсөв болон Төсвийн тухай хуульд нийцсэн байх.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль 2011 онд батлагдсанаар төрийн байгууллагууд үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөц, худалдан авах үйл ажиллагаа зэрэгээ нээлттэй байлгах үүрэг хүлээсэн.
6 дүгээр зүйл. Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх	6.5.1. төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх; 6.5.6. төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх.	Ямар мэдээллийг, ямар арга хэрэгслээр, нийтэд мэдээлэхийг Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудад үүрэг болгосон.	Хэзээ мэдээлэх нь тодорхойгүй бөгөөд зөвхөн цахим хуудсаар мэдээлэх тохиолдолд орон нутгийн иргэдэд хүртээмжгүй байх талтай.		
8 дугаар зүйл. Төслийн цаглабар	8.1.4. Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор хэвлэн нийтлэх. 8.8.5. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 15-ны дотор нийтэд хэвлэн мэдээлэх. 8.9.4. Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх;	Ямар мэдээллийг нийтэд мэдээлэхийг төрийн холбогдох байгууллагуудад үүрэг болгосон.	Нийтэд мэдээлэх хугацаа, арга хэрэгсэл нь тодорхой бус. Төсвийн харилцааг зохицуулж буй хуулиудын зарим заалт хоорондоо зөрчилдөж байгаа.	Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах журмыг Засгийн газрын тогтоолоор батлан мөрдөж эхлээд байгаа.	Төсвийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлтийг холбогдох байгууллагуудад хүргэж байгаа ч олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаа бүрэн хэрэгжихгүй байна.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Хавсралт 5

<p>10 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх</p>	<p>10.2 Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын төлөвлөлтийг сайжруулах, ..., ил тод байдлыг хангах, ... зорилготой татвар төлөгчдийн төлөөлөл бүхий төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод болон салбарын эрдэмтдээс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус төсөв, санхүү, эдийн засгийн үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд байгуулж ажиллуулна.</p>	<p>Төсвийн үйл явцад олон талын оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлсэн</p>	<p>Үндэсний зөвлөлийг хэрхэн ажиллуулах, байнгын ажиллагааг хангах талаар тодорхой зохицуулалт одоогоор байхгүй</p>		<p>www.iltod.gov.mn дээрх дараах мэдээлэл тавигджээ. Үүнд: 1. 2013 оны төсвийн төслийн танилцуулга; 2. 2013 оны нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд гэсэн хоёр файл байсан. Бусад нь байгаагүй; УИХ-ын чуулганы байнгын хороодын банэгдсэн хуралдааны үеэр буюу хэлэлцээд эхэлсэн хойно, эсвэл хэлэлцэж дууссаны дараа хэвлэл мэдээллээр 2013 оны Монгол улсын төсвийн дэлгэрэнгүй мэдээлэл, задаргаа, хөрөнгө оруулалтын жагсаалт нээлттэй болж байв. Хэлэлцүүлгийн явц хэвлэл мэдээллээр нээлттэй байсан¹.</p>
<p>16 дугаар зүйл. Төсвийн шууд захи-рагч, түүний бүрэн эрх</p>	<p>16.5.7.байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;</p>	<p>Төсвийн мэдээ, тайлан, холбогдох мэдээллийг тайлагнах эрх зүйн үндсийг бий болгосон</p>	<p>Хэнд, хэрхэн тайлагнах талаар тодорхой заалт байхгүй</p>	<p>Сангийн сайд мэдээ, тайланг гаргах талаар холбогдох журмуудыг гарган мөрдүүлж байгаа.</p>	
<p>20 дугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо</p>	<p>20.1.Бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, НББ, тайлагналын нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн</p>	<p>Хэзээ мэдээлэх нь тодорхойгүй бөгөөд зөвхөн цахим хуудсаар мэдээлэх тохиолдолд орон нутгийн иргэдэд хүртээмжгүй байна.</p>		
<p>41-р зүйл. Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах</p>	<p>41.7.Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, өөрийн орлого, зарлагын хэмнэлт, тэдгээрийн зарцуулалт, гүйцэтгэлийн ил тод байдлыг хангах, олон нийт, байгууллагын хамт олонд нээлттэй байх шаардлага, нөхцөлийг тогтоосон журмыг Засгийн газар батална.</p>	<p>Төсвийн мэдээ, тайлан, мэдээллийг олон нийтэд ил тод болгох эрх зүйн үндсийг бүрдүүлсэн</p>	<p>Хэнд, хэрхэн ил тод болгох талаар тодорхой заалт байхгүй</p>	<p>Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах журмыг Засгийн газрийн тогтоолоор батлан мөрдөж эхлээд байгаа.</p>	<p>Иргэд төсвөө хянана сүлжээнээс хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Ховд аймаг, тус аймгийн Дөргөн сум, Нийслэл, нийслэлийн БЗД-ийн цахим хуудсуудыг туршилтаар ажиллуулж байна.</p>
<p>52-р зүйл. Болзошгүй өр төлбөр</p>	<p>52.1.Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн талаарх мэдээллийг Улсын Их Хурал болон нийтэд мэдээлнэ.</p>	<p>Энэ заалт нь иргэдэд чухал ач холбогдолтой.</p>	<p>Улсын өрийн талаарх мэдээлэл олон нийтэд ил тод болж чадахгүй байгаа.</p>		<p>Улсын өрийн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод болгох зохицуулалтыг нарийвчлах шаардлагатай.</p>
<p>55 дугаар зүйл. Сонгуулийн өмнөх эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдал</p>	<p>55.3.УИХ энэ хуулийн 55.1-ын мэдээлэлтэй танилцсаны дараа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгуулийн өмнөх макро эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тайланг бэлтгэж, нийтэд мэдээлнэ.</p>	<p>Олон нийтэд мэдээлэхийг үүрэг болгосон нь чухал зохицуулалт болсон.</p>	<p>Цахим хуудсаар л ил тод болгож байгаа нь хөдөөгийн иргэдэд хүртээмжтэй байхад саад болдог.</p>		<p>www.iltod.gov.mn цахим хуудсанд сонгуулийн өмнөх макро эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тайланг Сангийн яам гаргаж, олон нийтэд мэдээлсэн.</p>

Хавсралт 5

64 дүгээр зүйл. ИТХ-ын бүрэн эрх	64.1.2. тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, ..., нийтэд мэдээлэх	Ямар мэдээллийг нийтэд мэдээлэхийг бүх шатны ИТХ-д үүрэг болгосон.	Ямар арга хэрэгслээр нийтэд мэдээлэхийг тодорхой заагаагүй	Орон нутгийн төсвийн төслийг боловсруулах журмыг Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар батлан мөрдүүлж байгаа.	ИТХ-ын тогтоолыг мэдээллийн самбар, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргадаг.
68 дугаар зүйл. Орон нутгийн төсөв батлах	68.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүргээмжтэй байдлаар мэдээлнэ.				
67 дугаар зүйл. Орон нутгийн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх	67.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ				
Зөвлөлдөх орчин					
6 дүгээр зүйл. Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх	6.5.2. Төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах; 6.5.5. хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;	Төсвийн үйл явцад олон нийтийг оролцуулах боломжийг бүрдүүлсэн	Олон нийтийн саналыг хэрхэн тусгаж харгалзан үзэх талаар хуулийн тодорхой зүйл, заалт алга байна.	Орон нутгийн төсвийн төслийг боловсруулах журмыг Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар батлан мөрдүүлж байгаа.	Шууд зөвлөгөөнөөр иргэдийн санал хүсэлтийг шууд мэдэх боломжтой, гэхдээ хүмүүсийн санал тэр бүр шийдвэрт тусгагдахгүй байх явдал их байна.
60 дугаар зүйл. Орон нутгийн хөгжлийн сан	60.3.6. орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг хориглосон.	Гарсан санал, хамтаараа гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхгүй бол хуулийн заалтууд үнэ цэнэгүй болно	Орон нутгийн төсвийн төслийг боловсруулах журмыг Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар батлан мөрдүүлж байгаа.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой шийдвэр гаргахад иргэдийг оролцуулах ажил эхлэл төдий байна.

Хавсралт 5

<p>63 дугаар зүйл. Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах</p>	<p>63.1. Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна. 63.2. Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно. 63.3. Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.</p>	<p>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хэрхэн зарцуулах талаар иргэдийн саналыг авах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн</p>	<p>Иргэд, өрхийн хэдэн хувийг оролцуулах шаардлага тодорхой болоогүй</p>	<p>Орон нутгийн төсвийн төслийг боловсруулах журмыг Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар батлан орон нутгийн хөгжлийн сангийн талаар иргэдээс санал авах, эрэмбэлэх зохицуулалтыг бий болгосон.</p>	<p>Зөвлөлдөх оролцооны хэлбэр Улаанбаатар хотод сайн хэрэгжиж байна. Тухайлбал, хороодд ээригэдийг оролцуулан “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн 2013 оны төсвийг хэлэлцэхэд Хан-Уул дүүргийн 16-р хорооны иргэд хамтаараа өөрсдийнхөө асуудлыг хэнээс ч асуухгүй шийдэж чадсан байна. Хан-Уул дүүргийн нийт 16 хороо 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилттэй “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгийг Хорооны Иргэдийн Нийтийн Хурлаараа хэлэлцэн шийдвэрлэсэн байна.</p>
<p>67 дугаар зүйл. Орон нутгийн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх</p>	<p>67.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.</p>				
Идэвхтэй оролцоо					
<p>6 дүгээр зүйл. Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх</p>	<p>6.5.2. төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;</p>	<p>Иргэд орон нутгийн төсвөө төлөвлөхөд оролцож сурснаар чадваржина.</p>	<p>Төсвийн циклийн дагуу оролцох боломжууд нь зарим талаараа хангалтгүй байгаа.</p>	<p>Энэ талаарх нарийвчилсан зохицуулалт бий болгох шаардлагатай.</p>	<p>Иргэдийн идэвхтэй оролцоог хэрхэн хангах нь өнөөг хүртэл тодорхой болоогүй.</p>
<p>6 дүгээр зүйл. Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх</p>	<p>6.5.6. төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж...</p>	<p>Энэ заалт нь төсөвт иргэд, ТББ-ын оролцоог хангах боломжийг нээсэн</p>	<p>Н а р и й в ч и л с а н зохицуулалт байхгүй</p>		<p>Энэ зохицуулалт эхлэл төдий хэрэгжиж байна.</p>

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Хавсралт 5

Иргэдийн хяналт					
6 дугаар бүлэг. Төсвийн зарчим	6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах; 6.5.4.төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах;	Төсвийн үйл явцад иргэд, олон нийт хяналт тавих эрх зүйн үндсийг бий болгосон	Одоогоор нарийвчилсан зохицуулалтыг бий болгоогүй	ЗГТ-2012/17 4.3. Төсвийн гүйцэтгэлийн тайланг эрх бүхий этгээд дор дурдсан хугацаанд олон нийтэд мэдээлнэ:4.3.1. төсвийн байгууллага сар, улирлын тайланг сар, улирлын гүйцэтгэл гарснаас хойш 7 хоногийн дотор; 4.3.2. төсвийн байгууллага хагас жилийн тайланг 7 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор;4.3.3. төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг 4 дүгээр сарын 25-ны дотор; 4.3.4. сум, дүүргийн төрийн сан хагас жилийн тайланг 7 дугаар сарын 25-ны дотор, жилийн тайланг 3 дугаар сарын 5-ны дотор.4.4. Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ.	Иргэд, ИНБ-ын хяналт, мониторинг хийх замаар төсвийн үйл явцад оролцох талаар 2006 оноос эхлэн донор байгууллагууд, олон улсын төсөл, хөтөлбөрийн шугамаар олон ажлууд хийгдэж байна
10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх	10.2.Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын төлөвлөлтийг сайжруулах, түүний тайлагналт, ... олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зорилготой татвар төлөгчдийн төлөөлөл бүхий төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод болон салбарын эрдэмтдээс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус төсөв, санхүү, эдийн засгийн үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд байгуулж ажиллуулна.	10.3.Энэ хуулийн 10.2-т заасан үндэсний зөвлөл нь төсвийн төсөл болон улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ Засгийн газарт хүргүүлнэ.Хийх ажлыг нь тодорхой зааж өгсөн			Монгол улсад төсвийн ил тод, нээлттэй байдлыг үнэлэх зорилгоор хийж буй анхны бие даасан судалгаа Нээлттэй Нийгэм Форум, “Иргэд Төсвөө Хянана” иргэний нийгмийн сүлжээтэй хамтран 2010 оны дөрөвдүгээр сараас 2011 оны тавдугаар сарын хооронд явуулсан байна. “Шилэн түрийвч” аян. Гол төлөв сургууль, цэцэрлэг, эмнэлэг, мөн төсвийн зарим байгууллагын төсвийг эцэг эх, эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдэд нээлттэй болгон танилцуулж хяналт тавих боломж олгодог.
64 дүгээр зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх	64.1.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;		Иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн төлөөллийг хэрхэн оролцуулах, олон нийтийн хяналтыг хэрхэн хийх талаар төрийн байгууллагууд ойлголт бага, дургүй, мэдээлэл, аргачлал ил тод бус байдаг.		
64 дүгээр зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх	64.1.2.тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих,	Иргэд хурлын төлөөлөгчдөрөө дамжуулан хяналт тавих боломжтой	Иргэдийн зүгээс хяналт тавих боломж хязгаарлагдмал	Энэ төрлийн хяналтыг хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалт байхгүй	Иргэний танхимын хэлэлцүүлгүүд зэрэг оролцон хяналт тавьж болно.

2. Концессийн тухай хуулинд хийсэн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Сөрөг тал	Журам, хөтөлбөр	Хэрэгжилтийн байдал
<i>Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал</i>					
<i>7-р зүйл. Нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх</i>	7.1.3.концессын зүйлийн жагсаалтыг нийтэд мэдээлэх;	Энэ хууль нь шинэ батлагдсан тул мэдээллийн ил тод байдал, уралдаант шалгаруулалтын үе шатууд тодорхой.	Мэдээллийг бүрхэг тараадаг, хуулийн дагуу байгуулагдсан Нийслэлийн өмчийн газар, бусад ижил төстэй байгууллагуудын үйл ажиллагаа нь ил тод бус.		
<i>11 дүгээр зүйл. Төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт</i>	11.2.2.уралдаант шалгаруулалтыг товлон зарлах;		мэдээлэх хугацааг тодорхой тогтоогоогүй байна.		
<i>12 дугаар зүйл. Уралдаант шалгаруулалтыг зарлах</i>	12.2.Уралдаант шалгаруулалтын зар мэдээг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлэхээс гадна, шаардлагатай бол олон улсад өргөн хэрэглэгддэг хэлээр гардаг тухайн салбарын хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно. 12.3.Уралдаант шалгаруулалтад оролцох санал ирүүлсэн этгээд саналыг хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө урьд нь өгсөн саналаа буцаан авах, эсхүл дахин санал ирүүлэх эрхтэй. 12.4.Уралдаант шалгаруулалтад оролцох санал ирүүлэх хугацаа нь түүнийг нийтэд зарласнаас хойш хоёр сараас доошгүй байна. 12.5.Эрх бүхий этгээд нь уралдаант шалгаруулалтын талаар танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах зэргээр нийтэд мэдээлэл өгөх үүрэгтэй.	Мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр хамааралтай хүмүүст нь хүргэхээр зохицуулсан. Хэн, юуг хэнд, ямар механизмаар хүргэхийг тодорхой заасан.	мэдээлэх хугацааг тодорхой тогтоогоогүй байна.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	

Хавсралт 5

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд хийсэн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
<i>Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал</i>					
21 дүгээр зүйл. Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх	21.1.Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ. 21.2.Захиалагч тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно.	Мэдээллийн ил тод байдлын шалгуурыг хангасан.		Удаа дараагийн өөрчлөлт хийсний үр дүнд иргэдийн оролцооны заалтууд улам тодорхой болж байгаа, цахим тендер, бусад давуу талууд ихтэй.	Хэрэгцээ шаардлагын үнэлгээ хийхээс эхлээд бэлтгэл үед буюу тендерийн зураг төсөл баримт бичиг боловсруулах үед урьдчилсан зар мэдээ өгөх заалт байхгүйгээс цөөхөн хүн мэддэг. Мөн хамгийн гол эрсдэл нь иргэд хохирох, тухайн орон нутагт гэнэт нэг зам бариад эхэлдэг, мэдээлэл муу, тендерийн бүхий л үе шатны мэдээлэл ил тод, тодорхой байх хэрэгтэй. Орон нутагт мэдээлэл маш муу түгдэг, Энэ нь мэдээллийг хязгаарлагдмал хүрээнд түгээдэг, нийтийн зар мэдээний самбар байхгүй, газар нутгийн байршлаас болоод тухайн худалдан авалтын зарыг сонсоогүй аж ахуйн нэгж, иргэн байх зэрэг маш олон дутагдлууд байна. 2009 оноос зарим аймгуудын ИНБ-уудын сүлжээ нь ЗДТГ, ИТХ-тай түншлэлийн гэрээ байгуулж, төлөөллөө үнэлгээний хороонд оруулж эхэлсэн байна. Үүнд хандивлагч орнууд, манай улсад үйл ажиллагаа хэрэгжүүлж буй олон улсын байгууллагууд, түүний дотор Мерси Кор Монгол, АНУ-ын Азийн сан зэрэг байгууллагуудын хүчин чармайлт, хэрэгжүүлж буй төслүүд гол үр нөлөө үзүүлсэн.
53 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага,	53.5.4. худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх вэб хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох, боловсронгуй болгох;	Мэдээ мэдээлэлийг нийтэд түгээх арга механизмыг тодорхой тусгаж өгсөн бөгөөд www.e-procurement.mn сайт ажиллаж байна.		<u>ССТ-2007</u> 6.2. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага болон орон нутгийн нэгж нь шаардлагад нийцсэн хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерг оролцогчийг сонгон шалгаруулах үүрэгтэй бөгөөд энэ талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод гарган тавина.	
53 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага,	53.7.Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нийт зарлах тендерийн 20-оос доошгүй хувийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулна.	Худалдан авах ажиллагааны бүхий л үе шат, үр дүнг иргэд мэдэх эрхтэй.	Худалдан авалтын оролцогч талууд руу чиглэсэн, үр шимийг хүртэгч иргэн, ТББ-ын оролцоо хамгийн их шаардах ёстой хууль, гэтэл мэдээлэл бүрхэг, тодорхой бус, цаг хугацаандаа бус хаалттай тендерийг хөхиүлэн дэмжсэн харагдаж байна.	Энэ мэдээллийг хэрхэн өгөх нь үе шат бүрт яаж өгөх талаар журамд тодорхой тусгаагүй.	

Хавсралт 5

Идэвхтэй оролцоо					
<p>7¹ дүгээр зүйл. Худалдан авах ажиллагаан дахь олон нийтийн оролцоо</p>	<p>7¹.2.Сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болно. 7¹.3.Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам, заавар, жишиг баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж мөрдүүлнэ. 7¹.4.Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийг өргөнөөр оролцуулах зарчмыг баримтална</p>	<p>Орон нутгийг хөгжүүлэх сангаас санхүүжилт аван, гэрээгээр ажиллах эрх зүйн орчин баталгаажсан. Эрх зүйн болон төсөв санхүүгийн талаасаа.</p>	<p>Ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлалтай.</p>	<p>Сангийн сайдын тушаалаар “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ыг батлан хэрэгжүүлж эхлэх нөхцөлийг бүрдүүлсэн.</p>	<p>Орон нутагт хийгдэх зарим ажлууд, тухайлбал явган зам тавих, гэрэлтүүлэг тавих гэх мэт ажлуудад тэнд амьдардаг иргэд өөрсдөө оролцож, тодорхой цалин хөлс авах гэх мэт зохицуулалтууд орон нутгуудад хийгддэг.</p>
<p>47 дугаар зүйл. Үнэлгээний хороо</p>	<p>47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.</p>	<p>Иргэний нийгмийн байгууллага оролцох боломжтой болсон</p>	<p>И Н Б - у д ы н төлөөлөлийг хэрхэн оролцуулах, үнэлгээний хороонд ямар эрх үүрэгтэй ажиллах талаар заалт байхгүй</p>	<p><u>Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 301 тоот тушаалаар</u> “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ыг шинэчлэн баталж гаргасан. Энэхүү журмын 2.2-д 47.4-д заасан төлөөллийг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд заавал оруулна” гэж заасан байна.</p>	<p>“Худалдан авах ажиллагааны төлөө түншлэл” сүлжээ 2010 оны 5-р сард “Нийгмийн Хариуцлагын Төлөөх Түншлэл” Сүлжээний дэд сүлжээ болон байгуулагдсанаас эхлэн арав гаруй ИНБ-ыг нэгтгэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.</p>

Хавсралт 5

Иргэдийн хяналт					
“52 дугаар зүйл. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх	52.3.Хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагыг энэ хуулийн 35-39 дүгээр зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж, захиалагчийн үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, аудит хийлгэж болно	Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангаснаар худалдан авах ажиллагааны ил тод байдал, үрдүн сайжирч, авилга буурах, төрийн үйлчилгээний чанар дээшлэх, Засгийн газарт итгэх иргэдийн итгэл нэмэгдэх эерэг нөлөө үзүүлнэ	Захиалагчийн үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, аудит хийх чадавхитай хувийн хэвшлийн болон мэргэжлийн ТББ-ууд цөөн байгаа.	<u>Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 301 тоот тушаалаар</u> “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ыг шинэчлэн баталж гаргасан. Энэхүү журмын 2.2-д “Хуулийн 47.6-д заасны дагуу Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэжлсэн байх бөгөөд хуулийн 47.4-д заасан төлөөллийг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд заавал оруулна” гэж заасан байна.	Өнөөдрийн байдлаар УБ хот, 12 аймагт хийсэн судалгаагаар 110 орчим ИНБ-ууд ХАА-ны анхан шатны мэдлэг олгох, сертификаттай сургалтад хамрагдснаас 64 хүн сертификаттай байна. Гэтэл аймаг нийслэл, дүүргүүд, төсөвт байгууллагууд, төрийн өмчит байгууллагууд, яамд, ХААГ дээр тендер зарлагдаж, үнэлгээний хороонд ажиллах шаардлага хангасан Иргэний нийгмийн төлөөллийг хаанаас, яаж авахаа мэдэхгүйд хүрч байна. Иргэн энэхүү үнэлгээний хороонд орж ажиллах эрх нээлттэй бөгөөд энэ тохиолдолд гэрчилгээ авсан байхыг шаардаж байгаа аж.

4. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд хийсэн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээлэлийн хүртээмж ба ил тод байдал					
7 дугаар зүйл.Төсвийн тусгай шаардлагыг баримтлах	7.1.3.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг гаргах, тайлагнах, баглах.		Хэнд хэрхэн тайлагнах талаар тодорхой заагаагүй		Хэрэгжилт ил тод байна.
5-р зүйл “Төсвийн удирдлагын зарчим	5.1.1-д.төсвийн богино, дунд хугацааны бодлого, стратеги зорилт, урт хугацааны чиг хандлагын төсөөлөл, тэдгээрийн агуулга, хэрэгжилт нь ил тод байх”		Өгч байгаа мэдээлэл нь хялбаршуулсан, энгийн бус. Иргэдэд уншихад ойлгомжгүй		www.iltog.gov.mn, moff.gov.mn


 СУДАЛГААНЫ САН

Хавсралт 6

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулинд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын зэрэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр,	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг	4.1.4. Холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах	Иргэдийн байгаль орчны мэдээлэл авах эрхийг нээсэн.	Тунхаглалын шинжтэй, хариуцах эзэнгүй, арга зам нь тодорхойгүй, нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэхийг тусгаагүй.	ЗГТ-2012/85-5.3. Иргэн, хуулийн этгээд нь улсын төсөв, шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр бүрдүүлсэн байгаль орчны өгөгдөл, мэдээллийн нэгдсэн тооллогыг жилд нэгээс доошгүй удаа хийж дүнг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	Мэдээллийн хүртээмж, арга хэрэгсэл, хариуцах эзэн, түүний хариуцлагыг хуульчлаагүйгээс хэрэгжилт хангалтгүй.
10 дугаар зүйл. Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээ	Хяналт-шинжилгээний сүлжээ нь байгаль орчин түүний баялгийн талаар хүн ам, сонирхогч аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангах	Байгаль орчинтой холбоотой мэдээллээр хангах үүргийг төрийн холбогдох байгууллагууд даалгасан.	Мэдээллээр хангах механизм, хариуцлагын тогтолцоог хуульд тодорхой заагаагүй.	Журмаар нарийвчлан заагаагүй.	Мэдээллээр хангах механизм, хариуцлагын тогтолцоог хуульд тодорхой заагаагүйгээс хэрэгждэггүй.
15 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх	15.1.6 Байгаль орчны тухай мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах...	Төрийн захиргааны төв байгууллагад иргэд, байгууллагыг мэдээллээр хангах үүргийг хүлээлгэсэн.	Ямар арга замаар ямар хугацаанд ямар мэдээллээр иргэд, байгууллагыг хангах талаар тодорхой заагаагүй.	ЗГТ-2012/85-4.1. Байгаль орчны мэдээллийн төв мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг түгээх үүргийг хүлээнэ.	Мэдээлэх механизм, хариуцлагын тогтолцоог хуульд нарийвчлан тусгаагүйгээс хэрэгжилт тааруу байгаа.
Идэвхтэй оролцоо					
4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг	4.1.3 Байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх	Нутгийн иргэд хамтран байгалиа хамгаалж, түүний ашиг шимийг хүртэх боломжийг нээж өгсөн.	Санхүүжилтийн асуудлыг хуулиар зохицуулаагүй.	БОАЖСТ-2010/А-250 -2.1. Нутгийн иргэд өөрийн байнга оршин суугаа сум, дүүргийн нутаг дэвсгэрт байгаа байгалийн тодорхой төрлийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, эзэмших иргэдийн нөхөрлөлийг Монгол Улсын Иргэний хуулийн 476, 481 дүгээр зүйлд заасны дагуу байгуулна. ЗГТ-2010.04.14/90 Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлөр -9.5.2. Зорилт 2. Байгалийн нөөц ашиглагчдын бүлгүүд, байгаль хамгаалагчдын нөхөрлөлүүдэд байгалийн нөөцийг зохистой ашиглах эрх, үүргийн тогтолцоог бий болгох замаар байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө (бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, усны менежментийн төлөвлөгөө, ойн менежментийн төлөвлөгөө зэрэг)-г хэрэгжүүлнэ.	Санхүүжилтийн асуудлыг хуулиар зохицуулаагүйгээс хэрэгжилтэд хүндрэл учирдаг.

Хавсралт 6

<p>4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг</p>	<p>4.1.6. Иргэд сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших</p>	<p>Байгалийн тодорхой баялгийн хамгаалалтыг нөхөрлөлд гэрээлэн шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн.</p>	<p>Байгалийн баялгийг хамгаалах үүргийг санхүүжилтийн хамт нөхөрлөлд шилжүүлэхийг хуульд тусгаагүй.</p>	<p>БОАЖСТ-2010/А-250- 3.1. Нөхөрлөл нь байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах ашиглах, эзэмших талаарх хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргаар уламжлан Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд гаргана. 3.2. Нөхөрлөлийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах тухай хүсэлтийг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх ажлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.</p>	<p>Санхүүжилтийн асуудлыг хуулиар шийдэж өгөөгүйгээс нөхөрлөлийн үйл ажиллагаа бэхжихгүй, үйл ажиллагаа нь төслөөс хамааралтайгаар тогтворжиж чадахгүй байна.</p>
<p>4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг</p>	<p>4.1.5 Байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах, байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах</p>	<p>Иргэдийн шаардах эрхийг баталгаажуулсан.</p>	<p>Иргэдийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг хуульд тусгаагүй.</p>	<p>БОАЖСТ-2010/А-250- 5.2. Хариуцан хамгаалж байгаа газар нутагтаа байгаль орчныг хамгаалах, хяналт шалгалт явуулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох, түүнчлэн учруулсан хохирлыг буруутай эдгээдээр нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах талаар эрх бүхий байгууллага албан тушаалтанд тавих, шаардах, шаардлагатай бол хуулийн байгууллагад хандах арга хэмжээ авна.</p>	<p>Иргэдийн шаадлагыг биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг хуульд тусгаагүйгээс шаардлага биелэхгүй талаар өнгөрч, иргэдийн идэвх буурах тал бий.</p>
<p>15 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p>	<p>15.1.14 Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах журам боловсруулан батлах</p>	<p>Иргэдийг байгаль хамгаалахад оролцуулах хөшүүргийг журамлан зохицуулахыг төрийн төв байгууллагад даалгасан.</p>	<p>Идэвхтэн байгаль хамгаалагчийн үйл ажиллагааг идэвхжүүлэх боломжийг бүрдүүлсэн.</p>	<p>БОАЯСТ-2010/А-115-1.3.Идэвхтэн байгаль хамгаалагч нь орон нутагтаа байгаль орчныг хамгаалах чиглэлээр суртал, ухуулга явуулж иргэдийн байгаль орчноо хайрлах сэтгэл зүйг төлөвшүүлэх замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үүрэг хүлээнэ. 7.1.1. Байгалийн нөөц баялгийг хууль бусаар бэлтгэсэн, агнасан, түүсэн тухай мэдээлсэн, илрүүлсэн идэвхтэн байгаль хамгаалагчийг тухайн зөрчил гаргагчид ногдуулсан торгуулийн 15 хувиар шагнаж урамшуулна. 7.4. Байгалийн нөөц баялгийг хууль бусаар бэлтгэсэн, түүсэн, агнасны улмаас учирсан хохиролд тавигдсан нөхөн төлбөрөөс байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгийн 20 хувиар тухайн зөрчлийг илрүүлэн, нөхөн төлбөрийг барагдуулсан идэвхтэн байгаль хамгаалагчийг урамшуулна. 7.5. Сум дүүргийн Засаг дарга өндөр амжилт гаргасан 1, аймаг, нийслэлийн Засаг дарга 3 хүртэл, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 10 хүртэл идэвхтэн байгаль хамгаалагчийг жил тутам шалгаруулан нэрэмжит шагналаар шагнаж байна.</p>	<p>Журмаар нарийвчлан тодорхой зохицуулалт хийсэн учир идэвхтэн байгаль хамгаалагчид идэвхтэй сайн ажилладаг.</p>

Хавсралт 6

<p>16 дугаар бүлэг. Аймаг, нийслэлийн ИТХ-ын болон ЗД-ын бүрэн эрх</p>	<p>16.2.7 Нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх</p>	<p>Н ө х ө р л ө л и й н санхүүжилтийг хуулиар баталгаажуулсан.</p>	<p>Хуулиар хүлэсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд төрийн байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг заагаагүй.</p>	<p>БОАЯСТ-2010/А-115-1.4. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нь нөхөрлөлийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг туслалцааг үзүүлэх, хяналт тавих эрх, үүрэгтэй.</p>	<p>Нөхөрлөлийн төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог хуульд заагаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байдаг.</p>
<p>16 дугаар бүлэг. Аймаг, нийслэлийн ИТХ-ын болон ЗД-ын бүрэн эрх</p>	<p>16.2.8 Нөхөрлөлийн үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ батлагдсан төсвийн хүрээнд дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах</p>	<p>Нөхөрлөлийг дэмжин хөгжүүлэх үүргийг төрд хүлээлгэсэн.</p>	<p>Хариуцлага хүлээлгэх тогтолцоог хуульчлаагүй.</p>	<p>БОАЯСТ-2010/А-115-3.3. Нөхөрлөлд энэ журмын 3.1.4, 3.1.5 дахь заалтад дурьдсан хөтөлбөр, газрын зургийг боловсруулж бэлтгэхэд аймаг, нийслэлийн Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. 5.4. Хариуцан хамгаалж байгаа газар нутагтаа нэн ховор, ховор амьтан, ургамал, түүний амьдрах орчныг хамгаалах, өвөл, хаврын улиралд болон цаг уурын хүндрэлтэй үед амьтдын гол идээшил нутагт өвс тэжээл, хужир мараа тавьж өгөх, ус задгайлах, амьтны халдварт өвчний голомтыг тусгаарлах, амьтны нөөцөд халгаатай махчин амьтдын тоо толгойг зохицуулах, сийрэгжүүлэх, туршилт судалгаа явуулах зэрэг арга хэмжээг мэргэжлийн байгууллагын зөвлөмж, туслалцаатайгаар авч хэрэгжүүлнэ. 5.10. Нутгийн иргэдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх болон нөхөрлөлийн үйл ажиллагааг иргэдэд тайлбарлан таниулах чиглэлийн сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлыг холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулж байна.</p>	<p>Нөхөрлөлийг дэмжин хөгжүүлээгүй тохиолдолд төрийн байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг хуульд тодорхой суулгаж өгөөгүй учраас хэрэгжилт тааруу байна.</p>
	<p>16.2.9 Тухайн жилд нөхөрлөлийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайланг ИТХ-д хэлэлцүүлэх</p>	<p>Н ө х ө р л ө л и й н х а р и у ц л а г ы г дээшлүүлэхэд нөлөө үзүүлнэ.</p>	<p>Тайлагнах хугацаа, хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгаагүй.</p>	<p>БОАЯСТ-2010/А-115 -5.1. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааны хөтөлбөр, менежментийн төлөвлөгөөний биелэлтийн байдлыг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр танилцуулж, тайлан тавьж байна.</p>	<p>Хэн нь ямар асуудлыг хэзээ хариуцан тайлагнах, тайлагнаагүй тохиолдолд хүлээх хариуцлагыг заагаагүй нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлдөг.</p>
<p>17 дугаар зүйл. Сум, дүүргийн ИТХ-ын болон ЗД-ын бүрэн эрх</p>	<p>17.1.8. Иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай хүсэлтийг хэлэлцэж саналаа сум, дүүргийн Хуралд уламжлах;</p>	<p>Иргэдийн хүсэлтийг хэлэлцэж саналаа уламжлахыг НӨУЕ-ны анхан шатны байгууллагад даалгасан.</p>	<p>НӨУЕБ-ын шуудардчиллын зарчмаар гаргасан шийдвэр эцсийнх биш дараагийн шатанд шилжинэ.</p>	<p>БОАЖСТ-2010/А-250-3.1. Нөхөрлөл нь байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах ашиглах, эзэмших талаарх хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргаар уламжлан Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд гаргана.</p>	<p>НӨУЕБ-ын шууд ардчиллын зарчмаар гаргасан шийдвэр эцсийнх биш дараагийн шатанд шилждэг нь иргэдэд чирэгдэлтэй байдаг.</p>

Хавсралт 6

<p>17 дугаар зүйл. Сум, дүүргийн ИТХ-ын болон ЗД- ын бүрэн эрх</p>	<p>17.1.5 Нутаг дэвсгэрийнхээ байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг нөхөрлөлд хариуцуулах асуудлыг баг, хорооны ИНХ-ын саналыг үндэслэн шийдвэрлэх</p>	<p>Нөхөрлөлийн асуудлыг сум, дүүргийн түвшинд шийдэх орчин бүрдсэн.</p>	<p>Нөхөрлөлийн асуудал олон шат дамжин шийдэгдэх болж байна.</p>	<p>БОАЖСТ-2010/А-250-3.2. Нөхөрлөлийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах тухай хүсэлтийг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх ажлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцан зохион байгуулна. 3.4. Энэхүү журмын 3.1-д заасан болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 311 дүгээр зүйлийн 311.2, 311.7 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан бол сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал асуудлыг хурлаараа хэлэлцэж, нөхөрлөлд байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцуулан хамгаалуулах тухай тогтоол гаргана.</p>	<p>Нөхөрлөлийн асуудал шийдвэрлэгдэх үйл явц шат дамжлагатай байгаа нь иргэдэд хүндрэлтэй байна.</p>
	<p>17.1.7 Нутаг дэвсгэртээ нөхөрлөлд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн үзэл баримтлалын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийг батлах, хэрэгжилтийг хянах</p>	<p>Байгалийн нөөцийн хамтын менежментийн зарчим хэрэгжих нөхцөл бүрдсэн.</p>	<p>Хөтөлбөр батлах, хэрэгжилтийг хянах процедурыг нарийвчлан заагаагүй.</p>	<p>БОАЖСТ-2010/А-250-Тав. Нөхөрлөлийн эрх, үүрэг 5.1. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааны хөтөлбөр, менежментийн төлөвлөгөөний биелэлтийн байдлыг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр танилцуулж, тайлан тавьж байна.</p>	<p>Хөтөлбөр батлах, хэрэгжилтийг хянах процедурыг нарийвчлан заагаагүй нь нөхөрлөлийн үйл ажиллагаанд тодорхойгүй байдал үүсгэдэг.</p>
<p>17 дугаар зүйл. Сум, дүүргийн ИТХ-ын болон ЗД- ын бүрэн эрх</p>	<p>17.2.7 ...Иргэдийн нөхөрлөлд хариуцуулах байгалийн тодорхой төрлийн баялгаас зохих болзол, хугацаатайгаар хууль, журмын дагуу хамгаалуулах, ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байгуулж, биелэлтэд нь хяналт тавих</p>	<p>“Ашиглагч нь хамгаалах”, “Байгалийн нөөцийн хамтын менежментийн зарчим” хэрэгжих үндсийг тавьж, байгалийн тодорхой төрлийн баялгийг ИНБ-д гэрээлэн шилжүүлэх болсон.</p>	<p>Болзол, хугацааг хуульд тодорхой заагаагүй.</p>	<p>БОАЖСТ-2010/А-250-4.1. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг үндэслэн тухайн сум, дүүргийн Засаг дарга нөхөрлөлтэй байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээг байгуулж, гэрчилгээ олгоно.3.4. Энэхүү журмын 3.1-д заасан болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 311 дүгээр зүйлийн 311.2, 311.7 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан бол сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал асуудлыг хурлаараа хэлэлцэж, нөхөрлөлд байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцуулан хамгаалуулах тухай тогтоол гаргана.</p>	<p>Гэрээлэн шилжүүлэх үйл ажиллагааны болзол, хугацааг хуульд тодорхой зааж өгөөгүй байдал нь шийдвэр гаргагчдыг өөрийн үзэмжээр хандахад хүргэдэг тал бий.</p>



Хавсралт 6

<p>17 дугаар зүйл. Сум, дүүргийн ИТХ-ын болон ЗД- ын бүрэн эрх</p>	<p>17.2.10 Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үр дүнг сумын ИТХ-д тайлагнах</p>	<p>Нөхөрлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг хуульд зааж өгсөн.</p>	<p>Тайлагнах хугацаа, үүргээ биелүүлээгүй бол хүлээлгэх хариуцлагыг хуульд тодорхой тусгаагүй.</p>	<p>БОАЖСТ-2010/А-250-5.4. Хариуцан хамгаалж байгаа газар нутагтаа нэн ховор, ховор амьтан, ургамал, түүний амьдрах орчныг хамгаалах, өвөл, хаврын улиралд болон цаг уурын хүндрэлтэй үед амьтдын гол идээшил нутагт өвс тэжээл, хужир мараа тавьж өгөх, ус задгайлах, амьтны халдварт өвчний голомтыг тусгаарлах, амьтны нөөцөд халгаатай махчин амьтдын тоо толгойг зохицуулах, сийрэгжүүлэх, туршилт судалгаа явуулах зэрэг арга хэмжээг мэргэжлийн байгууллагын зөвлөмж, туслалцаатайгаар авч хэрэгжүүлнэ. 5.10. Нутгийн иргэдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх болон нөхөрлөлийн үйл ажиллагааг иргэдэд тайлбарлан таниулах чиглэлийн сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлыг холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулж байна. 5.12. Байгаль орчныг хамгаалах чиглэлийн уулзалт ярилцлага, семинар зөвлөлгөөн, мэргэжил шинээр олгох хийгээд давтан сургах сургалтанд гишүүдээ хамруулж байна. 5.7. Хариуцан хамгаалж байгаа газар нутагтаа мод бут, ургамал тарих, амьтан шилжүүлэн болон сэргээн нутагшуулах ажлыг мэргэжлийн байгууллагын зөвлөлгөө туслалцаатайгаар хэрэгжүүлнэ. 5.5. Хариуцан хамгаалж буй газар нутгийн төлөв байдал, нөөц, түүний өөрчлөлт, хөдөлгөөнд тогтмол ажиглалт хийж, мэдээллийг байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид өгч байна</p>	<p>Нөхөрлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг хуульд зааж өгсөн хэдий ч хариулагыг үааж өгөөгүй нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлдөг.</p>
<p>18 дугаар бүлэг. Баг, хорооны ИНХ болон ЗД-ын бүрэн эрх</p>	<p>18.1.4 Нөхөрлөл байгуулах талаар багийн ЗД-аас ирүүлсэн саналыг хэлэлцэн шийдвэрлэх</p>	<p>Нөхөрлөл байгуулах саналыг шийдвэрлэх эрхийг анхан шатны хурлын байгууллагад өгсөн.</p>	<p>Анхан шатны хурлын шийдвэрийн дээд хүчин чадлыг баталгаажуулаагүй.</p>	<p>БОАЖСайдын тушаал-2010.07.22/ А-250-Бүрдүүлэх материал 3.1.2. байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалахыг зөвшөөрсөн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал</p>	<p>Анхан шатны хурлын шийдвэр эцсийн дээд хүчин чадалтай бус байгаа нь нэр хүнд, ач холбогдлыг бууруулдаг.</p>
	<p>18.2.5 Нөхөрлөлийг байгуулах болон түүний үйл ажиллагаатай холбогдсон саналыг ИНХ-д танилцуулж хэлэлцүүлэх</p>	<p>Нөхөрлөл байгуулах саналыг ИНХ-д хэлэлцүүлэх үүргийг ЗД-д даалгасан.</p>	<p>Нөхөрлөлийн гишүүдэд хуралдаа өөрсдөө оролцож асуудлаа танилцуулж хэлэлцүүлээгүй</p>	<p>БОАЖСайдын тушаал-2010.07.22/ А-250-Бүрдүүлэх материал 3.1.2. байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалахыг зөвшөөрсөн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал</p>	<p>Нөхөрлөлийн гишүүд асуудлаа шийдвэрлэхэд өөрсдөө биечлэн оролцох боломжгүй байгаа нь хүнд сурталтай байдаг.</p>

Хавсралт 6

<p>32 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалахад ТББ оролцох</p>	<p>32.2. Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаархи төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий ТББ-д эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.</p>	<p>Байгаль орчныг хамгаалах талаархи төрийн зарим чиг үүргийг ТББ-д гэрээлэн гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн чухал заалт болсон.</p>	<p>Х э р э г ж и л т и й г санхүүжүүлэх төрийн үүргийг “болно” гэдэг заалтаар заавал биелүүлэх албагүй болгосон.</p>	<p>БОАЖСТ-2008/30--1. Байгаль орчны төрийн болон ТББ-уудын ажлын уялдаа холбоог сайжруулах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажиллагаанд олон нийтийг өргөн оролцуулах, байгаль орчны мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын цар хүрээг өргөжүүлэх зорилгоор ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих орон тооны зөвлөлийг байгуулж,.... 1. ТББ-уудаар гэрээлэн гүйцэтгүүлэх ажлыг жагсаалтыг сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж гүйцэтгэчийг сонгон шалгаруулах, шаардлагатай зардлыг санхүүжүүлэхтэй холбогдсон арга хэмжээг зохих журмын дагуу зохион байгуулахыг газар, хэлтэс, агентлагийн дарга нарт даалгасгай.</p>	<p>Санхүүжилтийн асуудлыг хуулиар нэг мөр шийдэж өгөөгүйгээс гэрээлэн шилжүүлэх үйл ажиллагаа тогвортой, урт хугацаанд жинхэнэ утгаараа хэрэгжихгүй байгаа. БОНХЯ чиг үүргээ ТББ-д шилжүүлэхгүй богино хугацаатай төслийн тэтгэлэг өгөх төдийгээр аргацааж байна.</p>
Иргэдийн хяналт					
<p>4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг</p>	<p>4.1.2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах</p>	<p>Иргэдийн байгаль орчны хохирлыг шүүхэд нэхэмжлэх эрхийг нээсэн.</p>	<p>Шүүхийн зардлыг хэн хариуцах талаар зохицуулаагүй орхисон.</p>	<p>БОАЖСТ-2010/А-250-5.2. Хариуцан хамгаалж байгаа газар нутагтаа байгаль орчныг хамгаалах, хяналт шалгалт явуулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох, түүнчлэн учруулсан хохирлыг буруутай эдгээдээр нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах талаар эрх бүхий байгууллага албан тушаалтанд тавих, шаардах, шаардлагатай бол хуулийн байгууллагад хандах арга хэмжээ авна.</p>	<p>Шүүхийн зардлыг хэн хариуцах талаар зохицуулаагүй орхисон учир иргэд нэхэмжлэл гаргахаас түвэгшээдэг.</p>
	<p>4.1.5. Байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах</p>	<p>Иргэдийн шаардах эрхийг хуулиар баталгаажуулсан.</p>	<p>Шаардлагыг биелүүлээгүй бол хүлээх хариуцлагын тогтолцоог бий болгоогүй.</p>		<p>Шаардлага хүлээн авсан байгууллага, албан тушаалтанд асуудлыг шийдвэрлэх арга механизм, хариуцлагын тогтолцоог хуульд тодорхой тусгаагүйгээс тавьсан шаардлага биелэгддэггүй.</p>
<p>32 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалахад ТББ оролцох</p>	<p>32.1.1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах</p>	<p>ТББ-ын байгаль орчны хохирлыг шүүхэд нэхэмжлэх эрхийг нээсэн.</p>	<p>ТББ-ын шүүхийн өмнөх болон шүүхийн шатан дахь зардлын асуудлыг хуулиар зохицуулаагүй.</p>	<p>Журамлаж өгөөгүй орхисон.</p>	<p>ТББ-ын шүүхийн өмнөх болон шүүхийн шатан дахь зардлын асуудлыг хуулиар зохицуулаагүйгээс ТББ-д хүндрэл учруулж, байгаль орчны хэргийг шүүхээр шийдвэрлүүлэх ажиллагаа удааширдаг.</p>

Хавсралт 6

2. Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр,	Хэрэгжилтийн оноогийн байдал
<i>Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал</i>					
18 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцоо	18.1-д Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн үнэлгээ хийгдэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ	Ямар мэдээллийг ямар арга хэрэгслээр нийтэд мэдээлэхийг Төрийн захиргааны төв байгууллагад үүрэг болгосон.	Хэзээ мэдээлэх нь тодорхойгүй бөгөөд зөвхөн цахим хуудсаар мэдээлэх тохиолдолд орон нутгийн иргэдэд хүртээмжгүй байх талтай.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	Стратегийн үнэлгээг цоо шинээр хийх болсон.
5 дугаар бүлэг. Байгаль орчны стратегийн үнэлгээ	5.5.Төслийг хэрэгжүүлэгч салбарын яам болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн үнэлгээний дүгнэлтийн талаарх мэдээллийг нийтэд мэдээлж, өөрийн цахим хуудсанд байрлуулах бөгөөд хэвлэмэл хувилбартай танилцах боломжийг бүрдүүлнэ.	Ямар мэдээллийг нийтэд мэдээлэхийг төрийн холбогдох байгууллагуудад үүрэг болгосон.	Нийтэд мэдээлэх хугацаа, арга хэрэгсэл нь тодорхой бус.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	Хэрэгжиж эхлээгүй байгаа.
10 дугаар бүлэг. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжилгээ	10.5.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчдад танилцуулах ажлыг зохион байгуулна.	Мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр хамааралтай хүмүүст нь хүргэхээр зохицуулсан. Хэн юуг хэнд ямар механизмаар хүргэхийг тодорхой заасан.	Танилцуулга хийх хугацааг тодорхой заагаагүй.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	Хэрэгжиж эхлээгүй байгаа.
14 дүгээр бүлэг. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үүрэг	14.1.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах;	Мэдээлэл тогтмол байх нөхцөлийг хангасан зохицуулалт болсон.	Мэдээлэх механизм, хугацаа тодорхойгүй.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	Хэрэгжиж эхлээгүй байгаа.

Хавсралт 6

<p>39 дүгээр зүйл. Байгаль орчны мэдээллийн төвийн бүрэн эрх</p>	<p>39.1.4 Хэрэглэгчийг мэдээллийн сангаас мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах</p>	<p>Иргэдийг байгаль орчны мэдээллийн сангийн мэдээллээр хангах бүтэц бий болсон.</p>	<p>Мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг тодорхой заагаагүй бөгөөд иргэд ямар хэлбэрээр мэдээлэл авахыг зохицуулаагүй.</p>	<p>БОС-ССТ- 1999/ 154/201-4.1.Мэдээг холбогдох хуулиуд болон төв санг бүрдүүлэх журмын 20 дугаар заалтын дагуу тус сангийн мэдээ баримтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулахын тулд мэдээний ач холбогдлоос хамааран ялгаатай үнэ тогтооно.</p> <p>3.3. Мэдээний ашиглалтын талаар мэдээллийн санг хариуцагч нь хэрэглэгчидтэй гэрээ хийж, энэхүү журамд дурьдсан хариуцлагыг харилцан хүлээх талаар тохиролцоно.</p> <p>3.4. Мэдээгээр үйлчлүүлэгчид, хэрэглэгчид нь мэдээний бүрэн бүтэн байдал, хадгалалт, нууцлалыг хариуцахаас гадна уг мэдээг агуулсан файл, диск, зураг, тайлан зэргийг бусдад дамжуулах, худалдах, өөрчлөх, хувиран олшруулах, зохиогчийн эрхийг хөндөх зэргээр ашиглахыг хориглоно.</p> <p>3.8. Байгаль орчны болон “БОХ” маягтын статистик мэдээллийг албан ёсны бус хэрэгцээнд авч ашиглагч нь мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй.</p> <p>ЗГТ-2010/85-4.1. Байгаль орчны мэдээллийн төв мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг түгээх үүргийг хүлээнэ.</p> <p>4.3. Мэдээллийн сангийн мэдээллийг ашигласан тохиолдолд эх сурвалжийг заавал дурдана.</p>	<p>Хэдийгээр БОНБУ-ний тайлан байгаль орчны мэдээллийн санд тавигдаж байгаа нь сайшаалтай ч БОНБУ бүрэн эхээрээ бус зөвхөн цөөхөн тооны мэдээллүүд, нэрлэвэл, төслийн БОНБУ-ний ерөнхий мэдээлэл, БО-ыг хамгаалах төлөвлөгөө, БО-ны хяналт шинжилгээний хөтөлбөр зэргүүд агуулагдсан байдаг нь байгаль орчны холбогдолтой зарим мэдээллүүд олон нийтэд хаалттай хэвээр байсаар байгааг илтгэж байна.</p>
<p>Зөвлөлдөх орчин</p>					
<p>18 дугаар зүйл. Нөлөөллийн үйл ажиллагааны олон нийтийн оролцоо</p>	<p>18.2-т Засгийн газрын хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үндэсний болон бүс нутгийн хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд стратегийн үнэлгээ хийх явцад олон нийтээс санал авна.</p>	<p>Байгаль орчинд хохирол учруулахаас урьдчилан сэргийлсэн зохицуулалт болсон.</p>	<p>Олон нийтийн саналыг хэрхэн тусгаж харгалзан үзэх талаар хуулийн тодорхой зүйл, заалт алга байна.</p>	<p>Олон нийтийн оролцооны асуудлыг БОНХ-ийн сайдын багалсан журмаар зохицуулах бөгөөд одоохондоо батлагдаагүй олон нийтээр хэлэлцүүлж байгаа</p>	<p>Хэрэгжиж эхлээгүй.</p>

Хавсралт 6

<p>18 дугаар зүйл. Нөлөөллийн үйл ажиллагааны олон нийтийн оролцоо</p>	<p>18.3-т Стратегийн үнэлгээнд олон нийтээс санал ирүүлэх хугацаа нь ажлын 30-аас дээшгүй өдөр байх бөгөөд амаар болон бичгээр санал авна.</p>	<p>Санал авах хэлбэр, хугацааг зааж өгсөн.</p>	<p>Саналаа хэнд арга замаар гаргахыг хуульд тодорхой заагаагүй.</p>	<p>Олон нийтийн оролцооны асуудлыг БОНХ-ийн сайдын баталсан журмаар зохицуулах бөгөөд одоохондоо батлагдаагүй олон нийтээр хэлэлцүүлж байгаа</p>	<p>Хэрэгжиж эхлээгүй.</p>
<p>18 дугаар зүйл. Нөлөөллийн үйл ажиллагааны олон нийтийн оролцоо</p>	<p>18.4-т Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.</p>	<p>Үнэлгээнд сонирхогч олон талуудыг оролцуулах эрхийг нээж өгсөн.</p>	<p>Ямар арга механизм ашиглан иргэдийн санал авахыг тусгаагүй. Ямар тохиолдолд иргэдийн саналыг хүчинтэй гэж үзэх, иргэд зөвшөөрөөгүй болон иргэдээс санал аваагүй тохиолдолд үнэлгээний тайланг хүчин төгөлдөр гэж үзэх эсэхийг гүйцэд зохицуулаагүй орхисон.</p>	<p>Олон нийтийн оролцооны асуудлыг БОНХ-ийн сайдын баталсан журмаар зохицуулах бөгөөд одоохондоо батлагдаагүй олон нийтээр хэлэлцүүлж байгаа</p>	<p>Өмнөх хууль хэрэгжих үед иргэдээс санал авахад хувийн хэвшлийн байгууллагууд явуулах гэж байгаа үйлдвэрлэл, үйл ажиллагааныхаа тухай бодит мэдээллийг орон нутгийн иргэдэд өгөхгүйгээр хууран мэхэлж санал авах, цөөн тооны иргэдийг хамруулан санал авч, гарын үсгийг хуурамчаар үйлдэх, БОАЖЯ иргэдийн саналыг тусгаагүй үнэлгээг батлах гэх мэт зөрчлүүд гардаг. Түүнчлэн иргэд тухайн үйл ажиллагааны талаар эсрэг санал өгсөн атал харгалзан үзэлгүй зөвшөөрөл өгөх нь ч бий.</p>
<p>Иргэдийн хяналт</p>					
<p>9 дүгээр бүлэг. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө</p>	<p>9.12.Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина.</p>	<p>Байгаль орчны төлөвлөгөөний хэрэгжилтэд ТББ хяналт тавих боломжтой болсон.</p>	<p>ТББ хэзээ, хэрхэн, ямар санхүүжилтээр хяналт тавихыг хуульд тодорхой тусгаагүй.</p>	<p>Журмаар нарийвчлан зохицуулаагүй.</p>	<p>Хэрэгжиж эхлээгүй байна.</p>


Хавсралт 6

3. Ойн тухай хуулинд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
20 дугаар зүйл. Иргэний эрх, үүрэг	20.1.3. Холбогдох байгууллагаас ойн нөөц, түүний хамгаалалт, ашиглалтын талаар үнэн зөв мэдээллийг авах	Иргэдийн ойн нөөц, түүний хамгаалалт, ашиглалтын талаар мэдээлэл авах эрхийг нээсэн.	Мэдээлэл авах байгууллага, мэдээлэл авах арга зам, хугацааг тодорхой заагаагүй.	ЗГТ-2001/248 -Зорилт 4.4 Төрийн бус байгууллагуудыг ой, модны чиглэлээрхи үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, техник, технологи, бизнесийн мэдээллээр хангах, төсөл боловсруулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагаанд оролцуулна.	Төрийн ямар байгууллага, албан тушаалтнаас ямар хугацаанд ямар арга замаар мэдээлэл авахыг заагаагүйгээс хэрэгжилт тааруу байдаг.
39 дүгээр зүйл. Ойг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг	39.2. Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, буюу илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу урамшуулал олгоно.	Ойн зөрчлийг арилгахад иргэдийг оролцуулах хөшүүрэг болсон.	Мэдээлэл өгсөн иргэнийг хамгаалах хэрхэн талаар заагаагүй.	БОАЖСТ-2012/А-123 - 3.7. Нэг удаагийн үнэн зөв мэдээлэл нь нэг оноо болж тухайн иргэний нэр дээр мэдээллийн нэгдсэн санд хадгалагдана. 3.8. Хэрэв иргэний цуглуулсан оноо 5 болсон тохиолдол бүрт 250.0 мянган төгрөгний урамшуулал олгоно.	Мэдээлэгчийг хамгаалах зохицуулалт байхгүйгээс хэрэгжилт тааруу байна.
41 дүгээр зүйл. Ойн салбарын сургалт шинжлэх ухааны хангамж	41.2.4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ойн тухай мэдлэг, ойг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомжийг сурталчлах.	Иргэдийн оролцох эрхийг зааж өгсөн.	Сурталчилгааны зардлыг хэн, хэрхэн санхүүжүүлэх нь тодорхойгүй.	ЗГТ-2001/248-5 дугаар зорилт: 9. Ойн салбарын мэдээ, мэдээллийн боловсронгуй тогтолцоог бий болгож, чадавхийг дээшлүүлнэ.	Сурталчилгааг санхүүжилтийн хамт зохицуулаагүйгээс хэрэгждэггүй.
Зөвлөлдөх орчин					
25 дугаар зүйл. ТББ-ыг ойн санг хамгаалахад оролцуулах	25.1.2. Ойг хамгаалах талаарх саналаа холбогдох төрийн байгууллага болон зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад уламжлах;	ТББ-д ойг хамгаалахад оролцох боломж олгосон заалт болсон.	Иргэдийн санал олон шат дамжлагаар шийдэгдэх нь чирэгдэл учруулна.	ЗГТ-2009.07.22/227-2.2. Ойн санг гэрээгээр эзэмшихийг хүссэн аж ахуйн нэгж, байгууллага тухайн сум дүүргийн ИТХ-д хүсэлт гаргана. БОАЖСТ-2010/А-250-5.3. Хавар намрын хуурайшил ихтэй, түймрийн эрсдэл өндөр цаг үед байнгын эргүүл, жижүүр ажиллуулах, мэдээллийг сум, дүүргийн Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд тогтоосон хугацаанд мэдээлж байна. 5.11. Нөхөрлөл нь улсын болон орон нутгийн төсөв, олон улсын төслийн хөрөнгөөр гүйцэтгэх байгаль хамгаалах чиглэлийн арга хэмжээ, төсөл хөтөлбөр боловсруулах, санал өгөх, уралдаант шалгаруулалтанд оролцох эрхтэй.	2007 онд Ойн хууль шинэчлэгдэн батлагдснаас хойш нөхөрлөлийн тоо хурдацтай нэмэгдсээр 2011 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар Монгол улсын хэмжээнд 2011 оны байдлаар 631 ойн нөхөрлөл 1843723 га, 59 ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж 311732 га бүхий ойн санг тус тус эзэмшиж байна.

Хавсралт 6

Идэвхтэй оролцоо					
<p>25 дугаар зүйл. ТББ-ыг ойн санг хамгаалахд оролцуулах</p>	<p>25.1.4.Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах төсөл, зөвлөмж, аргачлал боловсруулж, холбогдох байгууллагад танилцуулан шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх;</p>	<p>ТББ-г ойн хамгаалахад оролцуулах боломж олгосон.</p>	<p>Төрийн ямар байгууллагад ямар арга замаар ямар хугацаанд шийдвэр гаргуулахыг тодорхой заагаагүй.</p>	<p>ЗГТ-2009.07.22/227- Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын бүрэн эрх 4.1.1. Эзэмшлийн ойд хяналт шалгалт зохион байгуулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох учруулсан хохирлыг буруутай этгээд, аж ахуйн нэгж, байгууллагаар нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах талаар эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах,шаардлагатай бол хуулийн байгууллагад асуудлыг тавих 4.1.3. Эзэмшлийн ойн сангийн газар, ус, ургамал, амьтны аймаг, бусад байгалийн баялгийг хамгаалах, төрх байдлыг хадгалах арга хэмжээ авах 4.1.6. ойд зорчин явагчид, байгалийн тодорхой баялгийг ашиглагчдад холбогдох хууль тогтоомжийг сурталчилах, мөрдүүлэх, гаргасан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах 4.1.7. ан амьтан, шувуу, загас зэрэг биологийн төрөл зүйл болон гол, горхи, булаг, шандны эх, хөвөө, хадлан бэлчээрийн талбайг хамгаалах, нөхөн сэргээх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх</p>	<p>ТББ-д ойг хамгаалахад оролцуулах эрх олгосон ч төрийн ямар байгууллагад ямар арга замаар ямар хугацаанд асуудлаа шийдвэрлүүлэхийг тодорхой заагаагүйгээс хэрэгжилт тааруу байна.</p>
<p>25 дугаар зүйл. ТББ-ыг ойн санг хамгаалахд оролцуулах</p>	<p>25.2.Төрийн захиргааны төв байгууллага ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр Б заасны дагуу ойг хамгаалах дүрмийн зорилго бүхий ТББ-аар гүйцэтгүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.</p>	<p>Ойн нөөцийн хамгаалалтыг ТББ-д шилжүүлсэн.</p>	<p>Ойн хамгаалах чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийг нэг мөр шийдвэрлэхээс төрийг “болно” гэж чөлөөлсөн.</p>	<p>Б О А Ж С Т - 2 0 0 9 / 3 0 7 - О й н мэргэжлийн байгууллагын ажиллах журам БОАЖС-2009/190- 6,3.Ойд гэрэлжүүлэх, тохируулах арчилгааны огтлол явуулсан явуулсан ажлын гүйцэтгэлийг шалгаж хүлээж авсан ажлын хэсгийн актыг үндэслэн холбогдох аймаг нийслэлийн Байгаль орчин аялал жуулчлалын газар улс, орон нутгийн төсвөөс эцсийн санхүүжилтийг олгоно.</p>	<p>Ойн хамгаалах чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийг нэг мөр шийдвэрлээгүйгээс хэрэгжилт тааруу.</p>



Хавсралт 6

<p>28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх</p>	<p>28.1.Ойн хэвийн өсөлт, хөгжилтийг хангах, бүтээмжийг дээшлүүлэх, ойг түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, экологийн тэнцлийг хадгалан хамгаалах зорилгоор энэ хуулийн 28.2.1-д заасан арчилгааг зөвхөн ойн мэргэжлийн байгууллага, цэвэрлэгээг ойн мэргэжлийн байгууллагаас гадна ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, иргэн гэрээгээр хийнэ.</p>	<p>М э р г э ж л и й н байгууллага, ТББ- ын гүйцэтгэх ажлыг заагласан.</p>	<p>Гэрээлэн шилжүүлэх ажлын зардлыг хэн хариуцахыг тодорхой заагаагүй.</p>	<p>Б О А Ж С Т - 2 0 0 9 . 1 0 . 2 3 / 3 0 7 - Ойн мэргэжлийн байгууллагын ажиллах журам БОАЖС-2009/190-3.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллага нь гэрэлжүүлэх, тохируулах арчилгааны огтлолыг гүйцэтгэхдээ тухай аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газаргаа гэрээ байгуулан ажиллана.</p>	<p>Ойн цэвэрлэгээг хийх аргачлал стандартын талаар нөхөрлөл, аж ахуйн нэгж, иргэнд сургалт, заавар, зөвлөгөө өгөх талаар учир дутагдалтай байдаг.</p>
<p>31 дүгээр зүйл. Мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах</p>	<p>31.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга бүх нийтээр мод тарих сарын ажлыг жил бүр зохион байгуулж, 16 насанд хүрсэн иргэн бүр нэг, аж ахуйн нэгж, байгууллага таваас доошгүй мод тарьж ургуулах, услах, арчлах бөгөөд өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд зардлыг хандивлана.</p>	<p>Мод тарих ажилд иргэдийг өргөнөөр оролцуулахыг төрд үүрэг болгосон.</p>	<p>Өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй иргэн зардлыг хандивлах гэдэг нь хэрэгжих магадлал багатай. Хэзээ тарихыг зааж өгөөгүй нь хяналт тавихад бэрхшээлтэй болно.</p>	<p>Холбогдох журам, хөтөлбөр батлагдаагүй.</p>	<p>Хяналтын механизмыг суулгаагүйгээс хэрэгждэггүй.</p>
<p>31 дүгээр зүйл. Мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах</p>	<p>31.2.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга мод суулгах талбайг сонгох, хөрс боловсруулах, тарьц суулгацаар хангах, тэдгээрийг услах, арчлах ажлыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, уг ажилд иргэдийг татан оролцуулна.</p>	<p>Мод тарихад иргэдийг татан оролцуулахдаа төр ямар үүрэг гүйцэтгэхийг тодорхой зааж өгсөн.</p>	<p>Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нарын үүргийг заагаж өгөөгүйгээс давхардал үүссэн. Үүргээ биелүүлэггүй тохиолдолд хүлээх хариуцлага нь тодорхойгүй.</p>	<p>Холбогдох журам батлагдаагүй.</p>	<p>Засаг дарга нар үүргээ биелүүлэггүй тохиолдолд хүлээх хариуцлагыг суулгаагүй учир хэрэгжилт тааруу байдаг.</p>
<p>17 дугаар зүйл. Баг, хорооны Хурлын бүрэн эрх</p>	<p>17.1.8. Иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн нутаг дэвсгэрийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай хүсэлтийг хэлэлцэж саналаа сум, дүүргийн Хуралд уламжлах</p>	<p>Иргэд өөрсдийн эрүүл аюулгүй орчиндамьдрах эрхээ хамгаалахад оролцох асуудлыг ш и й д в э р л э х и й г анхан шатны хуралд даалгасан.</p>	<p>НӨУЕБ-ын шууд ардчиллын зарчмаар гаргасан шийдвэр эцсийнх биш, дараагийн дээд шатны хуралд шилжиж хүчин чадлыг нь сулруулсан заалт.</p>	<p>Журам батлагдаагүй.</p>	<p>Байгалийн нөөцийн хамгаалалтыг гэрээлэх талаар НӨУЕБ-ын шууд ардчиллын зарчмаар гаргасан шийдвэр эцсийн хүчин чадалтай биш дараагийн шатанд шилжиж байгаа нь иргэдэд хүнд суртал чирэгдэл учруулж байна.</p>
<p>38 дугаар зүйл. Ойн дагалт баялаг, түүнийг ашиглах горим</p>	<p>38.8.Ойн сан бүхий газарт ургадаг хушны самар, зэрлэг жимс, жимсгэнэ, мөөг, эмийн ашигт ургамлыг хамгаалах бүсүүдийг байгуулж нутгийн иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлж болно.</p>	<p>Ойн дагалт баялгийн хамгаалалтыг ТББ-д гэрээлэн шилжүүлэх эрх зүйн орчныг нээсэн.</p>	<p>“Болно” гэсэн заалт нь төрийг энэхүү үүргийг заавал биелүүлэх шаардлагагүй болгодог.</p>	<p>Журам батлагдаагүй.</p>	<p>“Болно” гэсэн заалт нь дагалт баялгийн хамгаалалтыг ИНБ-д гэрээлэн шилжүүлэх төрийн үүргийг албан бус шинжтэй болгож, хэрэгжилтийг сулруулдаг.</p>

Хавсралт 6

Иргэдийн хяналт					
20 дугаар зүйл. Иргэний эрх, үүрэг	20.1.1. Ойн тухай хууль тогтоомжийг зөрчсөний улмаас ойн санд, эсхүл тухайн иргэний эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх болон учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах	Иргэдийн хариуцлага хүлээлгэх, хохирлыг нөхөн төлүүлэх талаар шаардлага тавих эрхийг олгосон.	Төрийн ямар байгууллага, албан тушаалтанд ямар арга замаар ямар хуганцаанд шаардлага тавих, шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тодорхой заагаагүй.	ЗГТ-2009.07.22/227- Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын бүрэн эрх 4.1.1. Эзэмшлийн ойд хяналт шалгалт зохион байгуулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох учруулсан хохирлыг буруутай этгээд, аж ахуйн нэгж, байгууллагаар нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах талаар эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах, шаардлагатай бол хуулийн байгууллагад асуудлыг тавих	Шаардах эрхийг хангах механизмыг тодорхой суулгаж өгөөгүйгээс хэрэгжилт хангалтгүй байдаг. Арга мухардсан ТББ-ууд хууль бус нийцгүй оролцооны аргыг хэрэглэх тохиолдол гардаг.
25 дугаар зүйл. ТББ-ыг ойн санг хамгаалахд оролцуулах	25.1.1. Ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;	ТББ-д ойн санд учруулсан хохирлыг шүүхэд нэхэмжлэх эрхийг нээж өгсөн чухал заалт болсон.	Шүүхийн өмнөх болон шүүхийн шатандахь зардлын асуудлыг зохицуулаагүй орхисон.	Журмаар зохицуулаагүй.	ТББ-аас шүүхэд нэхэмжлэл гаргахад зарцуулах зардлыг хөнгөвчлөх, чөлөөлөх, төрөөс хариуцах зэрэг зохицуулалтыг хийж өгөөгүй учир хэрэгждэггүй.
28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх	28.1.12 Захиргааны журмын биелэлтэд хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих	Ойн зөрчилтэй тэмцэхэд иргэдийн хүчийг ашиглахыг төрд даалгасан заалт болсон.	Иргэдийн санал, санаачлагыг ямар арга хэлбэрээр дэмжих нь тодорхой бус.	Журамлаагүй.	Иргэдийн оролцоог дэмжих хөшүүргийг хуульд заагаагүйгээс хэрэгждэггүй.

4. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Эерэг тал	Сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр,	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Иргэдийн хяналт					
5 дугаар зүйл. Байгаль орчныг нөхөн сэргээх ажиллагаа	5.2. Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орон нутгийн удирдлага болон нутгийн иргэдийн олон нийтийн хяналт дор 2 хүртэл жилийн хугацаанд хийж дуусгана.	Нөхөн сэргээлтийн ажлыг иргэд олон нийтийн хяналт дор заасан хугацаанд хийх үүргийг төрд даалгасан.	Иргэд, олон нийт ямар арга механизмаар хяналт тавих болон нөхөн сэргээлтийг хуулийн хугацаанд биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тодорхой зааж өгөөгүй.	Б О А Ж С Т - 2 0 0 9 / 3 7 0 - 3 . 2 Хамгаалалтын бүсийг тогтооход Сав газрын зөвлөл, байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын саналыг харгалзаж үзэж болно. Энэхүү заалтыг нарийвчлан журамлаагүй.	Иргэдийн хяналтын механизм, төрийн хүлээх хариуцлагыг хуульд тодорхой суулгаагүйгээс өнөөдрийг хүртэл хууль хэрэгжсэнгүй. “Болно” гэсэн заалт нь хяналтын чиг үүргээ төрийн байгууллага гэрээлэн шилжүүлэхээс зайлсхийх боломж олгож, хууль хэрэгжих боломжгүй болгосон.
	5.3. Энэ хуулийн 5.2-т заасан олон нийтийн хяналтыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах зорилго, чиглэл бүхий төрийн бус байгууллагуудад гэрээний үндсэн дээр хариуцуулж болно.	Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг ТББ-д гэрээгээр шилжүүлжгүйцтүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.	“Болно” гэж зааснаар төрийн байгууллагыг хуулийн энэхүү заалтыг заавал хэрэгжүүлэх үүргээс чөлөөлсөн.		

Хавсралт 6

5. Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хуулинд хийсэн дүн шинжилгээ

Зүйл	Хуулийн заалтын утга	Эерэг тал	Сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр,	Хэрэгжилтийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
9 дүгээр зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг	9.2-т Хөрсний доройтол, цөлжилтийн талаар үнэн зөв мэдээллийг эрх бүхий байгууллагаас авах, өгөх;	Иргэдийн мэдээлэл авах, өгөх эрхийг нээсэн.	Мэдээллийн агуулга, хэлбэр, арга зам, хугацааг тодорхой заагаагүй.	ЗГТ-2003/141-Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр ЗГТ-2010/90 - 9.4. “Сурталчилгаа, оролцоог нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих” тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь үр дүнд хүрнэ: 9.4.1. Зорилт 1. Бүх шатны боловсролын түвшинд тогтвортой хөгжлийн боловсролыг эзэмшүүлэх ажлын хүрээнд байгаль экологийг доройтуулж байгаа болон цөлжилтийг үүсгэж байгаа хүчин зүйл, хор уршгийн талаархи мэдлэгийг хүүхэд, залуучуудад эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлнэ. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 9.1.4.3. цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах, сэргийлэх уламжлалт мэдлэг, шинэ арга барил, дэвшилтэт технологийн талаар иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах, сурталчилгаа явуулах. 9.4.2. Зорилт 2. Цөлжилтийг нэмэгдүүлж байгаа шалтгаан, хүчин зүйл, үр дагаврын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, цөлжилттэй тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мэдээллээр хангана. 9.4.2.1. цөлжилт, түүнд хүргэж байгаа хүчин зүйлсийн талаархи олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг мэдээллийн бүхий л хэрэгслээр сургалт, сурталчилгаа, ярилцлага зэрэг арга хэлбэрээр тогтмол зохион байгуулах;	Иргэдийн мэдээлэл авах, өгөх механизм болон төрийн мэдээллээр хангах хариуцлагын тогтолцоог тодорхой хуульчлаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байдаг.
Идэвхтэй оролцоо					
10 дугаар зүйл. . Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх үйл ажиллагааг урамшуулах	10.1.3 Тухайн орон нутагтаа хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж ажлын байр нэмэгдүүлсэн	Хөрс хамгаалах болон цөлжилтөөс сэргийлэхэд иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлсэн.	Ямар төрлийн үйл ажиллагаа явуулж, хичнээн ажлын байр бий болгосон т о х и о л д о л д хэдий хэмжээний урамшуулал өгөх нь тодорхойгүй.	ЗГТ-2010/90 Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр - Зарчим: 8.4. Иргэдийн шууд оролцоог хангах урамшуулалтай байх; Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 9.4.2.2. цөлжилттэй тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний хийж байгаа ажлыг урамшуулах, дэмжихэд чиглэсэн олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах. 9.5.1.1. орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор газрын боломжит нөөцийн зохистой ашиглалтыг хангаж чадахуйц газар зохион байгуулалтын төлөвлөлтийг шинэчлэн боловсруулах; 9.5.2.3. орон нутагт малчид, малтай байсан иргэдэд орлогын нэмэлт эх үүсвэр бий болгож байгальд үзүүлэх дарамтыг багасгах; 9.5.2.4. ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг доройтол илэрсэн болон эрсдэл өндөртэй газар нутгийг нөхөн сэргээхэд чиглүүлж дэмжих. 9.5.3. Зорилт 3. Үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжлийн нөлөөгөөр доройтолд орсон газар нутгийг нөхөн сэргээхэд байгалийн нөөц, баялаг ашиглаж байгаа иргэдийн оролцоог нэмэгдүүлж “нөөц ашиглагч төлөх” зарчмыг нэвтрүүлнэ;	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэхэд иргэдийг оролцуулахад чиглэсэн болзол тодорхой бус, үүнийг төрийн ямар байгууллага, албан тушаалтан хэзээ, ямар арга замаар хариуцан гүйцэтгэхийг хуульчлаагүй учраас хэрэгжилт хангалтгүй.

Хавсралт 6

10 дугаар зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх үйл ажиллагааг урамшуулах	10.1.4. Нийтийн эдэлбэр газрын хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр хийсэн;	Хөрс хамгаалах, нөхөн сэргээхэд иргэдийн оролцоог дэмжсэн болсон.	Үйл ажиллагаа болон урамшууллын төрөл, хэмжээ, тодорхой бус.	БОАЖСТ-2010/А-250- 3.1. Нөхөрлөл нь байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах ашиглах, эзэмших талаарх хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргаар уламжлан Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд гаргана. 3.2. Нөхөрлөлийн байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах тухай хүсэлтийг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх ажлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.	Санхүүжилтийн асуудлыг хуулиар шийдэж өгөөгүйгээс нөхөрлөлийн үйл ажиллагаа бэхжихгүй, үйл ажиллагаа нь төслөөс хамааралтайгээр тогтворжиж чадахгүй байна.
Иргэдийн хяналт					
9 дүгээр зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг	9.1. Хөрсийг доройтуулж, цөлжилт үүсэх нөхцөл бүрдүүлсэн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, хөрсний бохирдлыг арилгах, нөхөн сэргээх түүнд хариуцлага хүлээлгэх талаар эрх бүхий албан тушаалтнаас шаардах	Иргэдийн хөрс доройтуулсан этгээдтэй хариуцлага хүлээлгэх талаар шаардлага тавих эрхийг нээсэн.	Тухайн албан тушаалтан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульд суулгаагүй.	Журмаар нарийвчдан зохицуулаагүй.	Иргэдийн хариуцлага тооцох эрхийг шаардлага тавих төдийгээр хязгаарлаж, шаардлага тавьсан албан тушаалтан түүнийг биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг хуульд заагаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.

6. Усны тухай хуулинд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр,	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг	4.1.4 Холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах	Усны талаар иргэд мэдээлэл авах боломжтой болсон.	Ямар байгууллагаас, хэзээ, ямар арга замаар мэдээлэл авах талаар тодорхой заагаагүй.	УИХТ-2010/24-3.6.5. Монголын ард түмний усыг хайрлан хамгаалах, зүй зохистой ашиглах уламжлалт зан үйл, ёс суртахууны хэм хэмжээг орчин үеийн шинжлэх ухааны мэдлэг, дэвшилтэт арга, технологиор баяжуулан өсвөр, залуу үе, нийт иргэдэд сурталчлан таниулах ажлыг усны салбарын бүх шатны байгууллага, боловсрол, соёл, урлаг, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран байнга тасралтгүй явуулах; 3.6.7. усны тахилгын уламжлалт зан үйлийг орчин үеийн соёл иргэншлийн нийтлэг хэм хэмжээ, хүсэл, сонирхолтой нийцүүлэн зохион байгуулж нийтийн хэвшил болгох;	Мэдээлэл авах механизмыг хуульд тодорхой тусгаагүйгээс хэрэгжилт тааруу байна.
10 дугаар зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх,	10.1.17. Улсын усны мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх, усны төлөв байдалтай холбогдолтой мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах	Иргэдийг усны талаар мэдээллээр хангах үүргийг төрийн захиргааны төв байгууллагад даалгасан.	Ямар арга механизмаар хэзээ, ямар мэдээллээр хангах талаар хуульд суулгаагүй.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	Хэрэгжиж эхлээгүй.

Хавсралт 6

17 дугаар зүйл. Сав газрын захиргааны бүрэн эрх	17.1.5. Сав газрын усны мэдээллийн дэд санг эрхэлж, олон нийтийг мэдээллээр хангах;	Иргэдийг мэдээллээр хангах үүргийг Сав газрын захиргаанд даалгасан.	Мэдээллийн механизм, хариуцлагын тогтолцоог хуулиар бүрдүүлээгүй.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	Хэрэгжиж эхлээгүй.
Идэвхтэй оролцоо					
20 дугаар зүйл. Сав газрын зөвлөл	20.1. Сав газрын захиргааны дэргэд сав газрын усны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дүгнэлт, зөвлөмж өгөх, хяналт тавих, олон талын оролцоог хангах үүрэг бүхий орон тооны бус усны сав газрын зөвлөлийг байгуулах	Тухайн нутгийн иргэдийн эрх ашгийг илэрхийлж, хамгаалдаг иргэдийн төлөөллийн байгууллагын бүтцийг бүрдүүлсэн.	Сав газрын зөвлөл нь нутгийн иргэд, эрдэмтэн, судлаачдаас бүрдэж, тухайн орон нутгийн иргэдийн эрх, ашгийг илэрхийлж хамгаалдаг тэдний төлөөллийн байгууллага байх ёстой атал нийт гишүүдийн дийлэнх нь төрийн захиргааны албан тушаалтан байхаар хуулиар зохицуулсан.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	Гишүүдийн дийлэнх нь төрийн захиргааны албан тушаалтан байхаар хуулиар зохицуулсан нь сав газрын зөвлөлийн зорилго, ашиг сонирхолдоо нийцсэн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хязгаарлаж, улмаар усны нөөцийн ашиглалтад тавих хяналтыг бодитой хийх, хариуцлага тооцох боломжийг бууруулсан зохицуулалт болсон. Сав газрын зөвлөл Ховд, Бороо, Хараа, Туул, Орхон зэрэг цөөн голуудынх л байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаа явуулах дүрэм журам боловсронгуй бус, санхүүгийн эх үүсвэрийг нь хууль тогтоомжоор нэг мөр шийдэж чадаагүй учраас тавьсан зорилгодоо хүрэхээр төдийлөн үр дүнтэй ажиллаж чадахгүй байна.
	20.2. Сав газрын зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны төлөөлөл, байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын алба, төрийн бус байгууллага, сум, дүүргийн иргэн, ус ашиглагч, эрдэмтэн, судлаач, усны мэргэжлийн байгууллагын төлөөлөл орсон байна.	Усны нөөцийг хамгаалахад иргэдийг оролцуулах бүтцийг бий болгосон.	Бүрэлдэхүүнд нь засаг захиргааны төлөөлөл, байгаль орчны алба, МХА, ус ашиглагч зэрэг ашиг сонирхлын зөрчилтэй байгууллага, хувь хүмүүс орохоор хуульчилсан. Ус ашиглагч өөрийн үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг гаргуулахгүйн тулд зөвлөлийн гишүүдэд нөлөөлөх боломж олгосон.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	СГЗ-ийн бүрэлдэхүүнд сонирхлын зөрчилтэй байгууллага, хүмүүс олноор орсон байгаа нь усны ашиглалтад олон нийтийн хяналт тавих боломжийг хаадаг. Ингэснээр Сав газрын зөвлөл нь ус ашиглагчийн үүргийн биелэлтийн талаар дүгнэлт гаргах, усны нөөцөд сөрөг нөлөөтэй тохиолдолд усны барилга, байгууламжийн ажлыг түдгэлзүүлэх санал гаргах, ус ашиглах талаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй этгээдийн ус ашиглах эрхийг түдгэлзүүлэх, зогсоох зэрэг хуулиар олгогдсон чухал эрх мэдлээ хэрэгжүүлж чадахгүйд хүрчээ. Мөн Усны сав газрын зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг шийдэх талаар эрх зүйн орчин байхгүйгээс Сав газрын зөвлөлүүд дээрх эрх, үүргээ хэрэгжүүлэн ажиллах боломжгүй байсаар байна.
13 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх	13.1.2. Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад рашааныг ашиглуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих;	Рашааны ашиглалт, хамгаалалт гэрээгээр ИНБ-д шилжүүлэх боломж бүрдсэн.	“Б а й г у у л л а г а” гэдгийг тодорхойлох шаардлагатай байгаа бөгөөд гэрээлэх хугацаа, с а н х ү ж и л т и й н асуудлыг хуульд тусгаагүй.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	Иргэд, байгууллагууд рашааныг гэрээлэн авсан тохиолдол олон байдаг ч санхүүжилтийн асуудлыг шийдээгүйгээс хамгаалалтын үйл ажиллагаа хангалтгүй байна.

Хавсралт 6

20 дугаар зүйл. Сав газрын зөвлөл	20.4.7. Урсац бүрэлдэх эх, усны эх үүсвэрийн орчмыг хамгаалах, ойжуулах, тохижуулах, нөхөн сэргээх арга хэмжээг нутгийн иргэдийн дэмжлэг, санаачилга, мэргэжлийн байгууллагын хүчийг нэгтгэн зохион байгуулах;	ИНБ-ын хүчийг усны нөөцийг хамгаалахад татан оролцуулах чухал заалт болсон.	Санхүүжилтийн асуудлыг зохицуулаагүй.	УИХТ-2010/24-3.6.11.Нийслэл, аймгийн төв болон томоохон хотуудад 20-50 км тойрогт, сум, суурин газруудад 10 км тойрогт, баг, хот айлд 5 км-ийн тойрогт орших гол, мөрөн, нуур, цөөрөм, булаг, шанд, уст цэгүүдийг ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлаас цэвэрлэх, голын гольдролыг нь сэргээх, тохижуулах, хамгаалах арга хэмжээг нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг оролцуулан жилд 2-оос доошгүй удаа (хавар 5 дугаар сарын 5, намар 10 дугаар сарын 15-нд) зохион байгуулж, түүнд иргэн бүр оролцдог болгож хэвшүүлэх;	ИНБ-д усны нөөцийг хамгаалах ажлыг урт хугацаанд санхүүжилттай нь шилжүүлэн гэрээлж өгөхгүй богино хугацаагй, эсхүл нэг удаагийн кампаничилсан арга хэмжээ болдог тул үр дүн муутай байдаг.
Иргэдийн хяналт					
20 дугаар зүйл. Сав газрын зөвлөл	20.4.3. Сав газрын захиргааны усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах шийдвэр гаргуулах, хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллагад санал хүргүүлэх;	Сав газрын захиргааг хянах боломжийг иргэдийн төлөөлөл оролцсон СГЗ-д олгосон.	СГЗ-д төрийн байгууллагын төлөөлөл олноор оролцсон байдаг нь өөрөө өөрийгөө хянах, хариуцлага тооцуулах санал тавихаар зохимжгүй байдлыг үүсгэсэн.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	Хэрэгжиж эхлээгүй.

7. Агаарын тухай хуулинд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр,	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
5 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх	5.3. Энэ хуулийн 5.1.1-д заасан Үндэсний хороо нь ажлын албатай байх бөгөөд уг ажлын алба нь байнгын цахим мэдээллийн сүлжээг ажиллуулж, иргэд мэдээлэл тогтмол авах боломжийг хангана.	Ямар байгууллага ямар хэрэгслээр иргэдийг мэдээллээр хангахыг зааж өгсөн.	Хэзээ, ямар мэдээллээр хангахыг тодорхой зааж өгөөгүй.	Журамлаагүй.	Цахим хэлбэрээр мэдээлэл өгөх нь мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангаж чадахгүй юм.
12 дугаар зүйл. Агаарын чанарын тухай мэдээлэл	12.3. Мэргэжлийн алба нь агаар бохирдуулах бодисын агууламж, физикийн сөрөг нөлөөллийн түвшин стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд холбогдох байгууллага, олон нийтэд шуурхай мэдээлж, эрүүл мэндийн зөвлөлгөө өгнө.	Ямар мэдээллийг хэдий иргэдэд хүргэхийг төрийн байгууллагад үүрэг болгосон.	Ямар хэрэгслээр мэдээлэл хүргэхийг зааж өгөөгүй.	Журамлаагүй.	Хэрэгжиж эхлээгүй.

Хавсралт 6

<p>15 дугаар зүйл. Агаарын чанарыг сайжруулах бүс</p>	<p>15.2. Энэ хуулийн 15.1-д заасны дагуу тогтоосон агаарын чанарыг сайжруулах бүсийн талаар нийтэд мэдэвлнэ.</p>	<p>Ямар мэдээллийг нийтэд хүргэхийг төрийн байгууллагад үүрэг болгосон.</p>	<p>Ямар хэрэгслээр хэзээ, хэрхэн мэдээлэл хүргэхийг тодорхой заагаагүй.</p>	<p>НИТХ-2011/131-Хоёр. Аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг: 2.1.9. Агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд Нийслэл, дүүрэг, хорооноос зохион байгуулахтай холбоотой сургалт, сурталчилгааны ажилд идэвхтэй оролцох; 2.1.11. Байгууллага бүр энэхүү журмыг иргэн, олон нийтэд сурталчилан таниулах;</p>	<p>Зөвхөн цахим хэлбэрээр энэ тухай мэдээлж байгаа нь хүртээмжтэй байдлыг хангаж чадахгүй байна.</p>
<p>15 дугаар зүйл. Агаарын чанарыг сайжруулах бүс</p>	<p>15.4. Агаарын чанарыг сайжруулах бүсийн хилийн зааг, байршлыг харуулсан 1:25000-аас доошгүй масштаб бүхий газрын зургийг тухайн нутгийн захиргааны байгууллага үйлдэж, нийтэд нээлттэй байлгана.</p>	<p>Ямар мэдээллийг нийтэд нээлттэй байлгахыг заасан.</p>	<p>Газрын зургийг хаана байршуулж, олон нийтийг чөлөөтэй танилцах боломжоор хангахыг хуульд тодорхой заагаагүй.</p>	<p>НИТХ-2011/131- Гурав. Иргэдийн хүлээх үүрэг: 3.1.5. Агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд Нийслэл, дүүрэг, хорооноос зохион байгуулж буй сургалт, сурталчилгааны ажилд идэвхтэй оролцох; 3.1.8. Агаарыг хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.</p>	<p>Газрын зургийг хаана байршуулахыг хуульд заагаагүй, хаанаас үзэж болохыг иргэдэд мэдээлдэггүйгээс хэрэгжилт хангалтгүй байгаа.</p>
Идэвхтэй оролцоо					
<p>30 дугаар зүйл. Цэвэр агаарын сан</p>	<p>30.3. Цэвэр агаарын сан нь түүний үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлтэй байна.</p>	<p>Агаарын бохирдлыг бууруулахад олон талын оролцоог хангасан бүтцийг бий болгосон.</p>	<p>Иргэдийн төлөөллийг шийдвэр гаргахад нөлөөлөх хэмжээнд оролцуулахыг хуулиар зохицуулаагүй.</p>	<p>БОАЖС-2011/4 дүгээр хавсралт. Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам: 5. Сангийн хөрөнгийг захиран зарцуулах, хяналт тавихтай холбоотойгоор Удирдах зөвлөл дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 5.1. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, сангийн хөрөнгийг өсгөх талаар гарсан санал, санаачлагыг дэмжих; 5.2. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах; 5.3. Сангийн хөрөнгөөс олгогдсон санхүүжилтийн зарцуулалтын байдалд хяналт тавьж, сайжруулах ажлыг зохион байгуулах; 5.4. Сангийн гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэн, шагнал урамшууллын асуудлыг шийдвэрлэх, сангийн үйл ажиллагаанд хяналт тавих; 5.5. Сангийн төсөв, орлого, зарлагын төлөвлөгөө, түүний тайлан мэдээг хэлэлцэж, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон холбогдох бусад байгууллагад хүргүүлэх;</p>	<p>Цэвэр агаарын сангийн Удирдах Зөвлөлийн 11 гишүүний зөвхөн 1 нь ТББ-ын төлөөлөл байдаг учир олон талын оролцоог тэгш хангасан шийдвэр гаргахад учир дутагдалтай.</p>

Хавсралт 6

Иргэдийн хяналт					
9 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг	9.1.10. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын явуулж байгаа үйл ажиллагаа нь агаар бохирдуулж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрсэн бол холбогдох байгууллагад шаардлага тавих, гомдол мэдүүлэх, мэдэгдэх	ИНБ-ын шаардах, гомдол мэдүүлэх, мэдэгдэх эрхийг хуулиар нээж өгсөн.	Шаардлага, гомдол, мэдэгдлээ ямарга замаар хэнд гаргах нь тодорхой бус. Барагдуулаагүй тохиолдолд хүлээх хариуцлагыг хуульд заагаагүй.	Журмаар нарийвчлан заагаагүй.	Шаардлага, гомдол, мэдэгдлээ ямар арга замаар хэнд гаргах, түүнийг нь барагдуулаагүй тохиолдолд хүлээх хариуцлагыг хуульд тодорхой тусгаагүйгээс хэрэгжилт тааруу.
4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг	4.1.5. Байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах	Иргэдийн шаардах эрхийг хуулиар нээж өгсөн.	Шаардлага тавих механизм, эргэх холбоо, хариуцлагын тогтолцоог хуульд суулгаагүй.	Журамлаагүй.	Шаардлага тавих механизм, хариуцлагын тогтолцоог хуульд суулгаагүй нь хэрэгжилтэд сөрөг нөлөөтэй байдаг. Шаардлагын хариуг эргэн мэдээлдэггүй.

8. Хог хаягдлын тухай хуулинд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр,	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Иргэдийн хяналт					
9 дүгээр зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг эрх, үүрэг	9.1.1. Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах	Иргэдэд шаардлага тавих боломж олгосон.	Ямар байгууллага, албан тушаалтанд ямар арга замаар шаардлага тавих нь тодорхой бус, хариуг хүлээн авах эргэх холбоо, шаардлагыг биелүүлээгүй бол хүлээх хариуцлагыг хуульд тусгаагүй.	Журмаар зохицуулаагүй.	Билэгдэл төдий заалт учраас биелдэггүй.

Хавсралт 6

9. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр,	Хэрэгжилтийн оноогийн байдал
Идэвхтэй оролцоо					
6 дугаар зүйл. Орчны бүсийн зөвлөл	6.1 Орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд нутгийн иргэдийн оролцоог өргөжүүлэх зорилго бүхий орон тооны бүсийн зөвлөл ажиллана.	Иргэдийн оролцоог хангасан бүтцийг зохицуулж өгсөн.	Зөвлөлийг байгуулан ажиллуулах талаар төрийн холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэгжүүлж өгөөгүй.	БОС-1998/112-9.Орчны бүсийн зөвлөлд нутгийн иргэдээс оруулах төлөөлөгчийг тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд хамрагдсан баг, хорооны Засаг дарга орон нутагтаа байнга оршин суудаг, нэр хүнд бүхий 5-аас доошгүй иргэний нэрийг дэвшүүлж иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн санал хураах замаар хамгийн олон санал авсан 3 хүнийг сонгоно.10.Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд нэг сумын хэд хэдэн багийн болон нэг дүүргийн хэд хэдэн хороо хамрагдсан тохиолдолд орчны бүсийн зөвлөлд оруулах төлөөлөгчийг баг, хороо тус бүрээс ижил тооны иргэдийн нэрийг дэвшүүлж, багууд болон хороодын иргэдийн Нийтийн Хурлын хамтарсан хуралдаанаар хэлэлцүүлэн санал хураах замаар хамгийн олон санал авсан 3 хүнийг сонгоно.	Иргэдийн оролцоотой хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх Орчны бүсийн зөвлөлийг орон нутагт байгуулах үйл явц удаан, төрийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудаас санал, санаачилга гаргадаггүй, гол төлөв донор байгууллагуудын төслийн хүрээнд, эсхүл ТББ-уудын шахалт шаардлагаар цөөн тоогоор байгуулагдсан байдаг.
6 дугаар зүйл. Орчны бүсийн зөвлөл	6.2 Зөвлөлийн бүрэлдэхүүнд нутгийн иргэдээс гурваас доошгүй төлөөлөгч байна.	Шийдвэр гаргахад нутгийн иргэд оролцох боломжийг хангасан.	Иргэдийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргахад нөлөөлж чадахгүй хэмжээний төлөөллийг заасан.		Засаг дарга нар зөвлөлийн төлөөлөгчийг нэр дэвшүүлдэг учраас аль болох өөрийн хүнийг оруулдаг тул иргэдийн эрх ашгийг илэрхийлж чаддаггүй.
6 дугаар зүйл. Орчны бүсийн зөвлөл	6.3 Зөвлөлд байгаль орчны чиглэлээр ажилладаг ТББ-ын төлөөлөгч ажиллаж болно.	Байгаль орчны ТББ-ын шийдвэр гаргахад оролцох боломжийг нээсэн.	“болно” гэсэн заалт нь ТББ-ын оролцоог заавал хангах албагүй болгож байна.		Байгаль орчны ТББ-ыг ОБЗ-д ажиллуулах нь Засаг дарга нарын үзэмжийн асуудал байдаг тул энэ заалт хэрэгждэггүй.

10. Амьтны тухай хуульд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр,	Хэрэгжилтийн оноогийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
5 дугаар зүйл.Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар төрийн болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх	5.3.6.Амьтны нөөцийн өөрчлөлтөд хяналт-шинжилгээ хийх, ан, амьтны мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллээр хангах;	Мэдээллээр хангах үүргийг төрд даалгасан.	Хэнийг, хэзээ, хэрхэн мэдээллээрхангах механизмыг тодорхой заагаагүй.	Журам боловсрогдоод хэлэлцүүлгийн шатанд шилжсэн бөгөөд олон нийтээс санал авч байгаа.	Хэрэгжиж эхлээгүй.

Хавсралт 6

Зөвлөлдөх орчин					
<i>21 дүгээр зүйл. Иргэн, нөхөрлөл, амьтан хамгаалах чиглэлийн мэргэжлийн болон ТББ-ыг амьтны нөөцийг хамгаалахад оролцуулах</i>	21.5.2. Амьтны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаарх саналаа холбогдох төрийн байгууллага болон зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн болон иргэдийн Нийтийн Хурал, Засаг даргад уламжлах;	Саналаа уламжлах эрхийг ИНБ-д өгсөн.	Ямар арга замаар хэзээ уламжлах, үүнд хариу өгөх эргэх холбоо, хүлээх хариуцлагыг хуульчлаагүй.	Журмаар нарийвчлан зохицуулаагүй.	Хэрэгжиж эхлээгүй.
	21.5.3. Агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулахад нөхөрлөл, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх;	ИНБ-ыг дэмжсэн заалт болсон.	Дэмжлэг нь ямар хэлбэр, хэмжээтэй байх нь тодорхойгүй.	Журмаар нарийвчлан зохицуулаагүй.	Хэрэгжиж эхлээгүй.
	21.5.4. Амьтныг хайрлах ёс зүй, зан заншил, үндэсний уламжлал, хууль тогтоомжийг сурталчлах.	Иргэдийн оролцооны арга замыг тодорхойлж өгсөн.	Хэдий хугацаанд ямар санхүүгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх нь тодорхой бус.	Журмаар нарийвчлан зохицуулаагүй.	Хэрэгжиж эхлээгүй.
Идэвхтэй оролцоо					
<i>6 дугаар зүйл. Амьтныг хамгаалах хэлбэр</i>	6.1.4, 6.1.6-6.1.9-д заасан үйл ажиллагааг байгаль орчны мэргэжлийн байгууллага, 6.1.7-6.1.9-д заасан үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд тус тус хэрэгжүүлнэ. 6.1.4. амьтны удмын санг хамгаалах, үр хөврөлийг хадгалах; 6.1.6. амьтныг сэргээн нутагшуулах; 6.1.7. үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийл; 6.1.8. биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх; 6.1.9. өвчилсөн, байгалийн гамшиг болон бусад аюулд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах;	Мэргэжлийн байгууллага, ТББ-ын шилжүүлэн гүйцэтгэх үйл ажиллагааг заагласан.	Хугацаа, санхүүжилтийг орхигдуулсан.	Журам батлагдаагүй	Хэрэгжиж эхлээгүй.
<i>14 дүгээр зүйл. Амьтан эзэмших</i>	14.1. Иргэн, хуулийн этгээд нэн ховроос бусад амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, ашиглах зорилгоор тодорхой нөхцөл, болзол бүхий гэрээний үндсэн дээр эзэмшүүлж болно.	Нэн ховроос бусад амьтан хамгаалах үүргийг шилжүүлсэн.	Хугацаа болон санхүүгийн эх үүсвэрийн асуудлыг хуульчлаагүй.	Журам батлагдаагүй	Хугацаа болон санхүүгийн эх үүсвэрийн асуудлыг хуульчлаагүйгээс хэрэгжилтэд хүндрэл учирна.

Хавсралт 6

21 дүгээр зүйл. Иргэн, нөхөрлөл, амьтан хамгаалах чмглэлийн мэргэжлийн болон ТББ-ыг амьтны нөөцийг хамгаалахад оролцуулах	21.3.Агнуурын нөөцийг хамгаалах талаар нөхөрлөл, хуулийн этгээд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 21.3.1.хариуцаж байгаа агнуурын бүс нутгийнхаа агнуурын нөөцийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу тогтвортой ашиглах, эзэмших;	Агнуурын нөөцийг гэрээгээр ашиглах эзэмших эрх шилжсэн.	Хугацаа болон санхүүгийн эх үүсвэрийн асуудлыг хуульчлаагүй.		
	21.6.Төрийн захиргааны төв байгууллага амьтныг хамгаалах талаарх төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу амьтны нөөцийг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.	Амьтан хамгаалах төрийн тодорхой чиг үүргийг ТББ-д шилжүүлсэн.	“Санхүүжүүлж болно” гэж санхүүжилтийг хамт шилжүүлэх үүргээс төр өөрийгөө чөлөөлсөн.	Журам батлагдаагүй	“Санхүүжүүлж болно” гэж санхүүжилтийг хамт шилжүүлэх үүргээс төр өөрийгөө чөлөөлсөн өр хэрэгжилтийг эрсдэлтэй болгосон.
Иргэдийн хяналт					
21 дүгээр зүйл. Иргэн, нөхөрлөл, амьтан хамгаалах чмглэлийн мэргэжлийн болон ТББ-ыг амьтны нөөцийг хамгаалахад оролцуулах	21.5.1.Амьтны тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, шаардлагатай тохиолдолд асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;	ИНБ-ын хянах, шаардах, асуудал тавьж шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан.	Механизм, хариуцлагын тогтолцоог тодорхой хуульчлаагүй.	Журмаар нарийвчлан заагаагүй.	Механизм, хариуцлагын тогтолцоог тодорхой хуульчлаагүй учраас хэрэгжилт хангалтгүй.

11. Ургамал хамгааллын тухай хуульд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Холбогдох журам, хөтөлбөр,	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
4 дүгээр бүлэг. Ургамал хамгааллын талаархи иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг	13.1.1 Төв, орон нутгийн, мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагаас ургамал хамгааллын тухай мэдээлэл авах	Иргэдийн мэдээлэл авах эрхийг нээсэн.	Мэдээлэл авах механизмыг хуульчлаагүй.	Журмаар нарийвчлан зохицуулаагүй.	Мэдээлэл авах механизмыг хуульчлаагүйгээс хэрэгжилт хангалтгүй.
Идэвхтэй оролцоо					
8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын үүрэг	8.1.6 Ургамал хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих	Ургамалын хамгаалалтыг мэргэжлийн холбоодод шилжүүлсэн.	Санхүүжилт, хугацааг хуульд заагаагүй.	Журмаар нарийвчлан зохицуулаагүй.	Санхүүжилт, хугацааг хуульд заагаагүй, гэрээлэн механизм тодорхойгүй учраас хэрэгждэггүй.

Хавсралт 6

Иргэдийн хяналт					
4 дүгээр бүлэг. Ургамал хамгааллын талаархи иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг	13.1.3 Ургамал хамгааллын үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа мэргэжлийн байгууллагаас уг үйл ажиллагаатай холбоотойгоор гаргасан дүгнэлт, арга хэмжээний талаар тайлбар шаардах, гомдол гаргах	ИНБ-д тайлбар шаардах, гомдол гаргах боломж олгосон.	Тайлбар шаардах, гомдол гаргах механизм, хариуцлагын тогтолцоог хуульд заагаагүй.	Журамлаагүй.	Тайлбар шаардах, гомдол гаргах механизм, хариуцлагын тогтолцоо байхгүй учир хэрэгжилт хангалтгүй.

12. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	Журам, хөтөлбөр,	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
6 дугаар бүлэг. Химийн хортой болон аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах нь	6.1.10. Химийн хорт болон аюултай бодисын асуудлаар олон улсын байгууллагатай мэдээлэл солилцох, эдгээр бодисын физик, химийн болон хор аюулын шинж чанар, осол, эрсдлийн үед авах арга хэмжээ, тухайн бодис, түүний хольц, хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх аргын талаархи мэдээллээр иргэдийг хангах	Иргэдийг ямар мэдээллээр хангах үүргийг төрд даалгасан.	Мэдээллийг хэн, хэзээ, хэрхэн өгөх нь тодорхой бус.	Ж у р м а а р зохицуулаагүй.	Мэдээллийн механизм хуульчлагдаагүй тул хэрэгжилт хангалтгүй.
Иргэдийн хяналт					
18 дугаар зүйл. Химийн хортой болон аюултай бодисын холбогдох зйл ажиллагаанд тавих хяналт	18.2 Иргэд, ТББ нь химийн хортой болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаархи санал, хүсэлтээ холбогдох төрийн байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.	Иргэд, ТББ-д санал хүсэлтээ шийдвэрлүүлэх боломж олгосон.	Иргэд, ТББ-ын санал хүсэлтийг шийдвэрлэх арга механизм, хариу өгөх эргэх холбоог хуульд заагаагүй.	Журамлаагүй.	Иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэх механизм, шийдвэрлээгүй бол хүлээх хариуцлагыг хуульд суулгаагүйгээс хэрэгжилт сул байна.

Хавсралт 6

13. Ашигт малтмалын тухай хуульд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал	журам, хөтөлбөр	Хэрэгжилтийн өнөөгийн байдал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал					
19 дүгээр зүйл. Өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа	19.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.3-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 30 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.	Иргэдийн төлөөллийн байгууллагаас санал авах боломж олгосон.	30 хоногийн хуулийн хугацаа нд багтаж орон нутгаас санал авахаар хязгаарлалт тогтоосноор орон нутгийн саналыг авсан нэр зүүсэн төдий зохицуулалт болсон.	Ж у р м а а р зохицуулаагүй. Зарим аймгууд өөрсдөө журамласан байдаг.	ИТХ, түүний тэргүүлэгчид нь иргэдийн эрх ашгийг төлөөлж чаддаггүй, худалдагддаг, иргэдэд санал авах талаар урьдчилан мэдэгддэггүй, ИТХ болон Засаг дарга ямар санал өгснийг иргэдэд эргэж мэдээлдэггүй, иргэдийнхээ эрх ашгийн эсрэг санал өгсөн албан тушаалтнуудтай хариуцлага тооцдоггүй зэргээс шалтгаалан ИТХ нь иргэдийнхээ эрх ашгийн эсрэг шийдвэр гаргах тохиолдол хавтгайрсан. 30 хоногийн хугацаанд ялангуяа хөдөөгийн алслагдмал сумын ИТХ саналаа амжуулж ирүүлдэггүй бөгөөд хугацаандаа ирүүлээгүй бол зөвшөөрсөнд тооцдог хуулийн зохицуулалтаар нутгийн иргэдийн эрх ашиг хохирч байна.
57 дугаар зүйл. Ашигт малтмалтай холбоотой мэдээлэл, бүртгэлтэй танилцах	57.4.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй химийн хорт болон бусад бодисын хэрэглээний талаархи мэдээллийг байгаль орчны болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийтэд нээлттэй болгож, тухайн мэдээллийг цахим хэлбэрээр түгээнэ.	Мэдээллийг нээлттэй болгохыг холбогдох яамдад даалгасан.	М э д э э л л и й г цахим хэлбэрээр түгээх нь хүртээмжтэй байдлыг хангаж чадахгүй юм.	Журмаар нарийвчлан заагаагүй.	БОНХЯ дэргэдээ иргэд, олон нийтийн мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх зорилгоор “Байгаль орчны мэдээллийн төв”-ийг ажиллуулж цахим хэлбэрээр мэдээлэл түгээж байгаа хэдий боловч энэ нь төвөөс алслагдмал хөдөө орон нутагт оршин суудаг иргэдэд хүртээмжгүй, цахим хэлбэрээр мэдээллийг хэрхэн олж авах аргын талаар танилцуулгыг урьдчилан тодорхой өгдөггүй, мэдээллийн санд шаардлагатай чухал мэдээллийг оруулдаггүй, мэдээллээ шинэчилдэггүй, тавьсан мэдээллээ иргэдэд зориулан энгийн ойлгомжтой хэллэг хэлбэрээр тусгайлан боловсруулаагүй байдаг учраас мэдээллийн найдвартай, эрэлт хэрэгцээ хангахуйц хүртээмжтэй эх үүсвэр болж чадахгүй байна.
Зөвлөлдөх орчин					
42 дугаар зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах	42.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.	Оролцогч талуудад хэлэлцүүлэг хийх боломж олгосон.	“Болно” гэсэн заалтаар олон нийтийн хэлэлцүүлэг хийх үүргээс нутгийн захиргаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийг чөлөөлсөн.		“Болно” гэсэн нь нутгийн захиргаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийг заавал хэлэлцүүлэг хийх албагүй болгосон тул хэрэгжилт сул хэвээр байна.

Хавсралт 6

Идэвхтэй оролцоо					
42 дугаар зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах	42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.	Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байраар хангахад эерэг нөлөө үзүүлэх зохицуулалт болсон.	Гэрээний үйл явц, хэрэгжилт, хяналтад нутгийн иргэд, сонирхогч талуудыг оролцох боломжийг тусгаагүй.	Ж у р м а а р зохицуулаагүй	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нутгийн захиргаатай гэрээ хийсэн цөөн тохиолдол байдаг бөгөөд олон талууд оролцсон Оролцооны гэрээг ТББ-уудын шахалтаар голдуу хийдэг.
Иргэдийн хяналт					
42 дугаар зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах	42.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно.	Иргэдийн төлөөлөл нөхөн сэргээлтэд хяналт тавих боломжтой болсон.	“Болно” гэсэн заалтаар иргэдийн хяналтыг заавал хэрэгжүүлэх албагүй болгосон.	Ж у р м а а р зохицуулаагүй.	Олон нийтийн хяналтын төлөөлөгчийг тусгай зөвшөөрөл цалинжуулдаг тул хөндлөнгийн хараат бус хяналт тавих чадваргүй байдаг.

Хавсралт 7

1. Эрүүл мэндийн салбарын эрх зүйн баримт бичгүүдэд оролцоог хангасан байдал

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал			
Эрүүл мэндийн тухай хууль	43.1.3.өөрийн эрүүл мэндийн тухай мэдээллийг эмч, эрүүл мэндийн байгууллагаас авах; 43.1.6.эрүүл мэндийн боловсролоо дээшлүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллага, ажилтнаас мэдээлэл авах; 43.2.4.хүний эрүүл мэнд болон нийгэмд аюул бүхий өвчин, хордлого, осол, гэмтэл, орчны сөрөг хүчин зүйлийн талаар эрүүл мэндийн байгууллагад цаг тухайд нь мэдээлэх;	Хувь хүн өөрийн эрүүл мэнд, эрүүл мэндийн боловсролтой холбоотой мэдээлэл авах, мөн эрүүл мэндэд сөрөг орчин, зүйлийн талаарх мэдээлэл өгөх үүргийг тодорхойлсон сайн.	Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, шийдвэр, түүнтэй холбоотой мэдээллээр хангах талаар зохицуулалт алга.
Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хууль	5.1.2.эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний талаархи мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах;	Бүтээгдэхүүний талаар хэрэглэгч үнэн зөв мэдээллээр хангагдах нөхцөл бүрдэнэ.	Яаж, хэзээ гэдэг тодорхой бус байна.
Тамхины хяналтын тухай хууль	4.1.4.тамхины хэрэглээ, дам тамхидалтын улмаас хүний эрүүл мэнд, эдийн засаг, байгаль орчинд учруулах сөрөг үр дагаврын талаархи шинжлэх ухааны үндэслэлтэй, бодит мэдээлэл, сургалт, сурталчилгаа	Тамхи, дам тамхидалтын хорын талаар иргэд илүү мэдлэгтэй болно.	Яаж мэдээлэх нь тодорхойгүй.
Хүнсний тухай хууль	6.1.1. хүнсний хангамж, аюулгүй байдлыг харгалзан тухайн жилд импортлох, экспортлох мал, стратегийн хүнсний нэр төрөл, хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх;		
Хүнсний тухай хууль	16.2. Иргэн, төрийн бус байгууллага хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг төрийн захиргааны болон хяналтын эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх...	ЗГ 2005 оны 245 дугаар тогтоолын 1 дүгээр	
Хувцгасан амьд организмын тухай хууль	5.2.Үндэсний хорооны аливаа шийдвэр нээлттэй байх бөгөөд гаргасан шийдвэрээ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээнэ.		
ЗГ 2005/ 245 тогтоол дүгээр хавсралт орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	4.2. Хүн амын дунд явуулах экологи, орчны болон нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд хэвлэл, мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглах	Мэдээллийг ямар аргаар түгээхийг тодорхойлсон нь сайн.	Эдгээр хэрэгслийг хэрхэн ашиглах нь тодорхойгүй.
Эрүүл мэндийн 43 дугаар зүйл. Иргэний эрх, үүрэг	43.1.3.өөрийн эрүүл мэндийн тухай мэдээллийг эмч, эрүүл мэндийн байгууллагаас авах; 43.1.6.эрүүл мэндийн боловсролоо дээшлүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллага, ажилтнаас мэдээлэл авах; 43.2.4.хүний эрүүл мэнд болон нийгэмд аюул бүхий өвчин, хордлого, осол, гэмтэл, орчны сөрөг хүчин зүйлийн талаар эрүүл мэндийн байгууллагад цаг тухайд нь мэдээлэх;	Хувь хүн өөрийн эрүүл мэнд, эрүүл мэндийн боловсролтой холбоотой мэдээлэл авах, мөн эрүүл мэндэд сөрөг орчин, зүйлийн талаарх мэдээлэл өгөх үүргийг тодорхойлсон сайн.	Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, шийдвэр, түүнтэй холбоотой мэдээллээр хангах талаар зохицуулалт алга.
Лавлагаа төвийн үлгэрчилсэн дүрэм	3.2.12. Төв нь үйлчлүүлэгчдийг эрүүл мэндийн болон өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах; 4.6.5 Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баглан, хэрэгжилтийн тайланг байгууллагын хурлаар хэлэлцүүлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд мэдээлэх;		
Зөвлөлдөх орчин			
Эрүүл мэндийн тухай хуулийн 43 дугаар зүйл.Иргэний эрх, үүрэг	43.1.5.хүний эрүүл мэндэд харш үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний талаар холбогдох байгууллагад өргөдөл, гомдол гаргах;		Холбогдох байгууллага гэдэг ямар байгууллагууд байх нь тодорхойгүй.

Хавсралт 7

<p><i>Хувиргасан амьд организмын тухай хуулийн 4 дүгээр зүйл. Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хороо</i></p>	<p>4.3.Үндэсний хорооны бүрэлдэхүүнд байгаль орчин, үйлдвэр, худалдаа, эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, улсын мэргэжлийн хяналтын байгууллага, биотехнологийн чиглэлийн эрдэм шинжилгээний байгууллага, холбогдох төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.</p>	<p>Олон нийтийн оролцоог хангасан нь сайшаалтай.</p>	<p>Гэхдээ сонгон шалгаруулалтыг хэрхэн зохион байгуулах нь тодорхойгүй.</p>
<p><i>ЭМ-ийн ТҮ-ний чанар, аюулгүй байдлыг зохицуулах салбар зөвлөлийн журам</i></p>	<p>1. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байна</p>		<p>Гэхдээ сонгон шалгаруулалтыг хэрхэн зохион байгуулах нь тодорхойгүй.</p>
<p>Идэвхтэй оролцоо</p>			
<p><i>Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчим</i></p>	<p>4.2.3.эрүүл мэндийн бодлого, арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, гэр бүл, иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх.</p>		<p>Иргэд, олон нийтийн оролцоог хангах механизм тодорхойгүй.</p>
<p><i>13 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл</i></p>	<p>13.3. Эрүүл мэндийн байгууллага нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дангаараа болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран явуулна.</p>		<p>Иргэд, олон нийтийн оролцоог хангах механизм тодорхойгүй.</p>
<p><i>16 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын чиг үүрэг</i></p>	<p>16.2.Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна. 20.2.5.хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах;</p>		<p>Иргэд, олон нийтийн оролцоог хангах механизм тодорхойгүй.</p>
<p><i>Эрүүл мэндийн тухай хуулийн 45 дугаар зүйл. Эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд төрийн бус байгууллагын оролцоо</i></p>	<p>45.1.2.эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд хамт олон, иргэнийг оролцуулах, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг дангаар болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах</p>		
<p><i>Эхийн сүү ордулагч бүтээгдэхүүний тухай хууль 5 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</i></p>	<p>5.1.4.эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.</p>		
<p><i>Тамхины хяналтын тухай хуулийн 4 дүгээр зүйл. Тамхины хяналтын талаар төрөөс баримтлах бодлого</i></p>	<p>4.1.3.тамхины хяналтын талаар бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тамхи үйлдвэрлэгчтэй холбоогүй хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын оролцоог дэмжих;</p>		
<p>Иргэдийн хяналт</p>			
<p><i>Эрүүл мэндийн тухай хуулийн 45 дугаар зүйл. Эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд төрийн бус байгууллагын оролцоо</i></p>	<p>45.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;</p>		<p>Эрх зохицуулалт шаардлагатай.</p>

Хавсралт 7

2. Боловсролын салбарын эрх зүйн баримт бичгүүдэд оролцоог хангасан байдал

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал			
Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйл. Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг	14.1.2.цэцэрлэгийн сургалтын орчин, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, сургалтын чанартай холбогдсон санал хүсэлт, гомдол гаргах; 14.1.3.хүүхдийнхээ эрүүл мэнд, өсөлт хөгжил, боловсролын асуудлаар мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа авах; 14.1.4.Ажиллагаатай холбогдох асуудлаар санал гаргах ; 14.1.5.хүүхдийг сургах үйл ажиллагаатай холбогдуулан өөрөөс гаргасан зардал, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих;	Эцэг, эх, асран халамжлагчид хүүхэдтэй холбоотой асуудлаар мэдээлэл, зөвлөгөө авах, санал гаргах эрхтэй байна.	Ихэнхдээ ийм ерөнхий заалтууд хэрэгжилт багатай .
Зөвлөлдөх орчин			
Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйл. Сургууль, цэцэрлэгийн зөвлөл /Сургуулийн өмнөх боловсролыг тухай, Бага дунд боловсролын тухай хууль/	35.2.Сургууль, цэцэрлэгийн зөвлөлд орох багш, ажилтан, сурагч, эцэг, эхийн төлөөллийг тэдгээрийн хамт олны хурлаас тус тус сонгоно.	Шийдвэр гаргах түвшинд эцэг, эхийн оролцоог баталгаажуулсан нь сайн.	Сонгон шалгаруулалтыг ил тод, шударга явуулах асуудал гарч байна.
Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйл. Удирдах зөвлөл	36.3.Удирдах зөвлөлд орох багш, суралцагчийн төлөөллийг хамт олны хурлаас сонгоно.		Сонгон шалгаруулалтыг ил тод, шударга явуулах асуудал гарч байна.
Төрөөс боловсролын талаар баримтлах үндсэн чиглэл, 4 Боловсролын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар	3/бүх шатны сургуулийн үйл ажиллагаагаа явуулах эрхийг баталгаажуулах үүрэг бүхий олон нийтийн төлөөлөлтэй магадлан итгэмжлэх байгууллага бий болгох;		
Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйл. Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг	14.1.6.цэцэрлэгийг хөгжүүлэх үзэл баримтлал, хөтөлбөр, дүрэм, журам боловсруулах, үйл ажиллагааны чиглэлийг боловсруулах, шийдвэр гаргахад оролцох.		Яаж оролцох тодорхойгүй. Оролцуулаагүй нөхцөлд ямар хариуцлага хүлээх нь тодорхойгүй.
Идэвхтэй оролцоо			
Төрөөс боловсролын талаар баримтлах үндсэн чиглэл,	10/хүүхэд, залуучуудын үүсгэл санаачлагын байгууллагыг дэмжих, тэдэнд туслалцаа үзүүлэх, эрх ашгийг нь хамгаалахад төрөөс анхаарах;		

Хавсралт 7

Бага насны хүүхдийн хөгжилд эцэг, эх, гэр бүл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас баримтлах чиглэл	Бүх заалтыг авч үзэх боломжтой.		
Иргэдийн хяналт			
Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйл. Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг	14.1.4.сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хяналт тавих		Хяналтын механизмыг орхигдуулсан.
	14.1.5.хүүхдийг сургах үйл ажиллагаатай холбогдуулан өөрөөс гаргасан зардал, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар хяналт тавих;		

3. Нийгмийн халамжийн салбарын эрх зүйн баримт бичгүүдэд оролцоог хангасан байдал

Хуулийн зүйл	Хуулийн заалтын утга	Зохицуулалтын эерэг тал	Зохицуулалтын сөрөг тал
Мэдээллийн хүртээмж ба ил тод байдал			
<i>Нийгмийн халамжийн тухай хуулийн 25 дугаар зүйл. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх</i>	25.1.4.нийгмийн халамжийн болон асрамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах, 25.1.9.нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдсон иргэд, байгууллагын санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;	Салбарын хэмжээнд нэгдсэн мэдээллийн тогтолцоо үүсгэх нь сайн санаачилга юм.	Түүнийг хэрхэн ашиглах, түүгээр дамжуулан оролцоог хангах механизм тодорхойгүй.
<i>Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйл. Нийгмийн ажилтан</i>	28.8.6.орон нутгийн иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллээр хангах,		
Зөвлөлдөх орчин			
<i>Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйл. Амьжиргааг дэмжих зөвлөл</i>	27.3.Зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах төлөөлөөс бүрдэнэ: 27.3.1.нийгмийн ажилтан 1 хүн; 27.3.2.төрийн байгууллагын төлөөлөл 2 хүн; 27.3.3.иргэний төлөөлөл 2 хүн; 27.3.4.төрийн бус байгууллагын төлөөлөл 2 хүн.		Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах журам алга.
Идэвхтэй оролцоо			
<i>Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйл. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ</i>	18.6.Энэ хуулийн 18.5-д заасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.		Зорилтот бүлгийн оролцоотой төрийн бус байгууллагуудыг дэмжих зохицуулалт хангалтгүй. /Бие даан амьдрах зарчмыг хөгжүүлэх

Хавсралт 7

<p><i>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын талаархи аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүрэг</i></p>	<p>11.2..... нийгмийн халамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх арга хэмжээ авна.</p>		
<p><i>12 дугаар зүйл. Төрийн зохих байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх</i></p>	<p>12.1.Энэ хуульд заасан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлж болно.</p>	<p>Оролцоог хангах сайн механизм.</p>	<p>Ил тод, шударга явуулах хэрэгсэл алга.</p>
<p><i>Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйл. Ахмадын байгууллага</i></p>	<p>9.1.Ахмад настны олонхийн нийтлэг эрх ашгийг төлөөлж чадах төв байгууллагыг улсын төсвөөс, орон нутгийн байгууллагыг тухайн орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлнэ. 9.2.Ахмадуудын санаачилгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд нийт ажиллагсдын 70-аас доошгүй хувийг нь ахмад настан эзэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад Засгийн газар болон аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр дэмжлэг үзүүлж болно. 9.3.Энэ хуульд заасан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг ахмад настны төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардлыг санхүүжүүлж болно.</p>		
<p><i>Нийгмийн халамжийн тухай хуулийн 25 дугаар зүйл.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх</i></p>	<p>25.1тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах; 25.9.....мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах;</p>		
<p><i>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр</i></p>	<p>Үйл ажиллагаа, 1.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үүсгэн санаачилсан төрийн бус байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд төрөөс арга зүй, мэдээллээр дэмжлэг үзүүлэх; 1.2.2. Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгэм хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах; 1.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөгжүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр олон улсын болон бүсийн байгууллагатай хамтран ажиллах; 1.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар Засгийн газраас хэрэгжүүлэх зарим арга хэмжээг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх асуудлыг судлан хэрэгжүүлэх; 1.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулагдах олон улсын болон бүсийн уралдаан тэмцээн, хурал зөвлөлгөөнд тэдгээрийг төлөөлөн оролцох иргэний нийгмийн байгууллагад дэмжлэг үзүүлэх.</p>		
<p>Иргэдийн хяналт</p>			
<p>Ахмадын сан байгуулах журмын сангийн үйл ажиллагаанд тавих хяналт</p>	<p>Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтанд тухай байгууллагын ахмадын байгууллага хяналт тавина.</p>		<p>Яаж гэдэг нь тодорхойгүй.</p>